

Remove Watermark Now

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 320807, 321316
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn

2016 ОН

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

2016 ОН



Монгол Улсын Их Хурлын
Тамгын Газар



Удирдлагын Академи



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



Empowered lives.
Resilient nations.

Remove Watermark Now

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2016



**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА
ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ**

Хэмжээ: А5 (176 x 250мм)
Хэвлэлийн хуудас: 17,6
"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

“Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлаг 2013 оноос хамтран хэрэгжүүлж байгаа билээ. Уг төслийн зорилго нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн эрх зүйн болон эдийн засгийн мэдлэг боловсролыг сургалтын тодорхой хөтөлбөрийн дагуу дээшлүүлж, иргэдээ төлөөлж ажиллах чадавхийг нь бэхжүүлэхэд чиглэгдэж ирсэн юм. Энэхүү төслийн хүрээнд Удирдлагын академи, Монгол Улсын их сургуулийн багш нарын оролцоотойгоор “ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалтын гарын авлага”, “ИТХ-ын төлөөлөгчдийн сургагч багшийн гарын авлага” хөтөлбөрийн дагуу бэлтгэгдэж, 2012 оны орон нутгийн сонгуулиар сонгогдсон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын нийт төлөөлөгчийг сургалтанд хамруулсан нь зохих үр дүнгээ өгсөн байна.

Ер нь орон нутгийн сонгууль бүрээр нийт төлөөлөгчдийн дийлэнх хувь нь шинээр солигдон сонгогддог тул төлөөлөгчдийн чадавхийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийг улам боловсронгуй болгохын зэрэгцээ тасралтгүй явуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан төсөл хамтран хэрэгжүүлэгч талууд уг төслийг 2020 он хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн чацуу дээр дурдсан сургалтын гарын авлагуудыг шинэчилж, 2016 онд шинээр сонгогдсон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийг сургалтанд хамруулж эхлээд байна.

Энэхүү сургалтын гарын авлагын агуулга нь үндсэн дөрвөн бүлгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагааны талаар; хоёрдугаар бүлэгт, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, төсөв, түүний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн талаар; гуравдугаар бүлэгт байгаль хамгаалал, газрын харилцааны талаар; дөрөвдүгээр бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллагад иргэдийн оролцоог хангах, тэдэнтэй харилцах асуудлын талаар тусгасан болно. Сургалт явуулах явцад ажиглагдсан сургамж, туршлага, сургалтад хамрагдсан төлөөлөгчдийн саналыг харгалзан гарын авлагын энэ удаагийн хэвлэлийн агуулгад зохих нэмэлт, сайжруулалт хийлээ.

Сонгогч олон түмний итгэлийг хүлээж шинээр сонгогдсон эрхэм хүндэт ИТХ-ын төлөөлөгч Та бүхэн иргэдээ төлөөлөн ажиллах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэ гарын авлагад тусгагдсан сэдэв бүрийн агуулгыг сайтар уншиж, өөрийн болгон эзэмшихийн хамт практик үйл ажиллагаандаа хуулийн дагуу бүтээлчээр хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна.

Эцэст нь, энэхүү гарын авлагыг боловсруулсан доктор, профессор Я.Бямбаяр, доктор, профессор Л.Отгонтуяа, доктор, профессор Г.Жаргал, магистр Б.Хандсүрэн болон хянан тохиолдуулсан доктор, профессор А.Бакей нарт, мөн бидэнтэй хамтран ажилласан бүх хүмүүст талархал дэвшүүлж байна.

***“Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг
бэхжүүлэх нь” төслийн нэгж***

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	6
Зургийн жагсаалт	7
Товчилсон үг	7

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа	8
1.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс	8
1.1.1. Нутгийн өөрөө удирдах ёс	8
1.1.2. Монгол Улсын төрийн удирдлагын тогтолцоо	10
1.1.3. Нутгийн өөрөө удирдах байгууллага	14
1.1.4. Нутгийн өөрөө удирдах байгууллагын Үндсэн хуулийн баталгаа	16
1.1.5. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээ	18
1.2. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааныг зохион байгуулах	33
1.2.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэрүүд	33
1.2.2. Хуралдааны дэг	42
1.2.3. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч	47
1.2.4. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр	56

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, төсөв: эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт	59
2.1. Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө	59
2.2. Орон нутгийн төсвийн эрх зүйн зохицуулалт	63
2.2.1. Төсвийн тухай ерөнхий ойлголт	63
2.2.2. Орон нутгийн төсвийн харилцааг зохицуулж буй хуулиуд	64
2.2.3. Төсвийн захирагчид	65
2.2.4. Монгол Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн	65
2.2.5. Улсын болон орон нутгийн төсвийн харилцаа	66
2.2.6. Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлага	66
2.2.7. Орон нутгийн төсөвт өр үүсэхтэй холбоотой зохицуулалт	67
2.3. Орон нутгийн төсвийн үйл ажиллагааны мөчлөг	67
2.3.1. Орон нутгийн төсвийг боловсруулж бэлтгэх үе шат	67
2.3.2. ИТХ-аар төсвийг хэлэлцэн батлах үе шат	70
2.3.3. Төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат	73
2.3.4. Төсвийг хянаж, үнэлэх үе шат	78
2.4. Төсвийн төсөлд тавигдах шаардлага	80
2.4.1. Орон нутгийн төсвийн төсөлд тавигдах шаардлага	81
2.4.2. Орон нутгийн төсвийн төслийн бүтэц, агуулга	82
2.5. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвлөлт	85
2.6. Орон нутгийн хөгжлийн сан, түүний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт	87
2.6.1. Орон нутгийн хөгжлийн сан	87
2.6.2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт	88
2.6.3. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	91
2.6.4. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт	92
2.7. Төсвийн ил тод байдал	97

2.7.1. Төсвийг ил тод болгох шаардлага	97
2.7.2. Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл, баримт ил болгох цаглабар, хэлбэр	100
2.7.3. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын өнөөгийн байдал	103
2.8. Төсвийн мэдээлэл, түүнийг шинжлэх арга зүй	105
2.8.1. ИТХ-д Засаг даргаас өргөн барьсан орон нутгийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, зардлын мэлээллийг төлөөлөгчийн зүгээс шинжлэх	105
2.8.2. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг төлөөлөгчийн зүгээс шинжлэх	111
2.9. Орон нутгийн төсөвт ИТХ-аас тавих хяналт	116
2.9.1. ИТХ-аас төсөвт тавих хяналтын арга хэлбэр	116
2.9.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ	119
2.8.3. Худалдан авах ажиллагаанд ИТХ-аас иргэдийг оролцуулах замаар хяналт тавих	121

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

Байгаль хамгаалал, газрын харилцаа	123
3.1. Тогтвортой хөгжил, ногоон хөгжилд улс, орон нутгийн үүрэг, оролцоо	123
3.1.1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, хэрэгжилт	123
3.1.2. Нөхөн сэргэх боломжтой болон боломжгүй нөөцүүд	130
3.2. Байгаль орчин болон газрын тухай хууль тогтоомж	135
3.2.1. Байгаль орчны хууль эрх зүйн зохицуулалт	135
3.2.2. Байгаль орчин, газартай холбогдон үүссэн зөрчлийг шийдвэрлэх	137
3.2.3. Байгаль орчин, газрын асуудлыг нутгийн төвшинд шийдэх арга зам, боломж	146
3.3. Байгаль орчны элэгдэл, эвдрэл, бохирдолд хүний оролцоо, нөлөө	148
3.3.1. Байгалийн зүй тогтлын дагуух өөрчлөлт, урьдчилан сэргийлэх, даван туулах арга	148
3.3.2. Хүний үйл ажиллагаанаас үүссэн эвдрэл, бохирдол ба шийдэл	150
3.3.3. Нутгийн хэмжээнд шийдвэрлэж болох асуудал	151
3.4. Тусгай хамгаалалттай газар нутаг: төр, иргэдийн оролцоо	153
3.4.1. Газар нутгийг тусгай хамгаалалтанд авах нийгэм-эдийн засгийн үндэслэл	153
3.4.2. Тусгай хамгаалалттай газрын эрх зүйн зохицуулалт	154
3.4.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилт	160
3.4.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалт дахь тулгамдсан асуудал	164
3.4.5. Нутгийн удирдлагын эрх хэмжээ, хэрэгжилт	167

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

Иргэдийн оролцоо ба иргэдтэй харилцах	172
4.1. Төлөөллийн ба шууд ардчилал	172
4.2. Иргэдийн оролцоо, түүний хэлбэрүүд	175
4.2.1. Иргэдийн оролцоо яагаад чухал вэ?	176
4.2.2. Иргэдийн оролцооны давуу ба сул тал	177
4.2.3. Орон нутагт иргэдийн оролцоог хангах боломжтой арга хэлбэрүүд	178

4.3. Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо	179
4.4. ИТХ-ын үйл ажиллагаанд хандаж буй иргэдийн хандлага, өнөөгийн байдал	183
4.5. Иргэдийн оролцоотой холбогдолтой хууль тогтоомжийн практик хэрэглээ	189
4.5.1. Төсвийн тухай хууль болон Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн хүрээнд	189
4.5.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн хүрээнд	192
4.5.3. Мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг хангах хуулийн хүрээнд	193
4.5.4. Нийтийн сонсголын тухай хуулийн хүрээнд	195
4.5.5. Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд	197
4.5.6. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд	200
Хавсралт.	202
Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам	202
Багийн Засаг дарга, малчид, тариаланчдын гурвалсан гэрээ	207
Эх сурвалж, унших материал	211

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Нэгдмэл улсын төрийн байгууламжийн хэв шинж	13
Хүснэгт 1.2. Бусад хууль, эрх зүйн актад заасан ИТХ-ын хяналтын эрх	25
Хүснэгт 2.1. Орон нутгийн төсвийн саналыг боловсруулж, хүргүүлэх цаглабар	68
Хүснэгт 2.2. Орон нутгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах цаглабар	71
Хүснэгт 2.3. Дотоод хяналт ба дотоод аудитын ялгаа	79
Хүснэгт 2.4. Орон нутгийн төсвийн төслийн бүтэц, агуулга	83
Хүснэгт 2.5. Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг ил болгох цаглабар	100
Хүснэгт 2.6. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын харьцуулалт	104
Хүснэгт 2.7. А аймгийн Б сумын 2016 оны төсвийн тэнцлийн үзүүлэлтүүд	105
Хүснэгт 2.8. А аймгийн Б сумын 2016 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөний төсөл	107
Хүснэгт 2.9. Орлогын албан татварын бүрдэлт	108
Хүснэгт 2.10. Бусад татварын бүрдэлт	108
Хүснэгт 2.11. А аймгийн Б сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд	109
Хүснэгт 2.12. А аймгийн Б сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн байдлын тайлан	112
Хүснэгт 2.13. А аймгийн Б сумын ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн тайлан, мян. төг.	114
Хүснэгт 2.14. А аймгийн Б сумын ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний тайлан, мян. төг.	115
Хүснэгт 2.15. А аймгийн Б сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмчийн өөрчлөлтийн тайлан, мянган төгрөг	116
Хүснэгт 2.16. Хэрэгжилтийн хяналт шинжилгээ ба үр дүнгийн хяналт	

	шинжилгээний гол нөхцөлүүд	120
Хүснэгт 4.1.	Ардчиллын хэлбэрүүд, онцлог шинж	172
Хүснэгт 4.2.	Иргэдийн оролцооны давуу болон сул талууд	177
Хүснэгт 4.3.	ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах шалгуур	181
Хүснэгт 4.4.	ИТХ-ын талаарх Нийслэлийн иргэдийн ойлголт (Судалгааны дүн)	184
Хүснэгт 4.5.	ИТХ-ын талаарх хөдөө орон нутгийн иргэдийн ойлголт (Судалгааны дүн)	185
Хүснэгт 4.6.	Нийтийн сонголын төрөл, зохион байгуулах үндэслэл	196
Хүснэгт 4.7.	Иргэдийн оролцоог хангахтай холбоотой зарим хууль тогтоомжийн заалтууд	201

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1.	Монгол Улсын төрийн байгууллагын тогтолцоо, байгууллага хоорондын харилцаа	11
Зураг 1.2.	Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах нь	13
Зураг 1.3.	Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцоо	14
Зураг 1.4.	ИТХ ба Засаг дарга хоорондын харилцаа	30
Зураг 1.5.	ИТХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр	33
Зураг 2.1.	Монгол Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн	65
Зураг 2.2.	Төсвийн хяналтын хэлбэрүүд	77
Зураг 2.3.	Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдал – 2013 он	103
Зураг 3.1.	Сумын зохион байгуулалтын төлөвлөгөө (жишээ)	146
Зураг 3.2.	Дорноговь аймгийн Сайншанд сумын өрхийн цэцэрлэг	149
Зураг 3.3.	Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний бүрэлдэхүүн	160
Зураг 3.4.	Дархан цаазат газар нутаг	161
Зураг 3.5.	Байгалийн цогцолбор газар	163
Зураг 4.1.	Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо	183
Зураг 4.2.	ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт	184

ТОВЧИЛСОН ҮГ

БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
ТХДАА	Төсвийн хяналт, дотоод аудитын алба
ТЭЗҮ	Техник-эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС, ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

1.1.1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁС

Юуны өмнө “өөрөө удирдах ёс” хэмээх нэр томъёоны мөн чанарыг сайтар ойлгох нь чухал. Нийгэм дэх өөрөө удирдахуйн нөхцөлд удирдлагын объект болон субъект давхцсан шинжтэй байдаг бөгөөд өөрсдийн ажил үйлсээ өөрсдөө хөтлөн явуулах, шууд хяналт тавих, төвлөрөлийг сааруулж, доод түвшинд эрх мэдлийг шилжүүлэх замаар хэрэгждэг онцлогтой. Өөрөө удирдах ёс нь гол төлөв хүн амын уламжлал, төрийн хууль тогтоомжоор дамжин хэрэгжинэ.

Нутгийн өөрөө удирдах ёс нь өнөөгийн ойлголтоороо суурин соёл иргэншил бүхий улс орнуудад анх үүссэн боловч нүүдэлчдийн дунд ерөөсөө байгаагүй гэж үзэж болохгүй юм. Монгол Улсын хувьд албан бус хэлбэрээр буюу тайван амгалан амьдрах, аж ахуйгаа эрхлэн хөтлөх зорилгоор хамтран ажиллах (саахалтын болон хот айлын зохион байгуулалт, ан гөрөө хийх г.м.) бусдад туслах, хамтран эзэмших, ашиглах эд баялаг (бэлчээр, худаг, гарам, гүүр гэх мэт) бий болгох зэргээр хамтын зохион байгуулалтад орж, өөрсдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргаж, өөрсдийн хүчээр хэрэгжүүлж байсан нь нутгийн өөрөө удирдах ёсны нүүдлийн мал аж ахуй эрхэлж аж төрдөг ахуй нөхцөлдөө нийцсэн өвөрмөц хэлбэр байжээ. Ураг төрлийн холбоонд үндэслэсэн амьдрал нь овог аймгийн хүрээнд тогтсон зан заншил, хэм хэмжээгээр зохицуулагдаж байснаа нийгмийн амьдрал нарийсч, “хэлэлцээрт төр” бий болсон нь иргэдийг төрийн “харьяалалд” оруулж, заавал сахиж мөрдөх хамтын хэм хэмжээг бий болгожээ.

Орчин үеийн шинжлэх ухааны утгаар авч үзвэл нутгийн удирдлага, өөрөө удирдах ёс гэж юу вэ? Эхлээд төв ба орон нутгийн байгууллагын ялгааг тодотгоё. Энэ талаар Б.Чимид “...Орон нутаг гэдэг бол газар зүйн байршлыг бус харин эрх мэдэл, эрх хэмжээний хүрээ, хязгаарыг илэрхийлдэг төр-хууль зүйн тухайлсан нэр томъёо” гэж тодорхойлсон. Тухайлбал, улсын хэмжээнд ажиллах эрх хэмжээний байгууллагыг “төв байгууллага, энэ нь хөдөө ч байрлаж болно, харин аймаг, нийслэл, сум дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгждэг, түүнээс хальж гарах ёсгүй эрх хэмжээтэй байгууллагыг “орон нутгийн гэж ангилдаг” гэж тайлбарласан байна. Тэгэхээр төв, орон нутаг гэсэн хоёр ойлголт нь тухайн

байгууллага хаана байршиж байгааг биш харин эрх хэмжээ нь улсын бүх нутаг дэвсгэрт хүчинтэй юу эсвэл нутаг дэвсгэрийн нэгжээр хязгаарлагддаг уу гэдгийг илэрхийлж байгаа ойлголт юм. Тиймээс аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо зэрэг нь орон нутаг мөн.

Одоо бид өөрөө удирдах ёс гэдэг ойлголтыг авч үзье. Б.Чимид “Өөрөө удирдах ёс гэж тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил, хэргийг тэндэхийн иргэд, хамт олон шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлуулан бие даан шийдвэрлэж эрхлэн хөтлөх, хариуцах ёсыг хэлнэ”¹ гэжээ. Харин “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 2006 оны шинэчилсэн найруулгаар “Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг, сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн” гэж тодорхойлсон. Энэ бол Монгол Улсын хуульд “Нутгийн өөрөө удирдах ёс” гэж юу болохыг анх удаа тодорхойлж өгсөн тодорхойлолт юм. Эдгээр тодорхойлолтод байгаа санааг задлан үзэх юм бол өөрөө удирдах ёс гэдэг нь:

- нутаг дэвсгэрийн нэгж юмуу ямар нэг байгууллага, хамт олон дотоод асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрх;
- шийдвэр нь хуулийн хүрээнд байх;
- гаргасан шийдвэрээ өөрсдөө хэрэгжүүлэх эрх хэмжээтэй байх;
- шийдвэр гаргаж хэрэгжүүлснийхээ үр дүнг өөрсдөө хариуцах зэргээс бүрдэнэ.

Энэ бүхнийг өөрөө удирдах ёсны тухай орчин үеийн шинжлэх ухааны ойлголт гэж болох юм.

Өөрөө удирдах ёсыг шууд ба шууд бус ардчиллын хэлбэрийг ашиглаж хэрэгжүүлнэ. Иргэд бүгдээрээ нэг газар цуглаад сонирхсон асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж болдог. Үүнийг шууд ардчилал гэнэ. Төрийн бус байгууллагын тухайд ингэж бүх гишүүд нь цуглаад их хурлаа хийж асуудлыг шийдвэрлэж болно. Багийн иргэд ч бас ийм байдлаар асуудлыг шийдвэрлэж болно. Тийм ч учраас манай улсын хуулиар баг, хороонд Иргэдийн нийтийн хурал байхаар заасан юм. Гэвч шийдвэр гаргахад оролцох эрхтэй хүмүүс олон тоотой байх нөхцөлд бүгдээрээ цугларах бодит боломжгүй байх нь ойлгогчтой. Ийм үед төлөөллийн байгууллага буй болгож, түүнд тэдгээр хүмүүсийн нэрийн өмнөөс асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах эрх олгодог. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь чухамхүү ийм төлөөллийн журмаар иргэдийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж буй байгууллага мөн.

Нутгийн өөрөө удирдах ёс үр нөлөөтэй хэрэгжихэд дээрх тодорхойлолтод байгаа нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон эрх хэмжээ, иргэд болон тэдгээрийн төлөөлөгчдийн асуудлыг хэлэлцэж, иргэдийн эрх ашигт нийцүүлэн зөв зүйтэй шийдвэрлэх чадвар, шийдвэрээ хэрэгжүүлэх чадвар, гарах үр дүнг нь хариуцах чадвар зэрэг зүйл маш чухал. Тэгэхээр эрх, үүрэгтэй байх, тэдгээрээ хэрэгжүүлж чадах эсэх зэрэг нь нэг асуудлын хоёр тал юм. Чадвар гэдэгт эдийн засаг, санхүүгийн нөөц, иргэд, тэдний төлөөлөгчдийн мэдлэг чадвар, нийтлэг сонирхлоо мэдэрч хамтран ажиллах, оролцогчдынхоо янз бүрийн хэсгийн сонирхлыг харгалзаж зөвшилцлийн журмаар шийдвэр гаргах эрмэлзэл, иргэдийн идэвх оролцоо зэрэг олон хүчин зүйл багтана.

¹ Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нутгийн удирдлага”, Боть 3, 13 дахь тал

Дэлхийн улс орнууд нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, өөрөө удирдах ёсны байгууллагыг чадваржуулахын тулд хөрөнгө, санхүүгийн бололцоог нь өргөтгөх, янз бүрийн сургалт хийх, орон нутгийн нэгжүүдийг нийлүүлж томруулах зэрэг олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлдэг.


Яагаад өөрөө удирдах ёс хэрэгтэй байдаг вэ? Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь иргэд өөрсдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тэдний оролцоог хангах замаар нийтлэг эрх ашгаа хамтарч хамгаалах боломж олгодог ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх түгээмэл хэлбэр гэж үзэж болно. Аливаа асуудлаар шийдвэр гаргахдаа нэг юмуу хэсэг бүлгийн явцуу эрх ашгийн үүднээс бус бүгдээрэнд нь хамаарах нийтлэг байдлаар зөв арга замыг олоход нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага чухал ач холбогдолтой.

Худалдаачид худалдаа наймаагаа аль болох ашигтай байдлаар эрхэлж, бүтээгдэхүүнээ борлуулах, хот, тосгодын оршин суугчид хог хаягдлаа зайлуулах, гал түймрээс сэргийлэх зэрэг асуудлаа өөрсдөө хамтран зохицуулж ирсэн түүхэн уламжлалтай улс орнууд бий. Манай оронд ч малчид бэлчээрээ улирлаар дундаа хуваарьтай ашиглах, хадлангийн талбайгаа хамтран усжуулж хамгаалан сайжруулж ирсэн уламжлалтай билээ. Ийм уламжлалаас гадна хүмүүсийг өөрсдөд нь хамаатай асуудлыг шийдвэрлэхэд өөрсдийг нь оролцуулаад зогсохгүй өөрсдөө шийдвэр гаргах эрх олгох нь уг асуудлыг зөвөөр шийдвэрлэх боломж олгодог. Байгаа мөнгөөрөө уул давааны зам засаж бэлчээрээ өргөтгөх үү, эсвэл цэцэрлэг байгуулах уу гэдгийн аль нь илүү хэрэгтэйг тухайн нутгийн оршин суугчид л хамгийн сайн мэдэрнэ. Үүнээс гадна ийнхүү орон нутаг асуудлаа өөрөө шийдвэрлэдэг байх нь төв засгийн газарт орон нутгийн жижиг асуудлаар хөөцөлдөхгүй улсын хэмжээний том зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүч анхаарлаа төвлөрүүлэх боломж олгоно. Өөрөө удирдах ёс нь хяналт, хариуцлагыг сайжруулах, авлига, хүнд суртал мэтийн сөрөг үзэгдлийг багасгах үр нөлөө бүхий хэрэгсэл юм.

1.1.2. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

1) Монгол Улсын төрийн байгууллагын тогтолцоо

Монгол Улсын Үндсэн хуулинд төр нь хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, иргэний нийгэмд үйлчилдэг нийтлэг эрх ашигт захирагдахыг тунхаглахын зэрэгцээ төрийн эрх мэдлийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Шүүхэд тэнцвэржүүлэн хуваарилах үзэл санаа тусгагдсан. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох эрх мэдлийг УИХ, гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх эрх мэдлийг Шүүх, Үндсэн хуулийн цэц хэрэгжүүлэхээр тусгасан гэж судлаачид үздэг. Тодруулбал, хуулийг зөвхөн иргэдийн төлөөллийн байгууллага тогтоож, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлж, хууль зөрчигдсөн эсэхийг зөвхөн шүүхийн байгууллага шийдвэрлэж байхаар төрийн эрх мэдлийн хуваарилалт хийгджээ.



Тайлбар :

- Сонгох юмуу томилох, огцруулах, чөлөөлөх г.м
- Санал болгох (цэцийн гишүүнээр томилох)
- Бүрэн эрхийг зөвшөөрч хууль гаргах
- Ажлаа тайлагнах, хариуцлага хүлээх
- Шийдвэрт хориг тавих
- Танилцах(томилогдоход нь)
- Хууль шийдвэр Үндсэн хуулинд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах, хуулинд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох

Зураг 1.1. Монгол Улсын төрийн байгууллагын тогтолцоо, байгууллага хоорондын харилцаа

Монгол Улсын төрийн тогтолцооны онцлог нь нэгд, Монгол Улс нэгдмэл улс, хоёрт бүх нийтийн сонгуулиар сонгогддог Ерөнхийлөгч, Улсын Их Хурал бүхий бүгд найрамдах улс гэдгээр тодорхойлогддог. Төрийн байгууллагууд хоорондын харилцааны шинж байдал ч мөн энэхүү онцлогийг тусгасан байдаг.

Монгол Улсын төрийн байгууллагыг түвшингөөр нь авч үзвэл төрийн дээд, төв, орон нутгийн болон анхан шатны гэж ангилж болно. Төрийн дээд байгууллагад Улсын Их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх орно. Төв байгууллагуудад төрийн яамд орно.

Орон нутгийн дунд түвшингийн байгууллагад аймаг, нийслэлийн төрийн байгууллага багтах ба анхан шатны байгууллагад сум, дүүрэг, баг, хорооны байгууллага орно.

2) Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцоо

Монгол Улсын засаг захиргаа, түүний нэгжийн удирдлага, төв орон нутгийн харилцаа нь тус улсын төрийн байгууламжийн нэгдмэл шинж чанараар, төрийн байгуулалт, үйл ажиллагааны ардчилсан шинжээр тодорхойлогддог. Нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд тус улс аймаг, нийслэлд; аймаг нь сумд, сум нь багт;

нийслэл нь дүүрэгт; дүүрэг нь хороонд хуваагдана. Харин хот, төсөн засаг захиргааны нэгжийн эрхгүй, хуулиар тогтоосон тусгай эрх зүйн байдалтай байдаг нь тус улсын онцлог нь юм.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ. Монгол Улсын Үндсэн хууль, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эрх зүйн байдлыг тодорхойлж, төв орон нутгийн харилцааг зохицуулсан байдаг.

59.1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.


Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйл

Монгол Улс нь төрийн нэгдмэл байгууламжтай улс юм. Тиймээс төрийн эрх мэдэл нь төв болон орон нутгийн байгууллагын хооронд хуваагддаггүй. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, шүүхийн нэгдмэл тогтолцоо хэрэгжүүлж байдаг. Тиймээс Засаг дарга болон орон нутаг дахь төрийн байгууллагууд нь төв байгууллагуудын төлөөлөгч, тэдний үргэлжлэл маягаар ажиллаж, төв байгууллагуудын шийдвэрийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрт нэг мөр хэрэгжүүлж байдаг. Нөгөө талаас нутгийн өөрөө удирдах ёсны дээр дурдсан давуу талуудыг ашиглах зорилгоор нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжид иргэдийн өөрөө удирдах ёсыг тогтоосон. Энд зэрэгцсэн хоёр байгууллага байгаа учраас л хосолдог гэж байгаа хэрэг биш юм. Өөрөө удирдах ёсны байгууллага болон Засаг дарга нь орон нутгийн асуудлыг шийдвэрлэхэд ч, төрийн дээд байгууллагуудын шийдвэрийг хэрэгжүүлэхэд ч өөр өөрийн эрх хэмжээ, чиг үүргийн хүрээнд оролцдогт үүний учир оршино.

Аймаг нийслэл, сум, дүүрэгт ИТХ, баг, хороонд Иргэдийн Нийтийн хурал нь тухайн орон нутагт оршин суугаа иргэдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлж, өөрийн удирдлагын зарчмаар ажилладаг. Харин төрийн удирдлагыг тухайн шатны Засаг дарга хэрэгжүүлдэг.

Төрийн байгууллага хоорондын харилцаа нь дээд шатандаа босоо (агентлаг-яам- Засгийн газар-УИХ), хэвтээ (яамд хоорондын, төрийн дээд байгууллага хоорондын гэх мэт) чиглэлд явагдана. Харин орон нутгийн хувьд босоо чиглэлийн харилцах харилцаа зонхилж, хэвтээ чиглэлийн харилцаа үндсэндээ бага байна. Аймаг дундын, сум дундын төсөл, хөтөлбөрийг орон нутаг өөрөө санаачлан хэрэгжүүлэх нь ховор, цөөн тохиолдолд мал оторлох, өвс хадлан хадах, худалдан авах, нутгийн хилийн цэс тогтоох гэх мэт асуудлаар аймаг хоорондын болон сум хоорондын хэвтээ харилцаа явагдаж байна. Энэ байдал нь манай улсын нэгдмэл байгууламж, төрийн босоо тогтолцоо, орон нутгийн эдийн засгийн сул хөгжил зэргээс шалтгаалж байгаа юм².

² А.Цанжид "Төрийн захиргаа". УБ.2009, 89 дэх талд.



Зураг 1.2. Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах нь

Ер нь төрийн байгууламж нь үндэсний түвшинд холбооны эсвэл нэгдмэл гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Холбооны улсуудад дунд түвшний засгийн газруудад төв засгийн газраас бие даасан байдал, автономит эрхийг үндсэн хуулиар олгосон байдаг. Харин нэгдмэл улсуудын төв засгийн газар үндсэн хуулийн хязгаарлалтгүйгээр засаг захиргааны нэгж байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах эрхтэй байна. Нэгдмэл улсуудын төрийн байгууламжийн бүтцийг төвлөрснөөс эхлээд хамгийн их төвлөрөл саарсан хүртэлх хэв шинжээр нь *холимог, хосолмол* ба *орон нутгийн өөрөө удирдах засгийн газар* хэмээн 3 ерөнхий бүлэгт ангилна³.

Хүснэгт 1.1. Нэгдмэл улсын төрийн байгууламжийн хэв шинж

Холимог (<i>fused systems</i>)	Хосолмол (<i>dual systems</i>)	Орон нутгийн өөрөө удирдах засаглал (<i>local self-government</i>)
<ul style="list-style-type: none"> Гүйцэтгэх ба хууль тогтоох эрх мэдэл хоорондоо холилдсон, Төвлөрсөн нэгдмэл тогтолцоотой, Орон нутгийн улс төрийн албан хаагчдыг эрх барьж буй Засгийн газраас томилдог, 	<ul style="list-style-type: none"> Төв засгийн газар ихээхэн эрх мэдэлтэй, Төв засаг орон нутгийн захиргаадыг зайнаас удирддаг буюу харьцангуй илүү эрх мэдэл олгодог. 	Орон нутгийн захиргаад төв засгаас ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлж, тогтоосон хязгаарын хүрээнд татвар тогтоох эрх мэдэлтэй.


Дээрх хүснэгтээс үзвэл Монгол Улсын төрийн байгууламжийн бүтцийг аль ч загварт хамааруулах боломжгүй, загвар бүрийн тодорхой элементийг авч “хольсон тогтолцоо” гэж үзэж болох юм. Энэ утгаар дэлхийн хаана ч байхгүй өвөрмөц тогтолцоо бөгөөд үүнийг Монгол Улсын онцлогт тохирсон хэмээн тайлбарладаг⁴.

Монгол Улсын төрийн тогтолцоо хэдийгээр босоо шинжтэй боловч тодорхой асуудлаар төвийн эрх мэдлийг хязгаарлаж, орон нутгийн эрх мэдлээр тэнцвэржүүлсэн байдаг. Тухайлбал, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг

³ Ц.Даваадулам “Нутгийн удирдлагын тогтолцоо ба засаглалын эрх мэдлийн тэнцвэр” Нутгийн удирдлага сорилт ба шийдэл үндэсний чуулганы эмхэтгэл. УБ.2016.38 дахь талд

⁴ Мөн тэнд, 54 дэхь талд.

өөрчлөх асуудлыг УИХ шийдэх эрхтэй боловч шийдвэр гаргахдаа тухайн нутгийн ИТХ, иргэдийн саналыг үндэслэх ёстой.



Зураг 1.3. Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцоо

1.1.3. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА

Орон нутгийн амьдрал олон талтай, аймаг, сум бүрт шийдвэрлэвэл зохих өөр өөрийн өвөрмөц асуудал байдаг. Тэдгээрийн зарим нь (жишээ нь, төсөв) жилд нэг л удаа ихэвчлэн хэлэлцэгддэг байхад нөгөө нэг хэсэг нь (ган зудтай тэмцэх, гамшгийн хохирлыг арилгах гэх мэт) тэндхийн иргэд цаг алдалгүй шуурхай шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага ч байдаг. Гэвч ийм нөхцөлд аймгаараа, сумаараа цуглараад байх боломж үгүй учир тэдэнд өөрсдийн төлөөлөгчдийн хийгээд түүнийг “хураангуйлсан” байгууллага, бас мэргэшсэн алба зайлшгүй хэрэгтэй болдог. Иймийн тулд төлөөллийн ардчиллын зарчмыг хэрэгжүүлэх замаар иргэдийг төлөөлөх хэлбэр бол нутгийн өөрөө удирдах байгууллага юм.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр байгуулагддаг, тухайн нутгийн иргэдийн хууль ёсны нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, тэднийг төлөөлөх, тухайн нутаг дэвсгэрийн амьдралын асуудлыг тэндхийн иргэдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж, хэрэгжилтийн байдалд нь хяналт тавих үүрэг бүхий, хамтын шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээдэг байгууллага юм.

59.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн хурлын чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь 4 жилийн хугацаатайгаар тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа иргэдээс шууд сонгогддог төлөөллийн байгууллага юм. Одоо орон нутгийн ИТХ-ын сонгуульд ашиглаж байгаа сонгуулийн систем нь мажоритар систем бөгөөд нийт төлөөлөгчдийг нэг буюу хэд хэдэн мандаттай тойргоос сонгоно. Харин баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн баг, хороонд байнга оршин сууж буй иргэдээс бүрдэх шууд ардчиллын байгууллага юм. Хамтын шийдвэр гаргадаг байгууллага болохын хувьд ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байдаг. Хуралдаан нь нийт төлөөлөгчдийн талаас илүү хувь нь хүрэлцэн ирснээр хүчинтэй болох ба хуралдаанд оролцсон нийт төлөөлөгчдийн талаас илүү хувийнх нь саналаар шийдвэрээ гаргана. Хурлын зохион байгуулалтын бусад хэлбэр нь (тухайлбал, хороод, намын бүлэг зэрэг) Хурлын шийдвэрийг үндэслэл сайтай, иргэдийн эрх ашигт нийцсэн байхаар гаргахад нь дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бүтцийн байгууллагууд юм.

15 төлөөлөгчөөс бүрдэх сумын ИТХ-ын хуралдаанд нийт төлөөлөгчдийн талаас илүү хувь нь буюу найм нь хүрэлцэн ирж, тодорхой асуудлыг хэлэлцээд тав нь дэмжихэд (өөрөөр хэлбэл, хуралдаанд оролцогчдын ердийн олонхийн саналаар боловч нийт төлөөлөгчдийн дөнгөж гуравны нэг нь) уг асуудал шийдэгдэнэ. Энэ нь хэсэг бүлэг (тухайн тохиолдолд ИТХ-ын цөөн хэдэн төлөөлөгч) нутгийн өөрөө удирдах байгууллагын өмнөөс төлөөлөн шийдвэр гаргах (магадгүй өөрсдийн эрх ашигт нийцүүлэн) хууль ёсны боломж бүрдсэн мэт харагдах боловч энэ нь хамтын хариуцлагын үүднээс авч үзвэл төлөөлөгчид хуралдаанд оролцоогүй нь уг асуудлыг дэмжсэн мэт болгож байгаагаараа илүү уршигтай юм. Эндээс хамтын болон төлөөллийн хариуцлагаа ухамсарлан ИТХ-ын төлөөлөгчид хуралдаанд ирж оролцох нь чухал болохыг харж болно.

Хамтын шийдвэрийн өөр нэг онцлог бол хамтын хариуцлага юм. Хэдийгээр тодорхой асуудлыг тухайн хуралдаанд оролцогчдын ердийн олонхийн саналаар баталдаг ч шийдвэр нь хэсэг бүлгийн шийдвэр бус, байгууллагын шийдвэр (өөрөөр хэлбэл, тухайн Хурлын тогтоол) болж гарах учир нутаг дэвсгэр дээр заавал биелүүлэх, бүх нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ болдог байна. Уг шийдвэрийг тухайн нутаг дэвсгэр дээр оршин сууж буй бүх иргэн, үйл ажиллагаагаа явуулж буй бүхий л байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, түүний дотор уг шийдвэрийг гаргахад оролцсон ИТХ-ын төлөөлөгч өөрөө (уг шийдвэрийг дэмжсэн эсэхээс хамаарахгүйгээр) даган мөрдөх үүрэгтэй.

ИТХ нь байнгын болон түр хороотой байдаг. Хороо нь хуралдаанаар бэлтгэх асуудлыг урьдчилан бэлтгэх, хурлын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Харин түр хороог цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт гаргах үүрэгтэйгээр байгуулна. Хороод нь эдийн засаг, нийгмийн салбараар мэргэжих зарчмаар байгуулагдана. Өөрөөр хэлбэл, тодорхой асуудлаар мэргэжсэн байна гэсэн үг юм. Харин намын бүлгүүд нь ИТХ-д суудалтай намын бодлогын үүднээс гарах гэж буй шийдвэрийг нягтлан үзэж санал гаргадаг. Тэгэхдээ асуудалд зөвхөн намын байр суурь буюу улс төрийн үүднээс бус аль болох ажил хэрэгчээр хандаж, зөв шийдлийг олохыг эрмэлзэх учиртай. Төлөөлөгч өөрийн хамгийн сайн мэдэх тэр чиглэлээр байгуулагдсан хороонд орох нь зүйтэй. Хороо болгонд намын бүх бүлгийн төлөөлөл оролцсон байхаар бодож хорооны бүрэлдэхүүнийг тогтоох нь хуралдааны үед зөвшилцөлд хүрэхэд сайн нөлөөтэй.

1.1.4. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА ҮНДСЭН ХУУЛИЙН БАТАЛГАА

Монгол Улсын ардчилсан нийгмийн эрх зүйн суурь зарчмуудыг 1992 оны шинэ Үндсэн хуулиар баталгаажуулж, тус Үндсэн хуулийн 3.1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж зааснаар иргэддээ төрийн дээд эрхийг олгохын зэрэгцээ нутгийн өөрөө удирдах ёсны шинэ тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг тавьсан. Мөн ИТХ-ын эрх зүйн зохицуулалт Үндсэн хуулинд тусгагдсанаар энэ байгууллага Үндсэн хуулийн статустай байгууллага болсон юм. Түүнчлэн уг хуулиар засаг захиргааны орон нутгийн болон анхан шатны нэгжүүдийг тодорхойлон заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн энэхүү заалт нь нутгийн удирдлагыг бие даан хөгжих үндсийг баталгаажуулсан заалт юм.

58.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 58 дүгээр зүйл

Энд аймаг, нийслэл, сум, дүүргийг Үндсэн хуулийн дээрх үзэл санааны дагуу эдийн засаг, нийгмийн цогцолборын хэмжээнд хүртэл хөгжүүлэх нь хамгийн чухал асуудал мөн. Энэхүү урт хугацааны зорилтыг хэрэгжүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллагын гүйцэтгэх үүрэг их байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд нутгийн удирдлагын бүтцийг тодорхойлон зааж удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн субъектын нэг нь өөрөө удирдах ёсны байгууллага болох Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Иргэдийн Нийтийн хурал мөн гэжээ.

59.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, тухайн хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйл

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь Үндсэн хуулийн биеэ даасан байгууллага болох нь дараах шинжээр илэрнэ. Үүнд⁵:

- Төрөөс хууль, тогтоолоор бус иргэд өөрсдөө сонгож байгуулах зарчмыг Үндсэн хуулиар тогтоосон. Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “аймаг, нийслэлийн ИТХ-ыг 4 жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр хурлын болон сум, дүүргийн хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.” гэж заасан байна. Өдгөө 2015 оны Сонгуулийн тухай хууль ёсоор эдгээр хурлыг тухайн аймаг, сум (нийслэл, дүүрэг)-ын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр шууд сонгож байгаа (Монгол Улсын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 3 дэх хэсэг).

⁵ Улс төрийн Боловсролын Академи. “Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал”, УБ.2000. Товхимол II, 24 дах талд.

- ИТХ, ИНХ нь төрийн чиг үүргийг бус харин иргэдийн нэрийн өмнөөс нутгийн удирдлагад оролцдог. Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2-т “нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага” гэсэн учир энэ. Түүнчлэн мөн хуулийн 62 дугаар зүйлийн 1-д хурал нь нутаг дэвсгэрийн хэмжээний асуудлыг “бие дааж шийдвэрлэх”, улсын чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг “оролцуулах” гэсэн нь өөрөө удирдах ёсны болон төрийн чиг үүргийн заагийг тогтоосон хэрэг юм.
- ИТХ нь зөвхөн тухайн нэгжийн иргэдийн дотроос сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.
- ИТХ, ИНХ нь бүрэн эрхийн хувьд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эрх барих байгууллага мөн. Энэ бол орон нутаг дахь “төрийн эрх барих” байгууллага гэсэн үг биш. Харин иргэдийн өөрсдийнх нь олгосон бөгөөд Үндсэн хуулиар баталгаажуулсан бүрэн эрхийн хувьд нэгжид оршин суугаа бүх хүн амыг засаглах бүрэн эрхтэй байгууллага гэсэн үг. Үүний хууль зүйн илрэл нь Үндсэн хуулийн 63 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хурлын тогтоол, Засаг даргын захирамжийг “... тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.” гэж заасан явдал юм.

Дээрх шинжүүдээс үзвэл нутгийн удирдлагын байгууллага нь иргэдийн өөрсдийнх нь байгууллага мөртлөө нэгжийн хэмжээнд нийтийг засаглаж байгаа болон олон нийтийн өөрөө удирдах ёсны байгууллагаас ялгарах шинжээрээ энэ бол биеэ даасан бөгөөд хамгийн гол нь “нутгийн өөрөө удирдах байгууллага” гэсэн Үндсэн хуулийн статустайгаараа онцгой ач холбогдолтой юм.

Мөн нутгийн өөрийн удирдлага нь Үндсэн хуулийн хүрээнд дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:

- иргэдийн орон нутгийн чанартай асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрхийг хангаж, улсын чанартай асуудлыг шийдвэрлэхэд тэднийг зохион байгуулж оролцуулах;
- нэгжийн нутаг дэвсгэрийн цогц хөгжлийг хангах;
- орон нутгийн иргэдийн эрх болон орон нутгийн ашиг сонирхлыг хамгаалах;
- нийгмийн үйлчилгээгээр хүн амын эрэлт хэрэгцээг хангах;
- нэгжийнхээ нутаг дэвсгэрийн хэмжээнд уламжлалт ёс заншил, нийгмийн хэв журмыг хамгаалж, эрх зүйн дэг журмыг дэмжих бэхжүүлэх;
- хүрээлэн буй орчин, хүний аюулгүй байдлыг сахин хамгаалах зэрэг болно.

Харин нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд байгууллага шийдвэрлэхийг Үндсэн хуулиар хориглосон байдаг.

Баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ыг нийтэд нь “Орон нутгийн Хурал” гэж хураангуйлж болно. Эдгээр Хурал нь тухайн нэгжийнхээ өөрөө удирдах байгууллага, эрх барих газар мөн. Харьяалах нутаг дэвсгэр, төлөөлөх хүн амын тооны хувьд “гурван шатны” гэх ялгаатай боловч дээд шатны нэгжийн Хурал нь доод нэгжүүд дэх Хурлыг харьяалж захирахгүй. Хурал бүр бие даасан эрх мэдэлтэй, “автономи” байдалтай ажиллаж, үр дүнг өөрийн төлөөлсөн иргэддээ хариуцан тайлагнана.

1.1.5. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ХЭМЖЭЭ

Хамгийн өргөн утгаар авч үзвэл, эрх хэмжээ хэмээх ойлголт нь төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон хууль зүйн хүчин чадалтай хэм хэмжээний албан ёсны шинжтэй заавал биелэгдэх үйл ажиллагааны хязгаар юм. Өөрөөр хэлбэл, эрх хэмжээ гэж орон нутгийн удирдлагын байгууллагын хуулиар олгосон үйлдэл, эс үйлдлийн хүрээ хязгаарыг хэлнэ⁶. Энэхүү ойлголт нь байгууллагын эрх үүргийг багтаадаг. Учир нь амьдрал баян учраас ямар нэг үйл ажиллагаа эрхийн ч, үүргийн ч шинжтэй байх нь элбэг. Нутгийн удирдлага нь зарчмын хувьд орон нутгийн чанартай асуудлуудыг эрхлэх ёстой. Гэвч нутгийн удирдлагын шинж чанар, үйл ажиллагааг бодит амьдрал дээр судлан үзвэл чухамхүү орон нутгийн шинжтэй болон нийт улс орныг хамарсан бодлогын шинжтэй үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа хосолсон шинжтэй байдаг. Эрх хэмжээ талаас нь үзвэл нутгийн удирдлага нь өөрийн эрх хэмжээ үйлчилдэг нутгийн асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ нийт улсын хэмжээний асуудлыг тухайн газар нутагт хэрэгжүүлэх учиртай.

Монгол Улсын Үндсэн хуулинд нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн эрх хэмжээг тодорхойлж, түүнийг хангах хууль зүйн баталгааг тогтоожээ.

62.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.

62.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйл

Жишээ 1. “Нэг аймгийн ИТХ-аас долоо хоног бүрийн нэг дэх өдөр буюу Даваа гаригт аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон шийдвэр гаргасан байна. Үүнийг нь нэр бүхий А, Б, В сумдын ИТХ-ууд үл зөвшөөрч өөрсдийн сумандаа өөр өөр өдрийг сонгосон шийдвэр гаргажээ. Энэ тохиолдолд аймгийн ИТХ-ын шийдвэр зөв үү? Өөр өөр шийдвэр гаргасан сумдын ИТХ-уудын шийдвэрийг зөв гэж үзэх үү?”

Шийдвэрлэх арга зам: Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18, 19 дүгээр зүйлүүдэд заасан Хурлуудын нийтлэг бүрэн эрх гэсэн хэсгээр аймаг, сумын ИТХ-ууд аль аль нь дээрх асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байхаар заасан боловч нэг асуудлаар хоёр өөр шийдвэр гаргасан тохиолдолд хэнийх нь шийдвэр зөв байхыг тодорхой хуульчлаагүй юм. Гэвч практикт доод шатны Хурал хууль, дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн шийдвэр гаргах нь зүйтэй бөгөөд хэрэгжүүлэхэд ч хялбар байх болно.

⁶ Д.Сүнжид. “Орон нутгийн түвшин дэх чиг үүргийн хуваарилалт”. Нутгийн удирдлага: сорилт ба шийдэл үндэсний чуулганы эмхэтгэл. УБ.2016. 64 дэх талд.

Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх, улсын хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулах гэсэн шалгуурыг тогтоож өгсөн болно. Эдгээр зохицуулалт нь өөр өөрийн онцлог утгатай.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээнд “эдийн засаг, нийгмийн асуудал” гэсэн нь улс төрийн харилцааны зарчмын асуудлыг шийдвэрлэхгүй, өөрөөр хэлбэл, нутгийн өөрөө удирдах байгууллагын иргэний Хурлуудыг “улс төржүүлэхгүй” гэсэн хязгаарлалт юм.

Үндсэн хуулийн дээрх заалтыг үндэслэн гарсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд (1992) нутгийн удирдлага, түүний дотор нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчмыг нарийвчлан заасан. Уг хууль засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулсан. Засаг захиргааны нэгж дэх төрийн болон нутгийн өөрийн удирдлага хоорондын эрх мэдэл, ерөнхий чиг үүргийн хуваарилалт, удирдлагын үндсэн зарчмыг тодорхойлсон.

Түүнчлэн хурлын байгууллагын үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, бүтэц, хурлын ээлжит ба ээлжит бус хуралдаан, түүнийг зарлах, шийдвэр гаргах зэрэг харилцааг тодорхойлсон байдаг.

Хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хурлын бүрэн эрхийг тодорхойлсон байна. Баг, хорооны иргэдийн Нийтийн хурлын бүрэн эрх нь агуулга талаас нь багцалж үзвэл өөрийгөө зохион байгуулах, Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх болон иргэдтэй холбогдох зарим асуудлыг сум, дүүргийн хуралд уламжлах гэсэн үндсэн гурван зүйлээс бүрдэж байна.

Сум, дүүргийн бүрэн эрхийг хуулийн 18 дугаар зүйлд өөрийгөө зохион байгуулах болон үйл ажиллагааных нь дэгтэй холбоотой асуудлууд, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаарх эрхийн хүрээнд төлөвлөлттэй холбоотой болон хяналтын асуудлыг заасан бол хуулийн 18.2-т орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүрэн эрхүүд туссан байна.

Хуулийн 19 дүгээр зүйлд аймаг, нийслэлийн хурлын бүрэн эрхийг хуульчлан тогтоосон байна. Түүнд 18 дугаар зүйлд байгаа сум, дүүргийн хурлын бүрэн эрхэд хамаарагдах бүх заалт бас аймаг нийслэлийн хурлын бүрэн эрх байхаар заажээ. Түүнээс гадна аймаг, нийслэлийн хурал нь үнэт цаас гаргах асуудлыг шийдвэрлэх, өмч хувьчлах бодлого, хувьчилж үл болох хөрөнгийн жагсаалт гаргах зэрэг үүргүүдтэй аж.

Нутгийн удирдлагын байгууллага нь аливаа төлөөллийн байгууллагын нэгэн адил гурван үндсэн чиг үүрэгтэй. Үүнд :

- төлөөллийн;
- нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоох;
- хяналтын чиг үүрэг зэрэг болно.

Товчоор хэлбэл, иргэн сонгосон төлөөлөгчиддөө хандаж “намайг төлөөлж ажилла”, “намайг төлөөлж хэм хэмжээ тогтоож ажилла”, “намайг төлөөлж хяналт тавьж ажилла” гэж эрх олгосон хэрэг юм. Нутгийн өөрөө удирдах ёсны хувьд эдгээр чиг үүрэг өөр өөрийн онцлогтой.

1) Төлөөлөх эрх хэмжээ

Тодорхой зорилго, чиглэлээр төлөөллөө сонгон илгээх, сонгогдсон төлөөлөгч сонгогчдоо төлөөлөн ажиллах нь төлөөллийн ардчиллын зарчим билээ. Гэхдээ төлөөллийн зорилго, чиглэлээс хамаарч уг төлөөллийн байгууллага нь сонгогчдынхоо нэг л шинжийг нь агуулж байх (өөрөөр хэлбэл төлөөлж байх)-ыг төлөөлөх гэх ажээ. Тэгвэл нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа иргэдийн төлөөллийг, тодруулбал, тухайн иргэдийн харьяаллын дагуу төлөөлөх чиг үүрэгтэй гэсэн үг.

Төлөөлөх чиг үүрэг нь сонгуульд оролцох эрхээс эхлэх бөгөөд тухайн нутаг дэвсгэрт албан ёсны бүртгэлтэй, сонгуулийн насанд хүрсэн, Монгол Улсын иргэн саналаа өгөх эрхтэй.

11.1. Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй.

11.8. Хорин таван нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, суманд санал авах өдрөөс өмнө 180-аас доошгүй хоногийн хугацаанд тасралтгүй, байнгын оршин суугчаар бүртгүүлсэн, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны орон нутгийн хуралд сонгогдох эрхтэй.

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйл

Жишээ 2. Сонгох эрх буюу төлөөлүүлэх эрх

1996 оны намраас эхлэн дараа дараачийн сонгууль бүрээр нийслэл хотод суралцаж буй, аймгуудын харьяат оюутнууд “нийслэл, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцож, саналаа өгөх боломжгүй нь иргэний эрхийг зөрчиж байгаа” хэмээн үзэж, өргөх бичиг үйлдэн, жагсаал цуглаан зохион байгуулах болсон. Эдгээр оюутны сонгох эрх зөрчигдсөн үү?

Шийдвэрлэх арга зам: Энэ нь иргэний эрхийг зөрчиж байгаа хэрэг биш юм. Тэдгээр оюутны хувьд өөрийн харьяа аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцох эрх нь хэвээр байгаа ба сонгуулийн санал хураах өдөр өөрийн харьяа нутаг дэвсгэрээс өөр газар зорчин явж байгаа иргэний нэгэн адил эрх зүйн үндэслэл үүсэж буй хэрэг.

Төлөөлөгч нь тодорхой тойргийн иргэдийг ИТХ-д төлөөлдөг бол ИТХ нь тухайн аймаг, сумын нийт иргэдийг төлөөлөн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж байгаа юм. Энэ утгаараа ИТХ нь иргэдээ төлөөлөн шийдвэр гаргаж, иргэдээ төлөөлөн хяналт тавьж байгаа гэж үздэг. Орон нутагт иргэдийг төлөөлөхийн утга нь Хурлын шийдвэр иргэдийн олонхийн сонирхолд нийцэж байх явдал юм. ИТХ бол өөрөө удирдах ёсны байгууллага. Тиймээс түүний шийдвэр гаргаж байгаа нь иргэд цуглаад тухайн асуудлыг хэлэлцээд шийдвэр гаргах байсныг орлож байгаа гэсэн үг. Тиймээс ИТХ иргэдийн сонирхлыг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргахын өмнө иргэдтэй зөвлөлдөж, санаа бодлыг нь сонсож байх учиртай. Энэ бол төлөөллийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж байгаа хэрэг мөн. Энэ асуудлыг

Захиргааны ерөнхий хуулийн 27 зүйлд⁷ сонсох үйл ажиллагааг зохион байгуулах гэж зааж өгсөн байна. Сонсох үйл ажиллагааг 20-иос дээш иргэн асуудал хөндсөн тохиолдолд төлөөлөгчөөр дамжуулан зохион байгуулахаар заасан нь ИТХ-ын төлөөлөгч иргэдийг сонсох үйл ажиллагаанд төлөөлнө гэсэн агуулга биш юм.

27 дугаар зүйл. Сонсох ажиллагааг явуулах

- 27.1. Захиргааны шийдвэр гаргах захиргааны байгууллага эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлно.
- 27.2. Сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд дараах байдлаар хүргүүлнэ:
- 27.2.1. хорь буюу түүнээс доош тооны этгээдийг сонсохоор бол мэдэгдлийг этгээд тус бүрд шууд хүргүүлэх;
- 27.2.2. хорин нэг буюу түүнээс дээш тооны этгээдийг сонсохоор бол энэ хуулийн 20.1-д заасан төлөөлөгчид шууд хүргүүлэх, эсхүл тухайн орон нутагт хүргэх боломжтой хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шуудан болон тэдгээрт урьдчилан мэдэгдэх бусад арга хэрэгслийг ашиглан хүргүүлэх.
- 27.3. Сонсох ажиллагааны талаарх мэдэгдэлд дараах мэдээллийг тусгана:
- 27.3.1. сонсох ажиллагааг явуулах журам, ажиллагаа явуулах он, сар, өдөр, цаг, байрлал, дарааллын талаарх мэдээлэл;
- 27.3.2. захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль, захиргааны хэм хэмжээний актын зүйл, заалт;
- 27.3.3. захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл.
- 27.4. Сонсох ажиллагааг дараах арга хэлбэрээр явуулна:
- 27.4.1. сонсгол зохион байгуулах;
- 27.4.2. саналыг бичгээр авах;
- 27.4.3. биечлэн уулзах;
- 27.4.4. утсаар санал авах;
- 27.4.5. цахим хэлбэрээр санал авах;
- 27.4.6. төлөөлөгчөөр дамжуулан санал авах;
- 27.4.7. бусад.
- 27.5. Сонсох ажиллагаа явуулах хугацаа оролцогчийн тайлбар, санал гаргах боломжийг хангасан байна.
- 27.6. Сонсох ажиллагааны явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулна.
- 27.7. Сонсох ажиллагааны үед гарсан саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй шалтгааныг тайлбарлах үүрэгтэй

Захиргааны ерөнхий хууль

2) Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох эрх хэмжээ

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ буюу тухайн нутгийнхаа иргэдийн амьдрал, хөгжлийн асуудлыг хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд тэрхүү шийдвэр нь тухайн нутаг дэвсгэр дээр засаглах, өөрөөр хэлбэл, түүнийг заавал биелүүлэх ёстой байдаг. Энэхүү эрх нь нутгийн өөрөө удирдах байгууллагад сонгогчдоос олгосон эрх бөгөөд өөрсдийгөө удирдах, өөрсдийг нь төлөөлөн шийдвэр гаргах эрхийг шилжүүлсэн гэсэн үг юм. Энэхүү эрхээ нутгийн иргэдийн язгуур эрх ашигт нийцүүлэн бие даан хэрэгжүүлэх

⁷ Захиргааны ерөнхий хууль, 2015, <http://legalinfo.mn/law/details/11259?lawid=11259>

нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн чиг үүргийн нэг байна.

Хуулийн хүрээнд нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлан гаргах нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн үйл ажиллагаа билээ. Энэ чиг үүргийн хүрээнд хамааруулан авч үзэх өөр нэг асуудал бол ИТХ нь өөрийн дотоод зохион байгуулалтын асуудлыг өөрөө тогтоох эрхтэй байдагт оршино. Энэ эрхийн дагуу нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн хуралдааны дэг зэрэг дотоод зохион байгуулалтын асуудлыг ч бие даан шийдвэрлэдэг.

62.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.

62.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

62.3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйл

ИТХ, Засаг дарга нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд ажиллаж, гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэл, хариуцлагыг бүрэн хүлээх үүрэгтэй. Хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхийн тулд ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоол нь хууль тогтоомжид нийцсэн байх шаардлагатай. Хурлаас гаргасан зарим шийдвэрийг судлан үзэхэд эрх мэдлээ хэтрүүлсэн, хуулийн заалтыг буруу хэрэглэсэн, тогтоох ёсгүй татвар, хураамжийг тогтоосон, Засаг даргын гаргах ёстой шийдвэрийг гаргасан, нийтээрээ дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон боловч Хууль зүйн яаманд бүртгүүлээгүй зэрэг дутагдлууд нийтлэг байна. ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн Хурал л өөрөө өөрчлөх буюу хүчингүй болгоно, эсвэл хэн нэгэн иргэн Захиргааны хэргийн шүүхэд өргөдөл гаргаж, түүний дагуу шийдвэрийг түдгэлзүүлэх буюу хүчингүй болгоно. Иймээс ИТХ нь шийдвэр гаргахдаа дээрх шаардлагад нийцүүлэн, хууль зүйн үндэслэлд ихээхэн анхааралтай хандах хэрэгтэй байдаг. Хурлаас хуульд нийцсэн зөв шийдвэр гаргахад ИТХ-ын төлөөлөгчдийн хууль эрх зүйн мэдлэг, Хурлын ажлын албаны ажилтнуудын төлөөлөгчдөд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаанаас ихээхэн хамааралтай.

Аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэрээс тухайн нутаг, дэвсгэрийн иргэдийн нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг Хууль зүйн яаманд, сум, дүүргийн ИТХ-ын шийдвэрээс дээд шатны удирдлагад хамааралтай шийдвэрийг хүргүүлж байх нь ажлын уялдаа холбоог хангахад зайлшгүй шаардлагатай байдаг нь амьдрал дээр харагдаж байна. Жишээ нь, Сумын ИТХ-ын тогтоолоор тухайн орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газрын тухай шийдвэр аймагт очоогүйгээс тухайн газрыг ашигт малтмалын хайгуулын лиценз хүссэн компанид олгохоор зөвшөөрсөн саналыг

аймгийн ИТХ-аас өгсөн тохиолдол гарсан. Энэ нь ажлын уялдаа, холбоо муу байгаатай ч холбоотой. 2006 оны 12 дугаар сард Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлд ИТХ-д асуудал оруулах эрх бүхий субъектуудын тоог нэмэгдүүлсэн⁸.

Орон нутгийн удирдлагаас хууль, тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр нь тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэг хүлээнэ. Хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлүүлэхээр хуульчлагдсан болно.

Засаг захиргааны тухайн нэгжид үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дээд шатны байгууллагад харьяалагддаг аж ахуйн нэгж, албан газар, байгууллагын гаргасан шийдвэр хууль тогтоомж, Засгийн газар, ИТХ, Засаг даргын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрт харшилбал Засаг дарга түүнийг өөрчлөх буюу хүчингүй болгуулах саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах бөгөөд энэхүү саналыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлнэ. Эдгээр хуулийн зохицуулалт нь орон нутгийн удирдлагаас хуулийг дээдлэх, биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих өргөн боломж байгааг илтгэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 5 дугаар сарын 20-ны 01 дүгээр тогтоолоор “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэж шийдвэрлэсэн ба аймаг, нийслэлийн ИТХ доод шатныхаа Хурлын шийдвэрийг хүчингүй болгодог байсан хуулийн заалтыг хүчингүй болгосон. Тэгэхээр ИТХ-ын шийдвэрийг зөвхөн УИХ эсвэл тухайн Хурал өөрөө өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй болсон. Иймд ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоолыг батлан гаргахдаа хууль зүйн үндэслэлийг маш тодорхой заах шаардлагатай.

ИТХ-ын шийдвэрийг шүүх хүчингүй болгох эрхтэй боловч өөрийн санаачлагаар шийдвэрлэх эрхгүй, зөвхөн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд л асуудлыг авч үзнэ. Мөн хууль, тогтоомжид зөвхөн сум, дүүргийн ИТХ-д олгосон бүрэн эрхийг аймаг, нийслэлийн ИТХ тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг хориглосон. Дээрх хуулийн зохицуулалт нь тухайн ИТХ-ын бие даасан байдлыг хангасан, үйл ажиллагаагаа хэнээс ч хамааралгүй явуулах боломж бүрдүүлж өгснөөрөө ач холбогдолтой юм.

ИТХ-аас олон төрөл зүйлийн, янз бүрийн агуулгатай шийдвэр гардаг. Тэдгээрийн дотор үйл ажиллагааны хөтөлбөрийн шинжтэй болон дүрэм журам тогтоосон шийдвэр чухал байдаг. Үйл ажиллагааны хөтөлбөрийн шинжтэй шийдвэрүүдэд Хурлын иргэдийг төлөөлөх болон улсын хэмжээний бодлогын асуудлыг шийдвэрлэхэд иргэдээ татан оролцуулах чиг үүргүүд тусгалаа олсон байх ёстой. Энэ талын сайн жишээ гэвэл, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ИТХ-ын ажиллагаа юм. Тэнд сонгуулийн дараа Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн

8 24.1.Хурлын Тэргүүлэгчид, хороо, түүнчлэн төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

24.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

24.3.Энэ хуулийн 24.1, 24.2-т заасан саналд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 1 хоногийн өмнө Хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй. (МУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 зүйл)

хөтөлбөр болон төлөөлөгчдийнхөө сонгогчдод амалсан зүйлийг багтаасан 4 жилийн үйл ажиллагааны үндсэн чиглэл гаргаж хэрэгжүүлдэг байна. Дүрэм журам тогтоосон шийдвэр нь иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэт боомилсон шинжтэй байж болохгүй юм. Төрөөс нийгмийн амьдралд хэт хутгалдан орох ёсгүй гэдэг зарчмыг ИТХ ч бас баримтлах нь зүйтэй.

Шийдвэр гаргахын тулд төлөөлөгчид Монгол Улсынхаа төрийн тогтолцоо, нутгийн удирдлагын тогтолцоо, төрийн удирдлагын төвшин хоорондын харилцааны зарчмуудыг маш сайн мэддэг байх нь зүйтэй. Хэдэн жилийн өмнө нэг сумын ИТХ шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тогтоол гаргасан талаар шуугиан болж байсан билээ. Энэ нь чухамдаа дээрх суурь асуудлуудыг мэддэггүйгээс үүдэн гарсан алдаа юм.

Шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбоотой чухал зүйл бол төрийн албан бичгийн хэм хэмжээг сахих явдал юм. Төлөөлөгч тодорхой асуудлыг хариуцан судалж, хуралдаанд оруулахдаа хуралдааны материал, түүний дотор шийдвэрийн төслийг бэлтгэдэг. Тиймээс төлөөлөгч хүн манай улсад мөрдөгдөж байгаа албан бичгийн стандартыг судлаж, түүний дагуу бичиг баримт бэлтгэдэг, монгол хэл бичгийн хэм хэмжээ, үсгийн дүрэм, найруулгыг мэддэг байх нь зүйтэй.

3) Хянах эрх хэмжээ

ИТХ нь тухайн нутаг дэвсгэртээ өөрийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хянахаас гадна УИХ-аас батлан гаргасан хуулийн хэрэгжилт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан даалгавар, зөвлөмж, Засгийн газрын тогтоолуудын хэрэгжилтийг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй. Хяналтын гол хэсэг бол төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалт, түүний үр дүнгийн байдалд хяналт тавих явдал юм. ИТХ-ын хуралдаанаар батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, өр авлагын шийдэл, орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүний зарцуулалтын байдалд нийт иргэдийн эрх ашгийн өмнөөс хяналт тавина. Тухайлбал, УИХ-аас орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулдаг байхын тулд төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах зорилготой “Шилэн дансны тухай хуулийг (2014)” батлан гаргасан юм. Уг хуулийн 8 дах хэсэгт “шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заажээ.

ИТХ нь нутаг дэвсгэрийн хэмжээнд боловсрол, эрүүл мэнд, орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой асуудлууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйлдвэрлэл буй бүтээгдэхүүн, үзүүлж байгаа үйлчилгээний үнэ, тариф үндэслэлтэй эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Жилийн эхэнд хяналт шалгалтын график гарган Засаг даргын Тамгын газар, Аудитын газар, Мэргэжлийн хяналтын байгууллагатай ажлаа уялдуулан тухайн байгууллага, аж ахуйн нэгж дээр давхардсан шалгалт хийхгүй байх, зарим шалгалтыг хамтран зохион байгуулах хэлбэрээр ажилладаг.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиас гадна бусад хуулиар ИТХ-д нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрхийг

олгосон байна. Хурал нь хяналтын эрхээ хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг баримтлан ажиллах бөгөөд хяналтын ажлаа зохион байгуулахдаа мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэдийг оролцуулах нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 тоот тогтоолоор “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг баталсан. Энэхүү тогтоол нь Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулах зорилготой ба уг тогтоолын 7.5-д Нутгийн өөрөө удирдах байгууллагаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичиг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон 7.7-д заасан Засгийн газар, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гадаад, дотоодын бусад хуулийн этгээдтэй байгуулсан, хоёр тал харилцан үүрэг хүлээсэн гэрээний хүрээнд хяналт шалгалтыг явуулна.

Хүснэгт 1.2. Бусад хууль, эрх зүйн заасан ИТХ-ын хяналтын эрх

Хууль, тогтоол	Зүйл, заалт	Агуулга
Төрийн хяналт шалгалтын тухай хууль	12.1.2	Дээд шатны болон тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийнхээ холбогдох бүх байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгах
Төсвийн тухай хууль	64.1.1	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих
	64.1.2	Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлж байх
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	77.1	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах
	77.4	Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхтэй
Нийгмийн халамжийн тухай хууль	27.6	Иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус Зөвлөлийн үйл ажиллагаанд суманд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, хороонд иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид хяналт... тавих эрхтэй.
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль	7.7	Бүх шатны ИТХ нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан...батлах
	19.5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” хяналт тавина.

Боловсролын тухай	29.1.2	ИТХ нь “орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих” бүрэн эрхийнхээ дагуу тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих
Эрүүл мэндийн тухай	10.1.3	Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хөтөлбөр, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих
	10.1.4	Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний хамтын оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах бүрэн эрхийн дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлнэ.
Соёлын тухай хууль	14.1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, түүний хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлж, хяналт тавина.
Аялал жуулчлалын тухай хууль	18.1.1	Нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл энэ талаар Засаг даргын тайланг хэлэлцэхээр хуульчлагдсан байна.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	16.1.1	Аймаг, нийслэлийн ИТХ байгаль орчныг хамгаалах, баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, хяналт тавих
	16.1.3	Байгаль орчныг улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих
	17.1.1	Сум, дүүргийн ИТХ нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих
	17.1.4	Сум, дүүргийн ИТХ нь байгаль орчныг хамгаалах талаар Засаг даргын ажлын тайланг хэлэлцэх
Ойн тухай	17.1.5	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих
Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль	13.1.1	Сум, дүүргийн ИТХ нь нутаг дэвсгэртээ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих
Газрын тухай	20.1.1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих
	57.1	Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина.

Газрын хэвлийн тухай	7.1.1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн салбарын хууль тогтоомж, түүнчлэн тухайн салбарын асуудлаар нутаг дэвсгэртээ мөрдөхөөр батлан гаргасан Хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхтэй.
	18.2.7	Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих эрх
Орон сууцны тухай	8.1.1	Нутаг дэвсгэртээ орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах болон хүн амын эмзэг хэсгийг орон сууцаар хангах бодлого тодорхойлж, хэрэгжилтэд нь хяналт тавих, хүн амын эмзэг хэсгийг орон сууцаар хангах бодлого тодорхойлж, хэрэгжилтэд нь хяналт тавих
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	20.1.1	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, төрийн бодлогыг тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод тусгах, хэрэгжилтэд хяналт тавих
	20.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тухайн шатны Засаг даргын тайланг хуралдаанаараа хэлэлцэж, дүнг нийтэд мэдээлнэ.
Жижиг дунд үйлдвэрийн тухай	12.1.2	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам батлах
	12.1.3	Тухайн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн хөтөлбөр батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.
Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль	9.1	-Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн ИТХ хянан үзэж, зөвшөөрөл олгох, -Тухайн засаг захиргааны нэгжид байх сүм, хийд цуглааны тоо, хязгаарын талаар бодлоготой ажиллах, зөвшөөрөлгүй ажиллаж байгаа, иргэдийг төөрөгдүүлж шашны зан үйлд татан оролцуулж байгаа, насанд хүрээгүй бага насны хүүхдийг эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр шашны сургалт, цуглаанд хамруулж байгаа аливаа үйлдэлд хяналт тавьж, саналаа холбогдох байгууллагад уламжлах
Дайчилгааны тухай хууль	17.1.1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн дайчилгааны даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, энэ талаар Засаг даргын мэдээлэл сонсож, чиглэл өгөх: дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг хуваарилж, зарцуулалтад хяналт тавих үүргийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүлээнэ.

Жишээ 3. “ А сумын ИТХ-ын төлөөлөгчид “Багийн иргэдийн Нийтийн Хурал нь нэр төдий, орон тооны бус ажилладаг, Тэргүүлэгчид нь ч ажиллах нөхцөл боломжоор хангагдаагүй тул татан буулгаж, Багийн Засаг даргад ажлыг нь хавсаргах, эсвэл орон тооны болгох хэрэгтэй” гэж үзсэн байна. Ингэж шийдвэрлэж болох уу?

Шийдвэрлэх арга зам: Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар “НӨУБ бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ, баг, хороонд ИНХ, тухайн Хурлын хуралдааны чөлөөт цагт түүний Тэргүүлэгчид мөн”. Багийн ИНХ, багийн Засаг дарга нь хуулиар өөрт олгогдсон тус тусын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нутгийн удирдлагын хоёр өөр субъект тул бие биенээ татан буулгаж өөрчлөх эрх хэмжээгүй байхаар хуульчлагдсан болно.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т зааснаар “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэснийг хэрэгжүүлж, орон нутагт хийгдэж байгаа ажилд ИТХ-ын төлөөлөгчид, иргэдийг оролцуулсан явцын хяналт хийдэг.

Сайн туршлага. Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөл

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 14 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавих “Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ыг батлан зөвлөлийг 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулдаг. Зөвлөл нь олон нийтийн оролцоог хангах чиглэлээр орон нутгийн төрийн бус байгууллагуудын зөвлөлийн хурлаас сонгогдсон 3 төлөөлөл, Хэрлэн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаас томилсон иргэний 2 төлөөлөл, сумын ИТХ-ын 2 төлөөлөгч бүхий нийт долоон хүний бүрэлдэхүүнтэй. Хэрлэн сумын 10 багт сайн дурын 5 ажлын хэсэгтэй бөгөөд нийт 25 хүн ажилладаг.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж, гүйцэтгэж буй ажлуудтай газар дээр нь танилцаж, зөрчил дутагдлыг илрүүлэх, хуулийн дагуу ил тод нээлттэй, хариуцлагатай болгох зорилгоор Хэрлэн суманд 2013 онд хэрэгжсэн 7.2 тэрбум төгрөгний санхүүжилттэй 63 ажлыг хамруулж, хяналт үнэлгээний ажлыг хийсэн. Энэхүү зөвлөл нь тухайн суманд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэл, чанарын асуудалд хяналт үнэлгээ хийхдээ газар дээр нь ажиллан иргэдийн саналыг авсан байна.

Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөл 10 багт, баг тус бүр гурван хүний бүрэлдэхүүнтэй хяналтын баг байгуулан ажилласан бөгөөд сумын ИТХ-ын төлөөлөгч, олон нийтийн байгууллага, иргэний төлөөллийг оруулсан 40 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 61 ажил дээр үнэлэлт, дүгнэлт өгсөн байна. Ингэхдээ тус сумын 10 багийг таван хэсэг болгон иргэдийн дунд хөрөнгө оруулалтын ажлын талаар сэтгэл ханамжийн үнэлгээний судалгаа хийжээ.

Эх сурвалж: hural.mn/Иргэдийн Төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас/

ИТХ нь орон нутагт ажиллаж байгаа төрийн байгууллагуудын дарга, эрхлэгчдийн илтгэл сонсголыг хэлэлцэж болно. Энэ талаар сайн жишээ олон байдаг.

Сайн туршлага.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаараа сургууль, эмнэлэг, цэцрлэгийн эрхлэгчдийн тайланг хэлэлцэхээс гадна сум багийн Засаг дарга, цагдаа болон төсвийн зарим байгууллагын жилийн ажлын тайланг багийн нийтийн хуралд тавиулах ажил зохиосон нь хяналтын оновчтой хэлбэр юм.

Эх сурвалж: Нутгийн удирдлага сэтгүүл, 2007, 2, 15 дахь тал

ИТХ-ын төлөөлөгч нь хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж, хариуг нь сонсдог. Хууль, бусад шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар холбогдох албан тушаалтанд бичгээр хандсаныг “асуулга” гэнэ. Асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг бичгээр өгнө. Тухайн ИТХ-ын төлөөлөгчөөс Засаг даргад тавьсан асуулгын хариуг хэлэлцэж, шаардлагатай бол зохих шийдвэр гаргана.

Нийгмийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой нэг асуудлаар холбогдох албан тушаалтанд бичгээр хандсаныг “асуулт” гэнэ. “Асуултыг хүлээн авсан албан тушаалтан хариуг 14 хоногийн дотор бичгээр өгнө” гэж заасан байдаг. Харамсалтай нь, асуулга болон асуулт тавих, тэдгээрийн хэлбэр, хариуг сонсох, хариуцлага тооцох зэрэгт ИТХ-ын дарга, төлөөлөгчид анхаарал бага тавьдаг учраас хяналтын дээрх хөшүүргийг бараг хэрэглэхгүй байна.

Зарим төлөөлөгч хуралдааны үед амаар асуулт тавихыг асуулга гэж ойлгодог, асуулгыг бичгээр үйлдэх, асуулгын хариуг тодорхой хугацаанд сонсох талаар мэдэхгүй байна. ИТХ-ын төлөөлөгчөөс холбогдох албан тушаалтанд асуулга, асуултыг яаж тавих, түүний хариуг хэрхэн хэлэлцэх талаар ямар нэгэн журам батлан гаргаагүй байгаагийн зэрэгцээ ИТХ-ын хуралдааны дэг, Тэргүүлэгчдийн хуралдааны дэгд ч тусгайлан зааж өгөөгүй байна.

ИТХ-ын төлөөлөгч нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах, шаардлага тавьж биелэлтийг хангуулах, ИТХ-аас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх санал гаргах, хууль тогтоомж, дээд шатны болон тухайн ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг Засаг дарга хэрхэн зохион байгуулж байгааг шалгах, үнэлгээ өгөх зэрэг эрхтэй бөгөөд ИТХ-ын байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар санаачлага гарган ажиллах нь чухал.

Сүүлийн жилүүдэд төрийн удирдлагад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч байна. Оролцооны янз бүрийн шинэ хэлбэр гарч байгаагийн дотор төлөөллийн ардчилал, иргэний танхим, олон нийтийн оролцоот төсөв зэргийг нэрлэж болно. Иргэдийн оролцооны ийм хэлбэрийг иргэдийн өөрийн удирдлагын байгууллага болох ИТХ-ын үйл ажиллагаатай уялдуулах, тэдгээрийг зохион байгуулах ажлыг ИТХ гардан хийдэг байх нь зүйтэй. Учир нь энэ бүх үйл

ажиллагааны эцсийн үр дүн нь ИТХ-ын шийдвэр болж гарна. Иргэдийн өрөлцсөн ийм хэлбэр нь ИТХ-ын шийдвэр гаргах, хянах чиг үүргийн аль алинд хамаарах бөгөөд эцсийн дүндээ иргэдийг үр нөлөөтэй төлөөлөх боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Сайн туршлага.


ИТХ-ын Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хуралдаан 2008 оноос зохион байгуулагдаж ирсэн бөгөөд үр дүнтэй арга хэмжээ болдог. 2008 оноос хойш бид аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, дүүрэгт хэрэгжиж байгаа үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй танилцан, гарсан үр дүнг ИТХ-ын Тэргүүлэгчдийн өргөтгөсөн хуралдаанд танилцуулах, иргэдээр үнэлүүлэх ажлыг тогтмол хийж хэвшээд байна.

*Багахангай дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгч Х.Цогцэцэг
Эх сурвалж: hural.mn/Иргэдийн Төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас/*

Нутгийн өөрөө удирдах байгууллага ба Засаг дарга хоорондын харилцаа

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аливаа төлөөллийн ардчиллын байгууллагуудын нэгэн адил шийдвэрийг нь хэрэгжүүлэх үүрэгтэй, өөрт нь ажлаа хариуцан тайлагнадаг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай байдаг нь нутгийн захиргааны байгууллага буюу Засаг дарга юм. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засаг даргын үйл ажиллагааг чиглүүлж, явц, үр дүнд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх үүргийг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн нэрийн өмнөөс хэрэгжүүлнэ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн шатныхаа Засаг даргатай харилцах, хамтран ажиллах ёстой. Засаг дарга бол төр, засгийг төлөөлж, төрийн хууль тогтоомжийг сурталчилж хэрэгжүүлэхийн зэрэгцээ ИТХ-ынхаа шийдвэрийг биелүүлж байх үүрэгтэй. ИТХ нь Засаг даргад нэр дэвшүүлэн, мөрийн хөтөлбөрийг нь батлан, биелэлт үр дүнг сонсож, үнэлгээ дүгнэлт өгнө. Засаг даргаас өргөн барьсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл Засаг даргыг огцруулах санал тавина. Гэвч энэхүү харилцааны асуудал нь тэр бүр хуулиар зохицуулахад хялбар биш, төвөгтэй, хувь хүмүүсийн харилцаа, боловсрол, хүмүүжил, ёс суртахууны түвшингээс хамааралтай нилээд эмзэг асуудал юм.



Зураг 1.4. ИТХ ба Засаг дарга хоорондын харилцаа

Энэ нь харилцан тэнцүү эрх бүхий нутгийн удирдлагын хоёр субъектын харилцаа юм. Тэгэхээр Засаг дарга, ИТХ нь гар санаа нэгдэн ажиллах, хуулиар олгосон чиг үүргээ тууштай хэрэгжүүлэх учиртай юм. Харин тус бүрийнхээ хуулиар заасан чиг үүргийн заагаас хальж, өдөр тутмын ажилд нь хөндлөнгөөс оролцох нь зохимжгүй. Үйл ажиллагааны хүрээ, зорилго, мөрдөж хэрэгжүүлэх хууль, ажиллах объект нь нэг учраас ИТХ, Засаг дарга хоёрын үйл ажиллагаа нэгдмэл байх ёстой. Гэхдээ хуулиар тус тусад нь олгосон чиг үүрэг бий.

Сайн туршлага. Ховд аймгийн Үенч сумын ИТХ-ын дарга Ш.Отгонбаяртай хийсэн ярилцлагаас

Асуулт: Ховд аймгийн Үенч сум 2014 оны улсын тэргүүний сум болсон. Сумын ИТХ-ын ажлын гол онцлог юу вэ?

Хариулт: Манай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын амжилттай ажиллаж байгаа учир нь ИТХ-ын хяналтын чиг үүргээ үндсэн гол шугам болгон ажиллаж байгаад оршиж байгаа юм. Дээр нь иргэдийн оролцоог хангах, идэвхийг нэмэгдүүлэх чиглэлээр янз бүрийн ажил, арга хэмжээнүүдийг авч явуулж байна. Сумын Иргэдийн хурал бодлого төлөвлөлт, хяналт шалгалт, зөвлөмж зөвлөгөөгөө зөв хийгээд явах юм бол орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага суманд төгөлдөржиж, түүний дагуу цаашид Засаг дарга өгсөн бодлогыг зөв хэрэгжүүлээд явах юм бол амжилтанд хүрдгийг манай сумын ИТХ, Засаг дарга, түүний Тамгын газар, төсөвт албан газруудын удирдлагууд, тэнд ажиллаж байгаа хүмүүс, нутгийн зон олон харуулж чадаж байгаа. Сумын ИТХ-ын төлөөлөгчид мэдлэг туршлагатай, үндсэн чиг үүргээ сайн мэддэг болон Засаг дарга нь үндсэн чиг үүргээ сайн мэддэг байж, хоёулаа хамтран сайн ажиллавал сум орноо хөгжүүлэхэд гар, бие, сэтгэлээ нийлүүлээд ажиллах боломжтой. Хамгийн гол нь тэр ажлыг тухайн сумын ИТХ-ын дарга, түүний тэргүүлэгчид, Засаг дарга, Засаг Даргын Тамгын Газрын хамт олон үүнийг ухамсарлан сайн ойлгох юм бол урагштай явна гэдгийг бид харуулж, мэдэрч байна.

Эх сурвалж: hural.mn/Иргэдийн Төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас/

Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, тухайн нутаг дэвсгэрийг хөгжүүлэх чиглэлээр батлагдсан урт, богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар хийгдэж байгаа ажлууд, иргэдийн санал, шүүмжлэлийн мөрөөр авч байгаа арга хэмжээний үр дүнг тухай бүр ИТХ-ын эсвэл Тэргүүлэгчдийн хуралдаанаараа авч хэлэлцэн, газар дээр нь үзэж танилцах ажлыг зохион байгуулна.

Ийнхүү тогтоосон хэм хэмжээний хүрээнд ИТХ Засаг даргын үйл ажиллагааг хянах үүргээ үндсэн хоёр хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- тайлан, сонсголыг хэлэлцэх;
- ажлын хэсэг, комисс томилон ажиллуулан хяналт шалгалт явуулна.

Тайлан: Тайлан бол Засаг даргын тодорхой хугацаанд гүйцэтгэсэн ажлын өөрийн үнэлгээ юм. Өөрөөр хэлбэл, энэ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэл юм. Тайланг жил бүр болон 4 жилээр зөвхөн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэнэ. Хуралдаанаас өмнө Тэргүүлэгчид, хороо болон Намын бүлгүүд хэлэлцэн, санал дүгнэлтээ боловсруулна.

Сонсгол: Энэ нь нэг буюу хэд хэдэн үйлдэл/эс үйлдлийн талаар бэлтгэсэн тайлбар, дүгнэлт юм. ИТХ-ын нэг эсвэл хэд хэдэн төлөөлөгчийн асуулгын хариу болон тодорхой үйлдэл/эс үйлдлийнхээ талаар ИТХ-д сонсгох нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд оруулж буй мэдээлэл гэсэн хоёр хэлбэртэй байдаг.

Энэхүү асуудлаар ИТХ заавал тогтоол гаргах албагүй бөгөөд тогтоол гаргах эсэхийг хуралдааны дэгийн дагуу санал хурааж шийдвэрлэнэ.

Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар:

- ИТХ нь Засаг даргад нэр дэвшүүлнэ, огцруулах, чөлөөлөх асуудлаар саналаа гаргана.
- ИТХ нь шийдвэрээ гаргаж, Засаг дарга түүнийг нь хэрэгжүүлнэ. Гэхдээ ИТХ-ын шийдвэрийг холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн, хэрэгжүүлэх боломжгүй гэж тухайн шатны Засаг дарга үзвэл шийдвэр батлагдсан өдрөөс хойш 3 өдрийн дотор хориг тавина. Хоригийг хүлээн авах эсэхийг ИТХ хуралдаанаараа 15 хоногийн дотор багтаан хэлэлцэж шийдвэрлэнэ.
- ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах ба хэрэгжилтэд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгнө.
- ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны тайланг сонсож хэлэлцэх ба явц, үр дүнг нь үнэлж, үнэлэлт дүгнэлт өгнө
- Засаг дарга нь нутаг дэвсгэрийн хэмжээний амьдралын тодорхой асуудлыг санаачлан боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлэн хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна.

Үүний зэрэгцээ ИТХ-ын хороод өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд Засаг даргын үйл ажиллагаа, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянан шалгана.

“Нийтийн сонсголын тухай хууль” (2015)-ийн 8.1 дэх заалтад нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн нутаг дэвсгэр дэх захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулна, мөн хуулийн 11-д тухайн орон нутгийн ИТХ, Төлөөлөгч хүсэлт гаргасан, тухайн асуудал эрхэлсэн Байнгын хороо шийдвэр гаргасан тохиолдолд Улсын Их Хурал, Засгийн газар тодорхой асуудлаар тухайн асуудалтай холбоотой газар нутагт очиж орон нутгийн сонсгол зохион байгуулна гэж заажээ.

Сайн туршлага⁹. ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс 1992-2015 оны хугацаанд 3178 тогтоол батлан гаргажээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоолуудын хэрэгжилт амьдрал дээр ямар байгаа, ард иргэдэд үр өгөөж нь хэрхэн хүрч байгаа болон тэдгээрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах

⁹ УИХ-ын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төсөл (2013-2016). Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. “Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал: Сум дундын эмнэлэгийн үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавих нь”. УБ. 2016. 129 дэх талд.

арга хэмжээг тодорхойлох зорилгоор тус аймгийн ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, ажлын албаны бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан 20 сум, 104 багийн хүрээнд батлан гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, иргэдэд өгч буй үр өгөөжийг тодорхойлохын тулд сум багийн нийт 1000 гаруй иргэнээс 8 бүлэг, 46 асуулт бүхий санал асуулгыг явуулжээ.

Тус ажлын үр дүнд хэрэгжилт удаашралтай байгаа хууль, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авахаар төлөвлөсөн байна. Эерэг үр дүн нь хууль, тогтоол, шийдвэр хэрэгжиж байгаа байдалд иргэдээс саналаа илэрхийлэх бодит нөхцөл бүрдсэн, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагуудыг оролцуулах боломж бүрдсэн байна.

Эх сурвалж: hural.mn/Иргэдийн Төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас/

2015 онд баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”-ийн 14.6-д “Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх...” гэж заажээ.

1.2. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

1.2.1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ХЭЛБЭРҮҮД

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь байнгын ажиллагаатай байгууллага юм. ИТХ нь үйл ажиллагаагаа дор дурдсан зохион байгуулалтын 5 хэлбэрийг ашиглан явуулна. Эдгээр нь ИТХ-ын шийдвэрийг иргэдийн эрх ашигт нийцсэн, хэрэгжих үндэслэлтэй байлгахад чиглэсэн.



Зураг 1.5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр

1) ИТХ-ын хуралдаан

Хуралдаан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэр юм. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа, баг, хорооны Хурлын хуралдааныг жилд

З-аас доошгүй удаа тус тус хуралдуулна.” гэж хуульчлан заажээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хамтын шийдвэр гаргадаг этгээдийн хувьд хуралдах нь түүний шийдвэрээ гаргах үндсэн арга бөгөөд нийт төлөөлөгчийн олонх нь хуралдаанд оролцоноор хүчин төгөлдөр болж (өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах хууль ёсны бүрэлдэхүүн бүрдэж) шийдвэрээ гаргадаг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг хэн нэгэн этгээд, түүний дотор ИТХ-ын дарга, төлөөлөгч дангаараа буюу хэсэг бүлгээрээ төлөөлөн гаргах эрхгүй бөгөөд хуулийн дагуу иргэдээс сонгогдсон бүрэлдэхүүн хуралдаж байж сая шийдвэр гаргах эрх нь үүсдэг.

Хуралдаанаар тухайн Хурлын эрх хэмжээнд хамаарах бүхий л асуудлыг, түүний дотор тухайн Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг ч хэлэлцэн шийдвэрлэж болно. Хурлын эрх хэмжээнд хамаарах бүхий л асуудал гэдэгт хуулиар заасан Хурлын бүрэн эрхээс гадна хуулиар хориглоогүй болон бусад байгууллага, албан тушаалтны бүрэн эрхэд хамааруулсан асуудлаас бусад асуудлыг ойлгоно.

Тэргүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарах асуудал нь ч тухайн Хурлын хуралдаанаар хэлэлцэж болох асуудалд хамаарна. Учир нь Тэргүүлэгчид нь зөвхөн Хурлын хуралдааны чөлөө цагт бүрэн эрхээ хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг гүйцэтгэдэгт оршино. Тэргүүлэгчид шаардлагатай гэж үзвэл хэлэлцсэн ямар ч асуудлаа Хуралдаанд оруулан хэлэлцүүлж болно.

23.1.Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

23.3.Төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүйн шаардсанаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ээлжит бус хуралдаан хуралдуулж болно.

23.7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын хуралдаанд тухайн Хурлын нийт төлөөлөгчийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.

23.10.Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл

Хуралдааныг ИТХ-ын дарга удирдан явуулна. Хурлын даргын эзгүйд Тэргүүлэгчдийн аль нэг нь удирдан явуулахаар хуульд заасан. Харин чухам аль Тэргүүлэгч удирдах учиртайг Хурал өөрөө тогтоох учиртай. “Өөрөө” гэсний учир нь хуулиар бус, нутгийн өөрөө удирдах байгууллага журамлан зохицуулах нь зүйтэй гэсэн үг. Хэрхэн зохицуулах нь тухайн Хурлын өөрийнх нь асуудал мөн боловч хуулийн хүрээнд зохицуулах хэд хэдэн боломж байгааг энд дурдах нь зүйтэй. Нэгд, Хурлын даргын эзгүйд хуралдааныг зохион байгуулах нь тодорхой болбол түүний урьдчилан санал болгосноор Тэргүүлэгчдийн хуралдаанаар урьдчилан хэлэлцэж, аль нэг Тэргүүлэгчийг хуралдаан даргалуулахаар томилж байхаар тогтоож болно. Хоёрт, Хурлын дарга хүрэлцэн ирээгүй тохиолдолд хуралдааны эхэнд аль нэг Тэргүүлэгчийг хуралдаан даргалуулахаар нийт төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар сонгож байхаар тогтоож болно.

59.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн хурлын чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйл

23.6. Анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь, бусад хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон төлөөлөгчдийн аль нэг нь нээж удирдана.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл

Анхдугаар хуралдааныг хуульд зааснаар ИТХ-ын тухайн хуралдаанд оролцож байгаа, шинээр сонгогдсон нийт төлөөлөгчдийн хамгийн ахмад нь даргална. Зарим аймаг, сум, дүүрэгт Хурлын даргаа сонгосны дараа шинээр сонгогдсон дарга нь анхдугаар хуралдааныг даргалж байсан нь хууль зөрчсөн хэрэг юм. “Хуралдааныг даргална” хэмээх үүрэг нь хамтын шийдвэр гаргадаг байгууллагын хувьд онцгой үүрэг бөгөөд юуны өмнө шийдвэр гаргах үйл явцыг хууль болон холбогдох бусад эрхийн акт (тухайлбал, Хуралдааны дэг)-ын хүрээнд удирдан явуулах, хэлэлцүүлэг, санал хураалтыг удирдах, хуралдааны дэг сахиулах ажил үүнд хамаарна. Энд “даргалах” хэмээх үүрэгт “өмнөөс нь шийдвэр гаргах” асуудал огт хамаарахгүй. Хуралдааны үед хууль дээдлэн, цөөнхийг сонсож, зарчимч, шударга хандах ёстой. Анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй Хурлын тэргүүлэгчид зарлана. Ээлжит болон ээлжит бус хуралдааныг тухайн Хурлын тэргүүлэгчид хуралдаан эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна. Ээлжит бус хуралдааныг Төлөөлөгчдийн гуравны хоёрын шаардснаар, эсвэл тэргүүлэгчдийн шийдвэрээр хуралдуулна. Анхдугаар хуралдаан нь Хурлын тэргүүлэгчид, даргыг сонгоно. Хэрвээ сонгууль болсноос хойш 50 хоногийн дотор анхдугаар хуралдаан хуралдуулж, ИТХ-ын дарга сонгож, засаг даргад нэр дэвшүүлж чадаагүй бол тухайн ИТХ-ын тарсанд тооцож, дахин сонгууль явуулна. Ийм тохиолдол нь ИТХ-д олонх байхгүй эсвэл олонх хагарснаас зөвшилцөлд хүрч чадаагүйгээс болдог. Ингэх нь орон нутгийн амьдралд сөрөг нөлөөтэй байдаг.

Баг, хорооны иргэдийн Нийтийн хурал

Баг, хорооны иргэдийн Нийтийн хурал нь иргэдийн сайн дурын үндсэн дээр нийтээрээ чөлөөтэй оролцох зарчмаар явагддаг.

23.10. Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

23.11. Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах буюу огцрох тухай хүсэлтийг нь хэлэлцэх тохиолдолд аймгийн төвийнхөөс бусад сумын багийн Хуралд багийн нийт өрхийн 50-иас доошгүй хувийн төлөөлөл оролцсон бол хүчинтэйд тооцно.

23.12. Баг, хорооны Хурлын хуралдааныг хэсэгчлэн зохион байгуулж болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл

Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлыг жилд гурваас доошгүй удаа хийж тэгж хуульд заасан боловч ажлын шаардлага, дээд шатны Хурлын удирдлага, чиглэл, Засаг даргын санаачлагаар ээлжит бус хурлыг хэдэн ч удаа хийж болох юм.

Хурал хийх тов, хэлэлцэх асуудлыг Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэн, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын зарыг нийт иргэддээ бүрэн хүргэхэд ИТХ-ын Тэргүүлэгчид анхаарах хэрэгтэй. Баг хорооны Хурлын Тэргүүлэгчдийг 3-5 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

Жишээ 4. ИТХ-ын даргын эзгүйд Тэргүүлэгчдийн хуралдааныг хэн удирдах вэ? Гаргасан шийдвэрийг хэрхэн ёсчлох вэ?

Шийдвэрлэх арга зам: “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 23.6 дахь заалтанд “Анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь, бусад хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон төлөөлөгчдийн аль нэг нь нээж удирдана” гэж заасан. Практик дээр ийм тохиолдолд Хурлын даргын санал болгосон нэг Тэргүүлэгч хуралдааныг удирдан явуулж, шийдвэрийг ёсчилж баталгаажуулахдаа ИТХ-ын дарга өөрөө гарын үсэг зурж баталгаажуулж байгаа. Гэхдээ ийм асуудлыг ИТХ-ууд хуульд заасан хэм хэмжээнд нийцүүлэн ИТХ-ынхаа дүрэм эсвэл ИТХ-ын хуралдааны дэгээр зохицуулаад явах боломжтой.

1) ИТХ-ын ажлын алба

ИТХ-ын ажлын алба нь ИТХ-ын өдөр тутмын үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж, хэвийн явагдах нөхцөлийг хангах үүрэг бүхий ИТХ-ын бүтцийн байнгын нэгж юм. Өмнө дурдсан зохион байгуулалтын үндсэн 5 хэлбэрээс ялгарах гол шинж нь ажлын алба бол ИТХ-ын туслах нэгж бөгөөд төлөөлөгч биш мэргэжлийн албан хаагчдаас бүрддэгт оршино. Ажлын албаны үндсэн чиг үүрэгт:

- ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах, дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах;
- ИТХ-ын төсөв санхүүг захиран зарцуулах;
- ИТХ-ын шийдвэрийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудалтай холбоотой асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, хууль эрх зүйн лавлагаа гаргах, нийгэм, эдийн засгийн тооцоо гаргах;
- ИТХ-ын архив, албан хэргийг хөтлөн явуулах;
- ИТХ-ын шийдвэрийг түгээх, сурталчлах, нийтэд мэдээлэх, хэрэгжилтийг тооцох ажлыг зохион байгуулах;
- ИТХ-ын нэрийн өмнөөс байгууллага, албан тушаалтан, иргэдтэй харилцах, мэдээлэл түгээх, цуглуулах, боловсруулалт хийх;
- ИТХ-д хуулиар ногдуулсан бусад үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Иргэдийн санаа бодлыг судлах ажлыг зохион байгуулах, тэдгээрийг нэгтгэн боловсруулах, ИТХ ба Тэргүүлэгчдэд дүнг танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулах зэрэг ажил хамаарна.

ИТХ-ын ажлын албаны (ялангуяа сумдын ИТХ-ын ажлын албадын) бүтэц, орон тоо нь дээр дурдсан ажил үүргийг гүйцэтгэх боломж нөхцөлийг хангасан байх ёстой.

16.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал төсөвтэй байх бөгөөд түүнийг Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна.

20.3. Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Тэргүүлэгчид өөрөө тогтооно.

20.4. Ажлын албаны дарга нь тухайн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйл

Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэхийн тулд ИТХ-ын ажлын албадыг бэхжүүлж чадавхжуулах нь тун чухал билээ. Ялангуяа, ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа төлөөлөгчдийн нутгийн өөрөө удирдах ёсны талаарх мэдлэг чадвар, туршлага хомс, үүний зэрэгцээ идэвх оролцоо сулхан байгаа өнөө үед ажлын албад нь зохих орон тоотой, мэдлэг чадвартай байх нь чухал юм.

2) ИТХ-ын тэргүүлэгчид

Тэргүүлэгчид нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг тодорхой хугацаанд (Хурлын хуралдааны чөлөө цагт) гүйцэтгэдэг, тухайн ИТХ-ын бүрэлдэхүүнээс нь сонгогддог, бие даасан шийдвэр гаргах эрх бүхий этгээд бөгөөд Тэргүүлэгчдийн үндсэн чиг үүрэг нь ИТХ-ыг удирдах гэхээсээ илүү байнгын тасралтгүй ажиллагааг нь хангах явдал юм.

ИТХ-ын Тэргүүлэгчдийг түүний удирдах бүрэлдэхүүн хэмээн ойлгох нь түгээмэл байдаг. Энэ нь ИТХ-ын төлөөлөгчид, улмаар ИТХ-ын өөрийнх нь ач холбогдлыг бууруулж, цөөхөн хүн нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөн шийдвэр гаргахад хүргэнэ. Иргэдийн оролцоо бага, сонгогдсон төлөөлөгчдийн идэвх сул, чадавх доогуур гэж яригдаж байгаа өнөө үед ИТХ-ын үйл ажиллагаанд илүү цаг заваа зориулах, илүү идэвхтэй, чадавх өндөр төлөөлөгчдийг Тэргүүлэгчдээр сонгон ажиллуулах нь нутгийн өөрөө удирдах ёсны төлөвшилд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Тэргүүлэгчдэд хэдийгээр ИТХ-ыг удирдах үүрэг байхгүй ч хамгийн зохион байгуулалттай, идэвхтэй хэсэг нь байж, нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэхэд манлайлагч байх учиртай. Тэргүүлэгчид нь иргэдийн санаа бодлыг сонсох, ИТХ-ын шийдвэрийг иргэдэд сурталчлах, орон нутгийн хэмжээний бодлого боловсруулах зэрэг ажилд тэргүүлэн оролцож, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах гол хүч болдог билээ.

3) Хороо

Хороо нь ИТХ-ын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах дотоод зохион байгуулалтын нэг хэлбэр юм. Хороо нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хурлаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрийн төсөлд санал өгөх, эрхлэх асуудлаараа иргэдийн санаа бодлыг судалж хэлэлцэх, дүгнэлт гаргах, тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зэргээр

ИТХ-ын шийдвэрийг үндэслэлтэй, хэрэгжих магадлалтай гаргахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг эрхлэн явуулна.

21.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хороог байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл

Жишээ 5.

Хороог байгуулахдаа уг хороонд хэдий хэр өргөн хүрээтэй асуудал хариуцуулж байгааг нягтлан харах нь зүйтэй. Хэт их өргөн хүрээтэй асуудал хариуцан авсан хороо нь идэвхтэй ажиллахын оронд “нуугдмал” байдалд шилжин орох нь элбэг байгаа талаар Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын ИТХ-ын дарга О.Мандахбаяр судалгаандаа дурджээ.

ИТХ нь бүрэн эрхийнхээ хугацааны эхэнд үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож, тэр чиглэлээрээ хороод байгуулан ажиллана. Хороодын тоо, нэг хорооны гишүүний тоо хэд байхыг ИТХ өөрөө тогтоох бөгөөд нийт төлөөлөгчөө тэнцүү хуваан 4-5 хороотой болгон зохион байгуулж байгаа өнөөгийн нийтлэг практикаас зайлсхийж, нэг төлөөлөгч хэд хэдэн хорооны гишүүн байж болохоор зохион байгуулах боломж бий. Ингэснээр хороодын үйл ажиллагааны уялдаа сайжрах ба хороодын дунд хариуцан ажиллах асуудлын давхцал, хийдэгдэл гарахгүй байх магадлал нэмэгдэх юм. Мөн хороо бүрт намын бүлэг бүрийн төлөөлөл орох боломжтой болно.

Сайн туршлага. Хан-уул дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, VI хорооны ИНХ-ын дарга О.Батхуягтай хийсэн ярилцлагаас

Асуулт: Та Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарын зөвлөлийг ахлан ажилладаг. Энэ санаачилга тань шинэлэг санаа байна. Энэ талаараа дурьдвал?

Хариулт: Хан-Уул дүүрэгт 2008 онд ИНХ-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор ИНХ-ын дарга нарын зөвлөл гэдгийг анх удаа байгуулсан. Бүх хороодын ИНХ-ын дарга нар болон Тэргүүлэгчид хамаардаг. Тус зөвлөл нь өөрийн гэсэн зорилго, зорилтыг жилийн эхэнд дэвшүүлэн ажиллаж, өөрийн чиг үүрэг, дүрэм журамтайгаар ажиллаад явж байгаа. Тус ИНХ-ын дарга нарын зөвлөл байгуулагдсанаараа Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хороодод тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэж болохоор асуудлын талаарх саналаа ИТХ-д оруулах, ингэснээр асуудал түргэн шуурхай шийдвэрлэх боломж бүрдэж байгаа. Өөрөөр хэлбэл, олон үйл ажиллагааг эмх цэгцтэй, уялдаатай болгож байгаа. 2012 онд бүрэлдэхүүн шинэчлэгдэж, дараах санал, санаачилгуудыг ИТХ-д оруулан шийдвэрлүүлсэн. Тухайлбал:

- хороо бүрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн зардлыг шийдвэрлэж, хороо бүрт 10-аас доошгүй иргэнийг урамшуулалт эргүүлээр

- тодорхой хугацаагаар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллуулсан;
- хороо бүртээ Иргэний танхимтай болох тухай асуудлыг ИНХ-ын дарга нарын зөвлөл санал оруулж, дэмжигдэн орон тооны ажилтантай болж, тэдний цалингийн санг дүүргийн ИТХ-ын төсөвт суулгасан;
 - ИНХ-ын дарга нарын зөвлөл байгуулагдсанаараа сургалтын чиглэлд анхаарч, ИНХ-ын дарга нар мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх, туршлага солилцох, сайн туршлагатай хорооныхоо үйл ажиллагаанаас суралцах болсон. Жишээ нь, архив албан хэрэг хөтлөлт, захирамжлалын бичиг баримтын стандарт зэргийг бусад хороо нь суралцдаг, энэ нь нийслэл, бусад дүүргийн ИНХ-ын үйл ажиллагаатай танилцах, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, төрөл бүрийн сургалт хийж байгаа нь ач холбогдолтой байгаа. Бусад дүүрэг манай энэ зөвлөлийг маш их дэмжиж байгаа. Бие биеэ мэддэг, эрх ашгийг нь хамгаалдаг зөв зохион байгуулалтад орсныг дэмжиж байгаа.

Эх сурвалж: hural.mn/иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас

Зайлшгүй байх хороодод төсөв санхүүгийн, нутгийн захиргааны асуудал эрхэлсэн хороодыг нэрлэж болох ба харин нийгмийн бодлогын болон хөдөө аж ахуйн бодлогын асуудлаар тус тус хэд хэдэн хороо байгуулж болох юм. Тухайлбал, тухайн ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд тэргүүлэх чиглэлээ тодорхойлохдоо нийгмийн халамжийн асуудлаар эсвэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гэх мэтчилэн нийгмийн бодлогын тодорхой асуудлаар дагнасан хороо байгуулж ажиллуулж болох юм.

Түүнчлэн хороог заавал Тэргүүлэгчдийн хэн нэгнээр удирдуулах бус, харин өөр нэг төлөөлөгчөөр удирдуулж, Тэргүүлэгчид нь бусад төлөөлөгчдийн хамтаар хорооны үйл ажиллагаанд оролцдог байвал Тэргүүлэгчдээс гадна хороодын дарга нар ч гэсэн бас нэгэн идэвхтэй оролцоотой төлөөлөгчид байх болно. Хорооны эрх хэмжээ, ажиллах хэлбэр, хүлээх хариуцлагыг ИТХ өөрийн эрх хэмжээний хүрээнд бие даан тогтооно.

Жишээ 6. Хэнтий аймгийн ИТХ-ын бодлогын Хороодын үйл ажиллагаа

ИТХ болон Засаг даргын үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Хурлын байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгожиргэдийн санал бодлыг Хурлын шийдвэрт тусгах, төлөөллийн чиг үүргийг нь хэрэгжүүлэх зорилгоор Хэнтий аймгийн ИТХ нь Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн, Нийгмийн хөгжил, хүн ам зүйн, Төрийн байгуулалт, хууль зүйн, Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн, Иргэдийн өргөдөл, гомдол, Иргэний танхимын, Авилга, ёс зүйн, Хяналт шинжилгээ, сургалт судалгааны хороо гэсэн 7 бодлогын хороо байгуулан үр дүнтэй ажиллуулж байна. Хороод нь хариуцсан чиглэлээр шийдвэрлэх шаардлагатай, тулгамдсан асуудлыг иргэд, олон нийт, холбогдох байгууллагын оролцоотой судалж боловсруулах, шалгаж танилцах, үнэлэлт дүгнэлт гаргах, ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал боловсруулж хэлэлцүүлэх, гаргасан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг тооцох зэрэгт ахиц гарсан.

Эх сурвалж : hural.mn/иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас

Хороо нь эрхэлж байгаа асуудлынхаа хүрээнд иргэдийн санаа бодлыг судлах, ИТХ-аар хэлэлцэх асуудлын талаар саналаа гаргах, холбогдох бичиг баримтыг боловсруулах, түүний хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн үндэслэлийг судлах, байгууллага, албан тушаалтны (түүний дотор тухайн нэгжийн Засаг даргын) үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, батлагдсан шийдвэрийг сурталчлах, тайлбарлан таниулах, хэрэгжилтийг нь тооцох, нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Мөн ИТХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн асуудлыг өөрийн эрхлэх асуудлын хэмжээнд хэлэлцэж, санал дүгнэлтээ гаргана. Хорооны шийдвэр нь бие даасан шийдвэр биш бөгөөд уг асуудлаар ИТХ шийдвэрээ гаргаж байж сая албан ёсны болох юм.

21.3. Хороо тухайн Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл

4) Түр хороо

Түр хороо нь тодорхой асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулах, Хурлын нэрийн өмнөөс иргэдийн санаа бодлыг судлах, тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хянан шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг хугацаатай ажил үүргийг шуурхай гүйцэтгэж болно.

21.4. Хурал нь цаг үеийн асуудлыг судлах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дугаар зүйл

Түр хорооны бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журам, гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг ИТХ тогтооно.

21.5. Хорооны тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн Хороо болон түр хороо, ажлын хэсэг байгуулах, түр хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг Хурал өөрөө тогтооно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дугаар зүйл

Түр хороо нь гүйцэтгэж буй үүргийнхээ хүрээнд гаргах шийдвэр нь ИТХ-ын шийдвэрийн төсөл, шийдвэрийн төсөлд гаргасан санал дүгнэлт, шийдвэрийн хэрэгжилт, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт, дүгнэлт байна. Гэхдээ энэ нь ИТХ-аар хэлэлцсэний дараа баталгаажиж, албан ёсны шийдвэр болох учиртай. Өөрөөр хэлбэл, түр хороо нь бие даан шийдвэр гаргахгүй, харин ИТХ-ын шийдвэрийн үндэслэлийг боловсруулах юм. Түр хороог аливаа ажлын хэсгээс ялган авч үзэх нь чухал. Түр хороо нь Хурлын албан ёсны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эрхлэн явуулах үйл ажиллагаа нь Хурлаас олгосон бүрэн эрхээр баталгаажин хэрэгжих учиртай.

5) Намын бүлэг

Намын бүлэг нь ИТХ-д төлөөлөлтэй улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлалын хүрээнд тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар саналаа илэрхийлэх боломж олгож байгаа, ИТХ-ын үйл ажиллагааны нэг хэлбэр юм.

Намын бүлгийн бүрэлдэхүүн, түүний ажиллах хэлбэр, нам, эвслийн бүлгээс ИТХ-ын хуралдаанд саналаа гаргах журмыг ИТХ өөрийн онцлогийг харгалзан бие даан тогтоох нь зүйтэй. Нам, эвслийн бүлэг нь тодорхой албан тушаалтан (ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Засаг дарга)-ыг томилох, сонгох, чөлөөлөх, огцруулах, түүнчлэн тухайн нэгжийн төсөв, түүний гүйцэтгэл, нутгийн хөгжлийн бодлого, газар эзэмших, өмчлөх, байгалийн баялаг ашиглах, олборлох зэрэг чухал ач холбогдолтой, нутгийн иргэдийн язгуур эрх ашигтай шууд холбоотой асуудлуудад саналаа нам, эвслийн бүлгийн хуралдаанаараа хэлэлцэн дүгнэлтээ нэгтгэн оруулж, ИТХ-аар хэлэлцүүлэх боломжтой. Харин асуудал бүрээр нам, эвслийн бүлэг бүр саналаа илэрхийлэх албагүй бөгөөд саналаа гаргахдаа юуны өмнө намын бус, харин нутгийн иргэдийн нийтлэг эрх ашгийг эн тэргүүнд харгалзах нь зүйтэй.

Өнөөдөр улс төрийн намууд нутгийн өөрөө удирдах байгууллагыг сэргөлдөх талбар болгох хандлага байгаа болохоор нам, эвслийн бүлэг нь ИТХ-ын үйл ажиллагааг дэмжих бус, зарим үед гацаахад хүргэх тохиолдол аймгийн ч, сумын ч түвшинд удаа дараа гарч байсныг энд тэмдэглэх нь зүйтэй.

Жишээ 7. *Аймаг, сумын ИТХ-ууд намын бүлэгтэй байна гэсэн ямар заалт байна вэ? Гэтэл “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 26.2-т “... аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг ... нэр дэвшүүлэх эрхтэй...” гэжээ.*

Зарим тохиолдолд хуулийн төсөөтэй заалтуудад нийцүүлэн асуудлыг шийдвэрлэх явдал бий. Шинээр сонгогдсон аймаг, сум, дүүргийн ИТХ-ын Анхдугаар хуралдаанаар 8 ба түүнээс дээш суудал авсан нам бүлэг байгуулсан шийдвэрээ тухайн хуралдаанд танилцуулж шийдвэрээ хуралдаан даргалагчид хүргүүлэн Анхдугаар хуралдааны шийдвэр гаргуулах явдал түгээмэл байна (жишээ нь: Улсын Их Хурлын тухай хуулийн 26.4 дэх заалт).

Шийдвэрлэх арга зам:

ИТХ-ууд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн өөрийн хуралдааны дэгийг баталдаг. Дэгэндээ энэ асуудлыг тусган ИТХ өөрөө шийдвэрлэх боломжтой. Жишээ нь, Төв, Баянхонгор аймгийн ИТХ, зарим сумдын ИТХ-ууд “Дүрэм”-дээ энэ талаар тодорхой заалт оруулж хичнээн суудал авсан тохиолдолд нам бүлэг байгуулах эрхтэй байх, намын бүлгүүд хэрхэн ажиллах талаар нарийн зохицуулалт хийжээ.

Монгол Улсад нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэхэд улс төрийн намуудын гүйцэтгэсэн үүргийг үгүйсгээгүй ч намууд ИТХ-ын үйл ажиллагаанд голлох үүрэгтэй оролцохдоо зөвхөн өөрсдийн эрх ашгийн үүднээс асуудалд ханддаг нь нутгийн өөрөө удирдах ёсны хөгжилд чөдөр тушаа болж байгаа цөөнгүй тохиолдол бий. Иймд ИТХ зөвхөн хуулийн хүрээнд, хууль дээдэлж ажиллахыг үйл ажиллагаандаа хэвшил болгох нь чухал ач холбогдолтой.

1.2.2. ХУРАЛДААНЫ ДЭГ

23.14. Хуралдааныхаа дэгийг тухайн Хурал өөрөө тогтоож тогтоолоор батална.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл

Хуралдааныг хуулиар тогтоосон хэм хэмжээний хүрээнд, тухайн Хурлаас тогтоосон “Хуралдааны дэг”-ээр зохион байгуулна. Хуралдааны дэг нь хуралдааны үед үүсэх эрх зүйн харилцааг зохицуулах баримт бичиг юм. Хуралдааны дэгийг өөрийн онцлогийг тусган тухайн Хурал өөрөө тогтоож мөрдөнө. Дэг боловсруулахдаа хуулийн заалтыг хуулж бичих бус, харин тухайн хуулийн хүрээнд дэлгэрүүлж, тодорхой болгох замаар хуралдааныг аливаа саадгүй явуулах боломжийг бүрдүүлэхэд анхаарах учиртай. Өөрөөр хэлбэл, дэг нь ямагт асуудлыг шийдэх зөв гарц байх ёстой. ИТХ-ын хуралдааны, анхдугаар хуралдааны, Тэргүүлэгчдийн хуралдааны болон баг, хорооны иргэдийн Нийтийн хуралдааны дэг гэх мэтчилэн олон төрлийн дэгийг боловсруулан мөрдөж ажилладаг. ИТХ-ын хуралдааны дэгийг шаардлагатай гэж үзвэл тухай бүр нь засвар оруулан сайжруулаад байх боломжтой бичиг баримт юм. Гэвч дэгийг тухайн тодорхой нөхцөл байдалд тохируулан олон дахин өөрчилж болохгүй. Тэгвэл дэггүй байсантай ижил болно. Тийм учраас дэгийг анхлан их сайн боловсруулах нь зүйтэй. Тиймээс хуралдааны дэг нь төлөөлөгчид болон тэргүүлэгчдийн эрхийн баталгаа, түүнийг хэрэгжүүлэх тулгуур болохын хувьд аль болох тогтвортой, тодорхой байх шаардлагатай.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасанчлан хуралдааны процессын зарим асуудлыг түүний жишгээр хуралдааны дэгдээ тусгах нь илүү ач холбогдолтой гэж үзэж байна.

Жишээ нь, Улсын төсвийн төслийг Улсын Их Хурал дөрвөн удаагийн хэлэлцүүлэг хийж, бүх Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, нам, эвслийн бүлгүүд хуралдаанаараа хэлэлцэж, дүгнэлтээ гаргаж, баталдаг. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар төсөв хэлэлцэхдээ дээрх жишгийг харгалзан үзэх хэрэгтэй юм. Тухайн засаг захиргааны нэгжийн жил бүрийн төсөв, төсвийн тодотгол зэрэг асуудлыг хэлэлцэхэд холбогдох материалыг төлөөлөгчдөд Хуралдааны өмнө танилцаж, дүгнэлт гаргах цаг, боломж өгөхгүйгээр хэлэлцдэг, Засаг дарга, түүний Тамгын газрынхан “дээрээс ирсэн төсвийн төслийг өөрчлөх ямар ч боломжгүй, энэ байгаагаар нь баталж өг” гэсэн шаардлагыг тавьж, зарим төлөөлөгч өөрийнхээ үйл ажиллагаанд хэдэн төгрөг зарцуулагдахаар төсөвлөснийг ч бараг мэдэхгүй төсвийг баталж байна.

Иймд тухайн жилийн төсвийг хэлэлцэн батлах, төсөвт тодотгол хийх, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх дэгийг ИТХ-ын хуралдааны дэгэд тусгай бүлэг болгон оруулж, төсвийг 2-3 хэлэлцүүлгээр хэлэлцэж баталдаг тогтолцоонд шилжин, асуудалд бодитой, анхааралтай хандах шаардлагатай байна.

Эх сурвалж: Тунгаамал төв, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батлах зарим журам, дүрмийн төслүүд, УБ.2016,11 талд

1) Хуралдааны дэгийн зохицуулалт

Хуралдааны дэгээр доор дурдсан асуудлыг зохицуулна. Үүнд:

Хуралдааныг нээх: Хуралдааныг нээх ажиллагаанд хуралдааныг албан ёсоор нээж байгааг мэдэгдэх, хуралдаан хүчинтэй эсэхийг буюу хуралдаанд ирвэл зохих нийт төлөөлөгчдийн ердийн олонх буюу талаас илүү хувь нь хүрэлцэн ирсэн эсэхийг тогтоож мэдээлэх; хэлэлцэхээр товлосон асуудлуудыг танилцуулах, батлуулах зэрэг хамаарна. Мөн хуралдаанд урилгаар оролцож байгаа албан тушаалтнууд, холбогдох хүмүүсийг танилцуулах, тэдгээрийн үг хэлэх, асуултад хариулах зэрэг эрх, үүргийг тодорхой заана.

Хуралдааны дотоод журам: Хуралдааны байрт тавих шаардлага; хуралдааны үед үг хэлэх, асуулт асуух, завсарлага авах журам, хугацаа, нэг асуудлаас завсарлага авбал ямар хугацаатай байх, дараагийн асуудлыг хэлэлцэхэд оролцох эсэх, хуралдааны хугацааг сунгах журам; хуралдааны үед сахиулах дэг журам, ноогдуулах хариуцлагын хэм хэмжээ зэрэг горимын асуудлууд хамаарна.

Хуралдааны явцын тэмдэглэл хөтлөх: Хуралдааны явцын тэмдэглэл хөтлөх, аудио, видео бичлэг хийх журам, явцын тэмдэглэлийг ашиглах, хадгалах, нийтийн хүртээл болгох асуудлууд хамаарна.

Хуралдааны бичиг баримтыг боловсруулах: Хуралдааны үед хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийн төслийг боловсруулах, төсөлд санал хураалтаар орсон өөрчлөлтийг алдаагүй тусгаж байх ажлын хэсэг ажиллуулах хэрэгцээ гардаг. Энэхүү ажлын хэсгийн бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журам, үүрэг, хариуцлагыг хуралдааны дэгд тусгах нь зүйтэй. Албан хэрэг хөтлөх стандартад үндэслэсэн, нутгийн өөрөө удирдах байгууллагын онцлогийг тусгасан тодорхой журмыг хуралдааны дэгийн зэрэгцээ боловсруулж мөрдөж болно.

Асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах: Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг сонсох, хэлэлцэх горим, шийдвэр гаргахад шаардлагатай саналын хэмжээ ("хуралдаанд оролцсон нийт төлөөлөгчдийн талаас илүү хувь" гэх мэт) зэргийг нарийвчлан тогтоох учиртай. Мөн тухайн нутгийн хувьд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл зарим асуудлыг шийдвэрлэх саналын доод хэмжээг ердийн олонхоор бус, тухайлбал дийлэнх олонхоор (66.7 хувиас дээш) тогтоохыг үгүйсгэхгүй. Энэ нь хуульд харшлахгүй бөгөөд гагцхүү хүчин төгөлдөр мөрдөж буй хуралдааны дэгд заасан байх шаардлагатай.

Асуудлыг хэлэлцэх дарааллыг мөн хуралдааны дэгд зааж өгөх нь зохимжтой. Дараалал нь асуудал тус бүрт ерөнхийдөө адил байх ба асуудлыг санаачлагчаас танилцуулах; асуулт, хариулт; Тэргүүлэгчдийн саналыг сонсох; холбогдох хороодын саналыг сонсох; нам, эвслийн бүлгийн саналыг сонсох; төлөөлөгчдийн саналыг сонсох; тодорхой саналуудаар санал хураах; саналыг тоолж шийдвэрлэх гэсэн ерөнхий дараалалтай байх нь зүйтэй.

25.1. Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл

- *Санал гаргах, санал хураах, тоолох:* Хуралдааны үед төлөөлөгч саналаа гаргах (үг хэлэх буюу бичгээр илэрхийлэх замаар), хэлэлцэж байгаа асуудлаар санал хураах (ил буюу нууц санал хураалт), саналыг тоолох, Тооллогын комисс байгуулах, түүний ажиллах журам зэргийг үүнд хамааруулан тогтооно.
- *Шийдвэрийг ёсчлох:* Хурлын шийдвэрийг батлах, гарсан шийдвэрийн эхийг уншиж сонсгох, хэвлэх, гарын үсэг зурах, тамгалах журам, шийдвэрийн эх хувийн тоо зэргийг үүгээр тогтооно.
- *Хуралдааныг хаах:* Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан хэмээн хуралдаанд оролцож буй нийт төлөөлөгчдийн олонх нь (талаас илүү хувь нь) үзсэн тохиолдолд үүнийг хуралдаан даргалагч албан ёсоор мэдэгдэж хуралдааныг хаана.

25.2.Хурлын болон Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолд Хурлын дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдаан даргалагч тус тус гарын үсэг зурна.

25.4.Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл

Хурал нь өөрийн бүрэн эрхэд нь хамаарах төсөв, санхүү, нийгэм, эдийн засгийн (тухайлбал, төсөв, түүний гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалт, орон нутгийн хөгжлийн хэтийн төлөв), улс төрийн (Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, батлах, үнэлж дүгнэх, Засаг даргатай хариуцлага тооцох) зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх талаар тусгайлан зохицуулалт хийх шаардлагатай юм. Мөн төлөөлөгчийн эрх хэмжээ, хариуцлага, нутаг дэвсгэртээ ажиллах журмыг нарийвчлан боловсруулж мөрдөх учиртай ба үүний зэрэгцээ иргэдийн санаа бодлыг судлах, шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог хангах, иргэд ба ИТХ-ын харилцааг зохицуулах асуудлыг мөн журамлан шийдвэрлэвэл зохино.

ИТХ-ын хуралдааны дэгд дараах нийтлэг асуудлыг анхаарч тусгах нь зүйтэй байна. Үүнд¹⁰:

- Аймаг, нийслэлийн, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгд Хурлын төлөөлөгч, намын бүлэг, Хороо болон дэд хороодоос асуудал санаачлан боловсруулж өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх талаар нарийвчлан зохицуулалт хийх шаардлагатай. Хуралд асуудал санаачлахын өмнө Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Үндсэн чиглэл, жил бүр хийх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөлтэй уялдуулах нь чухал. Мөн Хуралд иргэн, төрийн бус байгууллага, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагаас асуудал оруулахаар санал тавих эрхээ эдлэхийн тулд ямар шаардлагыг хангасан байх, ямар хугацаанд бэлтгэн ирүүлэх талаар нарийн зааж тусгавал Хурлын ажлын албаныханд ч, тухайн асуудал оруулах санал тавихаар бэлтгэж байгаа иргэн болон хуулийн этгээдэд ч хялбар болно.
- Хүндэтгэлийн хуралдаан хийж болох эсэх, хэрвээ хийх шаардлага гарвал хэн,

¹⁰ Тунгаамал төв, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлах зарим журам, дүрмийн төслүүд. “Жишиг хуралдааны дэгийг боловсруулах болсон шалтгаан”.УБ.2016.10 дах талд.

хэзээ зарлаж, хэрхэн яаж хуралдуулах асуудлыг дэгэндээ тусгасан байх ёстой. Одоогоор ийм дэг байхгүй байна.

- Хурлын даргыг ямар хугацаанд эзгүй тохиолдолд (ажлын 7 хоног, 10 хоног гэх мэт) аль нэг тэргүүлэгч гишүүн түүний санал болгосноор хурлын даргын үүргийг түр орлон гүйцэтгэхийг хуралдааны дэгдээ тусгайлан зааж өгөх шаардлагатай. Хугацаа заагаагүй орхисны улмаас нэгэн сумын Хурал дарга нь хуралдаанаа орхиод явсны улмаас бүтэн сар хуралдаанаа хийх боломжгүй, төсвөө баталж чадахгүй байсан тохиолдол гарч байна.
- ИТХ-ын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд Засаг дарга, түүний орлогчид, харьяа газар, хэлтсийн дарга нарыг аль болохоор оруулахгүй байх, тэргүүлэгч гишүүдийг тодорхой хугацаагаар (ротациар) сольж ажиллуулах зэрэг туршлага байдаг. Тэргүүлэгч гишүүн бүрийн ажил, үүргийн хуваарийг гаргах, тодорхой ажлын хороо, байгууллага, сум, хороог хариуцуулах, зохих зардал, урамшуулал олгох зэрэг асуудлыг тодорхой журмаар зохицуулах шаардлагатай. Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэрийг тухай бүр цахим хуудсандаа тавьж, нийт иргэдэд мэдээлдэг байхаар дэгэндээ тусгах хэрэгтэй.
- Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6-д "...хуульд өөрөөр заагаагүй бол асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ." гэж заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааныхаа дэгд тусгайлан зааснаас бусад асуудлыг төлөөлөгчдийн олонхийн саналаар, илээр шийдвэрлэж байхаар тогтох шаардлагатай. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төлөөллийн байгууллага тул иргэдийн оролцооны үндсэн суваг нь өөрийн харьяа нутаг дэвсгэрээс сонгогдсон төлөөлөгч байх учиртай. Нөгөө талаас иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан, бусад үйл ажиллагаа нь иргэдэд ил тод, нээлттэй байх нь оролцооны чухал нөхцөл юм.
- ИТХ жил бүрийн төсвийг хэлэлцэж батлах, төсвийн тодотгол хийх, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж, шийдвэр гаргадаг. Эдгээр асуудлын дарааллыг хуралдааны дэгэндээ маш нарийн тогтоож, хэлэлцүүлгийн үе шатыг нэмэгдүүлэх шаардлагатай.

2014 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал анх удаа нийслэлийн 2015 оны төсвийн төслийг хоёр үе шаттайгаар хэлэлцэн баталжээ. Энэ жишгийг бүх хурлууд үйл ажиллагаандаа нэвтрүүлвэл илүү үр дүнтэй байж болох юм.

- Эрх хэмжээний хүрээнд баримт бичгийн төслийг иргэдэд сурталчилж тэдний саналыг өргөнөөр авах зорилгоор хурал цуглаан зохион байгуулах, хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтээр хэлэлцүүлж болно гэсэн заалт ИТХ-ын хуралдааны дэгд байгаа нь иргэний оролцоог хангахад чиглэсэн сайн туршлага болохуйц зохицуулалт юм. Орон нутгийн төсөв, нийгэм, эдийн засгийн томоохон хөтөлбөр, тулгамдсан нийтлэг асуудлын төслийг боловсруулахдаа иргэдийн саналыг тусгах зорилгоор нээлттэй сонголт, хэлэлцүүлэг зохион байгуулах талаар дэгд тусгах шаардлагатай юм. Энэ нь тухайн шийдвэр гаргагчийн сонирхлоос үл хамааран иргэдийн оролцоог хангах боломжийг бий болгоно. Орон нутгийн удирдлагад нээлттэй сонголт хийх туршлага бага ч зарим сумдад нэг бус хийсэн байна. Нээлттэй сонголыг хэрхэн зохион байгуулах талаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд

заасан бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ жишгээр зохион байгуулж болох юм.

- ИТХ-ын хуралдааны үеэр иргэд чөлөөтэй орж, ажиглах нөхцлийг бүрдүүлэх, хуралдаанд иргэд асуудал оруулж хэлэлцүүлэх эрхийг хангах чиглэлээр хуралдаан эхлээгүй байхад шийдвэрлэх асуудал, мөн шийдвэрийг хэвлэн нийтлэх, холбогдох албан тушаалтан, байгууллагад хүргүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг тооцох, үнэлэх, хяналт тавих, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг бэлтгэх, боловсруулах зэрэг хуралдааны дараа үүсэх асуудлыг тусгайлан журамлан зохицуулах нь зүйтэй. Тэдгээр журамд дараах зүйлийг тусгах. Үүнд:
- Хуралдааны тов, хэлэлцэх асуудал, иргэдийн саналыг хэдийд сонсох, хэзээ санал хураах зэргийг урьдчилж мэдээлж байх талаар;
- Хурлын шийдвэрийн төслийг урьдчилан олон нийтээр хэлэлцүүлж, санал авах арга хэлбэрийн талаар;
- Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж урьдчилж нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, саналын хайрцаг ажиллуулах талаар;
- ИТХ-ын хуралдааны болон Тэргүүлэгчдийн хуралдааны тэмдэглэлтэй сонирхсон иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөгчид танилцах боломжийн талаар;
- Нийтэд зориулсан мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээх талаар;
- ИТХ-ын төлөөлөгч нэг бүрийн хэлсэн үг, санаачилсан шийдвэрийн төслийн талаар, бусад хийсэн ажлын талаарх мэдээллийг цахим хуудсанд оруулж, иргэдтэй шууд харьцдаг боломжоор хангах талаар;
- Шаардлагатай тохиолдолд иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах хэсэг байгуулж ажиллуулах талаар;
- ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийг хэрхэн оролцуулсан, тэдний санал, бодлыг хэрхэн тусгасан талаар ямар хугацаанд тайлагнах талаар тус тус оруулах хэрэгтэй байна.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тодорхой хугацаа зааж тогтоосон асуудлуудыг хэлэлцэхэд нам, эвслийн бүлгүүдээс завсарлага авахыг хориглох зохицуулалтыг тусгах,
- Хурал дахь нам, эвслийн бүлэг тодорхой нэг асуудлаар завсарлага авах тохиолдолд ямар хугацаагаар өгөх, сунгах тохиолдолд ямар хугацаатай байх, нэг асуудлаар завсарлага авсан бол дараалалд байгаа нөгөө асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэх боломжийг нээлттэй байлгах,
- Хурлын төлөөлөгчөөс асуулга, асуулт тавих, түүний хариуг хэрхэн авах талаар тодорхой заах,
- ИТХ-ын Тэргүүлэгчид чуулганы чөлөөт цагт хуралдаж, Хурлын байгууллагын ихэнх шийдвэрийг гаргах эрхтэй. Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоол, хуралдаанаас гарсан шийдвэрийг хэдэн хоногийн дотор албажуулж, цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулах, ямар хугацаанд архивын нэгж болгон шилжүүлэх ёстойг заах,
- ИТХ, Засаг даргын эрх мэдлийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд тухайн Хурал Үндсэн хууль бусад хууль тогтоомж зөрчсөн, эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавихаар хуульчилсан. Хоригийг хэрхэн хэлэлцэх талаар Хуралдааны дэгд нарийн зааж өгөх шаардлагатай юм.

Сайн туршлага. Ховд аймгийн Үенч сумын ИТХ-ын дарга Ш.Отгонбаяртай хийсэн ярилцлагаас

Асуулт: Хурлаас хийсэн өөр шинэлэг үйл ажиллагааныхаа талаар?

Хариулт: Сумдад огт хэрэгжээгүй нэг том ажлыг хийсэн. Энэ бол хүндэтгэлийн хуралдаан. Манайх 2014 оны хотын тэргүүний сумынхаа мялаалгын наадмын баяраа тэмдэглэхдээ Улаанбаатар хотоос ирсэн нутгийн зөвлөлийн хүмүүс, Ховд аймгаас ирсэн нутгийн зөвлөлийн төлөөлөгчдөө оролцуулсан, нээлттэй хүндэтгэлийн хуралдаан хийсэн. Хүндэтгэлийн хуралдаан дээр Үенч сумын өнгөрсөн, өнөөдөр, ирээдүй гэсэн сэдвээр илтгэлүүд тавигдсан. Өнөөдөр бид улсын тэргүүний сум болчихлоо, энэ бол том амжилт боловч цаашид орон нутгаа хэрхэн хөгжүүлэх, хүний амьдрах орчин нөхцөлийг хэрхэн тааламжтайгаар өөрчлөх, Улаанбаатар хот уруу шилжиж нүүгээд байгаа шалтгааныг арилгах асуудал. Халуун, цэвэр устай, нэгдсэн халаалттай ийм орчинд л хүн амьдрахыг хүсч байна, дээр нь амьдралын баталгаатай ажилтай байх. Энэ орчин нөхцөлийг бид яаж бүрдүүлэх вэ гэдэг талаар хүндэтгэлийн хуралдаан зохион байгуулаад, зөвлөмж гарсан.

Эх сурвалж: hural.mn/иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас

1.2.3. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ

Орон нутгийн Хурлын Төлөөлөгч нь юуны өмнө тухайн нутгийн иргэдийг Хуралд төлөөлөх үүрэгтэй. Орон нутгийн хэмжээний бодлого, шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгах, тэдний эрх ашгийг хамгаалах ажлыг төлөөлөх үүргийг гүйцэтгэнэ. Хэдийгээр өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн дагуу төлөөлөгч нь Хуралд улс төрийн тодорхой намаас нэр дэвшиж сонгогдох боловч тэдний үндсэн үүрэг нь аль нэг намыг бус, харин өөрийг нь сонгосон нутгийн иргэдийг төлөөлөх явдал билээ. Төлөөлөгч нь тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугч байхаар заасан нь тухайн нутгийн иргэдийн язгуур эрх ашгийг илэрхийлэгч нь байна гэдгийг тодорхойлж буй хэрэг юм.

ИТХ-ын төлөөлөгч нь хуралд идэвхтэй оролцон, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй. Үүний тулд сонгогдсон тойргийнхоо иргэдтэй байнга уулзаж, хурлын шийдэх гэж байгаа асуудлаар иргэдийн санаа бодол ямар байгааг судалдаг байна. Тэгэхдээ Төлөөлөгч бол иргэдийн санаа бодлыг илэрхийлдэг дамжлага биш. Иргэдийн санаа бодлыг судлан иргэдийн дийлэнхийн сонирхол ямар байгааг ойлгох нь чухал. Үүний дараа уг сонирхлыг хэрэгжүүлэх хамгийн зөв арга замыг эрэлхийлэн саналаа ул үндэстэй боловсруулж тавих хэрэгтэй байдаг. Өөрийн бодлыг сонгогчдын санаа бодол, сонирхол мэтээр ярих, эсвэл цөөн хүний санаа бодолд түшиглэн санал тавих нь зохимжгүй юм. Төлөөлөгч хуралдааны дэгт захирагдан цаг баримтлах, хуралдаанаас хожигдохгүй байх, бусдыг доромжлон гүтгэх хийгээд бусдын үг хэлэх эрхийг хаагдуулан боох үйлдэл хийхгүй байх зэргээр хурлын үйл ажиллагааны хэм хэмжээг сахин ажиллах ёстой.

Төлөөлөгч нь нийтийн эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, үнэнч шударгаар ажиллах үүрэгтэй. Улс төрийн намын харьяаллаар сонгогдон ажиллаж байгаа ч тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн хүлээлгэсэн итгэлийг даасан төлөөлөгч гэдгээ ухамсарлах ёстой. Хурлын үйл ажиллагаанд оролцоходоо зөвшилцлийн зарчмыг баримтлах нь чухал.

Сайн туршлага. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ИТХ-ын төлөөлөгч Н.Эрдэнэсүвдтай хийсэн ярилцлагаас

Асуулт: Нутгийн өөрөө удирдах байгууллагын жаргал, зовлон энэ салбарт тулгамдаж байгаа асуудлыг төлөөлөгч хүний тухайд юу гэж дүгнэж байна вэ?

Хариулт: Иргэдийн төлөөлөгчийн гол мөн чанар нь сонгогдсон тойргийнхоо иргэдийн санал бодлыг тусгасан бодлогын шийдвэр гаргагч юм. Иргэдийн төлөөлөгч хүн сонгосон аймаг, сум, дүүрэг, багийн иргэдийн төлөөлөл болж, тэдний санал бодлыг сонсох, төрийн шийдвэр гаргах түвшинд хүргэх гэх мэтээр иргэний нийгмийн нэгээхэн хэсэг болж ажиллах ёстой. Энэ бол үндсэн үүрэг. Гэхдээ үүний цаана тухайн төлөөлөгч, орон нутгийнхаа бүхий л шатны хөгжилд шууд нөлөөлөх бодлого боловсруулахад оролцогч гэдгээ маш сайн ухамсарлах хэрэгтэй юм. Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нэг ёсондоо багийн менежемент дээр тулгуурласан үйл ажиллагаа. Дөрвөн жилийн үечлэлээр Иргэдийн хурал сонгогдож, төрөл бүрийн ажил мэргэжлийн хүмүүс, дээр хэлсэнчлэн, улс төрийн намаас нэр дэвшин сонгогдож байна. Монгол Улс ардчиллын замыг сонгосон цагаасаа эхлэн төлөөллийн буюу итгэж сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан төрийн үйл хэрэгт оролцож ирсэн. Өөрөөр хэлбэл, УИХ, аймаг, дүүрэг, сумын ИТХ-ыг сонгож байгуулах үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцож, үр дүнд нь илүү итгэдэг гэсэн үг. Энэ нь хэдийгээр дэлхий нийтийн жишиг боловч бас учир дутагдалтай талууд байна. Үүний гол жишээ нь тухайн шатны хурлын шийдвэрээр буюу ялсан намын мөрийн хөтөлбөрийг гол болгосон бодлого барьж ажиллаж, намыг нэгд, өөрөөр хэлбэл, иргэдийн эрх ашиг хоёрдугаарт тавигдаад байгаа явдал юм. Амьдрал дээр тухайн төлөөлөгч маань итгэж сонгосон иргэдээсээ илүү нэр дэвшсэн намаа төлөөлдөг нь нууц биш юм.

Эх сурвалж : hural.mn/иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас

Төлөөлөгч нь тухайн намаас сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн гол зорилтыг иргэдийн нийтлэг эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэхийн төлөө ажиллахаас бус улс төрийн намын явцуу эрх ашгийг хамгаалагч байдлаар ажиллаж болохгүй. Төлөөлөгч нь хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцон, иргэдтэй байнгын холбоотой байж, санаа бодлыг нь сонсох, шийдвэрт тусгуулахаас гадна Хурлын шийдвэрийг таниулан сурталчлах үүрэгтэй. Ингэх нь нэг талаас шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэдийг татан оролцуулах, нөгөө талаас иргэдийнхээ эрх ашгийг зөв илэрхийлж, шийдвэрт тусгасан эсэхийн шалгуур болдог.

Сайн туршлага

2015 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгээр орон нутагт хэрэгжиж байгаа “Иргэдийн оролцоог дэмжих замаар сонгуульд төлөөлөгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” санаачилгын хүрээнд сумын иргэдийн дунд судалгаа явуулжээ. Сумын багуудын иргэдийн дунд явуулсан санал асуулгад оролцсон болон Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаануудад оролцсон иргэдээс зарим төлөөлөгчид идэвхигүй, иргэдээ төлөөлж тэднийхээ эрх ашгийг хамгаалж чаддаггүй, хувийн эрх ашгаа бодож сонгогдсон төлөөлөгчид олон байна, тэдэнтэй хариуцлага тооцдог механизм хэрэгтэй байна гэсэн санал гомдол үргэлж гардаг.

Иймд сумын ИТХ-аас иргэдийн санал дээр үндэслэн “Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн ажлыг иргэдээс үнэлж, дүгнэх журам”-ыг боловсруулан гаргасан байна. ИТХ нь энэхүү журмыг хэрэгжүүлснээр бүх төлөөлөгчид улирал бүр багийн иргэдийн нийтийн хуралд тайлан тавьж, иргэдээр үнэлүүлдэг болж, иргэд маань төлөөлөгчдөө хэн нь хэн бэ гэдгийг танин мэдэх, төлөөлөгчид илүү идэвхитэй ажиллах, сумын хурлаас төлөөлөгчдөө урамшуулах, иргэд сонгуулиар хариуцлага тооцох олон сайн үр дүн гарна гэж хүлээж байгаа юм байна.

Эх сурвалж: hural.mn/Иргэдийн Төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас/

Төлөөлөгчийг хэдийгээр “төлөөлөгч” гэж нэрлэх боловч төлөөлөх үүргийг Хурал бүхэлдээ гүйцэтгэнэ. Учир нь нэг юмуу хэсэг төлөөлөгч иргэдийн нэрийн өмнөөс шийдвэр гаргахгүй. Тийм шийдвэрийг Хурал хүчин төгөлдөр бүхий ирцтэй хуралдаанаараа түүнд оролцогчдын талаас илүү хувийн саналаар гаргана.

Нутгийн иргэдийг төлөөлнө гэх энэхүү хүндтэй үүрэг нь ихээхэн хичээл зүтгэл, идэвх санаачилга шаардлага бөгөөд зүгээр ард түмний нэрийн өмнөөс хоосон ярихыг хэлэхгүй. Бусдыг төлөөлж байгаа хүний хувьд хууль эрх зүйн мэдлэгийн хүрээгээрээ, ухааны цараагаараа илүү байж санан, сэдэгч, гүйцээн бүтээгч, цуцашгүй хөдөлмөрч байх ёстой. ИТХ-ын төлөөлөгч нь бусадтай хэл амаа ололцох, зөв шийдвэр гаргах, нийтэд тустай үйлдлийн төлөө бусдад үлгэрлэх, хэсэг, бүлэгтэй хамтран ажиллах, асуудалд ухаалаг хандах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх учиртай.

Төлөөлөгчид нь улс төрийн намуудаас болон иргэдээс бие даан нэрээ дэвшүүлж шууд сонгуулийн үндсэн дээр тухайн тойргийн иргэдээс 4 жилийн хугацаатай сонгогддог. Төлөөлөгчдийн бүрэн эрх зөвшөөрөгдсөн энэ үеэс өмнөх Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрх дуусгавар болж, шинээр сонгогдсон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ эдэлнэ. Үүнд:

- асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;
- хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал дүгнэлт гаргах, санал хураалгах;
- Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;
- Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Тэргүүлэгчдийг сонгох, хороо байгуулах, тэдгээрт сонгогдох, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргах;
- Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх санал гаргах;
- хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах;
- хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах;
- хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах, шаардлага тавьж биелэлтийг хангуулах;

- сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж, хариуг хуульд заасан хугацаанд авах гэж хуулийн шинэчилсэн найруулгаар эрхийг нь өргөтгөн зааж өгсөн болно.

Өмнө мөрдөгдөж байсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд төлөөлөгчийг чөлөөлөх, огцруулах тухай асуудал тусгагдаагүй байсан нь амьдрал дээр зарим хүндрэл учруулж байсан юм. Хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар зүйлээр энэ асуудлыг зохицуулсан заалтууд нэмэгдэж орсон.

- 13.1.1. нас барсан;
- 13.1.2. хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;
- 13.1.3. хүндээр өвчилсний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;
- 13.1.4. гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан;
- 13.1.5. тухайн орон нутгаас шилжсэн.

*Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,
түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйл*

Нөхөн сонгогдсон Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан төлөөлөгчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна. Хуулийн 14 дүгээр зүйлд “Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа” гэсэн асуудал шинээр нэмэгдэж орсон нь төлөөлөгчийг сонгуульд үүргээ биелүүлэхэд ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална.
- Төлөөлөгчдийн Хурлын ажилд оролцсон байдлыг харгалзан тэдгээрт Тэргүүлэгчид урамшуулал олгож болох бөгөөд хэмжээ, олгох журмыг нь аймаг, нийслэлийн Хурал баталж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгана.
- Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтан бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй.
- Засаг дарга, эрх бүхий бусад албан тушаалтан Хурлын төлөөлөгчийг ажлаас халах, чөлөөлөх, шилжүүлэх, өөрчлөх тохиолдолд саналаа тухайн шатны Хурлын Тэргүүлэгчдэд урьдчилан танилцуулж зөвшилцсөн байна.

Хурлын төлөөлөгч Хурлын байгууллагадаа ажиллахдаа ямар эрх үүрэгтэй ажиллах, ялангуяа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааны өмнөх хэлэлцүүлэг, шалгалтанд оролцох, дээрх хуралдаануудад үг хэлэх, санал гаргах, асуудал оруулах үйл ажиллагааны дэг, журмыг Хурал өөрөө нарийвчлан тогтоож өгөх нь илүү тохиромжтой байгаа юм. Мөн Хурлын ажлын хороо, түр хороо, ажлын хэсэгт ажиллахдаа ямар эрх эдлэх, Засаг дарга, түүний Тамгын газар, харьяа газар, хэлтэс, агентлагууд, нутаг, дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй харьцах, шийдвэр гаргахад оролцох оролцоог тухай бүр нь

нарийвчлан тогтоож өгөх нь одоогийн нөхцөлд илүү үр дүнтэй.

Хурлын төлөөлөгчийг сонгуульт үүргээ гүйцэтгэх үйл ажиллагааны баталгаагаар хангах зайлшгүй шаардлагатай. Үүнд, үндсэн ажлын зэрэгцээгээр сонгуульт үүргээ биелүүлэх боломжоор хангах, төлөөлөгчийн үүргээ биелүүлэхэд нь ямар нэгэн дарамтгүйгээр шаардлагатай материалыг танилцуулах, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шалгах, ИТХ-ын зөвшөөрөлгүйгээр ажил, албан тушаалаас нь өөрчлөхгүй байх, баривчлах, албадан саатуулахгүй байх зэрэг асуудлыг хуульчилсан. Мөн төлөөлөгчийг аливаа ажил зохион байгуулахад шаардагдах төсөв, унаа, томилолтын зардал, урамшуулал олгох, Төрийн мэдээлэл болон бусад шаардлагатай сэтгүүл, гарын авлагаар хангах, сургалт, семинарт оролцуулах, тойрогтоо зохион байгуулах арга хэмжээний зардлыг олгох хэрэгтэй байгаа болно. Дээрх зардлыг Хурлын байгууллагын төсөвт тусгаж батлан, төлөөлөгчдөд олгож ажиллах боломжоор хангах талаар зарим Хурлууд сайн ажиллаж байгаа бөгөөд зарим сумдад энэ асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хүндрэлтэй байна. Харин ИТХ-ын ажлын албанд үндэслэлгүйгээр орон тоо нэмэх зэрэг төсөв, зардлыг хэтрүүлсэн зохисгүй хандлага байж болохгүй.

ИТХ-ын төлөөлөгч дараах зүйлд анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

- Төлөөлөгч нь хуралдаанаар хэлэлцэх асуудалтай урьдчилан сайн танилцаж дүн, шинжилгээ хийх, лавлагаа материал, холбогдох хууль тогтоомжийг судлаж, ажил хэрэгч, бодитой санал гаргахад бэлтгэж байх;
- Төлөөлөгчийн гол үүрэг нь ИТХ-ын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаан, ажлын хэсэг, түр хороонд асуудал санаачилж оруулан шийдвэр гаргуулах явдал юм. Тухайн нэгжийн болон өөрийн сонгогдсон тойргийн хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай ямар ч асуудлыг санаачлан оруулах эрхтэй;
- Хуралдаанаар хэлэлцэх асуудлын чиглэлээр иргэд, сонгогчдын санал бодлыг судлах, өөрийн санал, бодлоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр илэрхийлэх;
- Орон нутгийн эдийн засаг, нийгмийн шаардлагатай асуудлаар холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт тавьж, хариуг авах;
- Эрдэмтэн, судлаачид, мэргэжлийн хүмүүстэй уулзах, ярилцлага хийх, лавлагаа, материалыг ажил хариуцсан хүмүүсээс шаардан олж авах, хуралдаанаар хэлэлцэх асуудалд өөрийн саналаа ажил хэрэгч, ул суурьтай бэлтгэх;
- Хурлын ажлын хороодод эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар санал оруулж хэлэлцүүлэх, Хурлаас зохион байгуулсан сургалт, семинар, уулзалт ярилцлага, бусад арга хэмжээнд идэвхтэй оролцох;
- Хурлын дотоод бүтэц, зохион байгуулалтын ажлыг сайжруулах талаар өөрийн байр сууриа илэрхийлэх;
- Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Засаг даргын Тамгын газар, харъяа болон дэргэдэх газар, хэлтсийн ажил байдалтай танилцах;
- Хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх ажил, хяналт шалгалтын ажилд биечлэн оролцох;
- Төлөөлөгч бүр Хуралдаа буюу тойрогтоо хийж байгаа ажлын талаар цахим хуудсандаа байнга мэдээлж, сонгогчдын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг барагдуулах ажилд онцгой анхаарах;
- Иргэдийн ахуй амьдрал, нийгмийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд илүүтэй анхаарах, Засаг даргын хамааралтай асуудлыг шүүрч авах, зэрэгцэн хөөцөлдөхгүй байх;
- Өөрийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарах, дотоодын хяналтыг зохион байгуулахдаа ажлын хороо, дэд хороо,

- Төлөвлөж байгаа ажил, хийж байгаа ажлынхаа явц, үр дүнгийн талаар иргэд олон түмэнд аль болохоор мэдээлж санал, хүсэлтийг нь авч, гарах шийдвэртээ тусгаж байх;
- Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааныг явуулын байдлаар газар дээр нь очиж хийх, иргэдийг урилгаар оролцуулж байх;
- Засаг даргын Тамгын газар, түүний газар, хэлтэс, албадын ажилтнуудыг хүлээн авч уулзаж, ажиллагсдын санал, хүсэлтийг сонсдог байх;
- Зохион байгуулагдаж байгаа сургалтанд идэвхтэй хамрагдаж, гадаад орны болон бусад аймаг, сум, дүүргийн Хурлын үйл ажиллагааны туршлагаас суралцах;
- Төлөөлөгчид, ажилтнууд, идэвхтэн, сонгуультнууд Хурлын үндсэн үүргийг хэрэгжүүлсэн, нийт иргэдийн санаа сэтгэлд нийцсэн, үлдэцтэй, үр нөлөө бүхий ажлуудыг санаачлан хийх зэргийг дурдаж болно.

1) ИТХ-ын төлөөлөгч сонгогдсон тойрогтоо ажиллах хэлбэрүүд

Хуульд зааснаар ИТХ-ын төлөөлөгч нь хууль, тогтоомж, Хурлын болон Засаг даргын шийдвэрийг иргэдэд цаг алдалгүй сурталчлах, тайлбарлан таниулах үүрэгтэй. Тухайлбал, иргэн шаардлагатай мэдээллийг авсны үндсэн дээр тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах, улсад ажилласан жилээ нөхөн тооцуулах, зээл, тусламж авах, хөнгөлөлт эдлэх, иргэний үүргээ биелүүлэх, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд оролцох зэрэг олон талын ач холбогдолтой. ИТХ-ын төлөөлөгч нь иргэд, сонгогчдын төлөө ажиллахаар тодорхой итгэл хүлээн сонгогдсон хүний хувьд сар болгон тогтсон нэг өдөр иргэдтэй уулздаг цагийн хуваарь гарган хууль сурталчлах ажлаа хийж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг байх хэрэгтэй байна. Төлөөлөгч нь иргэдэд зориулан зарлагдаж байгаа төсөл, хөтөлбөр, зээл, тусламжийн талаар мэдээлэлд онцгой ач холбогдол өгч байхаас гадна өөрсдөө төсөл бичих аргад суралцсан байх, түүнийгээ иргэдэд зааж, туслалцаа үзүүлдэг байх нь үр дүнтэй.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу төлөөлөгч нь сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах үүрэгтэй. Энэ бүх үйл ажиллагааныхаа талаар Төлөөлөгч нэгдсэн бүртгэл хөтөлж, сонгогч иргэдтэй байнгын эргэх холбоотой ажиллавал үр дүнд хүрнэ.

Иргэдийг төлөөлөн, тэдний эрх ашгийг илэрхийлж, бодлого тодорхойлох эрхтэй төлөөлөгчид иргэдтэй ойрхон ажиллах, тэдний санаа бодлыг сонсох, бодлого шийдвэрт тусгах байдал өнөө үед хангалтгүй байна. Төлөөлөгч, сонгогчдын хоорондын харилцаа холбоо сул байгаад ИТХ тэргүүлэгчид, Хурлын ажлын алба, төлөөлөгч нэг бүр анхаарч, ажилдаа өөрчлөлт гаргах шаардлагатай байна. Хурлын төлөөлөгч нь дараах байдлаар ажиллана. Үүнд:

- Төрийн хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах ажлыг тогтмол хугацаанд зохион байгуулж хэвших;
- Улсын Их Хурлын гишүүн, орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчидтэй нэг баг болж, хамтарсан уулзалт, ярилцлага, бусад арга хэмжээг зохион байгуулах, хамтран ажиллах;

- Сонгогдсон тойрогтоо тогтсон хуваарийн дагуу уулзалт хийх, гарсан санал, шүүмжлэл, хүсэлтийг хэрэгжүүлэхэд анхаарч, биелэлтийг дараагийн хурал дээр заавал мэдээлж хэвших, нутаг дэвсгэрийн байгууллага аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай тодорхой хугацаанд танилцаж байх;
- Нийгмийн эмзэг хэсэг, ядуу болон нэн ядуу иргэдийн амьдрал ахуйг анхаарч, тусламж дэмжлэг үзүүлэх талаар холбогдох байгууллага, хүмүүстэй хамтарч ажиллах;
- Иргэдийн тавьсан санал, хүсэлтэд анхааралтай хандаж, шуурхай шийдвэрлэх, тэдний эрх ашигтай холбоотой чухал асуудлыг дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- Сонгогдсон тойрог, дүүрэг, хорооны Хурал, Засаг дарга, ахмадын болон эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, цагдаа, хууль хяналт, төрийн бус байгууллагатай ажил төрлийн холбоотой хамтарч ажиллах;
- Төлөөлөгч нь сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тойргийнхоо иргэдэд мэдээлж, ажлын тайлангаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, намын бүлэгт хүргүүлэх;
- Тухайн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, иргэдийг түүнд хамруулах талаар санаачилга гарган ажиллах;
- Баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын ажлыг идэвхжүүлэхэд анхаарч тусалж ажиллах, иргэдийн нийтийн Хурлын дарга дээр иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах хайрцаг, дэвтрээ төвлөрүүлэн байнгын холбоотой ажиллах;
- Төлөөлөгч бүр өөрийн “нэрэмжит ажил”-ыг тодорхой хугацаанд хийж хэвших;
- Тойргийн иргэдийг шагнаж, урамшуулах, хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх, олныг хамруулсан өдөрлөг, уулзалт, гудамжны, байрны оршин суугчдын, ургийн зэрэг уламжлалт баярын арга хэмжээг зохион байгуулах зэргийг нэрлэж болох юм.

Хурлын Төлөөлөгч нь тухайн нутгийн иргэдийг төлөөлөх үүрэгтэй. Орон нутгийн хэмжээний бодлого, шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгах, тэдний эрх ашгийг хамгаалах ажлыг төлөөлөгч гүйцэтгэнэ.

Иргэдийг төлөөлөх гэдэгт юуны өмнө тэднийг сонсохоос эхэлнэ. Иргэдийг сонсохгүйгээр тэдний өмнөөс Хурал дээр тэдний санаа бодлыг хэрхэн дамжуулах вэ? Иргэдийг сонсох ажлыг хэд хэдэн хэлбэрээр зохион байгуулж болох юм. Үүнд:

- *Иргэдийн цуглаан зохион байгуулах:* Ойролцоо нутаглаж буй малчид, эсвэл хот суурин газарт нэг гудамж, байранд оршин суугчдыг тусгайлан зар түгээж, хэсэгчлэн цуглуулан тодорхой сэдвээр ярилцлага зохион байгуулж болно. Ярилцах сэдэв, цуглах өдөр, цаг, газраа урьдчилан зарлахын зэрэгцээ өөрөө ч тухайн сэдвээр ярих, бусадтай санаа бодлоо солилцох, Хурлын үйл ажиллагааны талаар мэдээлэхэд бэлтгэх нь зүйтэй. Өнөөдөр тодорхой сэдвээр иргэдийг цуглуулан санаа бодлыг нь сонсох, ярилцахад оролцооны асуудал хүндрэлтэй нь мэдээж байгаа ч тодорхой сэдвээр сонгогдсон тойрогтоо тогтмол иймэрхүү уулзалт зохион байгуулж хэвшвэл иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлж болно. Гагцхүү иргэдээс гаргасан саналыг Хурлын шийдвэрт тусгуулах талаар санаа тавьдаг, энэ талаар иргэдэд эргэж мэдээлдэг, гарсан шийдвэрийг иргэдэд тайлбарладаг байж гэмээ нь энэ оролцоо нэмэгдэх билээ.
- *Иргэдээс санал асуулга авах:* Өөрийн сонгогдсон тойрогтоо иргэдээс тусгайлан бэлтгэсэн асуулгын хуудсаар тодорхой асуудлын хүрээнд саналыг нь авч болох юм. Иймэрхүү асуулга нь иргэдээс нэг их цаг зарцуулалгүйгээр саналаа өгч

болох оролцооны хялбар арга боловч асуулгын боловсруулалтын түвшин, хамрах хүрээ, цуглуулсан мэдээллийн боловсруулалт зэргээс шууд хамааралтай учир үр дүн нь бодит байдлаас зөрөөтэй гарах нь бий. Энэ аргыг Хурлаар хэлэлцүүлэхээр санаачилж байгаа асуудлыг боловсруулахад юм уу, эсвэл Хурлаар хэлэлцэхээр товлохсон асуудлаар өөрийн саналаа бэлтгэхэд ашиглах нь тохиромжтой юм.

- *Иргэдтэй уулздаг байр бэлтгэж, тогтмол өдөр, цагт уулздаг байх:* Иргэдийн санаа бодлыг ямар нэгэн шүүлтүүргүй сонсож, тухайн асуудлаар өөрийн саналаа харилцан ярилцах, түүнчлэн Хурлын үйл ажиллагааг ч сурталчлахад тохиромжтой нэг арга нь энэ юм. Заавал долоо хоног бүр биш юмаа гэхэд сард нэгээс хоёр удаа тодорхой цаг гарган иргэдийг хүлээн авч уулзах хуваарь гарган зарлахаас энэ ажлыг эхлэх нь зүйтэй. “Хүн ирэхгүй байна” гэсэн шалтгаанаар өөрөө уулзалтад ирэхгүй байх нь цаашид нь энэ ажлыг унтраах үндэслэл болно. Уулзах газраа тогтмол цагт байж, нэг хүн ирсэн ч Хурлын болон өөрийн үйл ажиллагааны талаар мэдээлдэг, тухайн хүний санаа бодлыг хүндэтгэн сонсдог, тухайн асуудлаар Хуралд асуудал санаачилдаггүй юм аа гэхэд тодорхой албан тушаалтанд асуулга тавих, саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд бичгээр илгээх зэргээр иргэн хүнд туслахыг хичээдэг байх нь оролцоог нэмэгдүүлэх гол хүчин зүйл болох билээ.

Баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын хуралдаанд оролцож, иргэдийн санаа бодлыг сонсох, санаа бодлоо илэрхийлэх, иргэдийн нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тодорхой баримт бичгийн төсөл боловсруулж, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж болно.

Сумдын ИТХ-ын дарга нартай уулзаж ярилцаж байхад иргэдийн санаа бодлыг судлан нэгтгэж, ИТХ-ын хуралдаан дээр танилцуулах ажлыг санаачилсан төлөөлөгч гарахгүй байгааг тэд хүлээн зөвшөөрч байсан.

Хурлын төлөөлөгч нь Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох үүрэгтэй. Идэвхтэй оролцоо гэдэгт хуралдаанд бүрэн оролцох, үг хэлэх, саналаа илэрхийлэх, асуулт асуухаас гадна дангаараа буюу төлөөлөгчидтэй хамтран асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, Хурлын хорооны бүрэлдэхүүнд ажиллах, Хурлаас байгуулсан түр хороо, ажлын хэсэгт ажиллах, Хурлын үйл ажиллагааны талаар байгууллага, албан тушаалтан, иргэдэд мэдээлэл хийх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Хурлын үйл ажиллагааны талаар болон өөрийн саналын талаар мэдээлэл хийх, тодорхой байгууллага, албан тушаалтнаас асуулга авах, өөрийн эрх хэмжээний хүрээнд хяналт шалгалт хийх, шаардлага тавих, өөрийн саналаа холбогдох дээд байгууллагад илгээх зэрэг хамаарна.

Харамсалтай нь ИТХ-ын төлөөлөгчид, нутгийнхаа иргэдийг төлөөлөн шийдвэр гаргахад оролцох үүргээ умартан асуудалд намын байр сууринаас хандах явдал цөөнгүй байсаар байна. “Цөөнх болсон” гэх шалтгаанаар хуралдаандаа ч оролцдоггүй, “олонх болсон” гэх шалтгаанаар цөөнхөө сонсохыг ч хүсдэггүй, “эрх мэдэл байхгүй” гэх шалтгаанаар зоригтой шийдвэр гаргадаггүй, “урамшуулал байхгүй” гэх шалтгаанаар асуудал санаачлан хэлэлцүүлдэггүй байх нь ИТХ-ын төлөөлөгч үндсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн илрэл юм.

Төлөөлөгчид сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх хурлын үйл ажиллагааны Үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр, ИТХ-аар батлагдсан тухайн жилийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө зэрэг бодлогын шинж чанартай баримт бичгүүдийн биелэлтэд хяналт тавьж, үнэлгээ өгөх шаардлагатай. Үүнд ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд ч туслах үүрэгтэй. Хурлын төлөөлөгч нь сонгуульд анх нэр дэвшихдээ хувийн ямар нэгэн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд биш нутгийнхаа хөгжлийн төлөө, иргэдийнхээ сайн сайхны төлөө ирээдүй хойч үеийнхээ төлөө тэднийг төлөөлж ажиллаж чадна гэж амлалт авсан байдаг учраас өндөр мэдлэг, өргөн ёс суртахуунтай, үнэнч шударга, зарчимч, хариуцлагатай ажиллах ёстой.

Орон нутгийн удирдлагын хөгжил сан, Шведийн Ореброгийн их сургуулийн судалгааны ажлын тайланд дурдсанаар төлөөлөгчдийн ёс зүйн асуудалд "Иргэдийн ашиг сонирхлыг төлөөлөн ажилладаг байх"-ыг иргэдийн дийлэнх нь төлөөлөгчдийн баримтлах нэгдүгээр зэргийн асуудал гэж үзсэн байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 77.1 хувь нь Хурлын төлөөлөгчид ёс зүйн зөрчил гаргадаг гэж үнэлээд, эдгээр зөрчлүүд ямар хэлбэрээр илэрч байгааг эрэмбэлэхэд харилцааны доголдол 84.8 хувь, хүнд суртал гаргах 68 хувь, хүнийг ялгаварлан хандах явдал 64 хувь гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчид нь Хурлын төлөөлөгчидтэй холбоотой нийтлэг ажиглагддаг ёс зүйн зөрчлүүдэд: харилцааны доголдол 51.3 хувь, сонгосон иргэдтэйгээ уулзахгүй, төлөөлөхгүй байх 42.4 хувь, гаргасан шийдвэрийг ард нийтэд мэдээлэхгүй байх 40.7 хувь, хүнд суртал гаргах 40.7 хувь гэж үнэлсэн байна.

ИТХ-ын төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуулинд тодорхой болгох шаардлагатай. Тухайлбал, төлөөлөгчөөр сонгогдох болзол, түүний бүрэн эрх, баталгаа зэрэг асуудлыг нарийвчлах, ИТХ-ын төлөөлөгч нь Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн Цэцийн болон Улсын дээд шүүхийн гишүүн, тухайн нэгжийн засаг дара, Засаг даргын орлогчийн албыг давхар хашиж болох эсэх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

ИТХ-ын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чуулганаа тасалбал сонгогчдод нь энэ тухай мэдэгдэх, сард нэгээс доошгүй удаа иргэдийг хүлээн авч уулзах, уулзалтын тухай зарыг 3-аас доошгүй хоногийн өмнө сонгогчдын оршин суугаа байршлаар хүргэх ёстойг зааж, төлөөлөгчийг хариуцлагажуулах шаардлага ч байна. ИТХ-ууд ч төлөөлөгчийн үйл ажиллагааг тодорхой болгох чиглэлээр шаардлагатай журмуудыг гаргах, төлөөлөгчийн "Ёс зүйн дүрэм"-тэй болох хэрэгтэй байгаа нь амьдралаас харагдаж байна.

Ардчилал хөгжсөн оронд төлөөлөгчөөр дахин сонгогдохгүй байх нь ИТХ-ын төлөөлөгчид хүлээлгэж байгаа хамгийн том шийтгэл гэж үздэг. Намын нэрийн жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид идэвхтэй ажиллахгүй байх, Хурлаас зохион байгуулж байгаа ажилд зарим төлөөлөгч оролцохгүй байх, хуралдаандаа ирэхгүй байх зэрэг тохиолдолд хүлээлгэх ямар нэгэн хариуцлагын тогтолцоо байхгүй гэж ИТХ-ын ажлын албанаас санал гаргадагийг төлөөлөгчид анхааралдаа авах нь зүйтэй.

Орон нутгийн Хурлыг сонгох сонгуульд оролцох сонгогчдын ирц хүрэхгүй байгаа нь ИТХ-ын байгууллага иргэдэд хүрч ажиллахгүй байгаа, төлөөлөгч нь иргэд, сонгогчидтойгоо уулзаж, тэдний санаа бодлыг тухайн нэгжийнхээ үйл

ажиллагаанд тусгаж, хэрэгжүүлж чадахгүй байгаатай холбоотой. Иймд ИТХ хуулинд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, өөрийн үйл ажиллагаандаа иргэдийг оролцуулдаг, нээлттэй, ил тод, идэвхтэй ажиллах шаардлагатай.

Сайн туршлага. Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ИТХ-ын “Олон нийтийн хяналтын хороо”

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй бараа ажил үйлчилгээг хянах, шалгах, дүгнэлт гаргах, зөвлөх үүрэг бүхий “Хяналтын хороо”-ны бүрэлдэхүүнийг баталжээ. Хяналтын хороо нь ИТХ-ын төлөөлөгчөөр ахлуулсан бөгөөд иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, иргэн оролцсон 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ИТХ-ын дэргэд ажилласан байна. Энэхүү олон нийтийн хяналтын хорооны (ОНХХ) үндсэн чиг үүрэг нь :

1. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудыг тухай бүр нь илрүүлэн засч залруулах;
2. Ажлын явц төслийн эцсийн зорилго чиглэлтэй зохицож байгааг харах;
3. Одоогийн гүйцэтгэл нь төлөвлөгөө болон стандарттай нийцэж байгаа эсэхийг шалгах;
4. Үйл ажиллагаа нь хуулийн дагуу зөв дарааллаар явагдаж байгааг хянах;
5. Хэрэв шаардлагатай бол зөвлөгөө өгөх, санал гомдол гаргах, засч залруулах ажээ.

Эх сурвалж : hural.mn/иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн цахим хуудас

Төлөөлөгчдийг үүргээ идэвх чармайлттай хэрэгжүүлэхэд Хурал зохион байгуулалтын тодорхой арга хэмжээг авдаг байх нь чухал. ИТХ-ын туршлагаас харахад төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах график гаргах, үйл ажиллагааг нь дүгнэх журам гаргаж мөрдөх, хуралдаан, хяналт шалгалтын ажилд оролцсон байдал гэх мэтэд бүртгэл хөтлөх зэргээр ажилладаг нь үр дүнтэй байдаг байна.

1.2.4. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

ИТХ-ын шийдвэр нь хамтын шийдвэр юм. Хамтын шийдвэр гэдэг нь шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох эрх бүхий этгээдүүдийн олонх нь саналаа өгч гаргасан шийдвэр бөгөөд энэхүү шийдвэрийн хариуцлагыг зөвхөн тухайн шийдвэрийг дэмжиж саналаа өгсөн этгээдүүд бус, харин тухайн шийдвэрийг гаргасан байгууллага нь буюу таслах эрхтэй бүх этгээд өөрсдөө бүхэлдээ хүлээнэ.

ИТХ-ын шийдвэр нь тухайн харьяа нутаг дэвсгэртээ хүчин төгөлдөр, бүх нийтээр заавал биелүүлэх шийдвэр байна. Харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүхий л байгууллага, албан тушаалтан, тухайн нутаг дэвсгэрт байнга болон түр оршин суугчид, дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчид нь тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн ИТХ-аас Монгол Улсын хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй байна. ИТХ-ын шийдвэрийн төрөл нь:

- ИТХ-ын тогтоол;
- ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол;
- ИТХ-ын даргын захирамж;

- ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дүрэм, журам, төсөв, төлөвлөгөө, хөтөлбөр, шилжүүлсэн эрх мэдэл;
- Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн албан даалгавар, зөвлөмж, чиглэл, заавар;
- Мөн нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хандаж гаргасан илгээлт, уриалга, хүсэлт;
- Бусад этгээдтэй тухайн Хурлыг болон нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн байгуулсан гэрээ, хэлэлцээр.

ИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан хуралдааны дэг, хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан, мөн хуралдааны тэмдэглэл, мэдээлэл, асуулга, асуулт, албан тоот, илтгэл зэрэг баримт бичгийг гаргадаг.

ИТХ-ын шийдвэрт тухайн Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан тогтоол хамаарна. Хурлын Тэргүүлэгчид нь тухайн Хурлын хуралдааны чөлөөт цагт нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг гүйцэтгэж, тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэх тул Тэргүүлэгчдийн шийдвэр нь ИТХ-ын бусад шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр байж хэрэгжинэ.

ИТХ-аас шийдвэр гаргахын тулд тодорхой шаардлагыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид нийцсэн, түүний хүрээнд байх;
- тухайн нутаг дэвсгэрийн ард иргэдийн ашиг сонирхолд нийцсэн байх;
- биелэгдэх үндэслэлтэй байх;
- батлагдсан төсвийн хүрээнд байх;
- шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулагдсан байх;
- шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага, иргэдийн саналыг авсан байх;
- мөрдөгдөж эхлэх болон дуусах хугацаа тодорхой заасан байх;
- шийдвэрийг гаргахдаа үг үсэг, найруулгын алдаагүй, ойлгомжтой хэлбэрээр томъёолсон байх, архив, бичиг хэргийн стандарт, нормыг хангасан байх зэрэг шаардлагуудыг хангасан байх учиртай.

Нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргаж байгаа шийдвэрийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Хэм хэмжээ тогтоож байгаа байдлаар: урт хугацаанд мөрдөгдөх, хүн амын өргөн хүрээг хамарсан, заавал дагаж мөрдөх эрхийн акт журам, дүрэм;

Зөвхөн нэг байгууллага, тодорхой хүмүүс рүү чиглэгдсэн, тодорхой хугацаанд мөрдөгдөх эрхийн акт, гэрээ, тогтоол;

Эрх зүйн актын агуулгаар: эдийн засаг, нийгмийн чиглэлийн, байгаль орчныг хамгаалах чиглэлийн, нийгмийн дэг журмыг зохицуулах чиглэлийн гэх мэт.

Хүчин төгөлдөр болж мөрдөгдөх байдлаар: хэвлэл мэдээллээр заавал мэдээлэгдэх шаардлагатай нийтээр дагаж мөрдөгдөх шийдвэр ба зөвхөн холбогдох байгууллага, хүмүүст хүргээд мөрдөгдөх шийдвэр байна.

Сумдын ИТХ жилд дунджаар 50-70 орчим тогтоол гаргаж байгаагийн 80 орчим хувь нь ажлын хэсэг байгуулсан, төрийн дээд одон, медаль олгуулахаар уламжилсан, хяналт шалгалт зохион байгуулах тухай зэрэг нэг удаагийн шинж чанартай, зөвхөн тухайн асуудлыг шийдвэрлэсэн шийдвэр байна¹¹. Гэтэл ИТХ-ын байгууллага нь орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлогчийн хувьд тухайн орон нутагт ямар асуудалд гол анхаарлаа чиглүүлэх, хөрөнгө мөнгөө юунд зарцуулвал илүү үр дүнтэй байх талаар бодлогын шинж чанартай шийдвэр гаргах

¹¹ hural.mn/иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн цахим хуудас

ёстой. Оновчтой шийдвэр гаргахын тулд ард иргэдийн хүсэл, сонирхлыг судлах, холбогдох хууль, тогтоомжийн хүрээ, төсөв, санхүүгийн чадавхийг тооцоолох, хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох байгууллага, иргэдийн саналыг авах, судалгаа, лавлагаа бэлтгэх зэрэг ажлыг хийх шаардлагатай.

Засаг захиргааны тухайн нэгжид үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дээд шатны байгууллагад харьяалагддаг аж ахуйн нэгж, албан газар, байгууллагын гаргасан шийдвэр хууль тогтоомж, Засгийн газар, ИТХ, Засаг даргын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрт харшилбал Засаг дарга түүнийг өөрчлөх буюу хүчингүй болгуулах саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах бөгөөд энэхүү саналыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлнэ. Харин ИТХ, Засаг даргын хууль бус шийдвэрийн улмаас иргэд, байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

Хурлаас гаргасан шийдвэр заавал хэрэгждэг байх учиртай. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд нутгийн удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг зохицуулж өгсөн. Энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "...Хурал, Засаг даргаас эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ, хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлөх" гэж заасан.

.....oOo.....

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ: ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

2.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орон нутгийн төсвийг боловсруулахдаа үндэсний болон орон нутгийн урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй нягт уялдуулах шаардлагатай. Учир нь энэхүү урт, дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангах санхүүгийн баталгаа нь орон нутгийн төсөв юм.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль"-ийг УИХ-аар 2015 оны 11 дүгээр сарын 26-нд батлан мөрдөж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны эрх зүйн үндэс бүрдэж, улс, бүс, орон нутаг, салбарын хөгжлийн бодлогыг төлөвлөх, боловсруулах ажлын уялдааг хангах боломжтой болсны зэрэгцээ орон нутгийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөний нэгдсэн аргачлал, шаардлага тодорхой болсон юм.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд орон нутгийн хөгжлийн бодлоготой холбогдох дараах баримт бичгүүдийн тодорхойлолтыг тусгаж өгсөн байна. Үүнд:

- *Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл:* Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичиг;
- *Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт:* бүсчилсэн хөгжлийн бодлогод суурилсан, орон нутгийн онцлогийг харгалзан, байгаль орчны тогтвортой байдлыг хангасан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилго, зорилтыг тодорхойлсон баримт бичиг;
- *Бүсчилсэн хөгжлийн бодлого:* Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг;
- *Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр:* бүсчилсэн хөгжлийн бодлого болон аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод суурилсан, орон нутгийн

сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийг тусгасан, орон нутгийн хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичиг;

- *Дэд хөтөлбөр*: Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичиг хамаарна.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газар батлахаар хуульчлагдсан бөгөөд дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран хөгжлийн бодлогын баримт бичиг нь урт, дунд, богино хугацааны гэсэн 3 төрөлтэй байна.

- Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.
- Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг:
 - төрөөс баримтлах бодлого;
 - бүсчилсэн хөгжлийн бодлого;
 - аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.
- Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг:
 - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
 - Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
 - үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;
 - улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.
- Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг:
 - улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн боловсруулах бөгөөд энэхүү үндсэн чиглэлд дээр дурдсан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалт, зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгасан байна.

Нутгийн захиргааны байгууллага буюу Засаг дарга, ЗДТГ нь:

- Үндэсний хэмжээний бодлогын чанартай арга хэмжээ болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хязгаарыг хангаж байгаа төсөл, арга хэмжээний саналыг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулахаар жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор салбарын яам болон Сангийн яаманд хүргүүлнэ.
- Холбогдох яам, агентлаг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор Сангийн яаманд хүргэдэг болсон.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын

нийт дүн нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан тухайн салбарын зарлагын дээд хязгаараас хэтрэхгүй байхаар зохицуулсан байна.

Түүнчлэн аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэх, хянаж үнэлэхэд тавигдах шаардлагыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд дараах байдлаар тусгаж хуульчилжээ.

"14 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт

14.1. Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.14.2. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно.14.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн, Засаг даргын саналыг үндэслэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахад энэ хууль болон холбогдох журмыг баримтална.

14.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.14.5. Сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлоготой байж болно.

14.6. Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр

15.1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

15.2. Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

15.3. Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо Төсвийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт заасныг мөрдөнө.

15.4. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.

15.5. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах асуудал болон хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, үндэслэлгүй зорилт, арга хэмжээг тусгахыг хориглоно.

15.6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг төсөв, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан, дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

15.7. Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

15.8. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14, 15-р зүйл"

Орон нутгийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байх шаардлагатай. Засаг дарга эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 5-ны дотор ИТХ-даа өргөн мэдүүлж, тухайн шатны ИТХ батална. ИТХ эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-ыг УИХ 2016 оны 2 дугаар сарын 5-ны 19 тоот тогтоолоор баталсан. Уг үзэл баримтлалд эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглалын харилцан хамаарлыг бүхэлд нь тусгаж, Монгол хүний хөгжлийг эрхэмлэсэн цогц бодлого байхаар боловсруулсан бөгөөд 2016-2020, 2021-2025, 2026-2030 он гэсэн 3 үндсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь НҮБ-аас батлан гаргасан Тогтвортой хөгжлийн үзэл санаанд суурилсан төдийгүй Монгол Улсын өөрийн онцлог, тулгамдаж байгаа асуудлуудтай нягт уялдсан байна.

Тус үзэл баримтлал батлагдсанаар үндэсний болон орон нутгийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого нь үр дүнд суурилсан удирдлагын хүрээнд хэрэгжих бөгөөд бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нь харилцан уялдаатай, нэгдмэл зорилго, зорилтод чиглэсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн шинэ орчин бүрдсэн юм. Монгол Улсын салбар, аймаг, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн бодлого зэрэг дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогуудыг урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлснээр нэгдсэн бодлогоор улс орныг хөгжүүлэх боломжтой болж байна.

Иймээс аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг тодорхойлон хэрэгжүүлснээр орон нутгийнхаа хөгжлийн бодлогыг Монгол улсын хэмжээний болон салбарын хөгжлийн бодлоготой уялдуулах боломжтой болох төдийгүй Орон нутгийн хөгжлийн сангаа үр ашигтай зарцуулах бүрэн боломжтой болно. Тухайлбал, Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх

төслийг сонгоходоо Иргэдийн нийтийн хурлаараа иргэд эхлэн эрэмбэлжээр заасан бол мөн хуулийн 63.3-д баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгах боломжтойгоор хуульчилсан байна.

Орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, бүс нутгийн хөгжлийн бодлоготой нийцсэн дунд хугацаанд хэрэгжих, төсөвт өртөг өндөртэй томоохон төслүүдийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулан хэрэгжүүлэх боломжтой. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 4 жилд нэг удаа баталж, жил бүр Засгийн газраар тодотгон авч явах ба тус хөтөлбөрт улсын төсөв, зээл, тусламж болон концессийн гэрээ, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээ бүгд хамаардаг.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна. Тус хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг эхлээд хийх ба урьдчилсан судалгаагаар эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой үр дүнтэй болох нь тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийнх нь тооцоог хийдэг байна.

2.2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.2.1. ТӨСВИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Төр засгийн зүгээс өөрийн үндсэн үүргээ гүйцэтгэхийн тулд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн орлогын тодорхой хэсгийг улсын юмуу орон нутгийн төсөвт төвлөрүүлж, түүнийг зайлшгүй хэрэгцээнд зориулан дахин хуваарилахтай холбогдсон мөнгөний харилцааг төсөв гэнэ. Хэлбэрийн хувьд төсөв нь орлого, зарлагын төсөвлөсөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд жил бүр хууль тогтоох байгууллагаар түүнийг баталснаар төсөв нь хуулийн хүчин төгөлдөр санхүүгийн баримт бичиг болно.

Энгийн утгаар авч үзвэл, төсөв гэдэг бол санхүүгийн үндсэн төлөвлөгөө юм. Тухайн жилд байгаа хөрөнгийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалт хийх чиглэлийг заасан санхүүгийн санал хэмээн ойлгож болно. Улсын төсвөөс олгох шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг хэлбэрээр хуваарилах хөрөнгө, орон нутгийн татварын болон татварын бус орлогын тооцоо бол энэ төлөвлөгөөний орлогын тал юм. Үйлчилгээ үзүүлэхэд болон хөрөнгө оруулалтад зарцуулж байгаа цалин, бараа материал, тоног төхөөрөмж зэрэг нь төсвийн зарлагын тал болно. Жилийн төлөвлөгөөнд орлого, зарлага тэнцсэн байх шаардлагатай бөгөөд үүнийг төсвийн тэнцэл гэж нэрлэдэг.

Улсын төсвөөс санхүүжиж байгаа бүх байгууллага жилийн төсвөө боловсруулж батлуулах үүргийг хуулиар хүлээхийн зэрэгцээ улсын төсвийн хөрөнгөөр иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг хүргэх, хөрөнгө оруулалт хийх үүрэгтэй байдаг. Гэвч бүх иргэдийн хэрэгцээг хангахуйц хэмжээний орлого ямагт хүрэлцээтэйгээр бүрддэггүй учраас сонголт хийх шаардлагатай болдог. Төсвийн үйл ажиллагаа нь сонгуульт албан тушаалтнууд буюу ИТХ-ын төлөөлөгчид иргэд,

татвар төлөгчид, бусад сонирхогч талуудын саналыг сонссоны үндсэн дээр харилцан буулт хийх, зөвшилцөх замаар тэргүүлэх чиглэлийг тогтоох, Засгийн газар, нутгийн удирдлага хөрөнгө мөнгийг хаана, юунд зарцуулах шийдвэр гаргах механизмыг бүрдүүлдэг.

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 4.1.5-д “*төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг төсөв*” хэмээн тодорхойлжээ.

Төсөв зохиох, батлах, түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын эрх, үүргийг хуульчлан тогтоодог бөгөөд түүнийг төсвийн эрх гэнэ. Монгол Улсын төсөв нь улсын төвлөрсөн төсөв болон орон нутгийн төсвөөс бүрдэнэ. Төсөв зохиоход дараах үндсэн зарчмуудыг хангасан байх шаардлага тавигдана. Үүнд:

1. *Иж бүрэн байх.* Төр засгийн зүгээс өөрийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө тухайн жилийн төсөвт бүрэн тусгагдсан байх нь чухал.
2. *Нэгдмэл байх.* Төсөв нь нэгдсэн аргачлалын дагуу зохиогдохын зэрэгцээ төр, засгийн үйл ажиллагаатай холбоотой орлого, зарлага нэг л төсөвт тусгалаа олсон байх ёстой.
3. *Бодитой байх.* Төсвийн орлого, зарлагын төлөвлөсөн арга хэмжээ улсын болон орон нутгийн бодит бололцоо, шаардлагад үндэслэсэн байх бөгөөд бодитой хэрэгжих үндэстэй байх ёстой.
4. *Ил тод байх.* Хууль тогтоох байгууллага төсвийг хэлэлцэж батлах үйл ажиллагаандаа ил тод байх зарчмыг баримтлана.

2.2.2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛИУД

Эдүгээ төсөвтэй холбоотой харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, тэдгээрийг дагаж гарсан журмуудаар зохицуулж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн харилцааг зохицуулдаг. Тухайлбал, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн Дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувиас илүүгүй алдагдалтай, эсвэл ашигтай байх шаардлагатай. Мөн нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох, тухайн жилийн нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн хувь болон улсын өрийн хязгаарыг хуульчилж өгсөн байна.

Төсвийн тухай хуулиар (2011 оны 12 дугаар сарын 23-нд батлагдсан) төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж буй бөгөөд энэхүү хуулийн “Орон нутгийн төсвийн харилцаа” гэсэн есдүгээр бүлэг нь төсвийн шатлал хоорондын харилцаа, орон нутгийн төсвөөр аймаг, нийслэл, сум, дүүргийн хэрэгжүүлэх чиг үүрэг, орон нутгийн хөгжлийн сан, Засгийн газрын зарим чиг үүргийг орон

нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, орон нутгийн хэрэгцээнд зориулж өр үүсгэх, орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах, ИТХ, Засаг даргын төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх бүрэн эрх, орон нутгийн төсвийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулахад чиглэж байгаа болно.

Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх тайлагнахад төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв бодитой байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх зэрэг зарчмыг баримтална.


Шилэн дансны тухай хууль (2015 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдсөн) нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилготой бөгөөд төсвийн байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны ИТХ, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлэх болсон юм.

2.2.3. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИД

Төсвийн шинэ хуулиар төсвийг захиран зарцуулахад Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон Төсвийн шууд захирагч гэсэн томъёоллыг оруулж ирсэн. Орон нутгийн төсвийн хувьд ИТХ-ын дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар төсвийн ерөнхийлөн захирагч болно. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд Төлөөлөн гүйцэтгэх гэрээгээр буюу тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга нар байна. Төсвийн шууд захирагч нь тухайн төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нар юм.

2.2.4. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Төсвийг шатлалаар ангилан авч үзвэл Монгол Улсын нэгдсэн төсөв нь Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв гэсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.



Зураг 2.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн

Монгол Улсын нэгдсэн төсвийн үндсэн бүрэлдэхүүн болох орон нутгийн төсвийг Төсвийн тухай хуулийн 4.1.27 дахь заалтад “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсөв” гэж тодорхойлсон

байдаг. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэх бөгөөд сүүлийн жилүүдэд нэгдсэн төсвийн 30 орчим хувийг эзэлж байна.

2.2.5. УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦАА

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлж байгаа мөнгөний хувьд төв, орон нутгийн төсөв хоорондын харилцааны асуудал яригддаг байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 3 төрлийн шилжүүлэг олгодог. Энэ нь: 1) орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж олгох санхүүгийн дэмжлэг; 2) хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь зориулж олгох Орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлэг; 3) Засгийн газрын хэрэгжүүлэх зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд зориулж улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг байна.

Дээрх 3 шилжүүлэг нь улсын төсөвт нийт дүнгээрээ батлагдан орон нутагт шилжих бөгөөд аймаг, нийслэл нь сум, дүүрэгтээ олгох шилжүүлгийг мөн нийт дүнгээр нь баталж хүргүүлдэг бол сум, дүүрэг нь тухайн шатны ИТХ-аараа төсвийн төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжүүлнэ. Тухайлбал, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагуудын төсвийг баталж, хэрэгжүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих эрхийг нь гэрээгээр орон нутагт бүрэн шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл, байгууллага Засаг даргаараа дамжуулан тухайн шатныхаа ИТХ-аар төсвөө хэлэлцүүлэн батлуулж, Засаг даргаараа санхүүжилтийн хуваариа батлуулах болон хуваарьтаа өөрчлөлт оруулах замаар үйл ажиллагаагаа тухайн шатандаа удирдан авч явах боломжтой болсон гэсэн үг.

Төсвийн хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн жилийн батлагдсан төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг, сум, дүүргийн Засаг дарга сум, дүүргийнхээ жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж мөрдүүлэх болсон. Ингэснээр улсын төсвөөс олгогдсон санхүүжилтийн дүндээ багтаан санхүүжилтийн хуваарьт зохицуулалт хийх замаар дансны үлдэгдлээ удирдах, хугацаа хэтэрсэн өр авлага үүсгэхгүйгээр төсөвтөө шийдвэр гаргах эрхтэй.

2.2.6. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО, ЗАРЛАГА

Орон нутгийн төсөвт “орон нутгийн төсвийн суурь орлого, суурь зарлага” гэдэг ойлголт бий болсон. Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг тодорхойлоход ашиглагддаг. Жишээлбэл, улсын төсвийн хувьд аймгуудын суурь орлого, зарлагыг тооцсоны үндсэн дээр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээ хуваарилах бол аймаг, нийслэл нь сум, дүүргийн суурь орлого, зарлагыг тооцон санхүүгийн дэмжлэгийг тодорхойлдог.

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ. Орон нутгийн төсвийн суурь зарлага гэдэг нь төсвийн хуульд тусгагдсан орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зардал юм. Орон нутгийн төсвийн зарлага нь урсгал зардал, хөрөнгийн зардлаас бүрдэнэ.

Орон нутаг дээрх суурь орлогоо нэмэгдүүлэн нэмэлт орлого олох боломжтой болсон бөгөөд энэхүү нэмэлт орлогын дүнг оруулаагүй дүнгээс суурь төсвийн

тэнцлийг дээд шатны төсөв нь тооцож, санхүүгийн дэмжлэгийг олгоно.

Орлогоо нэмэгдүүлж нэмэлт орлого олох боломжийг хуулиар олгосон. Тухайлбал, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь зарим төрлийн татвар, хураамжийн хувь хэмжээг Улсын Их Хурлаас баталсан дээд болон доод хязгаарын хүрээнд нэмэгдүүлэн батлах эрхтэй, ийнхүү батлахдаа сум бүрийн саналыг харгалзан ялгаатай тогтоож өгч болно. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ зэргийг нэмэгдүүлж, нэмэлт орлого олж болно. Жишээ нь, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувийг 0.6-1.0 хувийн хооронд тогтоохоор хуульчилжээ.

2.2.7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ӨР ҮҮСЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТ

Орон нутгийн төсөвт өр үүсгэхтэй холбоотой харилцааг дараах байдлаар зохицуулна. Үүнд:

- Сум, дүүргийн төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн төсвөөс богино хугацаатай зээл олгож болно.
- Аймаг, нийслэлийн төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэхэд улсын төсвөөс зээл олгож болно.
- Нийслэлийн Засаг дарга төсвийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төслийг 4 хүртэлх жилийн хугацаатайгаар өр үүсгэн санхүүжүүлж болно.
- Орон нутгийн төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахыг хориглоно.

Дээрх зохицуулалтаас гадна орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагын дансны үлдэгдлийг чиг үүрэг хооронд шилжүүлэн ашиглах, өр дарах, орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хооронд өр үүсгэн санхүүжилт хийхийг төсвийн хуулиар хориглосон байдаг.

2.3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨЧЛӨГ

Жилийн төсвийн төслийг бэлтгэх, өргөн барих, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх ажиллагааг нийтэд нь төсвийн мөчлөг гэдэг. Ерөнхийдөө төсвийн мөчлөг тухайн санхүүгийн жилээс нэг жилийн өмнө эхэлж, санхүүгийн жил дуустал үргэлжилдэг. Орон нутгийн төсвийн мөчлөг нь:

- Орон нутгийн төсвийг боловсруулж, бэлтгэх;
- ИТХ-аар төсвийг хэлэлцэн батлах;
- Төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Төсвийг хянаж, үнэлэх үе шатуудаас бүрдэнэ.

Эдгээр шат тус бүрт ИТХ-ын зүгээс мэдвэл зохих, анхаарах асуудлуудыг авч үзье.

2.3.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ БОЛОВСРУУЛЖ БЭЛТГЭХ ҮЕ ШАТ

Орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, өргөн барих асуудлыг Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-аар (журмыг

хавсралтаас үзэж болно) зохицуулж байна. Уг журамд орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад баримтлах зарчим, төсвийн удирдамж, орон нутгийн суурь төсвийн санал боловсруулах, тусгай сангуудыг төлөвлөх, төсвийн тодотголын төсөл боловсруулах, төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах зэрэг асуудлыг тусгажээ.

ИТХ-ын бүрэн эрх

64.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

64.1.1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

64.1.2. тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;

64.1.3. төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах;

64.1.4. төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйл

Төсвийн тухай хуулийн “төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах” гэсэн 5 дугаар бүлгийн 27 дахь зүйлд төсвийн төсөлд тавигдах шаардлага, 28 дахь зүйлд орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, ИТХ-д өргөн барих цаглабарыг тогтоосон.

Хүснэгт 2.1. Орон нутгийн төсвийн саналыг боловсруулж, хүргүүлэх цаглабар

Төсвийн захирагчийн түвшин	Төсвийн саналын төрөл	Төсвийн саналыг хүргүүлэх хугацаа	Хүргүүлэх төсвийн захирагч, байгууллага
Орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Орон нутгийн төсвийн байгууллагын суурь төсвийн санал	Жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор	Сум, дүүргийн Засаг даргад
Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа явуулж байгаа тусгай улсын төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын суурь төсвийн санал		
Сум, дүүргийн Засаг дарга	Орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн	Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад

Аймаг, нийслэлийн Засаг дарга	Төлөөлөн гүйцэтгэх гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг	Жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор	Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид
	Орон нутгийн төсөвт байгууллагын суурь төсвийн саналыг	Жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	Сангийн яаманд
	<ul style="list-style-type: none"> • Үүнээс удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн суурь зардлын санал Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж авахаар бол холбогдох гэрээ, хэрэгжүүлэх хөтөлбөрийг төсвийн захирагч бүрээр боловсруулж, төсвийн төслийн хамт		
Сангийн яам	Орон нутгийн суурь төсвийн дэлгэрэнгүй мэдээллийг	Жил бүрийн 10 дугаар сарын 5-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргад
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулж, танилцуулгын хамт	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Тухайн шатны ИТХ-д
Аймаг, нийслэлийн Засаг дарга	Тухайн шатны төсвийн төслийг	Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн аудитор
Аймаг, нийслэлийн аудитор	Жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	ИТХ-д

Эх сурвалж: Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.3 дахь заалт

Засгийн газраас УИХ-д улсын төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 1 гэхэд өргөн мэдүүлдэг бөгөөд 10 дугаар сарын 5 гэхэд Сангийн яамнаас аймаг, нийслэлд орон нутгийн суурь орлого, зарлага, санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн тоог дэлгэрэнгүй эдийн засгийн ангиллаар мэдээлэл байдлаар суурь төсөв тооцоход хүргүүлнэ.

Мөн УИХ-аар 11 дүгээр сарын 15-нд улсын төсөв батлагдахад төсөв хоорондын шилжүүлгийн батлагдсан тооцоог дэлгэрэнгүйгээр өгнө. Аймаг, нийслэл нь сум, дүүрэгтээ суурь төсвийн задаргааг нь хүргүүлнэ. Төсвийн байгууллага энэхүү хүргэгдсэн суурь төсвийн задаргааг үндэслэн 11-12 саруудад дараа жилийн төсвийг тооцон, түүнд шаардлагатай сарын санхүүжилтийн хуваарийг бэлтгэнэ. Ийнхүү төсвийн төслийг бэлтгэхдээ дээд шатнаас ирүүлсэн суурь зардлыг эдийн засгийн ангилал хооронд зөвшөрөгдсөн хүрээнд, өр үүсгэхгүйгээр хөдөлгөөнд оруулах эрхтэй ба төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлнэ.

Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын хувьд цалин хөлстэй холбоотой зардал болон нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бусад Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээнд тусгагдсан зардлыг хөдөлгөөнд оруулах боломжгүй ба гэрээнд тусгагдсан чиглэл зарчмыг удирдлага болгоно. Мөн төсвийн хуулиар олгогдсон төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагчийн эрхээ хэрэгжүүлэх боломжтой.

2.3.2. ИТХ-ААР ТӨСВИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ҮЕ ШАТ

Төсвийн хуулиар төсөв батлах эрх бүхий байгууллага төсвийг батлахдаа шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлана.

Төсөв батлагдахад Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих хөрөнгө оруулалт ба орон нутгийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтын жагсаалтыг тусад нь хавсралтаар баталдаг. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр журмын хавсралт маягыг ашиглана.

Төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана. Өөрөөр хэлбэл, ИТХ-аар төсвийг хэлэлцэж байхад хөрөнгө оруулалтын төсөл шинээр нэмэгдэхэд тухайн төслийн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, зохих зөвшөөрлүүд нь олгогдсон эсэхийг нягтална. Мөн тухайн хөрөнгө оруулалт нь ашиглалтад орсноор урсгал зардал, орон тоог нэмэгдүүлэхээр байна уу гэдэг дүгнэлт хийгдсэн байх шаардлагатай бөгөөд хэрэв нэмэгдүүлэхээр бол тэрхүү зардлыг цаашид ямар эх үүсвэрээс шийдвэрлэх талаар тооцооны үндэслэл, тайлбарыг авч үзэх шаардлагатай.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын төслийн эхний жилд тавигдах санхүүжилт нь төсөвт өртгийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан дүнгээс багагүй байхаар тусгах шаардлагыг хуульчилсан тул хөрөнгө санхүүгийн боломжоо тооцох учиртай юм. Жишээлбэл, Ахуйн үйлчилгээний төвийг 200.0 сая төгрөгөөр 2 жилд барих төсөл хэрэгжүүлнэ гэхэд эхний жилдээ 100.0 сая төгрөг нь тусгагдсан байхыг шаардана. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хувьд ИТХ-аар хэлэлцэх явцад иргэдийн саналыг аваагүй төслийг шинээр нэмж тусгах боломжгүй. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь улсын төсөв УИХ-аар батлагдсанаас хойш 10 хоногт багтаан аймаг, нийслэлийнхээ дараа жилийн төсвийн төслийг, харин сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн төсөв ИТХ-аар батлагдсанаас хойш 5 хоногийн дотор сум, дүүргийн төсвийн төслөө эцэслэн боловсруулж, тухайн шатны ИТХ-даа өргөн мэдүүлдэг болсон юм. Энэ нь тухайн шатны ИТХ орон нутгийн төсвийн төслөө хүлээн аваад 10 хоногийн хугацаанд танилцан хэлэлцэж, батлах боломжийг олгож байгаа болно.

Хүснэгт 2.2. Орон нутгийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах цаглабар

Орон нутгийн төсвийн төсөл	Засаг дарга ИТХ-д өргөн мэдүүлэх хугацаа	ИТХ тухайн шатны төсвийн хэлэлцэн батлах хугацаа
Аймаг, нийслэлийн дараа жилийн төсвийн төсөл	Жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор	Жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор
Сум, дүүргийн дараа жилийн төсвийн төсөл	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	Жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор

Төсвийн тухай хуулийн 8.5.5-д аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Сангийн яам)-д хүргүүлэхээр заажээ.

Орон нутгийн төсөв батлах талаар ИТХ-ын бүрэн эрх:

68.1. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.

68.2. Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29-р зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

68.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг илтөд, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.

Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйл

Аймаг, нийслэлийн ИТХ нь Засаг даргын өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 5-ны дотор, харин сум, дүүргийн ИТХ нь жил бүрийн 12 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд хэлэлцэн баталж, тогтоол гаргана. Тухайлбал, сумын ИТХ нь орон нутгийн төсвийг баталсан тогтоолдоо дараах зүйлсийг заавал тусгана. Үүнд:

1. Сумын тухайн оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээ.
2. Сумын тухайн оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ.
3. Сумын тухайн оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээ.
4. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээ.
5. Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.
6. Урьд оны үлдэгдлээс санхүүжих урсгал зардлын дүн, хөрөнгийн зардлын дүн.
7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн.
8. Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт.
9. Төсөвтэй холбоотой бусад заалт.

Төсвийн тухай хуулиар сум, дүүргийн Засаг дарга ИТХ-аар батлагдсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын 7 өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхээр заажээ.

ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахад анхаарвал зохих зүйлс:

- Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэйгээр тооцож батлах, хийсвэрээр өсгөхгүй байх;
- Хууль тогтоомжоор тухайн шатны хуралд олгогдсон эрх хэмжээний хүрээнд төлбөр, хураамж ногдуулах, цуглуулах асуудлыг шийдвэрлэх;
- Орон нутгийн төсвийн байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих улсын төсөвт байгууллагын зардлыг үндэслэл, тооцоогүйгээр өсгөж батлахгүй байх;
- Эх үүсвэргүй урсгал болон хөрөнгийн зардал батлахгүй байх;
- Төсвийн шийдвэрийг гаргахдаа орон нутгийн хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, иргэдээс гарсан саналд тулгуурлан нийтийн эрх ашигт нийцсэн төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд анхаарах нь чухал.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ төсвийн төсөл хэлэлцэж батлах үйл ажиллагааг хурлын дотоод дэгээр зохицуулах бөгөөд тухайн хурлын онцлог байдалд тохируулан төсөв хэлэлцэж батлах тусгай журам гарган мөрдөж болно.

Орон нутгийн төсвийн тодотгол

Төсвийн шинэ хуулиар орон нутаг төсвийн эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар төсвөө тухайн шатандаа батлуулан хэрэгжүүлэх боломжтой болсон төдийгүй жилийн эцэст дансны үлдэгдлээ ерөнхий дансандаа төвлөрүүлэн зарцуулах боломжтой болсон бөгөөд төсвийн тодотгол хийх нөхөцлүүд хуулиар хязгаарлагдсан. Дараах 3 тохиодолд л орон нутаг төсөвтөө тодотгол хийх боломжтой. Үүнд:

- Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон. Өөрөөр хэлбэл сум, дүүргийн хувьд аймаг, нийслэл төсвөө тодотгосны дараа, аймаг, нийслэлийн хувьд улсын төсөвт тодотгол хийгдсэний дараа төсвөө тодотгоно.
- Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон.
- Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах зэрэг орно.

Шаардлагатай гэж үзвэл тухайн жилийн төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд дараах хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийг түр зогсоож болно. Үүнд:

- Санхүүжүүлэх хэмжээ нь багасахаар, эсвэл хасагдахаар төсвийн тодотголын төсөлд тусгасан;
- Тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй.

Дээд шатны төсөвт тодотгол орсны улмаас доод шатны төсвийн захирагч батлагдсан төсөвтөө зайлшгүй тодотгол оруулах шаардлагатай гэж үзвэл дээд шатны төсөвт тодотгол орсноос хойш 45 хоногт багтааж төсвийн тодотголын төслийг боловсруулж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ. Төсвийн тодотголын төслийг бэлтгэхдээ нэмэлт, өөрчлөлт оруулж буй зардлаар харуулна. Өөрөөр

хэлбэл, ямар эдийн засгийн ангиллын орлого, зарлага нэмэгдэж, хасагдаж байгааг анх батлагдсан төсөвтэй зэрэгцүүлэн харуулсан байх шаардлагатай болдог.

2.3.3. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЕ ШАТ

Төсвийн гүйцэтгэлийн үе шат нь Төсвийн тухай хууль болон орон нутгийн төсвийн журмын дагуу төсвийн орлогыг дайчлан оруулах, зарлагыг төсөвлөсөн үйл ажиллагаанд зарцуулах буюу төсвийн хөрөнгийг ашиглахаас эхлэн тайлан гаргах хүртэлх хугацааг хамарна.

Төсвийн гүйцэтгэлийг хангах гэдэг нь санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан орлогын эх үүсвэрийг холбогдох субъектүүдээс хугацаанд нь зохих шатны төсөвт татан оруулах, төлөвлөгөөт санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай, аривч хямгачаар зарцуулах үйл ажиллагаа юм. ИТХ-аас тухайн жилийн төсвийг баталсан тухай тогтоол гарснаар орон нутгийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах үе шат эхэлнэ. Гүйцэтгэлийн явцад төсвийн байгууллагууд батлагдсан төсвөө зарцуулж, үйлчилгээ үзүүлдэг. Батлагдсан төсөв нь төсвийг зарцуулах үйл ажиллагааг хянахад чухал ач холбогдолтой байдаг.

Манай улсад төсвийн жил 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд үргэлжилдэг. Энэ хугацаанд орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн үе шат давхцах ба энэ үе шатанд:

- Аймаг, сумдын Засаг дарга нар төсвийн орлогын төлөвлөгөөний дагуу орлогын эх үүсвэрийг зохих шатны төсөвт төвлөрүүлэх;
- Тухайн шатны төсөвтэй харилцагч төсөвт байгууллагын төсвийн шууд захирагчтай Засаг дарга үр дүнгийн гэрээ байгуулж санхүүжилтийг олгох;
- Сумдын Засаг дарга нар аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх гэрээгээ хэрэгжүүлэх үүднээс тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй улсын төсөвт байгууллагуудын шууд захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулан аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах;
- Орон нутгийн төсөвт байгууллагууд хүрэхээр тодорхойлсон зорилго, зорилтоо болон төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан “Үр дүнгийн гэрээ”-гээ биелүүлэх зорилгоор батлагдсан төсвийг үр дүнтэйгээр захиран зарцуулах;
- Орон нутгийн төсөвт байгууллагын түвшинд сар бүрийн эцэст тухайн сарын санхүүжилтийг тайлагнах төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргах;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн ба байдлыг харуулах санхүүгийн тайланг улирал бүр гаргах, төлөөлөн гүйцэтгэх гэрээ, үр дүнгийн гэрээний биелэлтийг харуулах тайланг улирал бүр гаргах;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд буюу тухайн шатны Засаг дарга улс, орон нутгийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн тайланг хагас, бүтэн жилээр гарган дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх зэрэг үйл ажиллагаанууд явагдана.

Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.

Төсвийн тухай хууль болон бусад заавар, журмуудад төсвийн байгууллага батлагдсанаас илүү төсөв зарцуулахыг хориглодог. Батлагдсанаас бага төсөв

зарцуулах нь үр ашигтай үйл ажиллагааг илтгэж болох авч, нөгөө талаас, төлөвлөгдсөн үйлчилгээ хэрэгжээгүй, эсвэл тухайн байгууллагын төсөв бодитой болж чадаагүйг харуулж болно. Иймээс ИТХ-ын төлөөлөгчид, санхүүгийн ажилтнууд жилийн туршид батлагдсан зардал болон бодит зардал (зардлын гүйцэтгэл) хоёрын харьцааг үргэлж хянаж байх ёстой. Төсвийн хэрэгжилтэнд ажиглагддаг түгээмэл үзэгдэл бол зардал хэтрэх явдал юм. Ийм байдал үүсгэхгүйн тулд явцын дунд хяналт шинжилгээг сайжруулж, зардлыг зөв төлөвлөх нь чухал байдаг.

Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн төсөвтэй холбоотой тодорхой зохицуулалтууд үйлчлэх болсон байна. Тухайлбал, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум, дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийг дараах зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах хүртэлх хугацаанд түр зогсоох эрхтэй болсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн;
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал тухайн жилийн төсвөө үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсан;
- Тусгай зориулалтын шилжүүлгийн зориулалт, зарцуулалтын нөхцөл, шаардлагыг зөрчсөн;
- Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандартыг мөрдөөгүйгээс нийт төсөв нь алдагдалтай гарсан;
- Орон нутгийн төсвийн тогтвортой байдал алдагдсан;
- Орон нутгийн төсвийг энэ хуулиар тогтоосон хугацаанд батлаагүй.

Дээрх нөхцөл үүссэн тохиолдолд зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилт болон орон нутгийн төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн харилцаанд оролцогчдын чадавхийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газар болон аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт тогтворжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр хуульчлагдсан байна.

Төсвийн тухай хуулийн төсвийн зарчим, түүнийг хэрэгжүүлэх, төсвийн жилийн талаарх 5-7 дугаар зүйл “Төсвийн хэрэгжилт, гүйцэтгэл” гэсэн 6 дугаар бүлгийн 35-47 дугаар зүйлд төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн явцын гол зохицуулалт болох төрийн сангийн нэгдсэн данс, төрийн сангийн тогтолцоо, төрийн сангийн нийтлэг чиг үүрэг, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, үр дүнгийн гэрээ, төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, төсвийн жил дамжин хэрэгжих арга хэмжээний зохицуулалт, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагаа, төсвийн зарлагын хэмнэлт, төсвийн урамшуулал, нэмэлт төсвийн асуудлыг нарийвчлан тусгаж өгсөн байна.

Үүнээс гадна төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналыг тухайн шатны Засаг дарга орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, ИТХ-д өргөн мэдүүлсний дагуу (Төсвийн тухай хуулийн 61.3) ИТХ нь холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай аймаг, нийслэлийн Засаг даргын байгуулсан төлөөлөн гүйцэтгэх гэрээ, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг төлөөлөн гүйцэтгэх гэрээгээр шилжүүлсэн нийт хэмжээнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгож баталдаг болсон.

Төсөвт зохицуулалт хийх. Төсвийн ерөнхийлөн захирагч нь.

1. Өөрийн төсвийн багцад хамаарах хөтөлбөр хооронд;
2. Түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд;
3. Төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;
4. Түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийнэ.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийх боломжтой бол төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд зохицуулалт хийнэ.

Төсвийн шууд захирагч нь зохицуулалт хийх саналаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тус тус хүргүүлж, Засаг дарга зохицуулалтын саналыг хянаж, зөвшөөрсний дагуу төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ. Энэ зохицуулалтын эрхийг ашигласнаар төсвийн байгууллага өр, авлага үүсгэхгүй байх боломжтой болж байна. Тухайлбал, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга нар болох бөгөөд харьяалагдах төсвийн шууд захирагчийн төсөвт зохицуулалт хийх асуудлыг өөрийн баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ.

Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг төсвийн хуулиар хориглодог байна. Мөн цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон хойшлогдсон, эсвэл зарцуулагдаагүй нэг удаагийн арга хэмжээний зардлыг бусад зардлын зүйлд шилжүүлэн зарцуулахгүй байх зарчим баримтална. Эдгээр зардалд зохицуулалт хийх бол Төсвийн ерөнхийлөн захирагчид хандан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ.

Төсвийн байгууллагын эдийн засгийн ангиллаарх зардлыг байгууллагын тогтмол зардал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал, эд хогшлын зардал, томилолт зочны зардал, бусад бараа үйлчилгээний зардлын бүлгүүдэд ангилах болсон бөгөөд батлагдсан төсвийн тухайн зардлын бүлгийн дүнг 20 хувиар нэмэгдүүлэх зохицуулалтын хүсэлт гаргах, түүнийг нь санхүүжилтийн хуваариар баталж хэрэгжүүлэх боломжтой болсон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн байгууллагаас ирүүлсэн 10 сая төгрөг хүртэлх зохицуулалт хийх хүсэлтийг судлан, зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд зохицуулалтыг хийх бол төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төсвийн байгууллагаас ирүүлсэн 20 сая төгрөг хүртэлх зохицуулалтыг хийнэ.

Төсвийн шинэ харилцаанд шилжсэнээр орон нутгийн төсвийн зарлагын 64 орчим хувийг улсын төсвөөс орон нутагт олгох (санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг) шилжүүлгүүд эзэлж байгаа ба тус шилжүүлгийн нийт дүнгийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг сум, дүүрэг нь аймаг, нийслэлдээ гаргах бол аймаг, нийслэл нь тусгай зориулалтын шилжүүлгийг хариуцсан салбарынхаа Төсвийн ерөнхийлөн захирагчид нь, санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийг Сангийн яаманд гаргаж, санхүүжилтээ шийдвэрлүүлнэ.

Сум, дүүргийн төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн төсвөөс богино хугацаатай зээл олгож болох төдийгүй санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулан тухайн сарын санхүүжилтээ

нэмэгдүүлэх хүсэлтийг аймаг, нийслэлдээ гаргах боломжтой. Аймаг, нийслэлийн хувьд орлогын эх үүсвэрийн боломждоо нийцүүлэн авч үзэн шийдвэрлэх боломжтой бол шийдвэрлэх, эсвэл улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хүсэлтийг гаргах байдлаар санхүүжилтийн дутагдлаа шийдвэрлэх боломжтой байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ. Төсвийн тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 2012, 2013 онд Сангийн сайдын тушаалаар 10 гаруй журам, зааврыг гаргаж “Төсвийн хууль тогтоомж II” эмхэтгэл болгон улсын болон орон нутгийн төсвийн захирагч нар, төсвийн байгууллагын удирдах ажилтнууд, төсөв санхүүгийн мэргэжилтнүүдэд гарын авлага болгон өгсөн байна. Энэхүү гарын авлагыг ИТХ-аар хэлэлцэн баталсан төсвийг Засаг дарга болон төсвийн байгууллагын шууд захирагчид хэрхэн хэрэгжүүлж буйг болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн батлахдаа хурлын төлөөлөгчид ашиглах боломжтой.

Төсвийн тухай хуулийн 8.8 дахь заалтын дагуу орон нутгийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг боловсруулж, хүргүүлэхээс гадна 8.9 дэх заалтад тусгагдсанаар төсвийн улирал, хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг тайлагнах хугацаа, цаглабарыг мөрдөж ажиллах үүргийг төсвийн захирагч нар хүлээдэг.

Орон нутгийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг дараах цаглабарын дагуу боловсруулж, хүргүүлдэг.

- 1) Төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ;
- 2) Төсвийн төвлөрүүлэн захирагч тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 4-ний дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ;
- 3) Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 6-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг боловсруулах цаглабар

8.9.1. төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;

8.9.2. төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.9.3. сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын

25-ны дотор дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

8.9.4. аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

8.9.5. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

Төсвийн тухай хуулийн 8.9 дэх заалт

Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна (Төсвийн тухай хуулийн 54.5). Үүнд:

- Тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл (нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр);
- Татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт;
- Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга (хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан);
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга зэрэг хамаарна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл явц нь дараах үе шатуудаар хэрэгжинэ. Үүнд:

- Орон нутгийн төсөв батлагдсаны дараа жилийн худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөөг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах (*Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаал*);
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний мэдээллийг олон нийтэд зарлан мэдээлэх;
- Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний босго үнэ зохих босго үнээс давсан бол үнэлгээний хороог байгуулах;
- Босго үнэтэй нийцүүлэн худалдан авах ажиллагааны аргыг сонгох (*Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол*);
- Тендерийн баримт бичгийг бэлтгэх, урилгыг зарлан мэдээлэх;


- Тендерийг хүлээн авах, нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлэх;
- Гэрээ байгуулах, гэрээг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
- Худалдан авах ажиллагааны хавтаст хэрэг бүрдүүлж, архивт шилжүүлэх, тайлагнах зэрэг болно.

Орон нутагт хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах эхний шатанд тухайн төслийн босго үнийг авч үзнэ. Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан босго үнийг бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад баримтална. Хэрэв бараа болон ажлын төсөвт өртөг нь 10.0 сая төгрөгөөс доош бол шууд худалдан авч болно. Харин бараа 50.0 сая төгрөг хүртэл, ажил 80.0 сая төгрөг хүртэл, үйлчилгээ 50.0 сая төгрөг хүртэл бол харьцуулалтын аргыг ашиглах, эдгээрээс дээш төсөвт өртөгтэй бол нээлттэй тендер шалгаруулалтын аргыг ашиглана.

2.3.4. ТӨСВИЙГ ХЯНАЖ, ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төсвийн хяналт шалгалтын зорилго нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа үнэн зөв явагдаж байгаа эсэхийг тодорхойлоход оршино. Энэхүү зорилгыг задалж үзвэл, төсвийн хөрөнгийг төлөвлөсөн нийтийн зорилгод ашиглаж байгаа эсэх; төсвийн орлого, зарлагын хэрэгжилтэд хүчин төгөлдөр хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэх гэдэг үндсэн хоёр асуудалд чиглэх ёстой. Үүнээс гадна дээрх зорилгын хүрээнд төсвийн хөрөнгийг зориулалтаар нь, хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байна уу, мөн тухайн байгууллага, орон нутаг төсвийн хөрөнгөөр хүрэх гэсэн зорилгодоо хүрсэн үү гэдгийг шалгаж тодруулахад чиглэгдэнэ.

Монголд төсвийн хяналт, үнэлгээний хэд хэдэн арга механизм байна. Энэ нь дотоод, гадаад гэсэн хоёр хэлбэртэй.



Зураг 2.2. Төсвийн хяналтын хэлбэрүүд

Дотоод хяналтанд дээд шатны Засаг даргын хяналт болон Төсвийн хяналт, дотоод аудитын алба (ТХДАА)-наас хэрэгжүүлэх хяналт орно. Гадаад хяналтын арга механизмд ИТХ-аас тавих мониторинг, төрийн аудитын байгууллагын зүгээс төсвийн зарцуулалт, үр дүнд тавих хяналт болон иргэдийн хяналт багтана.

Монгол улсад санхүүгийн хөндлөнгийн хяналтын дээд байгууллага нь Үндэсний аудитын газар юм. Харин санхүүгийн дотоод хяналт шалгалтыг Сангийн яам болон засаг даргын дэргэдэх Төсвийн хяналт, дотоод аудитын алба хариуцан

гүйцэтгэдэг. Санхүүгийн хяналт, шалгалтад Засгийн газраас байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдана.

Санхүүгийн хяналт, шалгалтыг дор дурдсан чиглэлээр хийдэг. Үүнд:

- санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт;
- өмч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт;
- санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан.

Дотоод хяналтын зорилго нь төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагаа гэж тодорхойлогдож байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, зөрчлийг тайлагнахаас илүүтэй байгууллагад учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сул талыг сайжруулах чиглэлтэй хэрэгжинэ. Хяналтыг явуулахдаа төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах болон хяналтаас гарсан зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээ гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэнэ. Төсвийн гадаад хяналтыг аймаг, нийслэлийн төрийн аудитын газар тавихаас гадна тухайн орон нутгийн ИТХ болон иргэдийн зүгээс тавих хяналт орж байдаг. Тухайн жилийн орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг хянах бүрэн эрх тухайн шатны ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх юм. Дотоод хяналт ба дотоод аудитын ялгааг дараах хүснэгтэд харьцуулан харууллаа.

Хүснэгт 2.3. Дотоод хяналт ба дотоод аудитын ялгаа

Ялгагдах шинж	Дотоод хяналт	Дотоод аудит
Хийх субъект	НББ, хууль, эдийн засаг гэх мэт байгууллагын дотоод нэгж, хэсгийн мэргэжилтнүүд хийдэг	Дотоод аудитын болон дотоод хяналтын ажилтнууд хийдэг
Зорилго	Үйл ажиллагааг үр ашигтай явуулах тасралтгүй хяналтыг эдийн засгийн субъект дээр хэрэгжүүлдэг	Байгууллагын нэгж хэсгийн ажлын чанарын хяналт, дотоод хяналтын системийн үнэлгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ
Эрхийн статус	Холбогдох аж ахуйн нэгж, албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагын тухай журмыг баримтална	Дотоод аудитын албаны журмыг удирдлага болгож төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа тайлагнана
Хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх технологи	Захиргаа, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн хяналтын арга, технологийг ашиглана	Урьдчилсан төлөвлөгөө, эрсдлийн үнэлгээ, хяналт шалгалтын үнэлгээ, аудитын хөтөлбөр боловсруулах, аудит хийх арга, баримтжуулалт зэрэг аудитын стандарт тусгай аргыг ашигладаг

Эх сурвалж: Майнбаяр Б. Дотоод аудит ба дотоод хяналт (COSO), тэдгээрийн ялгаатай талууд. Дэлхийн банк. Олон салбарыг хамарсан техник тусалцааны төсөл. УБ., 2011.

Засгийн газраас 2011 оны 11 дүгээр сарын 9-нд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн 311 дүгээр тогтоол гаргаж “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг баталсан. Гэхдээ энэ журмын 1.7 дахь заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийхэд энэхүү нийтлэг журам хамаарахгүй”¹² гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн “Хяналт, шалгалт” гэсэн 10 дугаар бүлгийн “Дотоод аудит” гэсэн 69 дүгээр зүйлд “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийн явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгч эрсдлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитыг хэрэгжүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитыг арга зүйгээр хангана. Дотоод аудитын дүрмийг Засгийн газар батална” гэжээ.

Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны 129 дүгээр тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”¹³-ийг, Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 30-ны 29 дүгээр тушаалаар “Дотоод аудитын хорооны дүрэм”¹⁴-ийг батлан гаргаж, бүх шатны төсвийн захирагч нар дагаж мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын дүрмээр Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон дотоод аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллах зэрэг харилцааг зохицуулдаг.

Дотоод аудитын үйл ажиллагааны зорилго нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

2.4. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Орон нутгийн төсвийн төсөл гэдгийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн, хуульд заасан шаардлагын дагуу төсвийн шатлал бүрээр төсвийн ангилал ашиглан бүх шатны Засаг даргаас тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн төсвийн санал гэж ойлгоно.

¹² Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 311 дүгээр тогтоолын хавсралт

¹³ Дотоод аудитын дүрэм. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 129 дүгээр тогтоол. Сангийн яам. “Төсвийн хууль тогтоомж II” заавар, журмын эмхэтгэл. УБ., 2013, 41-48 дахь тал.

¹⁴ Дотоод аудитын хорооны дүрэм. Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 29 дүгээр тушаал. Сангийн яам. “Төсвийн хууль тогтоомж II” заавар, журмын эмхэтгэл. УБ., 2013, 236-240 дэх тал.

2.4.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Орон нутгийн жилийн төсвийн төсөл нь дараахь шаардлагыг хангасан байна¹⁵. Үүнд:

- үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх;
- төсвийн тэнцэл алдагдалгүй байх;
- хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;
- эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;
- худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх шаардлагууд хамаарна. Мөн орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байхаар заажээ.

Байгууллага дээд шатнаас ирсэн суурь төсвийн төслийг үндэслэн төсвийн төслөө боловсруулах зарчим баримтална. Өөрөөр хэлбэл, төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь байгууллагуудын төсвийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн ангилал хооронд хөдөлгөөнд оруулах эрхийнхээ хүрээнд ажиллаж, өр үүсгэх хэмжээний хөдөлгөөнийг хийхгүй байх шаардлагатай юм.

Төсвийн шинэ хуулиар мөн төсвийн удирдамжийн тухай ойлголт бий болсон. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Сангийн яам) төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн төсөл бэлтгэх удирдамж хүргүүлэх ба тус удирдамжид орон нутгийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг тусган, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлдэг бол аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн Засаг даргад удирдамж хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг даргаас хүргүүлэх удирдамжид өөрийн мөрийн хөтөлбөр, төлөвлөлтийн бусад шаардлага, төсвийн төслийн санал хүргүүлэх хугацаатай холбоотой бусад заавар, чиглэлийг тусган холбогдох төсвийн захирагчид хүргүүлэх боломжтой болсон.

Төсвийн төслийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулж боловсруулах бөгөөд Төсвийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж батлуулах хугацаа, дараалал хуульчлагдсаныг дагаж мөрдөнө. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан улсын хэмжээний нэгдсэн төсвийн үзүүлэлтээр орлого, зарлага, төсвийн тэнцлийн үзүүлэлт, улсын өрийн дээд хязгаар гэх мэт мэдээллийг багтаан баталдаг. Иймд төсвийн задаргаа болон санал авагдахгүй.

УИХ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор хэлэлцэж, баталдаг бол Засгийн газар төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн зарлагын хязгаарыг 7 дугаар сарын 1 гэхэд батална. Зарлагын хязгаарыг боловсруулах үе шатанд төсвийн тухай хуулийн 8.3 дахь заалтыг мөрдөх бөгөөд тус батлагдсан зарлагын хязгаарын мэдээллийг Сангийн яамнаас төсвийн ерөнхийлөн захирагчид 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн удирдамжийн хамт хүргүүлнэ. Энэхүү Төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан Засгийн газраар батлагдсан зарлагын хязгаарт орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг

¹⁵ Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 7.1 дэх заалт

зэрэг нь нийт дүнгээрээ батлагдаж, аймаг, нийслэлд төсвийн удирдамжийн хамт хуулийн хугацаанд хүргэгдэнэ. Аймаг, нийслэл нь хүлээн авсан төсвийн удирдамж, улсын төсвөөс олгох шилжүүлгийн дүнг сум, дүүрэгтээ ажлын 3 хоногт багтаан хүргүүлэхээр журамласан. Өөрөөр хэлбэл, дараа жил нь улсын төсвөөс хүлээн авах улсын төсвийн шилжүүлгийн нийт дүн 7 дугаар сарын дундуур орон нутгийн байгууллагуудад урьдчилсан байдлаар тодорхой болдог болсон байна.

Үүнтэй зэрэгцэн орон нутгийн байгууллагууд дараа жилийн төсвийн дэлгэрэнгүй тооцооллоо хийж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэхээр бэлтгэж байдаг бөгөөд хүлээн авсан нийт дүнгийн мэдээлэлд үндэслэн төсөв дээрээ ажиллах, холбогдох саналаа боловсруулах боломжтой болсон юм.

2.4.2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСЛИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

Орон нутгийн төсөв нь тухайн орон нутгийн байгууллагуудын төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийн бүрдэл болно. Тухайн шатны Засаг дарга ИТХ-д орон нутгийн төсвийн төслөө өргөн мэдүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 32.2 дахь заалтад тусгагдсан зүйлсийг төсвийн төслийн танилцуулгад оруулсан байхаас гадна дараах зүйлсийг нэмж тусгах шаардлагатай (Төсвийн тухай хуулийн 67.1-67.3). Үүнд:

- орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;
- хуульд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;
- аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;
- дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, дээр дурдсан зүйлсийг багтаасан танилцуулгын хамт тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ. Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг ИТХ-д танилцуулна¹⁶. Орон нутгийн төсвийн танилцуулгад дараах мэдээлэл тусгагдсан байх шаардлагатай. Үүнд:

- төсвийн тэнцлийн үзүүлэлтийг тооцсон байдал;
- төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдлийн үнэлгээ;
- татварын орлогын тооцоолол;
- хөрөнгө оруулалтын жагсаалт;
- санхүүжилтийг зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, төсөвт үзүүлэх нөлөөлөл;
- ногдол ашгийн хэмжээ;
- хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, орц, хүрэх үр дүн гэх мэт.

Орон нутгийн төсвийн төслийг хамгийн багадаа 4 баганаар харуулах боломжтой байна. Тэрхүү багануудын зөрүүгээр төсвийн орлого, зарлагын хөдөлгөөнийг харж болно. Жишээлбэл, 2016 оны төсвийн төслийг Засаг дарга ИТХ-д оруулж ирэхдээ 2014 оны гүйцэтгэлийн багана, 2015 оны төлөвлөгөө юмуу хүлээгдэж буй гүйцэтгэлийн багана, 2016 оны дээд шатнаас ирүүлсэн суурь төсвийн багана, 2016 оны батлагдах багана гэсэн хэлбэрээр харуулна. Эдгээр багануудын зөрүүнээс ИТХ-ын төлөөлөгчид шийдвэртээ ашиглах мэдээллийг харж болно.

¹⁶ Төсвийн тухай хуулийн 67.1, 67.3 дахь заалт

Хүснэгт 2.4. Орон нутгийн төсвийн төслийн бүтэц, агуулга

Аймаг, нийслэлийн төсвийн төсөл	Сум, дүүргийн төсвийн төсөл
<ol style="list-style-type: none"> 1. Аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын тухайн жилд олох орлогын хэмжээг дараах байдлаар тооцсон байх: <ul style="list-style-type: none"> • аймаг, нийслэлийн төсвийн нийт орлогын дүнг нэр, төрлөөр; • төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлогын хэмжээ, харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр. 2. Аймаг, нийслэлийн Засаг дарга урсгал зарлага, хөрөнгийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дээд хэмжээг төсвийн захирагч бүрээр; 3. Бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тооцох: <ul style="list-style-type: none"> • аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийн хэмжээг сум, дүүрэг тус бүрээр; • аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг сум, дүүрэг тус бүрээр; • аймаг, нийслэлийн төсөвт сум, дүүргийн төсвөөс татан төвлөрүүлэх орлогын хэмжээг сум, дүүрэг тус бүрээр; • аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг зориулалтын чиг үүрэг, сум, дүүрэг тус бүрээр; • аймаг, нийслэлийн төсвөөс ОНХС-д хөрөнгө төвлөрүүлэхээр бол орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээгээр. 4. Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зардлыг зарлагын томсгосон ангиллаар тооцох; 5. Аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараах зүйлийг тусгана: <ul style="list-style-type: none"> • төсвийн захирагчийн нэр; • хөтөлбөрийн нэр; • тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт; • тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; • зарцуулах төсөв. 	<ol style="list-style-type: none"> 1. Сум, дүүргийн Засаг дарга өөрийн төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын тухайн жилд олох орлогын хэмжээг дараах байдлаар тооцсон байх: <ul style="list-style-type: none"> • сум, дүүргийн төсвийн нийт орлогын дүнг нэр, төрлөөр; • төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяалах төсөвт багууллагын өөрийн орлогын хэмжээ, харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр. 2. Сум, дүүргийн Засаг дарга урсгал зарлага, хөрөнгийн зарлагын дээд хэмжээг төсвийн захирагч бүрээр. 3. Сум, дүүргийн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутагт Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлж буй улсын төсөвт байгууллагад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг дараах байдлаар тооцох: <ul style="list-style-type: none"> • сум, дүүргийн төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг хөтөлбөрөөр, төсвийн захирагч бүрээр; • сум, дүүргийн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр. <ol style="list-style-type: none"> 1. Сум, дүүргийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулан, дараах зүйлийг тусгана: <ul style="list-style-type: none"> • төсвийн захирагчийн нэр; • хөтөлбөрийн нэр; • тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт; • тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; • зарцуулах төсөв. 2. Сум, дүүргийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулан, дараах зүйлийг тусгана: <ul style="list-style-type: none"> • төсвийн захирагчийн нэр; • хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр; • байршил; • хүчин чадал; • хэрэгжүүлэх хугацаа; • төсөвт өртөг; • санхүүжүүлэх эх үүсвэр; • тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн.

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагад тавигдах шаардлага

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх эрх олгогдсон. Мөн Төсвийн хуулийн хариуцлагатай байх зарчимд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төсвийн хуульд заасан чиг үүргээс бусад чиг үүргийг өөр хууль тогтоомжоор тогтоосон бол тухайн чиг үүргийг санхүүжилтийнх нь хамт шийдвэрлэн шилжүүлдэг байхаар хуульчилсан байна. Иймд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд санхүүжилтийнхээ эх үүсвэртэй орон нутагт шилжиж байна. Энэ хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамирын үйлчилгээг хэрэгжүүлэхээр санхүүжилтийн эх үүсвэртэй нь хамт орон нутагт шилжүүлжээ.

Эдгээр чиг үүргийг гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ. Гэрээг тухайн шатны төсөв батлагдсанаас хойш ажлын 14 хоногийн дотор байгуулна. Салбарын сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай, аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум, дүүргийн Засаг даргатай төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулна.

Тусгай зориулалтын шилжүүлэг нь чиг үүрэг бүрээр улсын төсөвт ерөнхийлөн захирагчийн багцад эхэлж батлагдана. Дараа нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлого, зарлагад батлагдана. Шилжүүлэг хүлээн авагч аймаг, нийслэлийн Засаг дарга Төсвийн төвлөрүүлэн захирагч нь болно.

Засаг дарга төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр төсвийн хуваарилалтын саналаа бэлтгэж, орон нутгийн төсвийн төслийн хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж батлуулна. Ингэхдээ тухайн чиг үүргийн төсвийг бусад чиг үүрэгт шилжүүлэх хөдөлгөөн хийхийг хориглодог байна. Харин төвлөрүүлэн захирагчийн эрхийн хүрээнд чиг үүрэг дотор зохицуулалт хийж болно. Өөрөөр хэлбэл, Боловсролын сайд буюу нэг сайдын багцад батлагдсан ч сургуулийн өмнөх боловсрол ба ерөнхий боловсролын сургуулийн төсөв хооронд шилжүүлэн батлах боломжгүй бол сургуулиудын төсвийг төвлөрүүлэн захирагчийн олгогдсон эрхийнхээ хүрээнд хөдөлгөөнд оруулж болно. Мөн Соёлын сайдын багцын нийтийн биеийн тамир ба соёлын үйлчилгээний зардлыг хооронд нь гүйлгэж батлах боломжгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээ, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг гэрээгээр шилжүүлсэн нийт хэмжээнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгон батална. Мөн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын өөрийн орлого буюу үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг тухайн шатныхаа ИТХ-аар батлуулан зарлагадаа зарцуулна. Хамгийн сүүлд батлагдсан төлөвлөгөө нь жилийн эцсийн тайлангийн төлөвлөгөөнд тусгагдаж явна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай зориулалтын чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхдээ тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутгийн төсвийн суурь зарлага болон бусад салбарын санхүүжилтэд шилжүүлэхгүй байх, өр, авлага үүсгэхгүй байх үйлчилгээний стандарт, тоо хэмжээ, чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчим баримтална.

Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна.

2.5. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨВЛӨЛТ

Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл нь төсвийн хөрөнгө оруулалт юм. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт нь зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хязгаарлагдахгүй. Орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалт нь:

- Улсын төсвийн санхүүжилтээр аймаг, нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалт;
- Улсын төсвийн санхүүжилтээр сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт;
- Аймаг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт;
- Аймаг, нийслэлийн төсвөөр сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт;
- Сум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт;
- Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт;
- Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт;
- Сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт;
- Зээл, хандив, тусламжаар аймаг, нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалт;
- Зээл, хандив, тусламжаар сум, дүүрэгт хийгдэх хөрөнгө оруулалт гэх мэтээр ангилагдаж болно.

Иймд дээрх орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг уялдуулах, үр ашигтай байдлыг хангах шаардлага гарна. Жишээлбэл, төсвийн шинэ хууль хэрэгжиж эхэлснээр орон нутагт бий болсон орлого 100 хувь орон нутагтаа зарцуулагдах болж, улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүжилт дээр дурдсан эх үүсвэрүүдийг нэмэхэд орон нутгийн төсөвт 2013 оноос эхлэн 2012 онтой харьцуулахад 2.5 дахин их төсөв зарцуулах болж өргөжсөн бол дунд хугацаанд зарцуулах төсөв 30-50 хувиар нэмэгдэх тооцоо хийгджээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хуульд заасны дагуу дараах асуудлуудыг нягтлан үзсэн байх шаардлагатай. Үүнд:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачаалал бий болох эсэх дүгнэлтийг гаргасан байх;
2. Хөрөнгө оруулалтын арга хэмжээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой нь урьдчилсан судалгаагаар нотлогдсон байх;
3. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад тухайлбал, газрын зөвшөөрөл болон инженерийн шугамд холбох зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгах;
4. Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байгаа эсэхийг нягтлах;
5. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг нь тодорхойгүй арга хэмжээ тусгагдсан эсэх.

Тухайлбал, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн санхүүжилтээр барьсан зарим барилга, байгууламжийн ашиглалтын зардлыг хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг асуудал барилгыг баригдсаны дараа яригдахгүй, төсөв нь тусгагдаж хэрэгжихээс өмнө шийдвэрлэгдсэн байхыг хуулиар зохицуулж өгсөн. Мөн зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл батлагдаад

тухайн жилдээ зураг төсвийг нь хийгээд ажил нь эхэлсэнгүй, зураг төсөв хийгдсэний дараа төсөвт өртөг нь дутаад тендер шалгаруулалт зарлагдсангүй, эсвэл олон жил дамжаад төсөв дутсан гэдэг асуудал хуулиа дагаж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд яригдах боломжгүй болох нь харагдаж байна.

29.3. Сангийн яам, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана:

- 29.3.1. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;
- 29.3.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;
- 29.3.3. нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;
- 29.3.4. санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;
- 29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх

Түүнчлэн Төсвийн тухай Монгол Улсын хуульд хөрөнгө оруулалтын төсвийг хэрхэн хийх талаар буюу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг жилийн төсвийн төсөлд хэрхэн тусгахыг дараах байдлаар нарийвчлан зохицуулжээ.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг ОНХС-гийн хөрөнгө оруулалтад тусгахыг хуулиар хориглосон. Харин нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг орон нутгийн төсвийн суурь зарлагад дараах байдлаар тусган хянуулж тооцохоор журамлажээ. Үүнд:

- Өөрийн хэрэгцээнд албан конторын барилга худалдаж авах, эсвэл шинээр барих бол өмнөх барилгын ашиглалтын хэрэгцээ хангахгүй болсныг нотолсон мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- Шинээр барих барилгын зураг төсөв, техникийн бусад зөвшөөрөл;
- Их засвар хийхээр бол холбогдох төсвийг зохих норм, норматив, дүрмийн дагуу бэлтгэсэн байх;
- Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдаж авахаар бол өмнө нь ашиглаж байсан хөрөнгө нь зохих элэгдлийн нормд заасны дагуу өртгөө бүрэн нөхсөн, эсвэл зохих журмын дагуу хэрэглээнээс актлагдсан бол орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлээс хасагдсаныг нотолсон байх;
- Албан хэрэгцээний автомашин авах бол зөвхөн шинэ автомашин худалдан авахаар тооцох;
- Шинэ хөрөнгө оруулалттай холбоотой урсгал зардлын хэмжээг тооцсон байх шаардлагатай.

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, орон нутгийн төсөвт авсан эзэл, хандив, дэмжлэг тусламжаар бий болсон хөрөнгө нь орон нутгийн өмчид

бүртгэгдэнэ. Мөн төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр орон нутгийн өмчид хамааруулна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхдээ Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-нд баталсан 290 тоот “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ыг мөрдөж ажиллах болсон байна. Тус журамд хөрөнгө оруулалттай холбоотой зарим нэр томъёог тусгажээ. Тухайлбал, барилга байгууламжид барилга, түүний гадна инженерийн шугам сүлжээг оруулах бол их засвар гэдэгт барилга байгууламжийн бүтээцийн бүрдэл хэсэг, инженерийн тоног төхөөрөмжийг солих, засч сэлбэх, түүний ашиглалтын байдлыг сайжруулах зорилгоор хийгдсэн барилгын засварыг оруулна. Харин тоног төхөөрөмжид авто тээврийн хэрэгсэл, тавилга, компьютер, техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг оруулж байна. Энэхүү ангилал нь орон нутгийн хөрөнгө оруулалтаас гадна гадаад зээл тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад мөн хамаарна.

2.6. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, ТҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ

2.6.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Төсвийн тухай хуулиар орон нутаг орон нутгийнхаа хөгжлийг дэмжих зорилготой Орон нутгийн хөгжлийн сантай байхаар хуульчилсан. Иймд аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр нь орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй, түүнийг хэрэгжүүлэх богино хугацааны төлөвлөгөөтэй байх шаардлагатай ба ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг эдгээр хөтөлбөртэйгээ уялдуулах төдийгүй улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн уялдааг ханган төлөвлөсөн байна. Ингэснээр хөгжлийн сангаар хэрэгжих төслүүд нь илүү үр ашигтай болох боломжтой.

ОНХС нь Төрийн санд тусдаа данстай, улсын төсөвт Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан байна. Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хүлээн авсан орлогын шилжүүлгийнхээ 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн ОНХС-д хуваарилах төдийгүй аймаг, нийслэл, сум, дүүрэг нь төсвийн хуулиар олгогдсон эрхийн хүрээнд хөгжлийн сангийн орлогоо өсгөж, зарлагаа нэмэгдүүлж болно.

ОНХС нь орон нутгийн төсвийн нэг хэсэг болох ба ИТХ-ын тогтоолын 2 дугаар хавсралтад ОНХС-д хүлээн авч буй орлогыг орлого талд, зарлагыг зарлага талдаа тусган батлуулж, хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчдөө бүртгэнэ. Тус сангийн худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг мөрдөх бол санхүүжилтийг зохион байгуулахад Сангийн сайдын баталсан 2012 оны 290 тоот “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ыг дагаж мөрдөнө. Мөн сум, дүүргийн түвшинд 20 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл хэрэгжүүлэх бол Сангийн сайдын 2013 оны 39 тоот тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ыг мөрдөж болно.

ОНХС-гийн зарцуулаагүй үлдэгдэл болон худалдан авах ажиллагааны явцад бий болсон хэмнэлт нь орон нутгийн хөгжлийн сангийн дансанд үлдэж, дараа жилийн эх үүсвэр болж, ИТХ-аар төсөв батлагдсанаар хэрэгжих боломжтой болох бөгөөд оны эхэнд бол батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр байдлаар зарцуулах боломжтой байна.

2.6.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулах боломжтой болон боломжгүй чиглэлийг Төсвийн тухай хуулиар хуульчилж өгсөн байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн санд хөрөнгийг хуваарилах аргачлалыг “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлан мөрдүүлж байгаа бол Сангийн сайдын 2012 оны 244 тоот “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг баталсан тушаалаар иргэдийн саналыг орон нутгийн хөгжлийн санд хэрхэн авах арга, дарааллыг тогтоож мөрдөн ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 7.6.6 дахь заалтад сум, дүүргийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэрхэн боловсруулахыг заасан бөгөөд уг журмын 12-р зүйлд аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хэрхэн хангахыг журамласны зэрэгцээ хавсралтад нь аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт, мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг оруулан баталжээ.

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6.3 дахь заалтад “Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхөд дараахь зүйлсийг баримтална” гэж тусгасан байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулиар ОНХС-гийн хөрөнгөөр зарцуулахыг хориглосон зүйлсийг баримтлах;
- Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт зарцуулахаар төлөвлөхгүй байх;
- Хөрөнгө, оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;
- Орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;
- Иргэдийн оролцоог хангасан байх;
- Зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр эх үүсвэртэй давхардуулахгүй байх;
- Төслөөр шинээр бий болсон, эсвэл сайжруулсан өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдолтой урсгал зардлын тооцоо, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай саналыг тусгасан байх асуудал хамаарна.

ОНХС-гаар хэрэгжүүлэх төслүүдийг хөгжлийн бодлоготойгоо дараах байдлаар уялдуулах боломжтой. Тухайлбал, иргэдийн Нийтийн Хурал 5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 30-ны хооронд хуралдаж, гаргасан шийдвэрээ 2 дугаар улиралд багтаан сум, дүүргийн Тамгын газарт хүргүүлдэг. Энэхүү хурлаас 14 хоногийн өмнө баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн санд иргэдийн гаргасан саналыг

нэгтгэн жагсаалт бэлтгэх ажлыг хэрэгжүүлэх ба тус дэлгэрэнгүй саналын мэдээллээ иргэддээ буцаан хүргэсэн байх үүрэгтэй. Мөн сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, дүүрэг, баг, хороонд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээллээр иргэдийг хангасан байхаар журамлагдсан байна.

Түүнчлэн ОНХС-д батлагдах төсөл нь иргэдийн саналыг заавал авсан байх ёстой тул дээрх мэдээллээс гадна зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжихээр мэдэгдсэн төсөл, урьд оны дансны үлдэгдлийг шинэ төсөлд зарцуулах, зураг төсвийн зардлыг оруулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн төслүүдийн мэдээллээ иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 14 хоногийн өмнө иргэддээ хүргэсэн байх шаардлагатай. Мөн ИТХ-ын төлөөлөгч ч иргэнийхээ хувьд саналаа гаргах, тухайн хугацаанд иргэддээ мэдээллийг түгээж ажиллах боломжтой юм.

Ийнхүү иргэд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэгдэх мэдээллийг урьдчилан 14 хоногийн өмнө дэлгэрэнгүй байдлаар хүлээн авснаар санал өгөх, сонголт хийхдээ илүү идэвхтэй хандах бөгөөд иргэдийн Нийтийн Хурлаас гаргах иргэдийн шийдвэр нь тухайн орон нутгийнхаа хэтийн хөгжлийн бодлогыг харгалзсан, түүнтэйгээ уялдсан байх боломж бүрдэнэ.

ОНХС-гаас хэрэгжих төсөл, арга хэмжээний зураг төсвийн зардлыг тухайн төсөл, арга хэмжээний батлагдсан төсвөөс нь санхүүжүүлэх, эсвэл тусад нь зураг төсвийн зардал батлуулан санхүүжүүлэх бөгөөд батлагдсан зураг төсвийн зардлыг зөвхөн ОНХС-гаас санхүүжүүлэхээр хуулиар зөвшөөрөгдсөн төсөл, арга хэмжээний зураг төсөвт зарцуулах боломжтой.

Сумдын чиг үүрэгт хамаарахгүйгээс сумын ОНХС-гаас санхүүжүүлэх боломжгүй, харин аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиглэлд хамаарах төслийн санал иргэдээс гарч дэмжигдсэн тохиолдолд тус саналын жагсаалтыг аймагтаа хүргүүлэн аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх боломжтойг журмаар зохицуулж өгсөн байна.

Боловсрол, эрүүл мэнд, соёл, нийтийн биеийн тамир гэх мэт нийгмийн салбарын байгууллагуудын барилгын засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хуулиар тодорхойлогдсон бусад чиг үүргийн хүрээнд ОНХС-гаас санхүүжүүлэх, харин дээрх салбарт шинээр баригдах барилгын асуудал нь тухайн салбарын хөгжлийн нэгдсэн бодлогын хүрээнд шийдэгдэх учраас эрхэлсэн сайдтай нь харилцан зөвлөлдөх, улсын төсөвт тусгуулах замаар хэрэгжүүлнэ.

ОНХС-гийн хөрөнгөөр зураг, төсөв зайлшгүй боловсруулах шаардлагагүйгээр хэрэгжүүлэх зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд дараах чиглэлүүдийг авч үзэх боломжтой байна. Үүнд:

- Барилгын тухай хуулийн 3.1.4 дэх заалтаар тодорхойлогдсон “барилга байгууламж”-д хамаарахгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ;
- Барилгын тухай хуулийн 14.1, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.8, 15.14, 15.15 дэх заалтын дагуу барилга, эрчим хүч, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгогддог барилгын тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдэхгүй үйл ажиллагаа;
- Барилга байгууламжийг дулаан, уур, цэвэр, бохир ус, цахилгаан, холбоожуулалт, радио, дохиоллын эх үүсвэр зэрэг инженерийн хангамжид холбох асуудлаар эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл олгох шаардлагагүйгээр хийгдэх төсөл, арга хэмжээ зэрэг болно.

Орон нутгийн хөгжлийн санд хэрэгжих боломжтой төсөл мөн эсэхийг тодорхойлохдоо Төсвийн тухай хуулийн 60.3, 60.4 дахь заалт болон 58 дугаар зүйлд тусгасан аймаг, нийслэл, сум, дүүргийн хэрэгжүүлэх чиг үүргийг авч үзэн тодорхойлох боломжтой байна.

ОНХС-гийн хөрөнгөөр зарцуулахыг хориглосон зүйлс:

- 60.3.1. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.
- 60.3.2. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;
- 60.3.3. Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;
- 60.3.4. Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа
- 60.3.5. Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;
- 60.3.6. Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.
- 60.4. Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.

ОНХС-гаас орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхээр батлахыг хуулиар хориглосон бөгөөд нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардалд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг даргын Тамгын газар болон баг, хорооны үйл ажиллагааны урсгал ба хөрөнгийн зардлыг оруулна.

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу сум, дүүргийн Засаг дарга нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад:

- төсвийн захирагчийн нэр;
- хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр;
- байршил;
- хүчин чадал;
- хэрэгжүүлэх хугацаа;
- төсөвт өртөг;
- санхүүжүүлэх эх үүсвэр;
- тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг тусган боловсруулж, төсвийн төслийн хавсралт байдлаар бэлтгэн сум, дүүргийн ИТХ-д өргөн барина.

Сум, дүүргийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог дараах байдлаар хангахаар журамласан байна. Үүнд:

- 1) Баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна:
 - Баг, хорооны иргэдээс санал асуулгыг авахдаа санал асуулгын хуудсаар, бүлгийн ярилцлага, цахим хэлбэрээр авна;
 - Саналыг асуулгын хуудсаар авахад “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 1 дүгээр хавсралтад заасан маягыг ашиглах ба маягыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ;

- Дээр дурдсан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна.
- 2) Баг, хорооны Засаг дарга иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 2 долоо хоногийн өмнө тухайн сум, дүүрэгт хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо, иргэдээс гаргасан саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, дүүрэг, баг хороонд хэрэгжүүлэх шаардлагатай хөгжлийн бодлого чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээлэл, өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх товч мэдээллийг баг, хороодод байршуулсан байна;
- 3) Баг, хорооны Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ;
- 4) Сум, дүүргийн Засаг дарга олон нийтээс авсан саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг олон нийтэд танилцуулан, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж болно;
- 5) Сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журамд заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ;
- 6) Сум, дүүргийн Засаг дарга баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй бол саналын жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж болно.

Төсвийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан журмуудад ОНХС-д аймаг, нийслэл, сум, дүүрэг хэдэн төгрөг хүлээн авах боломжтойгоо мэдэх боломж олгосон. Тухайлбал, Төсвийн хүрээний мэдэгдэл, Зарлагын хязгаар батлагдсаны дараа түүнд тусгасан ОНХС-гийн дараа жилийн урьдчилсан дүнг 7 дугаар сард Сангийн яамнаас аймаг, нийслэлд хүргүүлэх бөгөөд түүнийг нь аймаг, нийслэлээс сум, дүүрэгтэй хүргүүлнэ. Мөн УИХ-д улсын төсөв өргөн мэдүүлсний дараа түүнд тусгасан ОНХС-гийн дүнг 10 дугаар сард, харин батлагдсан дүнг улсын төсөв батлагдсаны дараа 11 дүгээр сард тус тус хүргүүлэхээр журамлажээ. Иймд дээрх мэдээллийг ашиглан хөгжлийн сангийн төслүүдээ урьдчилан тооцох, худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах, зураг төсвийг боловсруулах боломжтой.

2.6.3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТ

ОНХС-гийн эх үүсвэрийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь тухайн сард Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хэрхэн төвлөрнө тухайн дүнг аймаг, нийслэлд дараа сард нь хуваарилах зарчим санхүүжилтийн явцад мөрддөг. Хэрэв тухайн сард дээрх 2 орлого тасарвал төлөвлөгөөт санхүүжилт тасарсан дүнгээр дутуу олгогдож, жилийн дүнд мөн энэ зарчим үйлчилдэг.

Орлогын тасралтаас гадна дараах хүчин зүйлс санхүүжилтэд нөлөөлдөг. Аймаг, нийслэлийн ОНХС-д сар тутам олгох хөрөнгийг батлагдсан төлөвлөгөөний биелэлт, ажлын болон санхүүжилтийн гүйцэтгэлийн явц байдалтай нь уялдуулан авч үзэх чиглэл баримталдаг. Жишээлбэл, ОНХС-даа авсан санхүүжилтээ тухайн сум, дүүрэг зарцуулахгүй бол дараа сарын санхүүжилт нь багаар олгогдож байна.

Сум, дүүргийн дансны үлдэгдэл нь аймаг, нийслэлийн нийт үлдэгдэлд нөлөөлж, улмаар олгох санхүүжилтэд нөлөөлнө. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон аймаг, нийслэлийн дансны үлдэгдэлд үндэслэн тухайн аймаг, нийслэлд олгох орлогын шилжүүлгийг тооцдог байна. Өөрөөр хэлбэл, ажил нь хийгдээд санхүүжилт дутагдаж байгаа сумдын дансны үлдэгдлийг харгалзан тухайн аймгийн сумдын ОНХС-гийн нийлбэр тооцогдох ба бага үлдэгдэлтэй бол санхүүжилт шаардлагатай байна хэмээн үзэж, санхүүжилтийг дутагдал үүсгэхгүйн үүднээс илүү санхүүжилт олгох зарчим үйлчилдэг байна.

Ийнхүү дансны үлдэгдэлийг тооцдог болсноор ажил нь хийгдээгүй байхад мөнгө нэмж олгон дансан дахь ашиглалтгүй хөрөнгийг нэмэгдүүлэхгүй, нөгөө талаар ажил нь хийгдээд санхүүжилт нь дутагдаж байгаа сум, дүүрэг санхүүжилтээ нэмж авах бүрэн боломжтой болсон төдийгүй хөрөнгийг үр ашигтай байршуулах, удирдах боломжийг давхар олгосон байна.

ОНХС-гийн төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах явцад санхүүжилтийн эх үүсвэр дутагдах тохиолдолд орон нутгийн төсвийн хөрөнгөөс ОНХС-гийн төслийг санхүүжүүлж зохицуулах, эсрэгээрээ ОНХС-гийн дансны үлдэгдлийг орон нутгийнхаа төсвийн санхүүжилтэд ашиглахыг хориглосон. Санхүүжилтийг нэмэгдүүлэх хүсэлтийг дээд шатны төсөвт гаргах буюу сум, дүүргийн хувьд аймаг, нийслэл рүү, аймаг, нийслэлийн хувьд улсын төсвөөс олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх албан хүсэлтийг гаргаснаар санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулан санхүүжилтийг нэмж зохицуулдаг.

Улсын хэмжээнд ОНХС-гийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс 2014 оноос эхлэн Сангийн яамнаас “Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн систем”-ийг ажиллуулж эхэлсэн. Тус мэдээллийн системд сум, дүүрэг хүртэлх бүх сангуудын төслийн төлөвлөгөө, санхүүжилтийн сарын хуваарийн төлөвлөгөө бүртгэгдэх төдийгүй тухайн шатны санд хүлээн авч байгаа санхүүжилтийн дүн болон тухайн сангаас санхүүжсэн төслүүдийн мэдээлэл бүртгэгдэж явах боломжтой. Цаашид тус системийн мэдээлэл нь санхүүжилтийн шаардлагыг харуулах суурь мэдээлэл болох тул энэхүү системд мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай оруулж, шинэчлэн санхүүжилтийн асуудлаа шийдвэрлүүлнэ.

2.6.4. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Орон нутгийн хөгжлийн сан Төсвийн тухай хуульд тусгагдаж, 2013 оноос хэрэгжиж эхэлсэн харьцангуй шинэ ойлголт хэдий ч уг сангийн зарцуулалтын чиглэлээр хэд хэдэн судалгааны ажил хийгдсэн. Тухайлбал, 2013 онд Швейцарийн Хөгжлийн Агентлагийн захиалгаар IRIM судалгааны хүрээлэн “Төсвийн тухай

хуулиар зохицуулсан орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт болон иргэдийн оролцооны үнэлгээ” судалгааг хийсэн.

Уг судалгаагаар төсвийн тухайн хуулийг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор төв засгийн газар болон орон нутгийн түвшинд гарч буй бодлого, шийдвэрүүдийн үр нөлөө болон үр ашигтай байдлыг сайжруулахад шаардлагатай байгаа мэдээллийг боловсруулсан. Энэхүү судалгаагаар үндэсний хэмжээнд төлөөлөх боломжтой түүврээс мэдээлэл цуглуулах зорилго тавиагүй харин зориуд сонгосон цөөн тооны судалгааны талбарыг хамруулсан байна. Тиймээс, судалгааны дүн үндэсний хэмжээнд ерөнхий хандлага, дүр төрхийг харуулахаас илүүтэй тухайн сум, хорооны онцлогийг харуулж чадсан байна. Мөн энэхүү судалгаа нь учир шалтгааныг тайлбарлахаас илүүтэй нөхцөл байдлыг тодорхойлох, илрүүлэхэд чиглэгдсэн нь бусад судалгаанаас онцлог болсон байна (IRIM судалгааны хүрээлэн, 2013).

Үүнээс гадна мөн онд Сангийн яамны дэргэдэх Тогтвортой амьжиргаа-II төслийн захиргаа, Монголын Эмэгтэйчүүдийн Холбоотой хамтран “Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэнд үнэлгээ хийх нь” сэдэвт судалгаа хийсэн байна. Энэхүү судалгааны ажлаар хамтарсан төслийн судлаачид Архангай, Завхан, Хөвсгөл гэсэн гурван аймгийн 33 суманд ажиллаж, ОНХС-ийн 2013 оны хэрэгжилтийг иргэдийн оролцоог хангасан байдал, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн байдал, худалдан авах ажиллагааг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлсэн байдал, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьсан байдал гэсэн таван чиглэлээр үнэлэн судалсан байна.

Уг судалгааны дүгнэлтэд: “Сумдад ОНХС-ийн хөрөнгө хуваарилсан нь орон нутгийн удирдлагын идэвх санаачилгыг өрнүүлэн ач холбогдолтой ажил болсон байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хүний нүдэнд харагдахуйц бодитой ажлууд хийгдэж, нутгийн иргэдэд үнэлэгдсэн байна. ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх, захиран зарцуулах ажлын эхлэл болжээ. ОНХС-ийн үйл ажиллагаа 2013 онд шинэлэг учраас туршлага, дадлага дутагдсан боловч цаашдаа боловсронгуй болох үндэслэлтэй байна. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар идэвх санаачлагатай ажиллавал илүү үр дүнд хүрэх бололцоотой” гэж (Сангийн яам, Тогтвортой амьжиргаа II төсөл, Монголын эмэгтэйчүүдийн холбоо, 2013) судалгааны тайланд дурджээ.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх Ухааны Академийн харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захиалгаар доктор, профессор С.Нармандахаар ахлуулсан судлаачид 2014 онд “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа” (Мэдээллийн хүртээмж, иргэдийн оролцоо, санал өгөх, баталгаажуулах, хэрэгжүүлэх үйл явц) нэртэй судалгааны ажил хийсэн байна.

Уг судалгаагаар ОНХС-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд шинжилгээ хийсэн бөгөөд үйл ажиллагааны циклтэй холбоотой бүх зүйлийг шат дарааллын дагуу авч үзсэн байна. Үүнд:

1. ОНХС-д хөрөнгө хуваарилах, шилжүүлэх үйл ажиллагаа;
2. ОНХС, иргэдийн оролцооны тухай мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх үйл ажиллагаа;

3. Иргэдээс саналын хуудсаар санал авах үйл ажиллагаа;
4. Баг, хорооны ИНХ-аар ОНХС-ийн ажлыг хэлэлцүүлж, иргэдийн саналыг эрэмбэлж буй байдал;
5. Баг, хорооны ИНХ-ын саналыг сум, дүүргийн ЗДТГ эрэмбэлж, ИТХ-аар батлуулж буй байдал;
6. Батлагдсан ажил, үйлчилгээг гүйцэтгэх, тайлагнах сум, дүүргийн ЗДТГ-ын үйл ажиллагаа;
7. ОНХС-ийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн судалгааг хамруулжээ.

Үүнээс гадна ОНХС-гийн үйл ажиллагааг хойшид сайжруулах чиглэлээр Засгийн газар, орон нутгийн удирдлага авч хэрэгжүүлэх саналуудыг тусгаж өгсөн нь цаг үеэ олсон үр дүнтэй, шинэлэг зүйл болж чадсан (Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2014) гэж үзжээ.

Мөн 2014 онд Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академийн багш Ш.Батсүх, Я.Долгоржав, Б.Ганцоож нар “Шууд ардчилал иргэдийн оролцоо” (Иргэний танхим, Орон нутгийн хөгжлийн сан) нэртэй судалгааны ажил хийсэн байна.

Энэхүү бүтээл нь шууд ардчилал иргэдийн оролцооны талаарх онол, үзэл баримтлал, үүнтэй холбоотой Европын зарим орны туршлагыг сонгож авч үзсэн. Үүнээс гадна Монгол дахь хэрэгжилт, ялангуяа иргэний танхим, ОНХС-гийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, судалгааныхаа үр дүнд тулгуурлан санал зөвлөмж боловсруулсан байна (Батсүх. Ш., Долгоржав. Я., Ганцоож. Б, 2014).

Дээрх судалгаануудаас гадна Швейцарийн хөгжлийн агентлагийн Монгол дахь салбар (Питер Плант)-аас “Алслагдсан сум, орон нутагт төсвийн тухай хуулийн орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн эхний үе: дүгнэлт, зөвлөмжүүд” хэмээх судалгаанд хөдөөгийн сумдын удирдлагад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж буй төслүүдийн орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, үр дүнг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэхдээ нэмэлт үйл ажиллагаа зохион байгуулах, эсвэл одоо хийгдэж буй ажлын чиг хандлагыг өөрчлөх замаар хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэсэн байна. “Хөдөө орон нутгийн удирдлагад бодитой, үндэслэлтэй төлөвлөлт хийх чадвар эзэмшүүлэх арга замуудыг тодорхойлох, сумдын удирдлагыг сургадаг тогтолцоог бий болгох, “иргэний оролцоо”-г хангах явдлыг зөвхөн өнгөцхөн буюу хуралд иргэдийг урьж оролцуулах төдий утгаар биш, илүү өргөн цар хүрээтэй, орон нутгийн хөгжлийн зорилго, зорилтуудад хүрэхийн тулд илүү үр дүнтэй байдлаар ойлгож, зохион байгуулдаг болох нь чухал” гэж үзсэн байна.

“ОНХС-гийн хөрөнгийг үргэлж зөв зохистой байдлаар зарцуулах нь орон нутгийн удирдлагуудын хувьд хүндрэлтэй болох (чанарын хувьд ачаалал хэтрэх) болов уу гэсэн болгоомжлолыг төрүүлж байна” гэж тэмдэглэсэн байна (Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2014).

Мөн 2014 онд Монголын Улсын Үндэсний Аудитын газар “Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт”-ын талаар шалгалт хийж, тайлан гаргасан байна. Энэ аудитыг дараах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. ОНХС-гийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх,

2. Сум хөгжүүлэх сан (СХС)-гийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх.

Дээрх хоёр зорилтын биелэлт шалгалтын дүнгээр:

1. ОНХС-гийн орлогын эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналт сул байгаагаас орлого бүрдүүлэх боломжийг ашиглаагүй, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд сөрөг нөлөөлсөн байна.
2. СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийн бүрдүүлэлт хангалтгүй, санхүүжүүлсэн хөнгөлөлттэй зээл зориулалтын дагуу ашиглагдахгүй байна. Энэ тайлангаар ОНХС болон СХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна гэсэн нэгдсэн дүгнэлт гарсан байна.

Мөн 2015 онд Нээлттэй нийгэм форум “Нийслэлийн дүүргүүдийн ОНХС-гийн үйл явцын өнөөгийн байдал, түүнийг сайжруулах нь” хэмээх судалгааг хийсэн. Уг судалгааны хүрээнд Иргэдийн оролцоотой төсвийн төлөвлөлтийг бий болгох, үйл явцыг улам сайжруулах зорилгыг дэвшүүлж, 2013 оноос хэрэгжүүлж буй ОНХС-гийн төлөвлөлт, зохион байгуулалт, удирдлагатай холбоотой үйл явцын өнөөгийн байдал, тулгарч буй асуудлуудыг тодорхойлон, үйл явцыг сайжруулах зөвлөмж боловсруулсан.

Үндэсний аудитын газраас “2015 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан”¹⁷-г 2016 онд гаргаж, аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн зарцуулалттай холбоотойгоор дараах дүгнэлт өгсөн. Үүнд:

- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй, эрэмбэлсэн жагсаалтын дагуу төлөвлөгдөөгүй байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр зураг төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй, төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс хангалтгүй ажилласан байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.
- Орон нутгийн удирдлагууд өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар дорвитой арга хэмжээ авч ажиллахгүй байна.
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Дээр дурдсан дүгнэлтүүд орон нутгийн удирдлагын зүгээс ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөж, санхүүжүүлж, зарцуулахдаа гаргасан дараах зөрчлүүдтэй холбоотой гэж үзжээ. Тухайлбал,

- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2015, 2016-2021), аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн зорилт зэрэг бодлогын

¹⁷ ҮАГ. (2016). Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан: ОНХС-гийн хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдахгүй байна. Улаанбаатар. <http://www.audit.mn/wp-content/uploads/2016/06/oron-nutag-hogjin-san-2015.pdf>

баримт бичгүүдтэй уялдуулсан боловч зарим аймаг, сумдад батлагдсан маягтаар олон нийтийн нээлттэй санал асуулгыг зохион байгуулаагүй, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн. Энэ нь Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын “ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар, үндэслэл, иргэдийн хурлын санал, тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана” гэсэн 3.5 дахь заалт, “Баг хорооны Засаг дарга Иргэдийн нийтийн хуралд иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харьяа сум, дүүргийн ЗД-аас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдуулсан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ” гэсэн 5.7 дахь заалтыг зөрчсөнтэй холбоотой.

- Аймаг, сумдын удирдлага ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэж ИНХ-д хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэсэн боловч жагсаалтад тусгагдвал зохих “Хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг” гэх мэт зарим үзүүлэлтийг тооцож оруулаагүй байсан.
- Баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлж байгаа боловч тухайн хуралд оролцогчдын ирцийг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, нэгдсэн жагсаалтыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн батлаагүй, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг батлахдаа зураг төсөвгүй, ТЭЗҮ хийгдээгүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн тодорхойлолтгүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй, иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээг баталсан нь ОНХС-гийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн.
- ОНХС-гийн хөрөнгөөр 2015 онд шинээр хэрэгжүүлсэн нийт 3792 төсөл, арга хэмжээний 8.0 хувь буюу 303 ажлыг Худалдан авах ажиллагааны хууль, журмын дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар, 3.9 хувь буюу 146 ажлыг олон нийтийн оролцоотой болон хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар, 25.4 хувь буюу 963 ажлыг харьцуулалтын аргаар, 51.4 хувь буюу 1949 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлж, 11.4 хувь буюу 431 ажилд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.
- Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль, журмын заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг, төсөв, өртгийн тооцоог урьдчилж гаргаагүй, зураг төсвийг гаргуулсан боловч өртгийн тооцоог эрх бүхий байгууллагаар хянуулж баталгаажуулаагүй.
- ОНХС-нийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулснаас гадна зарим аймгийн удирдлага ОНХС-ийн хөрөнгийг иргэн, аж ахуйн нэгжид эргэн төлөгдөх нөхцөлөөр зээл олгосон.
- Зарим аймаг ОНХС-ийн хөрөнгөөр ойн арга хэмжээ тэмдэглэсэн нь Төсвийн

тухай хуулийн 60.3.3 дахь заалтыг, баяр наадмын зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээг дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн, санхүүжилтийг илүү олгосон, ажил гүйцэтгэж дууссан ч ашиглах боломжгүй байгаа хэд хэдэн тохиолдол байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл зарим талаар хангалтгүй, 47.9 тэрбум төгрөгийг холбогдох хууль, журам, зааврыг зөрчиж зарцуулсан.
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд худалдан авах ажиллагааны хууль болон “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т заасны дагуу захиалагч гэрээний биелэлтийг хянаж, дүгнэж хэвшээгүй, сумдад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг ихэвчлэн ЗДТГ-ын ажилтнууд тавьж байна. Эдгээр ажилтнууд нь захиалагчийн хяналт тавихад мэргэжлийн чадвар дутмагаас гүйцэтгэгч байгууллагад шаардлага бүрэн тавьж чаддаггүй, зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжгүй, захиалагчийн хяналтын зардал байхгүй, зарим аймгийн удирдлага энэ зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүйгээс ОНХС-гаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр үр дүнгүй, төсөл, дутуу, хугацаандаа хэрэгждэггүй зөрчил давтагдаж байна.
- ОНХС-гийн 2013, 2014 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, орон нутгийн удирдлагууд ОНХС-ийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт болон сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдал арилахгүй, давтан гарсаар байна.
- Шилэн дансны тухай хуулийн 3.2.2-т “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мөнгөн болон бусад гүйлгээг хамруулахаар заасны дагуу мэдээллийг самбарт байршуулсан ч ОНХС-гийн төсөв, гүйцэтгэлийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй зэрэг зөрчил илэрчээ.

Эдгээр судалгаа болон ҮАГ-аас гаргасан ОНХС-гийн зарцуулалтад хийсэн аудитын тайлангаас харахад аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-гийн хэрэгжилт 3 жилийн хугацаанд боломжийн түвшинд байгаа боловч зарцуулалтын талд ИТХ болон Засаг даргын зүгээс анхаарч ажиллах шаардлага байгаа нь ажиглагдаж байна.

2.7. ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

2.7.1. ТӨСВИЙГ ИЛ ТОД БОЛГОХ ШААРДЛАГА

Сүүлийн жилүүдэд Монгол улсын төрөөс төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр дэс дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, орон нутгийн төсвөөс хөгжлийн сангийн хөрөнгийг тусгайлан баталж, зарцуулалтыг нь иргэдийн саналаар шийдвэрлэдэг болж орон нутагт иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлгүүд өрнүүлдэг боллоо. Мөн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй

байдлыг хангах үүднээс олон нийтийн оролцоог бага багаар нэмэгдүүлж байна.

Төсвийн харилцааны шинэ нөхцөлд түүний ил тод, нээлттэй байдлыг хангах зорилт чухлаар тавигдаж, орон нутгийн төсвийг иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоогүйгээр бодитой төлөвлөх, хянах боломжгүй болж байна. Иргэд, татвар төлөгчдийн оршин суугаа газар нутаг, өдөр тутмын ажил, амьдралтай шууд холбоотой төсвийн үнэн зөв мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар өгч байх нь тэдний зүгээс төсвийн үйл явцад анхаарлаа хандуулж бүтээлчээр оролцох үндсэн нөхцөл болдог. Төсвийн талаар төрөөс, ялангуяа нутгийн удирдлагын зүгээс хүлээх хариуцлагыг тодорхой болгож, төсвийн талаарх мэдээллээр олон нийтийг хангаж, төсвийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь сайн засаглалыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Төсвийн ил тод байдал хангагдаагүй тохиолдолд олон нийтийн оролцоо бий болохгүй бөгөөд энэ нь мөн төсвийн бодлогыг боловсруулах үйл явц дахь олон нийтийн хэлэлцүүлгийн хамрах хүрээ, агуулгыг хязгаарлах болно. Нөгөө талаас, төсвийн үйл явц ил тод байх нь бодлого боловсруулагчдад хариуцлагын мэдрэмжийг бий болгох; төрөөс хариуцлагатай, шударга шийдвэр гаргадаг болгох; ирээдүйн хөгжлийн талаар илүү сайн төсөөлөл, стратегийг тодорхойлох; төсвийн төслийг цаг хугацаанд нь, үр дүнтэй боловсруулж хэрэгжүүлэхийг дэмжих; төсвийн үйл явцад хуулийн дагуу илүү сайн хяналт тавих; олон нийтийн хүсэл эрмэлзэл, итгэлийг бий болгох, түүнчлэн Засгийн газар, нутгийн удирдлага хүнийхээ төлөө ажиллах чадварыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг.

Төсвийн ил тод байдлын ойлголт нь ихэвчлэн төсвийн үйл явцын нээлттэй байдал, энэ үйл явцад олон нийтийг оролцуулах боломжтой холбоотой. Ил тод төсвийн үйл явц нь иргэд төр, орон нутгийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцох боломжит орон зайг бий болгодог хэдий ч оролцоонд тулгуурлан хариуцлагатайгаар шийдвэр гаргахыг баталгаажуулна гэсэн үг биш юм. Олон нийтийн оролцоог хангахуйц байхын тулд төсвийн үйл явц нь улсын болон орон нутгийн түвшинд аль алинд нь ил тод байх хэрэгтэй.

Төсвийн тухай хуульд төсвийн ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх үндсэн зарчмуудыг тодорхойлж, эдгээр зарчмыг хэрэгжүүлэхдээ төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлангийн талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр танилцуулж байхыг үүрэг болгосон билээ. Түүнчлэн УИХ-аас Шилэн дансны тухай хуулийг батлан гаргаж, энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталжээ.

Энэ журам нь шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоож, уг цахим хуудсанд мэдээлэл тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготойгоос гадна төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль

тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нь шилэн дансны цахим хуудсанд хууль, журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй гэдгийг тогтоож өгсөн.

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь батлагдсан жилийн төсөв, түүний гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, тэдгээртэй холбоотой гаргасан шийдвэр, томоохон хэмжээний мөнгөн гүйлгээний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай юм. Энэхүү зохицуулалтад хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал хамаарахгүй байна.

Төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэхдээ мэдээллийн самбар, цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглах боломжтой бөгөөд цахим болон мэдээллийн бусад хэлбэр ашиглаж байгаагаас үл хамааран мэдээллийн самбарыг заавал ажиллуулсан байхыг хууль, журамд заажээ.

Хэрэв төсвийн байгууллага цахим хуудастай бол тус цахим хуудсанд “байгууллагын төсөв” гэсэн цэс үүсгэн тэрхүү цэсэнд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл болон дунд хугацааны зорилго, зорилт, үйл ажиллагааны стратегийн мэдээллүүдээ оруулах, шинэчлэн байршуулах үйл ажиллагааг тухай бүр хэрэгжүүлнэ. Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төлөвлөлтийн хариуцсан нэгж тухайн шатны төсвийн сар, улирлын хуваарь, түүнд хийсэн зохицуулалтын тухай цахим хэлбэрээр болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэхээр зохицуулагджээ. Худалдан авах ажиллагааны ил тод байдал: Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 264 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу тухайн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцыг захиалагч байгууллага цаг хугацаа алдалгүй, шуурхай, үр ашигтай зохион байгуулахад шаардлагатай болсон. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө буюу тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нийтэд зарлан мэдээлэх, тендэрийн урилга бэлтгэх, зарлан мэдээлэх, захиалагч байгууллагуудаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг www.e-procurement.mof.gov.mn цахим хуудсанд байрлуулна. Орон нутагт өөрийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах болон нийтийн зар мэдээний самбар ажиллуулах боломжтой.

Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журамд аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэх бөгөөд түүнчлэн санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байхаар тогтоосон байна.

2.7.2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ ИЛ ТОД БОЛГОХ ЦАГЛАБАР, ХЭЛБЭР

Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл болон төсвийн баримт бичгийг олон ниүйтэд ил тод болгох цаглабар, төсвийн мэдээллийг ил тод болгох маягт, хэлбэрийг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Хүснэгт 2.5. Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг ил болгох цаглабар

Ил тод болгох хугацаа	Төсвийн баримт бичиг ба үйл явц	Төсвийн мэдээллийг ил тод болгох маягт, хэлбэр
Сар бүрийн 8-ны дотор (жилд 12 удаа)	Төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн сар (улирал, хагас, бүтэн жил)*-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.2, 2, 20-р хавсралт (цахим)
	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессийн зүйлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.4, 3-р хавсралт (цахим)
	Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.5, 4-р хавсралт (цахим)
	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.8, 2-р хавсралт (цахим)
	Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор	ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн хөтөлбөр, батлагдсан төсөв	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.2, 2, 20-р хавсралт (цахим)
	ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.1, 1-р хавсралт (цахим)
	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жилийн төлөвлөгөө, концессийн зүйлийн жагсаалт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.4, 3-р хавсралт (цахим)
	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.8, 2-р хавсралт (цахим)
	Тухайн оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.14 21-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 15-ны дотор	Өмнөх оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.14 22-р хавсралт (цахим)
Жил бүрийн 1-р сарын 10-ны дотор	Тухайн оны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)

Жил бүрийн 4-р сарын 25-ны дотор	ТЕЗ-ийн өмнөх оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн жилийн эцсийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.1, 1-р хавсралт (цахим)
	Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (төсвийн гүйцэтгэлийн тайлан)	Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтуудаар. МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.9 (цахим, PDF форматаар)
	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.6, 5-р хавсралт (цахим)
	Өмнөх оны хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.7, 6-р хавсралт (цахим)
	Өмнөх оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.10 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 1-ний дотор	Өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.11 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 15-ны дотор	Сум, дүүргийн төсвийн байгууллага (ТШЗ)-ын дараа жилийн төсвийн санал	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.3 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 7-р сарын 25-ны дотор	Аймаг, нийслэлийн төсвийн байгууллага (ТШЗ)-ын дараа жилийн төсвийн санал	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.3 (цахим, PDF форматаар)
	Сум, дүүргийн төсвийн зрөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч (ТЕЗ, ТТЗ)-ын дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 8-р сарын 1-ний дотор	Аймаг, нийслэлийн төсвийн төвлөрүүлэн захирагч (ТТЗ)-ын дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 8-р сарын 15-ны дотор	Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн дараа жилийн төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)
	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан хагас жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.6, 5-р хавсралт (цахим)
	2015 оны хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайлан	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.7, 6-р хавсралт (цахим)
	2015 оны хагас жилийн санхүүгийн тайлан (төсвийн гүйцэтгэлийн тайлан)	Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтуудаар. МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.9 (цахим, PDF форматаар)
Жил бүрийн 9-р сарын 15-ны дотор	2016 оны төсвийн төсөл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.16 (цахим, PDF форматаар)


Жил бүрийн 9-11-р сард	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр дараа жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, иргэд, олон нийтийн санал авах явц, урьдчилсан жагсаалт боловсруулж хэлэлцүүлэх, өргөн барих үйл явц, үр дүнгийн мэдээлэл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.15 11-р хавсралт (цахим)
Жил бүрийн 11-р сарын 10-ны дотор	Аймаг, нийслэлийн Засаг даргаас Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторт хүргүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	ТЕЗ-ын төсвийн төсөл, төсвийн төсөөлөл боловсруулах удирдамжийн хавсралт
Жил бүрийн 11-р сарын 25-ны дотор	Дараа жилийн төсвийн төсөлд аймаг, нийслэлийн ерөнхий аудиторын өгсөн дүгнэлт	Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторын өгсөн дүгнэлтийг бүрэн эхээр нь цахимаар
	Аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2-р хавсралт
Жил бүрийн 12-р сарын 5-ны дотор	Аймаг, нийслэлийн дараа жилийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал	Жил бүрийн 12-р сарын 5-наас өмнө хуралдсан байдлаар
Жил бүрийн 12-р сарын 10-ны дотор	Сум, лүүргийн Засаг даргаас сум, дүүргийн ИТХ-д өргөн мэдүүлсэн дараа жилийн төсвийн төсөл	Сангийн сайдын 2012 оны 244-р тушаал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2-р хавсралт
Жил бүрийн 12-р сарын 20-ны дотор	Сум, дүүргийн дараа жилийн төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал	Жил бүрийн 12-р сарын 20-ноос өмнө хуралдсан байдлаар
Жил бүрийн 12-р сарын 31-ний дотор	Дараа оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь	Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн сар, улирлын хуваарийн маягтаар
1, 4, 7, 10-р сарын 20-ны дотор (Жилд 4 удаа)	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын улирал бүрийн нөөц хөрөнгийн ил тод байдал	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн маягтаар
Жилийн турш (батлагдсанаас хойш 7 хоногийн дотор)	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.3, 1, 2, 20-р хавсралт (цахим)
Жилийн турш (үнэлгээний хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор)	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.6, 7-р хавсралт (цахим)
Жилийн турш (шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор)	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээ (гэрээ, хэлцэл хийсэн, санхүүжилт өгснөөс хойш)	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.9, 8-р хавсралт (цахим)
Жилийн турш (гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор)	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хамт	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.2.10 9-р хавсралт (цахим)
Жилийн турш (шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор)	Зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн тухай шийдвэр	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.7, 10-р хавсралт (цахим, PDF форматаар)

Жилийн турш (дүн гарснаас хойш 7 хоногийн дотор)	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	МУЗГ, 2016, 29-р тогтоол, ШДЦХТМАНСТЖ-ын 3.1.13 (цахим, PDF форматаар)
Тодотгол хийсэн тухай бүр	Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)	Тодотгол хийсэн бол тухай бүр

* Сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээ-сар бүрийн мэдээг дараа сарын 8-ны дотор гаргана, улирал бүрийн сүүлийн сарын мэдээ нь улирлын, 6-р сарын мэдээ хагас жилийн, 12-р сарын мэдээ бүтэн жилийн мэдээ байдлаар гарна гэсэн үг.

2.7.3. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Орон нутгийн төсвийн ил тод байдлыг аймаг, нийслэлийн түвшинд үнэлэх анхны судалгааг 2010-2011 онд Нээлттэй Нийгэм Форум (ННФ), “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ хамтран¹⁸ гүйцэтгэсэн байдаг. Орон нутгийн төсвийн ил тод байдалд гарч буй өөрчлөлтийг тодорхойлох үүднээс энэхүү судалгааг хоёр жил тутамд хийдэг болсон бөгөөд энд “Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013” сэдвээр 2013-2014 онд ННФ-ын санхүүжилттэйгээр иргэний нийгмийн байгууллагуудын хамтран хийсэн судалгааны зарим үр дүнг 19 танилцуулж байна. Аймаг, нийслэлийн дунджаар авч үзвэл орон нутгийн төсвийн ил тод байдал 2013 оны эцсийн байдлаар нийт авбал зохих 100 онооны 36.2 хувийг авсан нь хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна. Хөвсгөл аймаг хамгийн өндөр буюу 55.3 хувьтай үнэлэгдсэн бол Баянхонгор аймгийн үнэлгээ 15.0 хувь байна. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дээд оноо нь 55 байгаа учир аймаг, нийслэлийн “үнэлэгдсэн дундаж үзүүлэлт”-д үндэслэн орон нутгийн төсвийн ил тод байдлын өнөөгийн түвшинг үнэлэхэд “дунджаас дээш (43-аас дээш оноотой)” гэсэн үнэлгээг Хөвсгөл, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Ховд, Увс, Өмнөговь аймгууд авсан бол “дундаж (30-42 оноотой)” гэсэн үнэлгээтэй Улаанбаатар хот, Хэнтий, Архангай, Булган, Дархан-Уул, Дундговь, Орхон, Сүхбаатар аймгууд байна. Харин бусад аймгууд буюу Дорнод, Завхан, Өвөрхангай, Говь-Алтай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Баянхонгор аймаг “дунджаас доош (30 хүртэл оноотой)” түвшинд үнэлэгдсэн байна.



Эх сурвалж: “Орон нутгийн төсвийн ил тод байдал – 2013” судалгааны тайлангийн мэдээлэл
 Зураг 2.3. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдал – 2013 он

¹⁸ ННФ (2011). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011, Улаанбаатар

¹⁹ ННФ (2014). Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013, Улаанбаатар

Энэ нь аймаг, нийслэлийн түвшинд төсвийн ил тод, нээлттэй байдал нэн хангалтгүй байна” гэсэн 2011 оны судалгааны үр дүнтэй адил байгааг харуулна. Өөрөөр хэлбэл, төсвийн ил тод байдлыг хангах талаар хууль тогтоомжид хангалттай олон заалт тусгагдсан боловч эдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр үндсэндээ ахиц гарсангүй гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ зарим аймаг, тухайлбал, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Говьсүмбэр, Орхон, Дархан-Уул, Дундговь, Төв, Увс, Хэнтий аймгуудын төсвийн ил тод байдлын үнэлгээ сайжирсан бол Улаанбаатар хот болон Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ зэрэг аймгийн үнэлгээ буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Хүснэгт 2.6. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын харьцуулалт (2011 ба 2013 он)

№	Аймаг, нийслэл	Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011		Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013	
		Нийт оноо	Рейтинг	Нийт оноо	Рейтинг
1	Архангай	44.5	5	36.8	10
2	Баян-Өлгий	32.3	15	26.0	20
3	Баянхонгор	32.4	14	15.0	22
4	Булган	44.6	4	36.5	11
5	Говь-Алтай	29.4	17	26.7	19
6	Говьсүмбэр	38.3	8	51.5	3
7	Дархан-Уул	25.5	19	35.2	12
8	Дорноговь	28.2	18	48.9	4
9	Дорнод	36.5	11	29.3	16
10	Дундговь	18.0	21	34.5	13
11	Завхан	37.4	9	27.1	17
12	Орхон	16.6	22	32.1	14
13	Өвөрхангай	37.0	10	27.0	18
14	Өмнөговь	29.7	16	44.5	7
15	Сүхбаатар	34.6	12	31.4	15
16	Сэлэнгэ	47.6	3	18.3	21
17	Төв	40.2	6	51.9	2
18	Увс	38.4	7	46.4	6
19	Ховд	48.0	2	47.1	5
20	Хөвсгөл	33.8	13	55.3	1
21	Хэнтий	19.9	20	37.1	9
22	Улаанбаатар	55.5	1	38.7	8
Дундаж оноо		34.9		36.2	

Эх сурвалж: ННФ. Орон нутгийн төсвийн ил тод байдлын 2011, 2013 оны судалгааны тайлан

Судалгааны үр дүнгээс үзэхэд, орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дундаж оноо 2011 онд 34.9 байсан бол төсвийн ил тод байдлыг зохицуулсан хэд хэдэн эрх зүйн баримт бичиг шинээр батлагдан мөрдөгдөж байгаатай холбоотойгоор 2013 оны байдлаар 36.2 болж 1.3 оноогоор нэмэгдсэн нь аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг хангах ажилд бага ч болов ахиц гарч нутгийн удирдлагын зүгээс төсвийн үйл явц болон төсвийн баримт бичгийг ил тод, нээлттэй болгох эхний алхмууд хийгдэж эхэлж буйг илтгэнэ.

2.8. ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙГ ШИНЖЛЭХ АЛДАВЧИ

Тухайн шатны Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн орон нутгийн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайлан, зардлын мэдээллийг уншиж ойлгох, шинжилгээ хийх аргуудыг хурлын Төлөөлөгчдөд эзэмшүүлэх нь ИТХ-аас орон нутаг дахь төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавихад дэмжлэг үзүүлэх болно.

2.8.1. ИТХ-Д ЗАСАГ ДАРГААС ӨРГӨН БАРЬСАН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН, ЗАРДЛЫН МЭЛЭЭЛЛИЙГ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЗҮГЭЭС ШИНЖЛЭХ

Орон нутгийн төсөв нь орон нутгийн төсвийн орлого, зарлага болон санхүүжүүлэх эх үүсвэр гэсэн үндсэн 3 хэсэг мэдээллээс бүрдэнэ. Хамгийн эхэнд хийгдэх шинжилгээ бол орон нутгийн төсвийн тэнцэл хэсэг байна. Хэрэв тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн төсөв алдагдалтай бол тухайн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, зээлийн эх үүсвэр болон урьд оны үлдэгдлийн нийлбэртэй тэнцэж байгаа эсэхийг шалгана.

Хүснэгт 2.7. А аймгийн Б сумын 2016 оны төсвийн тэнцлийн үзүүлэлтүүд

№	Төсвийн ангилал	Төсөв, сая төг	Нийт дүнд эзлэх хувь
1.	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,268.0	100%
1.1.	Орон нутгийн орлого	116.0	5 %
1.1.1.	- Орон нутгийн орлого	106.0	
1.1.2.	- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого	10.0	
1.2.	Тусламжийн орлого	2,152.0	95 %
1.2.1.	- Санхүүгийн дэмжлэг	443.8	
1.2.2.	- Тусгай зориулалтын шилжүүлэг	1,437.4	
1.2.3.	- Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	270.8	
2.	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,307.5	100%
2.1.	Орон нутгийн суурь зарлага	559.8	24 %
2.1.1.	- Орон нутгийн төсвийн зарлага	549.8	
2.1.2.	- Урьд оны үлдэгдлээс санхүүжих зарлага	10.0	
2.2.	Орон нутгийн хөгжлийн сан	280.8	12 %
2.2.1.	- Орон нутгийн хөгжлийн сан	270.8	
2.2.2.	Үүнд: урьд оны үлдэгдлээс санхүүжих	10.0	
2.3.	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	1,447.4	63 %
2.3.1.	-Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	1,437.4	
2.3.2.	- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогоос санхүүжих зардал	10.0	
2.4.	Гадаад зээлийн ашиглалт	19.5	1 %

3.	НИЙТ ТЭНЦЭЛ	-39.5	
4.	Санхүүжилтийн эх үүсвэр:		
4.1.	- Зээлийн эх үүсвэрээс	19.5	
4.2.	- Урьд оны дансны үлдэгдэлээс	20.0	

Эх сурвалж: А аймгийн Б сумын 2014 оны төсвийн төсөл

Дээрх хүснэгтээс төсөвтэй холбоотой дараах дүгнэлтүүдийг гаргах боломжтой.

Үүнд:

1. Б сум нь төсөвтөө 106.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжтой бөгөөд орон нутгийн төсвийн орлогынхоо 5 хувийг өөрөө бүрдүүлэх боломжтой. 2,152.0 сая төгрөг буюу 95 хувийг нь улсын төсвөөс олгох шилжүүлгээр хүлээн авна.
2. Орон нутгийн төсвийн зарлагын 24 хувийг суурь зарлага, 63 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зарлага эзлэх бол 12 хувийг ОНХС-гийн хөрөнгө оруулалтад зарцуулах боломжтой байна.
3. Төсвийн хуулиар гадаад төслийн зээлийг хаана ашиглаж байна тухайн шатанд нь санхүүжилтийн эх үүсвэртэй нь тусгах болсон байна. Иймд гадаад төслийн зээлээс 19.5 сая төгрөгийг эх үүсвэртэй нь авч ашиглах бөгөөд энэ нь сумын төсвийн зарлагын 1 хувьтай тэнцэж байна.
4. ОНХС нь үлдэгдэлтэй гарч болдог сан бөгөөд дараа жилд нь зарцуулахдаа тухайн жилд орон нутгийн хөгжлийн сандаа хүлээн авах орлого дээрээ эхний үлдэгдлээ нэмж батлуулан хэрэгжүүлж болно. Иймд Б сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2015 онд зарцуулах нийт зардал нь 280.8 сая төгрөг болсон байна. Үүнээс 270.8 сая төгрөгийг тухайн ондоо аймгаасаа хүлээн авах бол 10.0 сая төгрөгийг үлдэгдлээсээ зарцуулна. Аймгаас хүлээн авах 270.8 сая төгрөг нь орон нутгийн тусламжийн орлогод бүртгэгдсэн байна.
5. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөв нь сумынхаа төсөвт орох болсон. Иймд 1,437.4 сая төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр хүлээн авах тул тус дүнг бууруулахгүйгээр зардлаа төлөвлөжээ. Төсвийн хуулиар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага өөрийн орлогыг тухайн шатныхаа ИТХ-аар батлуулах, ингэхдээ нэмэгдүүлэн батлуулж зардлаа нэмэгдүүлэх, мөн эсрэгээрээ бууруулах боломжтой болсон. Иймд Б сумын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд 10.0 сая төгрөгөөр орлогоо нэмж, тус дүнгээр зардлаа нэмэгдүүлэн батлуулж хэрэгжүүлнэ гэж хэлж болно. Б сумын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нийтдээ 1,447.4 сая төгрөгийн зардал гаргах боломжтой.
6. Б сумын төсвийн тэнцэл нь 39.5 сая төгрөгийн алдагдалтай байгаагаас 50 хувийг нь буюу 20.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Тухайлбал, орон нутгийн төсвийн байгууллагад 10.0 сая төгрөг зарцуулах бол үлдсэн 10.0 сая төгрөгийг нь Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр байна. Үлдэх 50 хувь нь гадаад төслийн зээлээр хэрэгжих төслийг санхүүжүүлнэ.
7. Орон нутгийн суурь зарлагын тэнцлийг авч үзвэл: Орон нутгийн суурь орлого

нь 106.0 сая төгрөг, зардал нь 559.8 сая төгрөг бөгөөд 10.0 сая төгрөгийн зардлыг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх тул улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээс 443.8 сая төгрөгийг авах шаардлагатай гэж тооцогдоно. Иймд тус 443.8 сая төгрөг нь тусламжийн орлого талд тусгагдсан байна.

Тухайн шатны Засаг даргаас ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар өргөн барих төсвийн төсөлд тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын тухайн жилд олох орлогын хэмжээг:

- Орон нутгийн төсвийн нийт орлогын дүнг нэр, төрлөөр;
- Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлогын хэмжээ, харьяалах төсөвт байгууллагын тухайн шатны төсөвт төвлөрүүлэх орлого тус бүрээр тооцсон байдаг.

Төсвийн байгууллагын өөрийн орлогыг тусад нь харуулах болсон нь тухайн байгууллага орлогоо нэмэгдүүлэх замаар зардлаа нэмэгдүүлэх боломжтой болсонд оршино. Жишээлбэл, тэнцлийн хүснэгтээс харахад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагуудын зардлыг өөрийн орлоготой тэнцэх дүнгээр улсын төсвөөс ирсэн дүнгээс нэмэгдүүлж батлуулсан байна.

Орон нутгийн орлогын хэмжээг хэрхэн тооцож ИТХ-д өргөн барьсан жишээг А аймгийн Б сумын жишээгээр дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2.8. А аймгийн Б сумын 2016 оны Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөний төсөл

№	Орлогын ангилал болон нэр төрөл	Төсөв, мян.төг.
А	ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	549,868.7
1	УРСГАЛ ОРЛОГО	106,030.0
1.1	<i>ТАТВАРЫН ОРЛОГО</i>	50,430.0
	Орлогын албан татвар	40,100.0
	Хувь хүний орлогын албан татвар	40,100.0
	– Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар	5,100.0
	– Үйл ажиллагааны орлогын албан татвар	25,000.0
	– Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	10,000.0
	Өмчийн татвар	120.0
	Бууны албан татвар	120.0
	Бусад татвар	10,210.0
	– улсын тэмдэгтийн хураамж	1,500.0
	– ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	5,000.0
	– ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих эрхийн зөвшөөрлийн хураамж	710.0
	– түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	3,000.0
1.2	<i>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</i>	55,600.0
	Төсвийн байгууллагын өөрийн орлого	600.0

	Хүү, торгуулийн орлого	30,000.0
	Нэр заагдаагүй бусад орлого	25,000.0
2	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	
3	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	443,838.7
	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	443,838.7
Б	ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-
	Төрийн сангийн харилцахын эхний үлдэгдэл	-
В	НИЙТ ЭХ ҮҮСВЭР	549,868.7

Сумын төсвийн суурь орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Урсгал орлогыг татварын (50,430.0 мянган төгрөг) болон татварын бус орлого (55,600.0 мянган төгрөг) гэж ангилдаг. Татварын орлогын гол эх үүсвэр нь тухайн сумын хувьд орлогын албан татвар, өмчийн буюу бууны албан татвар, бусад татвар болдог байна.

Орлогын албан татварыг цалин, түүнтэй адилтгах орлогоос бусад хувь хүний орлогын албан татвараар бүрдүүлэх бөгөөд энэ төрлийн орлого нь дараах байдлаар бүрдэхээр байна.

Хүснэгт 2.9. Орлогын албан татварын бүрдэлт

№	Үзүүлэлт	Дүн (мян.төг.)
1	Хувь хүний орлогын албан татвар (1=2+3+4)	40,100.0
2	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар	5,100.0
3	Үйл ажиллагааны орлогын албан татвар	25,000.0
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	10,000.0

Энд хувь хүний орлогын албан татвараар бүрдэх орлого нь гурван албан татварын хэлбэрээр буюу $5,100.0 + 25,000.0 + 10,000.0 = 40,100.0$ мянган төгрөг байхаар төлөвлөсөн байна. Түүнчлэн тус сумын төсвийн орлогын өөр нэг эх үүсвэр нь бусад татвар юм.

Хүснэгт 2.10. Бусад татварын бүрдэлт

№	Үзүүлэлт	Дүн (мян.төг.)
1	Бусад татвар (1=2+3+4+5)	10,210.0
2	Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0
3	Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	5,000.0
4	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох болон ан амьтан барих эрхийн зөвшөөрлийн хураамж	
5	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	3,000.0

Бусад татварт улсын тэмдэгтийн хураамж (нотариатын орлого гэх мэт), ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр (гоожин гэж ярьдаг), ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох болон ан амьтан барих эрхийн зөвшөөрлийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (элс, хайрга, шавар, чулуу ашиглах гэх мэт) хамаардаг.

Харин татварын бус орлого нь төсвийн байгууллагын өөрийн орлого (600.0 мянган төгрөг), хүү, торгуулийн орлого (30.0 сая төгрөг), нэр заагдаагүй бусад орлого (25.0 сая төгрөг)-оос бүрдэхээр тооцсон байна. Ийнхүү Б сумын хувьд урсгал орлогоор 106,030.0 мянган төгрөг олж, хөрөнгийн орлого оруулах боломжгүй тул тусламжийн орлогоор буюу аймгийн төсвөөс 443,838.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрээ 549,868.7 мянган төгрөг байхаар тооцон ИТХ-даа өргөн барьжээ.

А аймгийн Б сумын Засаг дарга нь сумын 2014 оны төсвийн суурь зарлагын төслөө боловсруулж дараах байдлаар өргөн барьсан байна. Үүнд:

1) Сумын ИТХ	35,603.2 мянган төгрөг,
2) Сумын ЗДТГ	246,457.3 мянган төгрөг,
3) Багийн Засаг дарга нар	45,197.4 мянган төгрөг,
4) Засаг даргын нөөц	6,000.0 мянган төгрөг,
5) Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ	5,300.0 мянган төгрөг,
6) Нийгмийн халамжийн үйлчилгээ	210,700.0 мянган төгрөг,
7) Байгаль хамгаалагчид	10,610,8 мянган төгрөг,
Нийт	559,868.7 мянган төгрөг.

Харин төлөөлөн гүйцэтгэх гэрээгээр буюу тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх байгууллагуудын зардлыг:

• Ерөнхий боловсролын сургууль	843,324.3 мянган төгрөг,
• Цэцэрлэг (СӨББ)	311,659.8 мянган төгрөг,
• Соёлын төв	57,494.5 мянган төгрөг,
• Сумын эрүүл мэндийн төв	198,698.7 мянган төгрөг,
• Спорт цогцолбор	36,259.4 мянган төгрөг,
Нийт	1,447,436.7 мянган төгрөг.

байхаар тооцон өргөн барьсан байна.

Тус сумын ЗДТГ-аас багуудын Иргэдийн нийтийн хурлаар иргэдээр хэлэлцүүлж гарсан санал, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сум, багт хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг дараах байдлаар гаргажээ.

Хүснэгт 2.11. А аймгийн Б сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд

№	Хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр	Байршил	Саналын тоо / өрх/	Төсөв, сая төг.
Суманд хамааралтай ажлууд				151.0
1	Сумын гэрэлтүүлгийг шинэчлэх, гэр хороололд гэрэлтүүлэг нэмж тавих	Сумын төв, багууд	195	40.0
2	Сумын төвийн инженерийн шугам өргөтгөлийн зураг төсөв	Сумын төв	129	20.0

3	Сурын талбайг тохижуулах	Стадион	126	2.0
4	Сумын фондны өвс, тэжээлийн агуулах, хашаа барих	Баянгол	107	15.0
5	Мал угаалгын хуучин 2 ванныг сэргээх, засварлах, нэг худаг гаргах	Тод, Өнгө баг	107	15.0
6	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах төв, халуун усны барилгын инженерийн шугам, төвийн худаг засвар	Сумын төв	103	12.0
7	Мал үржлийн пунктын багаж тоног төхөөрөмж худалдан авах	Суманд	87	7.0
8	Цэцэрлэгийн склад барих	Цэцэрлэг	79	20.0
9	Эмнэлгийн моргын тоног төхөөрөмж худалдан авах	Эмнэлэг	76	10.0
10	Сургуулийн дотуур байрны цонхыг вакумжуулах	Байранд	63	10.0
Тод баг				44.0
11	Алтайд худаг гаргах	Алтайн даваа	95	12.0
12	Дэнжийн хэсэгт худаг гаргах	I хэсэг	44	12.0
13	Биеийн тамир, тоглоомын иж бүрэн талбайн тохижилт	IV, VII хэсэг	40	10.0
14	Орон сууцны орчмын тохижилт	Орон сууц	25	10.0
Өнгө баг				43.8
15	Төвийн гэр хорооллын хойд хэсэгт гүний худаг гаргах	Дэнж I, II хэсэг	59	15.0
16	Хөдөөгийн хэсгийн Нарангийн орчимд гүний худаг гаргах	Наран	59	12.0
17	Суварганы хашааг шинэчлэх, тохижуулах	Сумын төв	49	10.6
18	Тоглоомын талбай барих /биеийн тамир/	Дэнжид	28	5.0
19	Нарийн гудамжийг цементлэх	Дэнж I, II хэсэг	23	1.2
Цэлмэг баг				42.0
20	Үерийн далан, сувгийн зураг төсөв хийлгэж ажлыг эхлүүлэх	I, II хэсэг	65	15.0
21	Хүүхдийн тоглоомын талбайг барих /биеийн тамир/	I, II хэсэг	55	5.0
22	Гэр хорооллын усан хангамж төслийг үргэлжлүүлэх	I, II хэсэг	24	10.0
23	Баянцогтод шинээр худаг гаргах	Баянцогт	7	12.0
НИЙТ ДҮН				280.8

А аймгийн Б сумын Засаг дарга ИТХ-даа сумын 2016 оны төсвийн суурь зарлагын төслийг 559.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх байгууллагуудын зардлыг 1,447.4 сая төгрөг, сумын ОНХС-аар санхүүжих хөрөнгө оруулалтын зардлыг 280.8 сая төгрөг байхаар буюу нийт 2,288.0 сая төгрөгийн зардлыг батлуулахаар өргөн барьсан байна.

ИТХ-ын төлөөлөгч нь тухайн шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих суурь зарлага болон хөрөнгө оруулалтын зардал, орон нутагт Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлж буй улсын төсөвт байгууллагад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ зэргийг Засаг даргын өргөн барьсан төсөлтэй танилцах, түүнчлэн ИТХ-ын тогтоолын хавсралтаар батлагдах байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг

шинжлэх замаар нягталж, холбогдох шинжилгээ хийж болно.

Мөн Засаг даргаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь хамгийн багадаа 4-5 баганаар бэлтгэгдэж орж ирсний зөрүүг тооцох замаар тодорхой дүгнэлт, шинжилгээ хийж шийдвэр гаргах боломжтой юм. Жишээ нь, дээд шатнаас 2016 оны суурь төсвийн орлогод тооцогдож ирсэн зарим төрлийн татварын орлого 2014 оны гүйцэтгэл, 2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс бага бол 2016 батлагдах төсөвтөө тухайн орлогын тооцоог нягтлан, боломжтой бол өсгөх замаар төсвийн зарлагаа нэмэгдүүлж баталж болно.

Үүнтэй мөн адил суурь төсөвт тооцогдож ирсэн зарлага их бага янз бүр байж болно. Байгууллага батлагдах баганандаа хэр хөдөлгөөн хийснийг, тэрхүү хөдөлгөөн нь үндэслэлтэй эсэхийг харахад гүйцэтгэл, хэрэгжиж байгаа төсөв, батлагдах төлөвлөгөөний төслийг харьцуулах аргыг ашиглана.

Орон нутгийн төсвийн нийт орлогод тодорхой орлогын төрлийн эзлэх хувь хэмжээг тооцох, өмнөх оноос өссөн, буурсан мөнгөн дүн, хувийг тооцож гаргах, орон нутгийн төсвийн нийт зарлагад төсвийн байгууллагын зардлын эзлэх хувь, эсвэл орон нутгийн төсвийнхөө хэдэн хувийг нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд, хэдэн хувийг боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээнд зориулахаар төлөвлөснийг тооцож, холбогдох харьцааг шинжлэх боломжтой.

Тухайн шатны Засаг даргын өргөн барьсан төсвийн төсөлд төсвийн орлого, зарлагын хэмжээнээс гадна нутгийн удирдлагын зүгээс хэрэгжүүлэх зарлагын хөтөлбөрүүд, тэдгээрийн хүрэх үр дүнг хэмжих чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлтийг тусгасан байхаар журамласныг өмнө дурдсан билээ. ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахдаа хурлын төлөөлөгчид эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг хэр оновчтой тодорхойлсон болон хүрэх түвшинг тодорхой гаргасан эсэхийг хянан үзэж, хэлэлцүүлгийн явцад төсвийн захирагч нараас асууж тодруулах боломжтой.

2.8.2. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЗҮГЭЭС ШИНЖЛЭХ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягтуудаар гаргаж, аудитаар баталгаажуулан тухайн шатны ИТХ-даа хуулийн хугацаанд өргөн барьдаг. ИТХ-ын төлөөлөгч нь Засаг дарга төсвийн гүйцэтгэлээ хурлаар хэлэлцэн баталсан төлөвлөгөөний дагуу захиран зарцуулсан эсэхийг хянан үзэж, төсвийн гүйцэтгэлийг батлахад оролцоно. Иймээс орон нутгийн тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүтэц, агуулгыг сайтар мэдэхийн зэрэгцээ түүнд тусгагдсан мэдээллийг уншиж ойлгох, шинжилгээ хийх чадвартай байх нь чухал.

Санхүүгийн тайланг гадаад болон дотоод хэрэглэгчид эдийн засгийн шийдвэр гаргахад шаардагдах, тухайн байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч), санхүүгийн үр дүн (орлого, үр дүн), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээний)-ийн талаарх мэдээллээр хангах зорилгоор бэлтгэдэг.

Санхүүгийн тайлангийн бүтэц. Санхүүгийн тайлан нь:

- санхүүгийн байдлын тайлан,
- санхүүгийн үр дүнгийн тайлан,

- цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан,
- мөнгөн гүйлгээний тайлан,
- тайлангийн тэмдэглэл, тодруулгаас бүрдэнэ.

Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А) буюу баланс нь байгууллагын хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн байдлыг цаг хугацааны нэг агшинаар тасалбар болгосон мэдээлэл юм. Баланс нь байгууллагын хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх, хөрөнгийн ашиглалт, үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлтийг тооцоход шаардлагатай чухал мэдээллийг агуулдаг. Баланс нь үндсэн гурван хэсгээс бүрддэг.

Хөрөнгө = Өр төлбөр + Цэвэр хөрөнгө/өмч

1. *Хөрөнгө* нь өнгөрсөн ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд байгууллага эзэмшилдээ авсан, ирээдүйд эдийн засгийн үр ашгаа өгөх нөөц юм.
2. *Өр төлбөр* нь өнгөрсөн ажил гүйлгээ, үйл явцын үр дүнд үүссэн, эдийн засгийн үр ашгийг агуулагч, байгууллагын хөрөнгөөр төлөгдөх үүрэг хариуцлага юм.
3. *Цэвэр хөрөнгө/өмч* нь бүх өр төлбөрийг барагдуулсны дараа байгууллагын эзэмшилд байгаа хөрөнгийн өөрийн эх үүсвэр юм.

Баланс нь актив, пассив гэсэн хоёр талтай. Балансын актив тал хөрөнгө, түүний байршил, эзэмших эрхийг, пассив тал хөрөнгийн эх үүсвэр түүний зориулалт, зээлдүүлэгчид ба өмч эзэмшигчдийн өмнө хүлээх үүргийг хариуцдаг. Бүх хөрөнгө болон өр төлбөрийг богино, урт хугацааны гэж ангилах нь шинжилгээ хийж, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Балансын элементүүдийн байршил, уялдаа холбоог хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.12. А аймгийн Б сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн байдлын тайлан

Хөрөнгө (актив)			Эх үүсвэр (пассив)		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I. Эргэлтийн хөрөнгө	24,174.5	22,256.1	I. Нийт өр төлбөр	51.4	
• Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,830.1		• Богино хугацаат өр төлбөр	51.4	
• Богино хугацаат хөрөнгө оруулалт			• Өглөг	51.4	
• Авлага	51.4		• Урт хугацаат өр төлбөр		
• Бараа материал	20,293.0	22,256.1	• Урт хугацаат зээл		
• Мал амьтад			II. Цэвэр хөрөнгө/өмч	1,662,163.4	1,647,662.2
• Урьдчилсан төлбөр			• Засгийн газрын хувь оролцоо	1,099,469.0	1,162,915.2
II. Эргэлтийн бус хөрөнгө	1,638,040.4	1,625,406.1	• Хуримтлагдсан үр дүн	-139,078.6	-217,026.0

• Биет хөрөнгө	1,637,833.1	1,624,822.8	• Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	701,773.0	701,773.0
• Биет бус хөрөнгө	207.3	583.3			
НИЙТ ХӨРӨНГӨ	1,662,214.8	1,647,662.2	ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ	1,662,214.8	1,647,662.2

Нэг жил хүртэл хугацаанд ашиглагдах хөрөнгийг эргэлтийн хөрөнгө, түүнээс дээш хугацаанд ашиглагдах хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгө (үндсэн хөрөнгө) гэнэ. Дараах тохиолдолд хөрөнгийг **эргэлтийн хөрөнгө** гэж үзнэ. Үүнд:

- байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлд ашиглахаар хүлээгдэж байгаа, эсвэл худалдан борлуулахаар эзэмшиж байгаа;
- үндсэндээ худалдах зориулалттай буюу богино хугацаатай эзэмшиж байгаа бөгөөд тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор ашиглахаар хүлээгдэж байгаа;
- мөнгө болон мөнгөтэй адилгах хөрөнгө хамаарна.

Эргэлтийн хөрөнгийг мөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалт, авлага, бараа материал, мал амьтад, урьдчилсан төлбөр гэсэн дэд хэсэгт хувааж санхүүгийн байдлын тайланд хөрвөх чадвараар нь байршуулдаг байна.

Эргэлтийн бус хөрөнгө (үндсэн хөрөнгө) гэж нэг жилээс дээш хугацаагаар ашиглагдаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхдөг хөрөнгө юм. Эргэлтийн бус хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө гэж хуваана. Биет хөрөнгийг газар, барилга, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө, дуусаагүй барилга гэж ангилдаг бол биет бус хөрөнгөд төсвийн байгууллагуудад хэрэглэгддэг програм хангамжууд хамаардаг.

Өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр гэж ангилна. Нэг жилийн дотор төлөгдөх өртөлбөрийг богино хугацаат өр төлбөр, түүнээс урт хугацаанд төлөгдөх өр төлбөрийг урт хугацаат өр төлбөр гэнэ. Ажилчин албан хаагчидтай хийх тооцоо, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагатай хийх тооцоо, хүн амын орлогын албан татварын тооцоо зэрэг өглөгийн үлдэгдлийг бусад өглөгт тусган харуулдаг. Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх урт хугацаат зээлийн үлдэгдлийг урт хугацаат өр төлбөр хэсэгт оруулна.

Цэвэр хөрөнгө/өмч нь санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх дүн гэж тооцно. Цэвэр хөрөнгө/өмчийн үзүүлэлтүүдэд:

- Засгийн газрын хувь оролцоо;
- хуримтлагдсан үр дүн;
- үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл багтана.

Санхүүгийн үр дүнгийн тайлан (СТ-2А) нь төсвийн байгууллага болон тухайн орон нутгийн тайлангийн хугацааны үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг харуулдаг. Үр дүнгийн тайланд тухайн тайлангийн хугацааны орлого, зарлагын гүйлгээг аккрузал зарчмаар бүртгэж тусгадаг. Энэ зарчмаар орлогыг олсон бөгөөд хэмжих боломжтой болсон үед, зардлыг зардал гарсан бөгөөд хэмжих боломжтой болсон үед нь бүртгэдэг.

Хүснэгт 2.13. А аймгийн Б сумын ТЭЗ-ийн санхүүгийн үр дүнгийн тайлан, мян. төг.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
88	Тусламж, санхүүжилтийн орлого	161,802.7	384,532.5
129	Татварын бус орлого	537.8	4,265.1
160	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	162,340.5	388,797.6
161	Ажиллагсдын зардал	85,987.5	206,243.1
181	Урсгал зардал	103,187.6	232,312.1
366	Тусламж, шилжүүлэг	0	3,544.6
411	Нийгмийн хамгааллын зардал	4,271.7	24,645.5
506	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	193,446.8	466,745.0
507	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III = I - II)	-31,106.3	-77,947.4
517	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-31,106.3	-77,947.4

Үйл ажиллагааны орлогод улсын төсвөөс авах урсгал болон хөрөнгийн санхүүжилт, орон нутгийн төсвийн санхүүжилт, нийгмийн даатгалын сан, бусад тусгай сан, тусламжийн орлогын эх үүсвэрээр санхүүжүүлсэн орлогыг тусгадаг. Түүнчлэн бараа, үйлчилгээний орлого нь өмчийн орлого, төсвийн байгууллагын ажил, үйлчилгээний орлого, торгууль, төлбөрийн орлогоос бүрдэнэ.

Үйл ажиллагааны зардлын голлох хэсэг нь ажиллагчидтай холбоотой зардал буюу цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, мөн бараа үйлчилгээний урсгал зардалд зориулагддаг. Бараа, үйлчилгээний урсгал зардалд төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулахад зарцуулах тогтмол зардлууд (гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус), эм, хоол, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, албан томилолт, ном хэвлэл, эд хогшил худалдан авах, урсгал засварын зэрэг үйл ажиллагааны зардлууд хамаарна.

Орлого болон зардлын үзүүлэлтүүдийг үйл ажиллагааны, үйл ажиллагааны бус үр дүн гэж ангилна. Үйл ажиллагааны орлогоос зардлыг хасч **“үйл ажиллагааны үр дүн”-г тодорхойлдог. “Үйл ажиллагааны нийт үр дүн”-г** тодорхойлохдоо “Үйл ажиллагааны үр дүн” дээр “Үйл ажиллагааны бус орлого”-ыг нэмж “Үйл ажиллагааны бус зардал”-ыг хасч гаргадаг байна.

Мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А)-д тайлангийн хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг тусгана. Мөнгөн гүйлгээний тайлан нь дор дурдсан хэсгээс бүрдэнэ.

- үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;
- хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;
- санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ.

Мөнгөн хөрөнгийг бүрдүүлсэн эх үүсвэрийг мөнгөн орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг мөнгөн зарлага гэсэн хэсэгт үзүүлэх ба нийт мөнгөн орлогоос нийт мөнгөн зарлагыг хасч үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр гүйлгээг тодорхойлдог. Үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр

нийт цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдлийг хасаж тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайланд тодорхойлогдсон “нийт цэвэр мөнгөн гүйлгээ” гэсэн дүнтэй тэнцүү байна.

Хүснэгт 2.14. А аймгийн Б сумын ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний тайлан, мян. төг.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
88	Тусламж, санхүүжилтийн орлого	161,802.7	384,532.5
133	Татварын бус орлого	537.8	884.5
161	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	162,340.5	385,417.0
162	Ажиллагсдын зардал	86,222.2	206,243.1
183	Урсгал зардал	63,128.6	153,303.9
359	Тусламж, шилжүүлэг	0	3,544.6
402	Нийгмийн хамгааллын зардал	4,271.7	24,645.5
485	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	153,622.5	387,736.8
486	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III = I - II)	8,718.0	-2,319.8
497	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (IV)	19,416.4	1,510.3
498	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-19,416.4	-1,510.3
510	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-10,698.4	-3,830.1

Үйл ажиллагааны мөнгөн орлогод төсвөөс авсан шилжүүлгийн орлого, төсөвт байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээний орлого, тусламжийн орлого хамаардаг. Үйл ажиллагааны мөнгөн зарлагад цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний зарлага, шилжүүлгийн зарлага зэрэг багтана. Үйл ажиллагааны мөнгөн орлогоос үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагыг хасч үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүнг гаргадаг.

Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээнд урт хугацаанд ашиглагдах хөрөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгөнд ороогүй бусад хөрөнгө оруулалтыг олж эзэмших болон худалдах үйл ажиллагаа орно. Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого хэсэгт хөрөнгө оруулалт ба үндсэн хөрөнгийг худалдсаны орлогын дүнг тусгадаг.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлага хэсэгт үнэт цаас авах, бусдад зээл өгөх зэрэг хэлбэрээр урт хугацаат хөрөнгө оруулалт хийх болон үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд болон капиталжих их засварт зарцуулсан мөнгөн зардлыг харуулдаг. Санхүүгийн үйлжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг төсөвт байгууллагын тайлангийн хугацаанд авсан зээлийн орлогоос, мөн хугацаанд төлсөн зээлийн үндсэн төлбөрийг хасч тодорхойлно.

Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А)-д байгууллагын өмч, хуримтлагдсан үр дүн, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ зэрэг цэвэр хөрөнгө/өмчийн аливаа өөрчлөлтийн хэмжээг тодорхой хугацаагаар үзүүлнэ. Үндсэн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт валютын ханшийн өөрчлөлтийг өмчийн өөрчлөлт гэж үзэн тайланд тусгадаг.

Хүснэгт 2.15. А аймгийн Б сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн Өмчийн өөрчлөлтийн тайлан, мянган төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
11	2015 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	1,099,469.0	701,773.0	-139,078.6	1,662,163.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,099,469.0	701,773.0	-139,078.6	1,662,163.4
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	63,446.2			63,446.2
17	Тайлант үеийн үр дүн			-77,947.4	-77,947.4
18	2016 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	1,162,915.2	701,773.0	-217,026.0	1,647,662.2

Хуримтлагдсан үр дүнг тооцоходоо дансны эхний үлдэгдэл дээр тайлант үеийн үр дүнг нэмж, эцсийн үлдэгдлийг гаргана. Цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэл дээр нийт нэмэгдсэн өөрчлөлтийн дүнг нэмж, хасагдсан өөрчлөлтийн дүнг хасч эзний өмчийн эцсийн үлдэгдлийг тодорхойлдог.

Санхүүгийн тайлангийн тодруулга: Санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тодруулгад санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний хэсэгт харуулсан дүнгүүдийн талаар хүүрнэсэн тодорхойлолт, эсвэл нилээд дэлгэрэнгүй жагсаалт буюу судалгаа, мөн болзошгүй өр төлбөр болон амлалт гэх мэт нэмэлт мэдээллийг багтаана. Жилийн эцсийн санхүүгийн тайлан бүрэн тодруулгатай, улирлын тайлан зөвхөн өр авлагын талаар тодруулгатай байна.

Санхүүгийн тайланг уншиж ойлгох, мөн бусад байгууллагатай харьцуулахад хэрэглэгчид туслах зорилгоор тэмдэглэл, тодруулгыг танилцуулга, нягтлан бодох бүртгэлийн бодлого гэсэн бүтэцтэй бэлтгэсэн байхыг шаарддаг.

2.9. ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ИТХ-ААС ТАВИХ ХЯНАЛТ

2.9.1. ИТХ-ААС ТӨСӨВТ ТАВИХ ХЯНАЛТЫН АРГА ХЭЛБЭЭ

ИТХ-аас хэрэгжүүлдэг үндсэн чиг үүргийн нэг нь хяналтын чиг үүрэг юм. Хяналтын чиг үүргийн хүрээнд ИТХ нь баталсан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хянах, батлан гаргасан журам, төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг ажлын хороод, тэргүүлэгчид, Төлөөлөгчдөөрөө дамжуулан, эсвэл мэргэжлийн байгууллага, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хянаж шалгах үйл ажиллагаа явуулдаг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ бүрэн эрхийнхээ дагуу төсвийн хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлж болно. Үүнд:

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөхдөө түүнд шаардлагатай төсвийг хянах;
- орон нутгийн төсвийн орлого, зарлагын төсөл, жилийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэн батлах;
- орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн байдлыг хянах
- орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хянах;
- орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэлэлцэх, төлөвлөх үйл явц, хөрөнгийн зарцуулалт, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянан шинжилж, үнэлэх;
- орон нутгийн байгууллагуудын Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих гэх мэт.

ИТХ-ын хувьд орон нутгийн төсөв, санхүүгийн байдал, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд дараах тайлан мэдээллийг ашиглана. Үүнд:

1. төсвийн байгууллагын зорилго, зорилт хангагдсан эсэх;
2. холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байгаа байдал;
3. жилийн төсвийн гүйцэтгэл болон төсвийн төлөвлөгөөнд аудитын байгууллагын гаргасан зөвлөмж, тайлан, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн эсэх;
4. байгууллагын хувьд жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний тайлан;
5. байгууллагын шилэн дансны үйл ажиллагаа, шилэн дансны цахим хуудсанд тавигдсан мэдээлэл;
6. орон нутгийн төсвийн сар, улирал, хагас жил болон жилийн тайлан гүйцэтгэлийн мэдээ, үүнд төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл орно;
7. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Засаг даргын улсын төсвийн ерөнхийлөн захирагчтай хийсэн гэрээний хэрэгжилтийн тайлан;
8. орон нутгийн төсвийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан;
9. хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл тайланг үнэлэх;
10. ИТХ-ын тогтоолын хавсралтаар батлагдсан тухайн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлантай ажиллах бүрэн боломжтой байна;
11. мөн бусад нэмэлт мэдээллүүд орно.

Эдгээр мэдээллийг ашиглан ИТХ-ын Төлөөлөгчид болон Иргэний зөвлөл, иргэд, Иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан төсвийн орлого бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн байдалд төлөвлөгөөт болон урьдчилсан хяналтыг ИТХ-аас хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Орон нутгийн төсөвт ИТХ-аас тавих хяналтыг хэрэгжүүлж буй зарим сайн туршлагыг дурдаж болно. Тухайлбал,

- Өвөрхангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2014 оны 38 дугаар тогтоолоор “Нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журам”-ыг батлан мөрдүүлж байна²⁰. Үүний зэрэгцээ тус аймгийн ИТХ “Иргэдийг чадавхижуулах замаар хяналтыг нэмэгдүүлэх нь” тэтгэлгийн хүрээнд ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлтөд иргэдийн саналыг авах, эрэмбэлэх ажлыг сүүлийн 2 жил орон нутагтаа

²⁰ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 8-9 дэх тал

үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх замаар иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж²¹ байна. Мөн аймгийн 19 сумаас орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас үнэлгээний хороонд иргэний төлөөллөө оролцуулж буй байдалд мониторинг хийдгээс гадна “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдэж байгаа бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих “Иргэний хяналт” багийн ажиллах журам”-ыг гарган эдгээр багууд ИТХ-ын хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хуралтайгаа хамтран ажиллаж чадавхижин туршлагажиж байна.

- Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ИТХ, багийн ИНХ-ын дэргэд Хяналтын хороог 7 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй ажиллуулж²², сум хөгжүүлэх сангийн хөрөнгө, ОНХС-гийн хөрөнгө, төсвийн зарцуулалт, суманд хэрэгжиж байгаа тендер шалгаруулалтад оролцон шалгарсан компани, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны явц, үр дүн, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг болсон.
- Сүхбаатар аймгийн ИТХ нь “ОНХС-гийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд аймгийн ИТХ-аас хяналт тавих, санал зөвлөмжөөр хангах нь” гэсэн чиглэлээр тэтгэлэг авч ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлагнах, хэрэгжилтэнд тавих хяналтад иргэд хэрхэн оролцох боломжтой талаар сургалт явуулж, Халзан, Асгат, Баруун-Урт, Уулбаян, Түмэнцогт сумд иргэдийн оролцоотой хяналтын зөвлөл байгуулан ажиллаж байна²³. Мөн Уулбаян суманд Засаг даргын захирамжаар ОНХС-гаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлаа сумын албан тушаалтнууд, ТАХ-дад хариуцуулан өгч эзэнжүүлжээ.
- Баян-Өлгий аймгийн ИТХ хяналтын чиг үүргээ иргэдтэйгээ хамтран²⁴ хэрэгжүүлэхээр аймгийн хэмжээнд болон сумдад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа болон хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүнд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөр ахлуулж, сум бүрийг хуваарилан ажиллажээ.
- Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын ИТХ ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд иргэдийн хяналтыг бий болгох зорилгоор “ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөл”-ийг иргэдийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс оролцуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан²⁵ ажиллуулдаг болжээ.
- Дундговь аймгийн Дэрэн сумын ИТХ бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажилд иргэдийнхээ хяналт, оролцоог нэмэгдүүлэх²⁶ чиглэлээр сумын ИТХ-ын дэргэд бодлогын 4 хороо байгуулан ажиллаж байна.

²¹ УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 105-112 дахь тал.

²² Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 9-11 дэх тал

²³ УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 113-116 дахь тал.

²⁴ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 34-36 дахь тал

²⁵ УИХТГ, ШХА, НҮБХХ (2016). Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг: Сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 192-193 дахь тал.

²⁶ Орон нутгийн хөгжлийн хүрээлэн (2016). Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхэтгэл. Улаанбаатар, 92-94 дэх тал

2.9.2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хяналт-шинжилгээ нь мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийснээр цаашид авч хэрэгжүүлэх алхмыг тодорхойлох боломжийг олгодог бол үнэлгээ нь хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх замаар төслийн хэрэгжилт, үр ашигтай байдалд үнэлгээ өгөх үйл ажиллагаа байдаг.

Орон нутгийн төсөвт санхүүгийн хяналтаас гадна гүйцэтгэлийн хяналт хийж болно. Гүйцэтгэлийн хяналт нь тогтмол бус нэг удаагийн шинж чанартай ба байгууллагын үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн байх ба байгууллага зорилго зорилтдоо хүрэхдээ төсвийн боломжит нөөцөө хэрхэн үр ашиг, хэмнэлттэй удирдаж байна гэдгийн үнэлж, дүгнэнэ. Тухайлбал, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөсөн зорилгоо хангасан эсэхэд дүн шинжилгээ хийж, үр дүнг тайлагнах ба төсвийн зарцуулалт буюу зарлага нь хэмнэлттэй үр ашигтай байж чадсан эсэхийг үнэлэх боломжтой.

Засгийн газраас яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого болон аймаг, нийслэлийн Засаг даргаас Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн биелэлтийг дүгнэх зорилгоор 2010 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр тогтоол гаргаж “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг баталжээ²⁷.

Уг журмын 5.7-д “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, төсөл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлого иргэдийн амьдралд ямар нөлөө үзүүлснийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт болон хэрэглэгчийн үнэлгээ харуулна”, 5.8-д “Хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр)-ийн хэрэгжилт, яам, аймаг, нийслэлийн Засаг даргаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргана. Санал асуулгын нэгдсэн дүнг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай хамт ирүүлнэ” гэж заасан байдаг.

Төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг зохион байгуулах үе шатанд хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үр дүнгийн хяналт шинжилгээ хийх явдал чухал ач холбогдолтой байдаг.

²⁷ Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр тушаалын хавсралт

Хүснэгт 2.16. Хэрэгжилтийн хяналт шинжилгээ ба үр дүнгийн хяналт шинжилгээний гол нөхцөлүүд²⁸

Хэрэгжилтийн хяналт шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүд (төслүүдийн хяналт шинжилгээнд гол төлөв хэрэглэгддэг байсан)	Үр дүнгийн хяналт шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүд (бодлого, хөтөлбөр, төсөл, стратеги зэргийн хяналт шинжилгээнд өргөн хэрэглэгддэг)
<ul style="list-style-type: none"> • Хэрэгжүүлэхээс өмнөх үеийн нөхцөл байдал, хүндрэлтэй асуудлыг тодорхойлох • Үйл ажиллагаа ба шууд бий болох гарцын талаар мэдээлэл цуглуулах • Орцын нийлүүлэлтийн талаар системтэй тайлагнах • Гарцын үйлдвэрлэлийн талаар системтэй тайлагнах • Хэрэгжилттэй шууд холбоотой байх (эсвэл цуврал хэрэгжилт) • Хөгжлийн үр дүнгийн илүү өргөн хүрээтэй асуудлын талаар бус харин захиргааны, хэрэгжилтийн болон удирдлагын талаарх мэдээллээр хангадаг. 	<ul style="list-style-type: none"> • Хэрэгжүүлэхээс өмнөх үеийн нөхцөл байдал, хүндрэлтэй асуудлыг илэрхийлэх суурь тоо мэдээ • Үр дагаврын шалгуур үзүүлэлтүүд • Гарцын талаарх мэдээлэл цуглуулах • Эдгээр нь үр дагаварт хүрэхэд хувь нэмэр хэнхэн оруулдаг болох • Өөрчлөлтийн талаарх оролцогч талуудын санаа бодолд илүү анхаарах • Үр дагаврыг бий болгох явцын ахиц өөрчлөлтийн талаарх чанарын болон тоон илүү их мэдээллийг системтэй тайлагнах • Стратегийн түншүүдтэй холбоотойгоор хийх • Хүлээгдэж буй үр дүнд хүрэхэд түншлэлийн стратегийн амжилт эсвэл алдааны талаарх мэдээллийг хуримтлуулах

Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоог төлөвлөх, бүрдүүлэх, тогтвортой ажиллуулах 10 алхам²⁹:

- 1) бэлэн байдлын үнэлгээ хийх;
- 2) хяналт шинжилгээ үнэлгээ хийх үр дагаврын үзүүлэлтийг тодорхойлох;
- 3) үр дагаварт хяналт шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 4) шалгуур үзүүлэлтийн суурь үзүүлэлт: Бид өнөөдөр хаана байна вэ гэдгийг тогтоох;
- 5) сайжруулахын тулд төлөвлөх:Зорилтот үр дүнгийн түвшинг тогтоох;
- 6) үр дүнгийн хяналт шинжилгээ;
- 7) үнэлгээний үүрэг;
- 8) үр дүнгийн мэдээллийг тайлагнах;
- 9) үр дүнгийн мэдээллийг ашиглах;
- 10) байгууллагын хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоог тогтворжуулах.

Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоог хэрэглэх нь байгууллага, орон нутаг, засгийн газрын үйл ажиллагаа явуулах хэлбэрт томоохон өөрчлөлт оруулахад мөн дэмжлэг болдог. Хэрэв ийм тогтолцоог зөв бүрдүүлж, тогтвортой ажиллагааг нь хангаж чадвал хариуцлагын тогтолцоо, ил тод байдлыг бэхжүүлж, гүйцэтгэлийг сайжруулан мэдлэг бий болгодог байна.

²⁸ Жоди Золл Кусек, Рей С.Рист. “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам”. Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлаг. 32 дох тал

²⁹ Жоди Золл Кусек, Рей С.Рист. “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам”. Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлаг. 40 дэх тал

2.8.3. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ИТХ-ААС ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН СУРГАЛТЫН ГАРЫН АЯЛАГА ЗАМААР ХЯНАЛТ ТАВИХ

Төсвийн тухай хуулиар төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно гэж заасан байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журамд төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй ажлын санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар төсвийн эрх захирагч, тухайн орон нутгийн захиргааны байгууллагаас орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудыг хөндлөнгийн хяналт тавих боломжоор хангах үүрэгтэй тусгажээ.

Хэрэв орон нутагт хэрэгжиж байгаа төсвийн хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой асуудлаар иргэд гомдол гаргавал нутгийн захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжгүй бол холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч, хяналт шалгалтын мэргэжлийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх боломжтой байна.

Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификатын сургалтыг Сангийн яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу МУИС-ийн Эдийн засгийн сургууль, ШУТИС-ийн Компьютер, менежментийн сургууль болон зарим төрийн бус байгууллагууд хамтран явуулж байна. Сургалт нь худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн агуулгыг бүрэн илэрхийлсэн сургалтын 24 цагийн багтаамжтай, лекц, ярилцлага, хэлэлцүүлэг, дасгал, сорил хосолсон байдлаар явагддаг. Энэхүү сургалтанд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төслийн гүйцэтгэчийг сонгох тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ИТХ-аас санал болгон оруулах боломжтой иргэд хамрагдаж АЗ сертификат авах тохиолдолд иргэд, иргэний нийгэм, ИТХ-ыг төлөөлөн хяналт тавьж оролцох боломжтой болно. ИТХ-аар батлагдсан хөрөнгө оруулалтын хэрэгжилт, худалдан авах ажиллагааны явцад иргэд, ИТХ-ын төлөөлөгчдийн зүгээс хяналт тавих чадварыг эзэмшүүлэхийн тулд хурлын төлөөлөгчид болон иргэдийг энэ сургалтанд хамруулах нь чухал ач холбогдолтой.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулах зохицуулалтыг³⁰ бий болгож сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах 20.0 сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болохоос гадна худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтлан ажиллах болсон юм. Энэхүү худалдан авах ажиллагааны журам, заавар, жишиг баримт бичгийг³¹ Сангийн сайд батлан мөрдүүлж эхлээд байна.

³⁰ Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 7.1.4 дэх заалт

³¹ Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, жишиг баримт бичиг. Сангийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 39-р тушаал. Сангийн яам. "Төсвийн хууль тогтоомж II" заавар, журмын эмхэтгэл. УБ., 2013. 241-272 дахь тал

Тухайлбал, сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах зорилгоор хүртэлх сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Сангийн сайдын 2013 оны 39 тоот тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын хүрээнд шийдвэрлэх боломжтой.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг заавал оролцуулах нөхцөлийг бүрдүүлсэн³². Үүний зэрэгцээ хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах замаар захиалагчийн зүгээс явуулж буй худалдан авах үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт, чанарт хяналт шинжилгээ, аудит хийлгэх ажлыг гүйцэтгүүлж болно. Ийнхүү худалдан авах ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэхэд ИТХ, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаснаар худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр дүн сайжирч, авлига буурах, төрийн үйлчилгээний чанар дээшлэх, Засгийн газарт итгэх иргэдийн итгэл нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Иймээс аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын зүгээс орон нутгийн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, орон нутгийн төсөвт хяналт тавих ажилд хурлын төлөөлөгчдийнхөө идэвх санаачилгыг өрнүүлэн ажиллах замаар ИТХ-ын төсөв, санхүүгийн эрх хэмжээгээ үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал байна.

pdfelement

³² Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 47.4 дэх заалт

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

3.1. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, НОГООН ХӨГЖИЛД УЛС, ОРОН НУТГИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

3.1.1. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ХЭРЭГЖИЛТ

Орчин үед дэлхий дахинд улс орон бүр эдийн засгийн өсөлт, хүний хөгжил, байгалийн нөөц, баялагийн ашиглалт гурвын хоорондын оновчтой шүтэлцээ, уялдааг хангахгүйгээр ирээдүйд тогтвортой хөгжих боломжгүй болохыг хүлээн зөвшөөрөөд байна. НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас олон улсын хэмжээний “Хүн төрөлхтөн - Байгаль орчин” тогтвортой хөгжлийн анхны чуулга уулзалтыг 1972 онд Стокхолм хотноо зохион байгуулж, НҮБ-ын гишүүн орнуудыг хуралдуулан олон улсын хэмжээнд баримтлах тогтвортой хөгжлийн тунхаглал болон хүрээлэн буй орчны хөгжлийн 26 зарчмыг баталсан байна. 1992 онд Холбооны Бүгд Найрамдах Бразил улсын Рио Де Жанейро хотод хуралдсан НҮБ-ын “Байгаль орчин - хөгжил” бага хурлаар олон улсын хэмжээнд стратегийн ач холбогдолтой тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахаар тогтож, үүний дагуу “Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг (1994-1998 он) боловруулж³³, хэрэгжүүлэх талаар зохих чармайлт гаргасан байна.

Тогтвортой хөгжлийн үндсэн агуулга, зорилт:

- 1) Экологийн зорилт: Байгалийн нөөцийг зохистой ашиглах, Байгаль орчныг доройтуулахгүй байх;
- 2) Эдийн засгийн зорилт: Үр ашигтай байх, өсөн нэмэгдэх хэрэгцээг зохистой хангах;
- 3) Нийгэм, соёлын зорилт: Ядуурлыг арилгах, амьжиргааны төвшинг дээшлүүлэх, шударга ёсыг тогтоохыг улс орнууд хөгжлийн бодлогодоо тусган хэрэгжүүлж байна.



³³ Засгийн газар 1998 оны 5 дугаар сард баталсан

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний 2002, 2006, 2010 оны тайлан, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн жил бүрийн тайлан, яам, орон нутгаас 2011 онд гаргасан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрт тусгагдсан төлөвлөгөөний биелэлт, Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангууд гарсан. (Хулдорж, Б., Бум-аюуш, М., Дагва, Ш., Мягмар, Д., Шомбодоон, Д. 2012). Улмаар Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг (2008 он) тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулж, 2016 он хүртэл хэрэгжүүлсэн.

Бодлогын эдгээр баримт бичгдийн агуулга нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгаль экологид гарч буй сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх, ногоон орчинг бүрдүүлэх, нөөцийг үр ашигтай ашиглах, баяжуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, ногоон ажлын байр нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэсэн.

Монгол Улсын нийт газар нутгийн 30 орчим хувийг улсын тусгай хамгаалалтад хамруулсан үед байгалийн унаган төрхийг хадгалах, чухал ач холбогдолтой ховордсон амьтан ургамал, ой бүхий газар нутгийг хамгаалах ажлыг авч хэрэгжүүлснээр экологийн тэнцвэрийг хангах зорилт дэвшүүлсэн бөгөөд 2015 оны байдлаар 14 хувь буюу 21.8 сая га талбай бүхий 61 газар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаад байна.

Монгол Улс сүүлийн жилүүдэд уул урхайн салбараас хэт хамааралтай болж, эдийн засгийн бүтэц улам эмзэг болж байна. Уул уурхайн олборлолтод үр ашиг муутай, хоцрогдсон техник, технологи хэрэглэж байгаагийн улмаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихэсч, нүүдлийн мал аж ахуйн бэлчээр доройтуулан, усны нөөцийг хомсдуулж байна.

Хот руу чиглэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөний дүнд хот төлөвлөлт нь хотжилтын хурдыг гүйцэхгүй, гэр хороолол зохицуулалтгүйгээр нэмэгдэж, байгаль орчны даац хэтрэн, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээ, авто замын ачааллын асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учирч, хотын агаар, ус, хөрсний бохирдол ихээр нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.



Улс орнуудын ирээдүйн хөгжлийн чиг хандлага нь 1) аливаа нөөцийг үр ашигтай зарцуулдаг, 2) байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлсэн, 3) хүлэмжийн хийн ялгарал багатай үйлдвэрлэлийг дэмжсэн, 4) нийгмийн ялгааг арилгаж, ядуурлыг бууруулахын төлөө эдийн засгийн шинэ тогтолцоо бий болгоход чиглэж байна.

2014 онд УИХ-аас баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-д байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, нийгмийн оролцоог хангаж, ядуурлыг бууруулах хөгжлийн загварыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэн тавьсан билээ.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030” баталсан. Эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглалын чиглэлээр баримтлах зарчим, зорилго, зорилт, үе шат,

хүрэх үр дүнг тодорхойлсон байна.

Тайлбар: Энэхүү баримт бичиг дэх тогтвортой хөгжлийн 4 үндсэн хүрээ болон Байгаль орчны болон нийгэм-эдийн засгийн гол салбаруудын хөгжилтэй холбогдох зорилго, зорилтыг хэсэгчлэн оруулав. Иргэдийн төлөөлөгч та эргэцүүлэн уншаарай.

Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монгол Улс 2030 онд:

- 1) Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17500 америк долларт хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ.
- 2) Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна.
- 3) Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.
- 4) Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.
- 5) Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.
- 6) Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ.
- 7) Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно.
- 8) Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно.
- 9) Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно.
- 10) Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна.

1.Эдийн засгийн тогтвортой хөгжил

Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.

Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:

- урт хугацааны эдийн засгийн дундаж өсөлтийг 6.6 хувиас доошгүй байлгах;
- нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах, төсвийн тэнцлийн алдагдалын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 2020 онд 15 хувь, 2025 онд 10 хувь хүртэл бууруулах;
- төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн нийт зарлага /улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцоноор/-ыг 2020 онд 35 хувь, 2030 онд 30 хувь хүртэл бууруулах;
- өрийн дээд хязгаарыг чанд сахин мөрдөж, өрийн зохистой түвшинг хангах, гадаад зах зээл дэх Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтмол дээшлүүлэхэд

чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх;

- гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулах;
- гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлж байх;
- төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийг тогтвортой, нам түвшинд барих;
- банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх;
- олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлэх;
- урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах.

Салбарын хөгжлийн зорилтыг хангах зарчим:

- өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах;
- байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэлийг дэмжих;
- үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг эдийн засаг, нийгмийн бүх салбарт чанд баримтлах.

1.1. Хөдөө аж ахуйн салбар

Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.

Зорилт 2. Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.

Зорилт 3. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.

Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2. Аялал жуулчлалын салбар

Зорилт 1. Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.

1.3. Аж үйлдвэрийн салбар

Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.

Зорилт 2. Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.

Зорилт 4. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.

1.4. Эрдэс баялгийн салбар

Зорилт 1. Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.

Зорилт 2. Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.5. Дэд бүтцийн салбар

Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.

Зорилт 2. Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана.

Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.

Зорилт 4. Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

Зорилт 5. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Зорилт 6. Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.

2. Нийгмийн тогтвортой хөгжил

Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:

- хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх;
- иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй,

чанартай байх;

- эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх;
- хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах;
- Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх;
- нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;
- нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;
- нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх.

3. Байгаль орчны тогтвортой хөгжил

Байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно.

Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчим:

- байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах;
- байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах;
- цэвэр технологийг дэмжих, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх;
- байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх;
- байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх.

3.1. Усны нөөцийн нэгдсэн менежмент

Зорилт 1. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.

I үе шат (2016-2020): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх.

II үе шат (2021-2025): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх, гадаргын усыг хуримтлуулах усан сангуудыг байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 23 хувьд хийх.

III үе шат (2026-2030): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх.

Зорилт 2. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

I үе шат (2016-2020): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.

II үе шат (2021-2025): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85 хувьд хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.

III үе шат (2026-2030): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэж, хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.

3.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.

I үе шат (2016-2020): Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгох.

II үе шат (2021-2025): Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жишиг төслүүдийг хэрэгжүүлж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулах.

III үе шат (2026-2030): Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг зөөлрүүлж, гамшгийн эрсдэл, түүнээс үүдэлтэй хохирлыг бууруулах.

Зорилт 2. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрсстөрөгчийн ялгарлыг бууруулна.

I үе шат (2016-2020): Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх.

II үе шат (2021-2025): Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 7 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 5 дахин нэмэгдүүлэх.

III үе шат (2026-2030): Эдийн засгийн бүтцэд өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 14 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 10 дахин нэмэгдүүлэх.

3.3. Экосистемийн тэнцвэрт байдал

Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.

I үе шат (2016-2020): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн

8.5 хувьд хүргэх.

II үе шат (2021-2025): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 27 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.7 хувьд хүргэх.

III үе шат (2026-2030): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9.0 хувьд хүргэх.

Зорилт 2. Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.

I үе шат (2016-2020): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох.

II үе шат (2021-2025): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх.

III үе шат (2026-2030): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 30 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 40 хувьд хүргэх.

4. Тогтвортой хөгжлийн засаглал

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах номлолын дагуу улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.

Тогтвортой хөгжлийн дээр дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, оролцоо асар их байх болно.

3.1.2. НӨХӨН СЭРГЭХ БОЛОМЖТОЙ БОЛОН БОЛОМЖГҮЙ НӨӨЦҮҮД

Байгалийн нөөцийг биологийн болон байгалийн богино хугацааны үйлчлэлийн жамаар сэргэн үржих, ашиглалтын дараа нөөц нь нөхөгдөх байдлаас хамааруулан нөхөн сэргэх боломжтой, нөхөн сэргэхгүй нөөц гэж ангилна.

Байгалийн нөхөн сэргэх нөөц, эрчим хүч

Байгалийн нөөцийг зохистой хэмжээгээр ашиглаж байхад өөрийн зүй тогтол жамаар өөрөө нөхөн сэргэж, үржин төлжиж байдаг. Жишээлбэл, Нарны болон салхины эрчим хүч, амьтан, ургамлын аймаг юм. Амьтан, ургамлын аймаг нь хэдийгээр байгалийн жамаараа өсөж, үрждэг боловч хүний буруу үйл ажиллагаанаас болоод нөхөн сэргэх боломжоо алдаж болох юм. Энэ утгаар нь “нөхөн сэргэх боломжит нөөц” үзэж байна. Бид “сэргээгдэх нөөц” гэж шавхагдашгүй мэт төсөөлж ирсэнээ одоо эргэцүүлэх шаардлагатай болж байна. Нэгэн зэрэг нөхөн сэргэдэг, үл сэргэдэг нөөцийн жишээ бол удаан ургалттай ой мод юм. Иймд нөхөн сэргэх

боломжит, боломжгүй нөөцийн ойлголт нь байгалийн үзэгдлийн эдийн засгийн агуулгатай болгож хэрэглэж буй арга юм.

Манай орны бэлчээрийн мал нь ган, зуд зэрэг байгалийн үзэгдлийг даван туулж, улам бүр чанаржиж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг (сүү, цагаан идээ, ноос, ноолуур, мах, арьс шир гэх мэт) нийлүүлдэг гайхамшигтай нөхөн сэргэдэг нөөц юм. Мөн л мал сүргээ хамгаалах, түүний бэлчээр ургамлын санг хамгаалахгүй бол нөхөн сэргэх боломжгүй болно.

Байгалийн нөхөн сэргэх боломжит нөөцийн эдийн засаг нь биологийн төрөл зүйл нь жам ёсны хорогдох, үржих нөөцийг судлах замаар экологийн системийн менежментийн өртөг, ач тусыг шинжлэн тодорхойлдог.

Биологийн нөхөн сэргэдэг нөөцүүд хугацаанаас хамаарч өсөх зүй тогтолыг “Үйлдвэрлэлийн буюу өсөлтийн функц”, тухайн нөөцийг ашиглах боломжийг “Хураалтын функц”-ээр тус тус тодорхойлдог. Нөөц их байх тусам хураалт өндөр бүтээмжтэй мөн хямд байна. Эсрэгээрээ нөөц багасах тусам хураалтын зардал болоод бүтээмж удаан байхад нөлөөлнө.

Байгалийн нөхөн сэргэх нөөцийг түгээмэл тохиолдолд нийтээр эрх тэгш ашиглах бөгөөд тодорхой зохицуулалтын хүрээнд хувийн өмчлөлийн хэлбэртэй байдаг. Тухайлбал, “Мал сүрэг төрийн хамгаалалтад байна” гэдэг нь Монгол Улсын үндэсний баялаг болох мал сүргийн эрүүл мэнд, үүлдэр угсаа, генийн сан, хүнсний аюулгүй байдалтай холбоотой юм. Тухайн мал сүрэг нь малчны өмчлөлд байх нь тэрхүү аж ахуй эрхлэгч, өрхийн эдийн засгийн баталгааг буй болгож байгаа хэрэг юм.

Байгалийн нөхөн сэргэх нөөц нь биологийн өсөлтөөр үржихэд таатай орчинг бүрдүүлэх нь нийтийн эрх ашиг, өмчлөлийн агуулгатай байдаг. Тухайлбал, манай улсад бэлчээр нийтийн өмч байдаг. Нийтийн өмч болсон бэлчээрт хувийн өмчийн малыг өсгөхтэй холбоотойгоор төрийн болон орон нутгийн зохицуулалт үйлчилж байдаг. Үүнийг орон нутагтаа, сум, баг, хот айлдаа хэрэгжүүлж ирсэн уламжлал, хэв хууль байсан агаад эдүгээ зах зээлийн нөхцөлд боловсронгуй болгох хэрэгцээ үүсэж байдаг. Үүнд л нутгийн удирдлага анхаарах зүйл юм.

Мал аж ахуй ба загасны аж ахуйн зохицуулалтын нийтлэг шаардлага

Далайн эргийн улс орнуудад далай, гол мөрний эрэг орчмын ан агуурын зориулалтаар түгээмэл төрөл зүйлийн загас, амьтан, шавьжийг нөхөн сэргэх боломжтой нөөц гэж үздэг. Загасны нөөцийн эдийн засаг нь дэлхий даяар 180.0 сая хүнийг ажлын байраар хангаж, жилд дунджаар 85.0 тэрбум долларын экспорт хийдэг дэлхийн хамгийн өргөн худалдаалагддаг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэг юм (Bonini et al. 2011). Дэлхийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын мэдээгээр загасны нөөцийн 50%-ийг бүрэн ашиглаж, 30% орчмыг хэт олборлож байгааг онцолсон байна. Дэлхийн Банкны судалгаагаар загасыг ихээр олборлож нөөц хомсдсоноор дэлхийн загасны эдийн засагт оруулах өгөөж жилд 51.0 тэрбум доллараар буурч, жилд 46-90 тэрбум долларын алдагдалд хүрсэн гэсэн мэдээ байна.

Далайн загас нь нийтийн өмчийн хэлбэртэй бөгөөд загасны аж ахуйн олборлож, бэлтгэсэн “бүтээгдэхүүн” нь хувийн өмч болдог.

Бэлчээрийн мал аж ахуй, загасны аж ахуйд нийтлэг зүйл нь байгалийн нөхөн сэргэх боломжит нөөцийг нийтийн өмчийн хэлбэртэйгээр зөв зохистой, экологийн

тэнцвэрийг хадгалж чадах хэмжээнд зохицуулах эрх зүйн зохицуулалт юм. Энэ нь тухайн нутаг орон, биологийн нөөцийн өсөлттэй холбоотой тул тус бүрийн өвөрмөц тал, арга ажиллагааны зохицуулалтыг шаарддаг.



Сэргээгдэх эрчим хүч



Уламжлалт мал аж ахуй

Адилтгавал, усанд унасан хүнийг олсоор татах, модноос дүүжлэгдсэн хүнийг татаж авах хоёр нь олсоор татан аварч байгаа утгаар ижил боловч 2 дахь тохиодолд тохирохгүй арга юм. Иймд байгалийн бүс, аймаг сум, орон нутгийн онцлог, иргэдийн уламжлалт аж ахуйн арга ажиллагаа зэрэг үндэс тулгуур хүчин зүйлийг анхаарч бэлчээр, тариалан, хот байгуулалт, уул уурхайг эрхлэх, эс эрхлэх шийдвэр, сонголтыг хийх, эрхлэж буй гол гол салбаруудын зохицуулалтыг амьдралд тулгуурлаж хэрэгжихүйц боловсруулж, шийдвэрлэх хэрэгцээ үүсэж байна.

Ойн нөөцийн зохицуулалт

Дэлхий даяар 3.8 тэрбум га газарт ой модтой бөгөөд энэ нь нийт дэлхийн газрын 29.6% эзэлдэг байна (FAO, 2001). Дээрх ойн 70% орчмыг арилжааны байдлаар ашиглаж болох дүнг боловсруулах боломжтой байна (НҮБ, 2000). Манай орны нийт нутаг дэвсгэрийн 8 хүрэхгүй хувь нь ойгоор бүрхэгдсэн талбай эзэлдэг бөгөөд байгалийн хүчин зүйл болон хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас жил ирэх тусам ойн нөөц буурах хандлагатай байна. Ойн түймрээс их хэмжээний талбайн ойн нөөц дахиж сэргэхээргүйнээр устаж байна. Ойгоос мод бэлтгэх, самар, жимс, эмийн ургамал түүх зэргээр бүтээгдэхүүн бэлтгэж зах зээлд ихээр нийлүүлэх, мөн ой, усны сав газарт уул уурхай эрхэлж ашигт малтал олборлож байгаа нь бас сөрөг нөлөө үзүүлсээр ирсэн. Ойн нөөцийн менежментийн анхаарах гол асуудал нь орон нутгийн иргэд өөрсдөө хамтдаа зөв зохистой ашиглах, нөхөн сэргээхэд хамтын хүч чармайлт гаргах, түлээний мод орлох өөр түлш, технологи олж үйлдвэрлэл, ахуйд нэвтрүүлэх явдал юм. Үүнд ИТХ гол анхаарал хандуулж ажиллавал зохино.

Бэлчээрийн нөөцийн зохицуулалт

Бэлчээрийн даацтай уялдсан зохицуулалт улс орон бүрийн хөдөө орон нутагт зайлшгүй хэрэгтэй байдаг. Бэлчээрт хувийн өмчлөл тогтоогдоогүйн улмаас нийтийн өмчийн оновчгүй тэнцвэр тогтох эрсдэлтэй юм. Олон улсын байгууллагуудын санхүүжилтээр бэлчээр нөөцийг оновчтой ашиглах менежментийн чиглэлээр олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж, бэлчээрийн ашиглалтын хамтын менежментийг

хэрэгжүүлж байгаа нь бэлчээрийн нөөцийн зохицуулалтын талаар чухал арга туршлага хуримтлуулсан юм.

Бэлчээрийн өвс ургамлын байнга нөхөн сэргэж ургах боломж нөхцөлийг жил бүр бүрдүүлж, бэлчээрийн нөөцийг цаашид ч он удаан жил тогтвортой ашиглаж, үр өгөөжийг нь хүртэхийн тулд малчид мал сүргийнхээ тоо толгой, бүтцийг тухайн хот айл болон өрхийн түвшинд бэлчээрийн даацад нийцүүлэх асуудал нэн чухал. Үүний тулд бэлчээрийг хуваарьтай ашиглах, сэлгэж ашиглах, нөхөн сэргээж сайжруулахад чиглэгдсэн хууль эрх зүй, малчдын уламжлал, сайн туршлагыг бэлчээр ашиглалтын хамтын менежментийн хүрээнд малчдын санал, санаачлагыг нэгэн зүгт төвлөрүүлэн зохион байгуулах нь нутгийн өөрөө удирдах байгууллагын чухал үүрэг мөн. Түүнчлэн мал, мах бэлтгэлийг бэлчээрийн даацад нийцүүлэн зохион байгуулах болон эдийн засгийн зохицуулалтын бусад аргуудыг ч хослон хэрэглэж болно.

Байгалийн нөхөн сэргэхгүй нөөц

Байгальд буй баялгаас хүний үйл ажиллагаар авч хэрэглэснээр өөрийн жамаараа нөхөж, сэргэх ямар ч боломжгүй нөөцийг “байгалийн нөхөн сэргэхгүй нөөц” гэнэ. Жишээлбэл, алт, нефть, нүүрс, өнгөн хөрс, төмрийн хүдэр, озоны давхарга болон удаан ургалттай ой мод гэх мэт. Эдгээр нөөцийн ерөнхий шинж чанар:

- анхны нөөц нь тогтмол буюу өсөн нэмэгдэхгүй (зарим нээгдээгүй байгаа нөөцийг үл тооцвол);
- олборлолт болон ашиглалт нь нөөцийн хэмжээг багасгаж, улмаар шавхагдана.

Байгалийн нөхөн сэргэхгүй нөөцийг ашиглахад олборлолтын зэргийг ямар хэмжээнд байлгах вэ гэдэг нь чухал асуудал байдаг. Олборлолтыг хэт хурдан хийвэл байгалийн нөөцийн үнэ буурч нөөц хурдан дуусна. Харин эсрэгээрээ хэт удаан хийвэл үйлдвэрлэлийн үр ашиггүй байдал бий болж үр өгөөж багасах болно. Байгалийн нөхөн сэргэхгүй нөөцийг ашиглахад хоёр төрлийн капитал байна. Үүнд:

- Байгалийн нөөцийн капитал => Нөөцийг өсгөж хөрөнгө оруулалт хийх боломжгүй, олборлолтоор нөөц багасна;
- Хүний бүтээсэн капитал => Хөрөнгө оруулалтын хэмжээгээр өсөж, элэгдлээр хорогдоно.



Ил уурхайн олборлолт



Гар аргаар алт олборлогчид

Төгс өрсөлдөөнт болоод монополизм зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүдийн сэргэхгүй нөөцийн анхны олборлолтын загварыг 1931 онд Харолд Хотелл гаргажээ. Хотеллийн загварыг 1970-аад онд сэргэхгүй (хомсдол) эдийн засаг болон төгс бус өрсөлдөөнийг шинжлэхээр хөгжүүлсэн ба ингэхдээ нефтийн эдийн засгийн жишээн дээр авч үзсэн байна. 1980-1990-ээд оны үед Хотеллийн загварт бодит зардлын бүтэц, технологийн өөрчлөлт болоод олборлолтын нөлөөллийг ихэд анхаарч эхэлжээ. 1990-ээд оны сүүлээс өнөөг хүртэл олборлолтоос үүдэлтэй байгаль орчны доройтол, мөн чулуужсан түлш ашиглалттай уялдсан дэлхийн дулаарлын асуудал судлаачдын гол анхааралд байна.

Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөцийн тусгай зөвшөөрөл олгох, олборлолт хийх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох, нөхөн сэргээх, ил тод байдлыг хангах, орон нутгийн оролцоог хангах гэх мэт олон асуудал маш их маргаан дагуулдаг тул тухайн орон нутгийн тогтвортой хөгжил, хүн амын сайн сайхан аж төрөх нөхцөл болон байгаль орчныг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн хүрээнд оновчтой шийдвэр гаргаж байгаа эсэхэд нутгийн өөрөө удирдах байгууллагууд хяналтын чиг үүргээ чиглүүлнэ.

3.1.3. Байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах арга зам



Хууль бусаар самар түүгчдэд шалгалт хийлээ. 2016.08.29 Дархан цаазат Богд Хан уул нь нийт 41.6 мянган га талбайтай, үүний 22.0 мянга га талбай нь ой бөгөөд түүний 20 хувьд нь хуш ургадаг. Хуш мод нь экологийн болон эдийн засгийн чухал ач холбогдолтой шилмүүст мод. Түүнчлэн хуш мод нь ойн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж

ус, хөрсийг хамгаалахын зэрэгцээ ойн олон төрөл, зүйлийн амьтан, шувууны амьдрах орчин, хүнс, тэжээлийн бааз, нөөц нь болдог. Мөн хэрэм, гахай, самрын шаазгай, жирх, баавгай, хур, сойр, гэх зэрэг амьтдын гол тэжээл нь самар юм. Жирх, хэрэм гэхэд л 6-10 кг самар идшиндээ нөөцөлдөг бол, баавгай өдөрт 20-30 боргоцой идэж 100-150 кг өөх хуримтлуулж байж ичдэг байна. Харин зэрлэг гахай 2.5 кг самар идэж байж онд ордог. Гэтэл өнөөх хууль бусаар самар бэлтгэгчид байгаль дахь амьтдын гол хоол тэжээл болох самрыг юу ч үгүй түүх нь холгүй байна. Тодорхой хугацаанд шинэчлэгдэн солигдон унаж байдаг хушны шилмүүс, боргоцой нь хөвсгөр байдаг тул бусад шилмүүст модтой харьцуулахад хөрсний сайн бордоо болж, усыг өөртөө хамгийн ихээр шингээдэг. Энэ нь ойн чийгшлийг удаан хадгалж, уур амьсгалын таатай орчинг бүрдүүлдэг. Ерөнхийдөө хушин ой нь бактери устгах чадвартай, фитонцид, эфирийн тос их ялгаруулдаг нь орчны агаарыг цэвэршүүлдэг тул эртнээс хушин ойг эмчилгээний зорилгоор ашиглаж байсан түүхтэй. Харин нь самарчид мод тайран багаж хийж хуш модыг цохиж самраа унагаадаг нь модыг гэмтээх, ургалтыг зогсоож үхжих шалтгаан болдог байна. Үүнээс гадна хог хаягдлыг их хэмжээгээр хаяж байгалийн бохирдуулж

ганц хуш модны ургалт биш 22 мянга га талбай ойд аюул нүүрлээд байна. Мөн бэлд гүйцээгүй самар нь давирхай ихтэй байдаг учраас нян вирус, бохирдлыг амархан татдаг бөгөөд халдварт өвчин тараах нөхцөл болдог гэдгийг эмч мэргэжилтнүүд анхааруулдаг. Тиймээс өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдлаа бодсон ч хуш модны самрыг хуулийн хугацаанд нь түүх хэрэгтэй. Самарын нэг килограммын экологи эдийн засгийн үнэлгээ 50.0 мянган төгрөг байдаг аж.

Иймд хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэхийн тулд хууль бус үйлдлийн үр дагаварыг энд жишээ татсан хууль бус самар түүгчдийнх шиг жишээгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сайн ойлгуулах ажил зохион байгуулахын зэрэгцээ хуулийн хариуцлагыг ч сануулах нь үр дүнгээ өгнө.

Тухайлбал, хууль бусаар самар бэлтгэсэн, тээвэрлэсэн тохиолдолд олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгө торгуулиар торгодог. Харин нь ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгуулиар торгодог юм. Мөн дөрвөн килограммаас дээш бол эрүүгийн хэрэг үүсэж, 3-6 сар болон таван жилийн хорих ялаар шийтгэгдэг байна. Эх сурвалж: <http://mpa.gov.mn/news/1655>

3.2. БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

3.2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Их Хурлаас баталсан, 2016 оны 9 дүгээр сарын 12-ны байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй 597 хуулиас байгаль орчин, түүний бүрэлдэхүүн болох хөрс, газар, ус, ой, агаар, ургамал, амьтны тухай, тусгай хамгаалалт, ашигт малтмал, хот байгуулалтын хүрээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, төрийн болон орон нутгийн ажил үйлчилгээтэй холбогдох 46 хуулийг хэрэгжүүлж байна. Эдгээр хуулийг Нутгийн удирдлагын нийтлэг хууль, Байгалийн нөөцийг хамгаалах, ашиглах, Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Хот байгуулалт, хог ариутгалын тухай гэсэн 5 хэсгээр бүлэглэн үзэж болох байна. Тухайлбал:

I хэсэг. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, Нутгийн удирдлагын ажлыг зохицуулсан нийтлэг хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай,
3. Захиргааны ерөнхий хууль³⁴,
4. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай³⁵,
5. Нийтийн сонсголын тухай³⁶,

³⁴ Энэ хуулийн зорилго нь нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэхэд оршино.

³⁵ Энэ хуулийн зорилт нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

³⁶ Энэ хуулийн зорилт нь төрийн байгууллага, албан тушаалтан энэ хуульд заасан асуудлаар нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад оршино.

6. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай³⁷,
7. Монгол Улсын хилийн тухай,
8. Гамшгаас хамгаалах тухай;

II хэсэг. Байгалийн нөөцийг хамгаалах, ашиглах хууль:

9. Байгаль орчныг хамгаалах тухай,
10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай,
11. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай,
12. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай,
13. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай,
14. Усны тухай,
15. Ус бохирдуулсны төлбөрийн тухай,
16. Агаарын тухай,
17. Агаарын бохирдлын төлбөрийн тухай³⁸,
18. Амьтны тухай,
19. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай,
20. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай,
21. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай,
22. Аялал жуучлалын тухай,
23. Ойн тухай,
24. Ургамал хамгааллын тухай,
25. Байгалийн ургамлын тухай,
26. Таримал ургамлын үр, сортын тухай,
27. Органик хүнсний тухай;

III хэсэг. Газрын тухай хууль:

28. Газрын хэвлийн тухай,
29. Газрын тухай,
30. Газрын төлбөрийн тухай³⁹,
31. Тариалангийн тухай,
32. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай,
33. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай,
34. Геодези, зураг зүйн тухай,
35. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай;

IV хэсэг. Ашигт малтмалын тухай хууль:

36. Ашигт малтмалын тухай,
37. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай,
38. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай,
39. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай,
40. Газрын тосны тухай;

³⁷ Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

³⁸ Энэ хуулийн зорилт нь агаар бохирдуулагч этгээдэд агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

³⁹ Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ногдуулах, уг төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

V хэсэг. Хот байгуулалт, хог хаягдал, ариутгалын тухай хууль.

41. Хот байгуулалтын тухай,
42. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай,
43. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай,
44. Хог хаягдлын тухай,
45. Химийн хорт болон аюултай бодисын тухай,
46. Эрүүл ахуйн тухай.

Эдгээр хуулийн Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын эрх, үүрэгтэй шууд холбогдох зүйл, заалтыг түүвэрлэн, “Иргэдийн Төлөөлөгчийн хөтөч” буюу “Орон нутгийн ажилтай холбогдох нийтлэг болон байгаль орчны талаархи хуулийн эмхтгэл”-д оруулсан болно.

Өнөөдөр байгалийн нөөцийг ашиглах, хамгаалахтай холбоотой эрх зүйн үндэс бүрэн бүрдсэн гэж үзэж болох боловч харатсалтай нь энэ чиглэлийн хуулиудын хэрэгжилт хангалтгүй байна. Иймд хууль болгоны хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжихгүй байгаагийн бодит шалтгааныг тогтоож, хэрэгжүүлэх талаар санаачлага гаргахад ИТХ болон төлөөлөгч бүр анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.2.2. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАРТАЙ ХОЛБОГДОН ҮҮССЭН ЗӨРЧИЙГ ШИЙДВЭРЛЭХ

Байгаль орчин, тусгай хамгаалалт, газар, ашигт малтмалтай холбогдон үүсэх зөрчил маргааныг сум, дүүргийн төвшинд тухайн шатны Засаг дарга, энэ төвшинд шийдэх боломжгүй үед аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга шийдвэрлэж байна. Эдгээр орон нутгийн байгууллагын төвшинд шийдэх боломжгүй буюу өөр хуулиар зохицуулах шаардлагатай үед дараах шүүхээр хэлэлцэж байна. Үүнд:

- Захиргааны хэргийн шүүх - албан тушаалтны гаргасан захирамж, тогтоол нь хууль зөрчсөн буюу хуулийг буруу хэрэглэсэн тохиолдолд;
- Иргэний хэргийн шүүх – газар өмчлөх, эзэмшихтэй холбоотой иргэдийн өмч, хөрөнгийн агуулгатай үед;
- Эрүүгийн хэргийн шүүх – газартай холбогдон үүсэх зөрчил маргаан нь гэмт хэргийн агуулгатай, авилгал хээл хахуултай холбоотой үед холбогдогч талуудын нэхэмжлэл, нотлох баримтад үндэслэн хуулийн дагуу хэлэлцэн шүүдэг.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрсөн үед Давж заалдах шатны шүүхэд хандаж, магадлуулах, мөн энэ шийдвэрийг эс зөвшөөрсөн үед Дээд шүүхийн хяналтын шатны шүүхэд хандаж, эцсийн шийдвэрийг гаргуулдаг. Шүүхийн өмнө иргэн, хуулийн этгээд, албан хаагч бүгд тэгш эрхтэй байна.

Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахтай холбогдсон аливаа маргааны Захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэхгүй⁴⁰ гэдгийг Дээд шүүхийн зөвлөмжид онцолсон байна (Амарсанаа.Ж, Баянбилэг.Д Захиргааны хэрэг, 265).

Газрын маргаантай хэргийн 15%-ийг газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам зөрчсөн, 31%-ийг бусдын эзэмшил, ашиглалтын газрын талаарх маргаан, 30%-ийг захиргааны байгууллагын хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах тухай, 24%-ийг газартай холбогдох бусад зөрчил, маргаан эзэлж⁴¹ байна гэсэн

⁴⁰ Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж “Газрын тухай хуулийг шүүхийн практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай”, 2006.04.28

⁴¹ Газар, удирдлага, эрх зүй, Хамтын, Ред Ж.Амарсанаа, Ш.Батсүх, УБ, 2005, 39 дэх тал

судалгааны дүнг 2012 онд гаргасан байдаг.

Газартай холбогдох зөрчил, маргаан, хэрэг нэмэгдэж, түүнийг 3 төрлийн шүүхээр хэлэлцэж байгаа нь дараах хүчин зүйлтэй холбоотой байна. Үүнд:

1. Газрын эрхтэй холбогдох хэрэг нь зах зээлийн эдийн засагт шинээр үүсэж байна;
2. Шүүхийн тогтолцоонд Газрын шүүхийн салбарласан зохион байгуулалт үүсээгүй;
3. Газрын хуулийн үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрэн хуульчлаагүй;
4. Газрын эрх зүйн салбараар мэргэжсэн эрх зүйч бэлтгэгдээгүй;
5. Газар-өмчийн зүйлийн төрөл тодорхойгүй, газар ашиглах стандартгүй;
6. Төр, орон нутаг, иргэн болон бусад хуулийн этгээдийн газрын асуудал нь нийтийн болон иргэний эрх зүй тус бүрд хамаарахын зэрэгцээ тэдгээрийн уулзварт авч хэлэлцэх шаардлагаас үүдэлтэй байна.

“Газар чөлөөлүүлэх, хохирол төлүүлэх, хөрөнгө мөнгө, иргэд хоорондын арилжаатай холбоотой маргаан, бусдын эзэмшил, газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах зэрэг маргааныг Иргэний хэргийн шүүх, газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэхтэй холбоотой эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр нь иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх маргааныг Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж”⁴² байна.

Жишээ 1. Тариалангийн зориулалтаар газар эзэмшүүлэхэд багийн иргэдийн санал хүчинтэй

Иргэн Д нэхэмжилдээ: “Сумын удирдлагууд багийн иргэдийн саналыг авалгүй дур мэдэн шийдвэр гаргаж хууль зөрчсөн. Багийн ИНХ-ын шийдвэргүйгээр сумын ИТХ-ийн дарга, засаг дарга нар 969 га газрыг хууль бусаар олгосон” гэж 2013.09.27-ны өдөр шүүхэд ханджээ.

А аймгийн засаг дарга, Х сумын засаг дарга нар А багийн ИНХ-ын шийдвэр (өмнө ажиллаж байсан) сумын засаг даргын шийдвэрийг буруутгаж, захирамжуудыг удаа дараа хүчингүй болгосныг Захиргааны анхан, давж заалдах, дээд шүүхийн хянах шалгах гэсэн 3 шатанд нэхэмжилэн, шалгуулж, 9 удаагийн хурал хийлгэж 2 жил үргэлжилжээ.

Үйл явдлын хураангуй

- 1) А аймгийн Б сумын ИТХ-ын 2010.06.21-ний өдрийн тогтоол, Засаг даргын 2010.06.21-ний “Газар эзэмшүүлэх тухай” А/47 дугаар захирамжаар дуудлага худалдаагаар К компанид газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан:
 - *Аймаг, сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 969 га газрыг дуудлага худалдаагаар К компани эзэмших болов. Эзэмшил газарт тариа тариалах бэлтгэл ажил, хөрөнгө оруулалт бэлтгэсэн боловч үйл ажиллагаа эрхлээгүй.*
 - *969 га газрыг газар тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн бөгөөд үүний 500 га нь атаршсан (1960-70 оны үед газар тариалан эрхлэж байсан) газар, 469 га нь бэлчээр байна. Атаршсан 500 газрыг бэлчээрт шилжүүлэх тухай, мөн бэлчээрийн 469 га газрыг тариаланд шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоол байхгүй болно.*
- 2) Сумын ИТХ-ын 2012.08.10-ны өдрийн хурлын тэмдэглэлд “Тухайн газрыг сүүлийн 30

⁴² Газрын багц хуулийн төсөл, хуулийн судалгаа, харьцуулалт, гадаад орнуудын судалгаа, МУИС-ын ХЗС-ын судлаачдын материалаас, 2013 он

- гаруй жилд бэлчээрийн зориулалтаар ашиглаж байсан” гэдгийг онцолсон байна.
- 3) Сумын Засаг даргын 2012.11.16-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” А/89 дүгээр захирамжаар “Багийн иргэдийн бэлчээрийг тариалан болгож өөрчлөхийг эсэргүүцсэн санал болон 2 жил ашиглаагүй⁴³” гэдгийг үндэслэж “К компанийн газар тариалангийн зориулалтаар эзэмших эрхийг хүчингүй болгов”
 - *К компаний газар эзэмших эрх дуусгавар болов.*
 - 4) Сумын Засаг даргын 2013.09.23-ны тогтоолд “Тухайн газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж ирсэн” А/118 дугаар захирамжаар 2012.11.16-ны өдрийн А/89 дүгээр захирамжийг хүчингүй болгосон
 - *К компаний газар эзэмших эрх сэргэв.*
 - 5) Сумын I багийн ИНХ-ын 2013.11.20-ны тогтоолд “Тухайн газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж ирсэн” гэдгийг санал нэгтэй тусгасан
 - 6) Захиргааны хэргийн анхан шатны 2014.02.10-ны өдрийн .. дугаар шийдвэр “Газрын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-д заасны дагуу эхлээд багийн ИНХ-ын саналыг авах байсан” гэдэгт үндэслэж, “Б сумын Засаг даргын А/89 дүгээр захирамж хүчинтэй” гэж иргэн Д-ийн нэмэмжлэлийг шийдсэн
 - *К компаний газар эзэмших эрх хууль бус байсныг тогтоож, эрхийг дуусгавар болгосон*
 - 7) Аймгийн Засаг дарга 2014.03.20-ны өдрийн А/156 дугаар захирамжаар “Газар тариалангийн зориулалтаар дуудлага худалдаагаар хуулийн дагуу К компанид газар эзэмшүүлсэн байхад Б сумын Засаг дарга үндэслэлгүйгээр газар эзэмших эрхийг хүчингүй болгосон” гэж үзээд Б сумын Засаг даргын А/89 дугаар захирамжийг хүчингүй болгов.
 - *Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон байхад А аймгийн Засаг дарга А/156 захирамж гаргасан*
 - *К компаний газар эзэмших эрх дахин сэргэв*
 - 8) Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны 2015.01.27-ны өдрийн 5 дугаар шийдвэр: Газрын тухай хуулийн 4 дүгээр 44 зүйлийн 4.1.3, 4.1.4, 61 дүгээр зүйлийн 61.1, ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн ж-д45 заасныг баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хангаж, А аймгийн Засаг дарга 2014.03.20-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” А/156 дугаар захирамжийг хүчингүй гэж шийдвэрлэжээ.
 - *Аймгийн Засаг даргын захирамж хүчингүй болов.*
 - *Тус газрыг Засаг дарга “тариалангийн газар” гэж үзсэн бол “Багийн ИНХ-ын санал авах журмыг зөрчиж”, мөн газар тариалангийн газар гэдгийг баттай нотолсон баримтгүйгээр газар эзэмших эрхийг сэргээсэн байна.*
 - *Тус газар нь бэлчээрийн зориулалттай ашиглаж ирсэн тул сумын Засаг даргын А/89 дүгээр захирамж Газрын тухай хуулийн 6 дугаар⁴⁶ зүйлийн 6.2, 52 дугаар зүйлийн*

⁴³ Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж “Газрын тухай хуулийг шүүхийн практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай”, 2008.03.31, №15 “газраа зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй (барилга, байгууламж, зам талбай, тариалан эрхлээгүй г.м) байхыг ойлгоно.

⁴⁴ Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. Газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах, 4.1.4. Газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу үндсэн зориулалтаар нь үр ашигтай, зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

⁴⁵ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн ж.

⁴⁶ Газрын тухай хуулийн 6 дугаар зүйл. Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана: 6.2.1. бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газар;

52.1, 52.2 дахь заалттай нийцэж байна.

- 9) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны 2015.03.25-ны өдрийн 145 дугаар шийдвэр “Захиргааны хэргийн анхан шатны 2015.01.27-ны өдрийн 5 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж”
- *Үүний дараа К компаний гуравдахь шатны шүүхэд хандав.*
- 10) Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015.05.25-ны өдрийн 129 дугаар шийдвэр “Захиргааны хэргийн анхан шатны 2015.01.27-ны өдрийн 5 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны 2015.03.25-ны өдрийн 145 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж” тогтоол гаргажээ.

Хэлэлцүүлэг:

- 1) Энэ хэрэг яагаад 2 жил, 3 шатны шүүхээр дамжих болов?
- 2) Багийн иргэд, ИНХ-ийн алдаа, амжилт юу вэ?
- 3) Сумын ИТХ, Засаг даргын алдаа, амжилт юу вэ?
- 4) Аймгийн Засаг даргын алдаа, амжилт юу вэ?
- 5) К компанид ямар буруу байсан бэ? К компани хохирсон уу?
- 6) Атар газар, бэлчээр, тариалангийн газрын зориулалтын өөрчлөлтийг ямар төвшинд хэзээ шийддэг вэ? Хаана шийдэх хэрэгтэй вэ?
- 7) Танай суманд ийм үйл явдал тохиолдсон уу? Тухайлбал, газар эзэмшүүлэхдээ Багийн ИНХ-ын санал авдаг уу?
- 8) Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан боловч яагаад хүчингүй болов?
- 9) Дуудлага худалдаагаар 969 га газрыг эзэмшихэд ямар хэмжээний төлбөр, хураамжийг ямар хугацаанд, хаана төлөх вэ? Түүнийг ямар зориулалтаар хэн ашиглах вэ?
- 10) Дуудлага худалдаагаар газар эзэмших эрх цуцлагдсан үед төлсөн төлбөр, хураамжийн ямар төрлийг буцаан олгох, ямар төрлийг буцааж олгохгүй вэ?
- 11) Оролцогч талуудын хариуцлага хаана суларсан байна вэ?

Эх сурвалж: (www.shuukh.mn сайт 2016)

Жишээ 2. Багийн ИНХ-ын нэхэмжлэл хүчингүй болсон нь

А аймгийн Б сумын Засаг даргын шийдвэрээр Т байгууллагад эзэмшүүлсэн 1 га газрыг I багийн ИНХ-аар хэлэлцээгүй, иргэдийн саналыг аваагүй гэж үзэж Захиргааны хэргийн шүүхэд ханджээ. Энэ асуудал 2 шатны шүүхээр 2 жил дамжин хэлэлцээд, Багийн ИНХ-ын нэхэмжлэл хэрэгсэхгүй болсон байна.



Үйл явдлын хураангуй

- 1) Т байгууллага нь Б сумын Засаг даргад 2013.01.10-ны өдөр Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлд дагуу хүсэлтээ албан бичгээр өгсөн.
- 2) А аймгийн Б сумын Засаг даргын 2013.01.28-ны өдрийн А/07 дугаар захирамжаар 1 га газрыг Т байгууллагад 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх шийдвэр гаргасан:

- Захирамжийн дагуу Газрын даамал газар дээр солбицлыг 2013.03.01-нд хэмжиж, 2013.11.14-ны өдөр “Газар эзэмх гэрээ, гэрчилгээ” олгосон,
 - Тус газар нь сумын төвийн суурьшлийн бүсэд хамаарах бөгөөд Т байгууллага хашаа барьсан.
- 3) Б сумын А багийн ИНХ 2013.10.05-ны өдөр хуралдаж, Т байгууллагын хашааны газар нь:
- Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй,
 - ИТХ-ын шийдвэр байхгүй,
 - Улсын баяр наадмын хурдан морины уралдаан олон жил уламжлал болдог, мөн машин зам, онгоц бууж байсан зэрэг зарим хэсгийг хаасан,
 - Сумын төвийн өнгө үзэмж, эмх цэгцэд сөргөөр нөлөөлөх, нийтийн эрх ашгийг ноцтойгоор зөрчсөн шийдвэр,
 - Энэ хашаатай зэрэгцүүлж, барьцаж иргэд хашаа барихаар зэхэж байна гэсэн шүүмжийн дагуу, газрын хэмжээг багасгах, эсвэл хашааг өөр газар барих хэрэгтэй,
 - “Сумын наадам үздэг талбайг улам багасгаж, нийтийн эрх ашиг зөрчсөн хуулийг илтэд хүндэтгэж үзээгүй тул шийдвэрийг хүчингүй болгох шаардлагатай” гэж санал, тогтоол гаргаж, Сумын ИТХ, Засаг даргад хандсан.
- 4) Б сумын ИТХ 2013.12.16-ны өдөр хуралдаж, 42 дугаар тогтоол гаргаж, “хашааны хэмжээг анх олгосон хэмжээнээс хэтрүүлсэн тул багасгах” шаардлагыг Т байгууллагад хүргүүлсэн.
- 5) ИТХ-ын тогтоолын дагуу арга хэмжээ аваагүй буюу Т байгууллага тайлбарлахдаа:
- Т байгууллага 2012 онд байгуулагдаж, захиргааны байрыг улсын төсвөөр 2013 онд баригдах болсон, үүнийг сумын Засаг дарга мэдэж байх учиртай,
 - Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулах (Сумын ИТХ 2013.01.13-нд хуралдаж, уг төлөвлөгөөг баталсан) нь Засаг дарга, Газрын даамлын ажил үүрэг, тусгагдсан эсэхийг манай байгууллага мэдэх үүрэггүй,
 - Газрын даамлын хэмжиж, бичиж өгсөн 1 га газрыг л бид хашаалсан,
 - Онгоц буудаг талбайг нэгэнт ашиглахаа больсон, морин уралдаанд саад болох зүйлгүй,
 - Хашаа өнгө үзэмж сайн бөгөөд хашаандаа 108 мод, бут сөөгийг тарьж ургуулж, ногоон байгууламж хийсэн,
 - I багийн ИНХ 2013.10.05-ны өдөр хуралдаагүйг нотолно, түүний тогтоол гэдэг хуурамч буюу 2016.02.18-ны өдөр (2 жил, 4 сарын дараа) гэнэт гарч ирсэн баримт,
 - Эдгээр нь Т байгууллагын үйл ажиллагааг эсэргүүцсэн хэсэг хүмүүсийн ажил.
- 6) Б сумын Засаг даргын 2015.05.29-ны өдрийн А/60 дугаар захирамжаар “газар эзэмших эрхийг цуцалж”, А/07 захирамжийг хүчингүй болгосон.
- Засаг даргын шийдвэрээр хашааны хэсгийг албадан буулгасан.
- 7) Б сумын ИТХ 2015.07.04-ны өдөр хуралдаж, 42 дугаар тогтоолыг хэвээр баталсан.
- 8) А аймгийн Засаг даргын 2015.07.02-ны өдрийн А/251 дүгээр захирамжаар Сумын Засаг даргын А/60 дугаар захирамжийг хүчингүй болгосон:
- Сумын Засаг дарга “Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дахь заалтыг зөрчсөн гэж захирамж гаргасан” боловч “57.3.4” гэж бичилтийн алдаа гаргасан тул захирамжийг хүчингүй болгосон,
 - Сумын Засаг даргад арга хэмжээ авсан.
- 9) Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заалтыг зөрчсөн тул “А аймгийн Б сумын Засаг даргын 2013.01.28-ны өдрийн А/07 дугаар захирамжийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүхэд өгсөн.
- 10) А аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.05.11-ны өдрийн

.. дугаар шийдвэрээр “Газрын тухай хуулийн 4 дүгээр⁴⁷ зүйлийн 4.1.3, 21 дүгээр зүйлийн 21.4.3, 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.2, 22.1.3, 27 дугаар⁴⁸ зүйлийн 27.1, 33 дугаар зүйлийн 33.1.1, ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9-д заасныг баримтлан А аймгийн Б сумын I багийн ИНХ-ын “А аймгийн Б сумын Засаг даргын 2013.01.28-ны өдрийн А/07 дугаар захирамжийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ”.

11) А аймгийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.06.22-ны өдрийн .. дугаар шийдвэрээр “А аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016.05.11-ны өдрийн .. дугаар шийдвэр”-ийг хэвээр үзэж:

- Маргаан бүхий газар нь бусдын эзэмшил газартай давхцаагүй, орц, гарцыг хаагаагүй бөгөөд нэхэмжлэлд дурдсан “авто зам, улсын баяр наадмын хурдан морины уралдааны замын зарим хэсэгт саад болсон, сумын төвийн өнгө үзэмж, эмц цэгцэд сөргөөр нөлөөлж, нийтийн эрх ашиг зөрчсөн” гэдэг нь шүүхийн үзлэгийн тэмдэглэл, гэрэл зургаар үгүйсгэгдэж (нотлогдохгүй) байна.
- Т байгууллагад 1 га газар эзэмшүүлсэн нь “I багийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчсөн” болох нь тогтоогдоогүй болно.

Хэлэлцүүлэг:

1. Энэ асуудал үүсэх болсон шалтгаан нь юу вэ?
2. Сумын ИТХ-ын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
3. Багийн ИНХ-ын үүргийг тодруулна уу?
4. Багийн ИНХ-аар тухайн асуудлыг нөхөн хэлэлцэж болох уу? Хэрэв болох бол хуралдсан хугацааг ямар он сараар бичих хэрэгтэй вэ?
5. Сумын Засаг даргын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
6. Газрын даамлын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
7. Аймгийн Засаг даргын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
8. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ач холбогдол юу вэ? Түүнд оролцогчдийн үүрэг, хариуцлага ямар байдаг вэ?
9. Т байгууллага ямар буруутай вэ?
10. Сумын ИТХ-ын шийдвэрийг Т байгууллага яагаад хэрэгжүүлээгүй вэ?
11. Танай суманд үүнтэй төсөөтэй асуудал үүсдэг үү?
12. Энэ асуудлыг оролцогч талуудын сонирхол эрх ашигт нийцүүлэн шийдэх боломж байсан уу? Байнга гомдол, санал тасрахгүй байхаар шийдэх ямар арга байна вэ?

Эх сурвалж: (www.shuukh.mn сайт 2016)

Жишээ 3. Дүүргийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж юуны учир буруудав?

Дүүргийн ИТХ-ын тогтоол, Засаг Даргын захирамжаар аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаагаар газар эзэмшүүлээд, түүнийгээ хүчингүй болгосон тохиолдол олон гарч байна. Энэ нь зөв шийдвэр үү?

Үйл явдлын хураангуй:

1. Дүүргийн Засаг даргын 2008.07.28-ны өдрийн “Хур хог цэвэрлүүлж, газрын зөвшөөрөл олгох тухай” 303 дугаар захирамжаар К-д аж ахуйн зориулалтаар 0.3 га газрыг эзэмшүүлсэн;

⁴⁷ Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 4.1.3. газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;

⁴⁸ Газрын тухай хуулийн 27 дугаар 27.1. Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.

2. Дүүргийн Засаг даргын 2012.10.25-ны өдрийн “Газар ашиглах эрхийг нэр шийлжүүлэх, гэрээ сунгах, баталгаажуулах, зориулалт, талбай, байршил өөрчилөх тухай” А/437 дугаар захирамжаар тус газрын хэмжээг 0.28 га болгож, байршил өөрчилж, 5 жилийн хугацаатайгаар аж ахуйн зориулалтаар эзэмшүүлсэн;
3. Газрын албатай К нь 2013 онд гэрээ байгуулж, гэрчилгээ авч, кадастрын мэдээллийн санд бүртгүүлж, газрын төлбөрийг төлж, уг газарт хашаа барьж, аж ахуйн зориулалтаар ашигласан;
4. Дүүргийн ИТХ-ын 2013.04.24-ний “Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай” 8/02 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2013.05.23-ны өдрийн А/287 дугаартай захирамжаар “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.3-т заасны дагуу, инженерийн шугам сүлжээ давхацсан” гэсэн үндэслэлээр К-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгосон;
5. К нь газар эзэмших эрхээ сэргээлгэхээр Захиргааны хэргийн шүүхэд 2015 оны 5 сард хандаж, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015.05.29-ний өдрийн 01 дугаар шийдвэрээр “К-ийн нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг сэргээсэн”;
6. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.05-ны өдрийн 02 дугаар хурлаар: Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 40 дүгээр зүйлийн 40.1, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч К-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Дүүргийн ИТХ-ын 2013.01.24-ний өдрийн 8/02 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2013.05.13-ны өдрийн А/287 дугаар захирамжийн К-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгож шийдвэрлэжээ (ө.х эрхийг сэргээсэн).
7. Анхан шатны шүүхийн шийдвэрийг Дүүргийн Засаг дарга эс зөвшөөрч, завж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан байна.
 - 2013 оны А/437 тоот захирамж нь Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг зөрчин тухайн оны дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, газар эзэмшүүлэх шийдвэр гаргах журам, хуулиар тогтоосон хязгаарлалт, зохицуулалтыг зөрчиж, хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэн, захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэлгүй газар эзэмших эрх олгосон;
 - Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг зөрчин газрыг хуульд заасан хугацаанд К нь 2008 оноос хойш зориулалтын дагуу ашиглаагүй тул Дүүргийн Засаг даргын шийдвэр хүчинтэй тул нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож өгнө үү.
8. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.01.13-ны өдрийн 03 дугаар магадлалаар: Анхан шатны шүүхийн 2015.11.05-ны өдрийн 02 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, Дүүргийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.
9. Дүүргийн ИТХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч: Засаг даргын 2008 оны 303 тоот захирамж, 2013 оны А/437 тоот захирамжаар К-д газар эзэмшүүлэхдээ
 - Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.2 “Хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заагдсан байна”, 33 дугаар зүйлийн 33.1.2, дугаар зүйлд “газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” гэж заасан байхад тухайн заалтыг ноцтойгоор зөрчин газар эзэмшүүлсэн байна.
 - Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор зааснаас бусад газар эзэмшүүлэхийг хориглоно” гэж заажээ.
 - Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг зөрчиж газрыг хуульд

заасан хугацаанд, гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, газар эзэмшүүлэх шийдвэр гаргах журам, хуулиар тогтоосон хязгаарлалт, зохицуулалтыг зөрчиж, захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэлгүй газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна.

- Иймд Дүүргийн ИТХ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн ИТХ-ын ээлжит ...-р хуралдаанаас Дүүргийн Засаг даргын 2008 оны 303, 2012 оны А/437 дугаар захирамжийн К-д холбогдох хэсгийг хүчингүй болгохыг дүүргийн Засаг даргад даалган шийдвэрлэсэн. Иймд Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж өгнө үү.

10. Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч:

- а. Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхэд “Газрын тухай болон бусад хууль тогтоомжийг зөрчин газар эзэмшиж байсан К-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгож, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн дагуу гаргасан Дүүргийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгон шийдвэрлэж, дээрх хуулиудын хэрэгжилтийг хязгаарласан, газар эзэмшигчийн хууль бус ажиллагааг дэмжин гарсан Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.05-ны өдрийн 02 дугаар шийдвэр, түүнд давж заалдан гаргасан Дүүргийн Засаг даргын гомдлыг хянан хэлэлцэж гаргасан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.01.13-ны өдрийн 03 дугаартай магадлалыг хууль зөрчсөн болохыг тогтоон хүчингүй болгож шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

11. Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2016.03.14-ны 04 дугаар шийдвэр:

- Дүүргийн ИТХ-ын хуралдааны 2013.04.24-ний өдрийн “Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай” 8/02 дугаар тогтоолоор нэхэмжлэгч К-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгохыг Дүүргийн Засаг даргад даалгаж шийдвэрлэсэн нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 20.1.1-д “газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаархи Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх”, 20.1.2-т “тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах” гэж Дүүргийн ИТХ-ын газрын харилцааны талаарх бүрэн эрхийг тодорхойлсон хуулийн заалтад нийцээгүй, нэхэмжлэгчийн газар эзэмших, ашиглах эрхийг зөрчсөн болох нь тогтоогджээ.
- Дүүргийн ИТХ нь хуулиар өөрт олгогдоогүй чиг үүргийг хэрэгжүүлж, хууль бус тогтоол гаргасныг үндэслэн тус дүүргийн Засаг дарга 2013.05.23-ны өдрийн А/287 дугаар захирамж гаргаж нэхэмжлэгчид газар эзэмших эрхийг олгосон тус дүүргийн Засаг даргын 2008 оны 303, 2012 оны А/437 дугаар захирамжийн нэхэмжлэгчид холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосон нь дараах байдлаар хуульд нийцээгүй байна.
- Тодруулбал хариуцагч Дүүргийн Засаг дарга нь газар эзэмшигчийн хүсэлтийг хүлээн авч 2012.10.25-ны өдөр А/437 дугаар захирамжаар эзэмшүүлсэн газрын хэмжээ, байршлыг өөрчлөн эзэмших хугацааг сунгасан, үүнд тулгуурлан гэрээг шинээр байгуулж, гэрчилгээ шинээр олгосон атлаа 2013.05.23-ны өдөр маргаан бүхий А/287 дугаар захирамжийг гаргаж нэхэмжлэгч нь газрыг зориулалтын дагуу ашиглаагүй,

Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасныг зөрчсөн хэмээн хуулийн тооллоор 2 жил болоогүй байхад дээрх үндэслэл зааж хүчингүй болгосон нь буруу болжээ.

- Түүнчлэн нэхэмжлэгчид газар эзэмшүүлсэн захирамж нь Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг зөрчин тухайн оны дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, газар эзэмшүүлэх шийдвэр гаргах журам, хуулиар тогтоосон хязгаарлалт, зохицуулалтыг зөрчиж хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэн, захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байхгүй байхад газар эзэмшүүлэх эрх олгосон, инженерийн шугам сүлжээ давхацсан үндэслэлээр Компанид эзэмшүүлсэн захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгосон гэж тайлбарлаж байгаа нь үндэслэлгүй юм.

2016-09-18 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав.

Хэлэлцүүлэг:

1. Энэ асуудал үүсэх болсон шалтгаан нь юу вэ?
2. Дүүргийн ИТХ-ын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
3. Дүүргийн Засаг даргын үүрэг, хариуцлагатай холбож тайлбарлана уу?
4. Дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ач холбогдол юу вэ? Түүнд оролцогчдийн үүрэг, хариуцлага ямар байдаг вэ?
5. К байгууллага ямар буруутай вэ?
6. Танай дүүрэгт үүнтэй төсөөтэй асуудал үүсдэг үү?
7. Энэ асуудлыг оролцогч талуудын сонирхол эрх ашигт нийцүүлэн шийдэх боломж байсан уу?

3.2.3. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗРЫН АСУУДЛЫГ НУТГИЙН ТӨВШИНД ШИЙДЭХ АРГА ЗАМ, БОЛОМЖ

Орон нутгийн байгаль хамгаалал, газрын харилцааны асуудал нь а) мал аж ахуй, б) газар тариалан, в) хот байгуулалт, г) тусгай хамгаалалт, д) уул уурхай, е) салбар хоорондын зохицуулалтыг хамарсан өргөн ойлголт төдийгүй эдгээр салбарын эдийн засгийн өгөөжтэй шууд холбоотой байна. Салбар тус бүрийн газар ашиглалтын үнэлгээ, үнэ тариф, төлбөр, хураамж, татвар бүрэн тогтоогүй байгаа нь аль нэг салбараа хүчтэй түрэх, үүний улмаас үүсэх зөрчил, маргааны үндэс болж байна. Салбар тус бүрийн хувьд газар ашиглалтын үнэлгээ, татвар тодорхой байх нь эдийн засгийн арга зохицуулалтыг хэрэглэх боломжийг бүрдүүлэх юм.

Сумын төвшинд жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэл сайтай, бодитой боловсруулж, хэрэгжилтийг зохион байгжуулах нь байгаль орчин, газрын асуудлыг орон нутагт зөв шийдвэрлэх гол арга зам мөн.



Зураг 3.1. Сумын зохион байгуулалтын төлөвлөгөө (жишээ)

Газар ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлөх, хамгаалах ажлыг зохион байгуулах үндсэн хэрэгсэл нь газар зохион байгуулалтын төлөвлөгөө мөн.

Орон нутагт байгаль хамгаалал, газрын харилцаанд үүсдэг зарим асуудал

- 1) Малын хөлийн татвар, мал бүхий иргэдээс авах албан татварыг (улс төржүүлэхгүйгээр) тогтмол авч, буцаагаад мал аж ахуйн салбарын нийтлэг хөгжлийн асуудалд (худаг гаргах, бэлчээр сайжруулах гэх мэт) зориулж зарцуулах.
- 2) Газрын үнэлгээний аргачлал, жишиг үнэлгээ: газрын төлөв байдал, зориулалтаас хамаарсан жишиг үнэлгээний аргачлал байхгүй тул бодит бус үнэлгээ

хэрэглэдгийг цэгцлэх.


- 3) Орон нутгаас ашиглаж буй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын үнэлгээ, төлбөр тогтоох асуудал.
- 4) Гүний ус ашиглаж буй аж ахуйн нэгжийн үнэлгээ, төлбөр тогтоох асуудал.
- 5) Лиценцээр ашиглаж буй газрын төлбөр хураалт, төсөвт бүрэн төвлөрүүлэх.
- 6) Аялал жуулчлалын компаниудын байгаль орчинд, ялангуяа бохирын цэвэрлэх системгүйгээс бохир усаа гол эрэгийн хөрсөнд шууд хийдэг.
- 7) Улаанбаатар хот, Эрдэнэт хот болон аймгийн төвд толгой компанитай аж ахуйн нэгжийн газрын төлбөр, байгаль орчны сөрөг нөлөөллийн төлбөр.

Эдгээр асуудлыг УИХ болон Засгийн газар, тус тусын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага анхаарч шийдэх, эсвэл аймаг, нийслэлийн хувьд шийдэх зохицуулалт үгүйлэгдэж байна. Өргөн уудам нутагтай, байгалийн 6 бүс, эдийн засгийн 5 бүстэй тул бүс нутгийн буюу аймгийн хэмжээнд шийдэх боломжийг олгож болох юм. Газар ашиглалтын татвар, байгалийн нөөц ашигласны хураамжаар эдийн засгийг дэмжих нь зах зээлийн түгээмэл арга билээ. Бид үүнийг хэрэглэх цаг үе болжээ.

Байгаль орчин, газрын харилцаатай холбогдон үүсэх зөрчил, маргаан нь 21 аймаг, 330 сум, Нийслэл, 9 дүүрэг, нарийвчилбал хөдөө, суурингийн сум, багт өөр өөр байх боловч хуулийн хүрээнд авч үзэх, хэрэгжүүлэх нь нутгийн удирдлагын чадвар юм.

Байгалийн нөөцийн хамтын менежментэд харилцан суралцах төслийн хүрээнд явуудсан судалгаанд хамрагдсан “Малчдын 32.8%, нутгийн удирдлагын 70% нь бэлчээрийн харилцааг зохицуулж буй хууль, тогтоомж хангалтгүй” гэж үзсэн нь бэлчээрийн эрх зүйн орчинд шинэчлэл хийх хэрэгтэйг харуулж байна (Ыханбай.Х 2010, 187).

Жишээ 4. Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицуулалт



“Сэлэнгэ аймгийн ИТХ-ын малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам” (2013), (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхтгэл 2016, 55-56)-ыг хэлэлцэж, аймаг, сумынхаа онцлогтой уялдуулж журам боловсруулна уу. Журмыг энэхүү гарын авлагын төгсгөлд хавсаргав

Иргэний яриа 1: Багийн ИНХ гэдэг нь иргэдийн саналыг дээд шатны байгууллагад уламжилдаг, эрх хэмжээнийхээ дагуу тогтоол гаргадаг байгууллага, Нутгийн өөрөө удирдах ёсонд хамгийн анхны нэгжийн шийдвэрийг тулгуурлаж шийдвэр гарах хуультай байдаг.

Иргэний яриа 2: Манай сумын хувьд ИТХ-ын шийдвэр хэрэгждэггүй. Сумын Засаг дарга, газрын алба мөн хариуцлагагүй ажиллаж байна. Газар авах асуудлыг сумын Засаг дарга шийдвэрлэдэг юм бол сумын ИТХ-ын тогтоол гэж байх хэрэгтэй юм уу.

3.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭЛЭГДЭЛ, ЭВДРЭЛ, БОХИРДОЛД ХҮНИЙ ОРОЛЦОО, НӨЛӨӨ


Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд нийцүүлэн байгаль орчноо хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах, бэлчээрийн мал аж ахуй, газар тариаланг бусад салбартай зэрэгцүүлэн хөгжүүлэх нь манай төр болон орон нутгийн удирдлагын өмнө тулгамдаж буй нийтлэг хэрэгцээ шаардлага юм.

Өсөн нэмэгдэж буй нийгэм-эдийн засгийн эрэлтийг хангахдаа байгалийн нөөцийг шавхагдашгүй мэт төсөөлөхөөс илүүтэй түүний элэгдэл, эвдрэл, бохирдолд хүний хүчин зүйл, бидний оролцоо их байгааг анхаарах хэрэгтэй цаг үед амьдарч байна.

Байгаль орчны элэгдэл, эвдрэл, бохирдолд нөлөөлж буй хүчин зүйлийг 3 ангилж, түүнээс сэргийлэх арга, нөхөн сэргээх боломжит аргуудыг танилцуулж байна. Үүнд:

- 1) Байгалийн зүй тогтолын дагуух өөрчлөлт, түүнээс учрах хохирол: ган, зуд, уруйн үеэр, элсний нүүдэл, цөлжилт;
- 2) Хүний үйл ажиллагаанаас үүссэн эвдрэл, бохирдол: хөрсний бохирдол, голын болон хөрсний ус, бэлчээрийн ус, хот суурины агаар;
- 3) Орон нутгийн хэмжээнд шийдвэрлэж болох асуудал, түүний шийдэл.

3.3.1. БАЙГАЛИЙН ЗҮЙ ТОГТОЛЫН ДАГУУХ ӨӨРЧЛӨЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ДАВАН ТУУЛАХ АРГА



Дэлхийн цаг агаарын өөрчлөлт, дулааралтай холбоотойгоор тухайн бүс нутгийн экосистемийн хүрээнд ган, зуд, газар хөдлөл, элсний нүүдэл, уруйн үеэр зэрэг нь тодорхой он жилийн хэмнэл давтамжтай өөр өөр нутагт ээлжлэн тохиолддог байгалийн үзэгдэл юм.

Байгалийн өөрийнх нь зүй тогтолын дагуух өөрчлөлт, түүний илрэх үзэгдлийг аль болох орон нутаг, цаг хугацааны хувьд нарийвчлал сайн урьдчилан мэдэх нь эдүгээ хүн төрөлхтөний чадах зүйл юм. Энэхүү давтамж, хэмнэлийг мэргэжлийн байгууллагууд судалж, цаг агаарын болон онцгой байдлын урьдчилсан мэдээгээр мэдээлж байдаг.



Цөлжилт, гол усны ширгэлт



Зуд, өвс тэжээл дууссан



Газар хөдлөлөөс үүссэн ангал, судаг



Баян өлгий аймаг, 2016 оны үер

Урьдчилсан мэдээнд ач холбогдол өгч сэрэмжилсэн бэлтгэл ажлыг хийх нь учирч болзошгүй эрсдэлээс хохирол багатай гарах гол арга юм. Өвөл хүйтэн хийгээд урт, хавар хавсарга ихтэй байхыг намар урьдчилан мэдээлсээр байхад хадлан бэлтгэхгүй “манай энд гайгүй байхаа” гэж найдах нь түгээмэл байдаг. Цасан шуурга болж, зам харгуй хаагдахыг мэдээлсээр байхад замд гараад осолдох гэх мэт эрсдэлд ордог.



Нэгдсэн хүчээр хадлан бэлтгэх



Айл өрхийн хэмжээнд хадлах авах

Байгалийн зүй тогтлын дагуух өөрчлөлтөөс үүдсэн ган, зуд, уруйн үеэр, элсний нүүдэл, цөлжилтийг багасгах хамгийн түгээмэл хийгээд боломжит арга нь бэлчээр, хадлангийн талбайгаа сайжруулах, цас, борооны илүүдэл усыг хуримтлуулж усан сан байгуулах, усжуулах, өвс тэжээлээ сайн базаах, ойжуулах, зүлэгжүүлэх ажил юм. Үүнийг орон нутагтаа хэрэгжүүлэхийг өрх, баг, сум, аймаг гээд төвшин бүрд хэрэгжүүлэхийг санаачлах, дэмжих нь өөрийн төдийгүй нийтийн төлөөх томоохон үйлс юм.



Зураг 3.2. Дорноговь аймгийн Сайншанд сумын өрхийн цэцэрлэг

Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгийн сумынхан ногоон зурвас байгуулах, хашаандаа цэцэрлэгт хүрээлэн байгуулах санаачилга өрнүүлж байна. Иргэн Ганбаатарын хашааны хийсэн ойжуулалт, загастай цөөрөм, хүрхрээ, чулуужсан үлэг гүрвэл болон чулуужсан модны цуглуулга 2014 оны 5 дугаар сар.

Ийнхүү иргэдийн өөрсдийн санал, санаачлагад тулгуурласан бүтээлч ажил үйлсийг орон нутгийн төвшинд төрийн багууллагуудын зүгээс сайн дэмжвэл хөгжлийн ямар ч тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой.

3.3.2. ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮССЭН ЭВДРЭЛ, БОХИРДОЛ БА ШИЙДЭЛ

Нийтээр эзэмшиж буй байгалийн баялгийн (бэлчээр, гол ус, ой мод, ан амьтан,...) хомсдол доройтолд малчин өрхийн мал сүргээ өсгөх эрмэлзэл, тариаланч ногоочдын химийн бодисын хэрэглээ, аялал жуулчлалын компани зам харгуй, хог хаягдал, уул уурхайн хяналтгүй үйл ажиллагаа зэрэг нөлөөлж байна. Иймд байгалийн баялгийг нийтээр эзэмшихийн зэрэгцээ түүнийг тодорхой хугацаа, хэмжээгээр хариуцуулан эзэнжүүлэх, татвараар зохицуулах хэрэгцээ үүсэж байна.



Ил хаясан хог хаягдал, жорлон



Хот, суурины агаарын бохирдол



Уул уурхай олборлолт



Рапс тариалалт



Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Ганга нуур ширгэжээ. Жил бүрийн намар дулаан орон руу нисэх олон мянган хун шувуу чуулдаг энэ цэнгэг устай нуурын ойр орчимд ураны хайгуул хийж, технологийн бус өрөмдлөгийн явуулснаар нуурын экосистем эвдэрч байна.



Уул уурхайн салбарт Лиценцтэй компани, гараар олборлогч хоёрын хооронд зөрчил хурцадсаар байна.

Жишээлбэл, Тариа, ногооны талбайгаа хашаалаагүй⁴⁹ байдлаас мал сүрэг орж тариаланчдад хохирол учруулна, үүнээс сэргийлж байна гээд хашааны оронд гүнзгий суваг нүх ухсанаар хонь, ямаа, тугал, бяруу, унага ороод гарч чадахгүй үхэж байна. Эхний тохиолдолд тариаланч хохирох, 2 дахь тохиолдолд мал, малчин болон байгалийн баялаг газар, хөрс эвдэрч байна.



Ойн түймэр



Газраа хамгаалсан судаг, шуудуй

Тариан талбайд малаа оруулсан малчныг торгодог аргыг хэрэглэх аймаг, сум байгаа нь нэг талаар дэвшилттэй боловч малчны эрх зөрчигдөж байгааг анхаарах хэрэгтэй юм. Энэ нь малчин, тариаланч хоёуланд тэгш (ойролцоо) боломж олгосон эрх үүргийг тодорхой болгож, хариуцлагын үнэлгээтэй, мөн нийтийн эзэмшлийн баялгийг ашигласан татварын зохицуулалт үгүйлэгдэж буйг харуулна. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журмыг Хавсралтаас үзнэ үү.

Хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч буй иймэрхүү гарз, хохирлыг таслан зогсоохын тулд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохын зэрэгцээ орон нутаг дахь төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хариуцлагыг дээшлүүлэх нь ач холбогдолтой байна.

3.3.3. НУТГИЙН ХЭМЖЭЭНД ШИЙДВЭРЛЭЖ БОЛОХ АСУУДАЛ

“Сумын удирдлагууд мал өсөж, үр тариа хурааснаа дээш нь тайлагнаж, газраа бусдад найр тавин өгч, цаг агаар хүндэрсэн үед тусламж гуйхаас хэтрэхгүй байна. Үүний цаана байгалийн доройтол, газрын эвдрэл, бэлчээрийн маргаан үүсэж байгааг үл анхаарч, хурлаар хэлэлцэхгүй, иргэдийн үгийг сонсохгүй байна” хэмээн ахмад малчид өгүүлэн суугаа нь зарим талаар үнэний хувьтай юм.

Ер нь ямар ч тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотойгоор олон талаас нь хэлэлцэж шийдвэл алдах биш онох нь илүү байдаг билээ. Нутгийнхаа асуудлыг иргэдтэйгээ хэлэлцэж, тэдний санал бодлыг сонсдог ИТХ үгүйлэгдэж байгааг орон нутагт судалгаагаар явахад иргэд олонтоо өгүүлдэг.

Багийн ИНХ-аар дараах асуудлыг шийдэх боломжтой бөгөөд шийдсэн туршлагууд байна. Тухайлбал:

- Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны бэлчээр, хадлангийн талбайн хуваарийг хэлэлцэх⁵⁰, бэлчээрийг сэлгэх, өнжөөх үед бусад нь ашиглахгүй байх,

⁴⁹ Олон мянган га талбайг хашаалах нь эдийн засгийн хувьд боломжгүй байдаг байна.

⁵⁰ Өвсний сөл, гарц сайн хадлангийн талбайг “өмч” мэтээр үе дамжин хэрэглэдэг, түүнийгээ бусдад түрээслэдэг үзэгдэл бий болсонд иргэд бухимдаж байна.

- Өвөлжөө, хаваржааг эзэнжүүлэх, ашиглалтгүй 3-5 жил болсон үед шинэ малчинд хариуцуулах⁵¹ дүрэм, дэг, журам гаргах,
- Багийн нутаг дэвсгэрт буй шатсан ойг цэвэрлэх, түлээний мод бэлтгэх, ойжуулах⁵²,
- Багийн нутаг дэвсгэрт буй зам засах, голын гарам хийх, булаг шандыг хашаалах,
- Багийн нутаг дэвсгэрт буй түүх дурсгалын зүйлийг сум, аймаг, улсын хамгаалалтад авах, явуулын хүмүүс ухах, зөөхөөс сэргийлэн хамгаалах⁵³,
- Отрын болон нөөц бэлчээр нутгийг ашиглах журам, зохицуулалт⁵⁴,
- Оторт явах малчин өрхийг дэмжих, оторт малаа явуулахад туслах,
- Жимс болон эмийн ургамлыг түүх, хураан авах нутаг, хугацааг тогтоох,
- Бэлчээрийг усжуулах, гүний худаг гаргах, малчид хөрсний ил ус уудаг асуудлыг шийдэх,
- Тариа, ногооны газрыг тариаланчдад эзэмшүүлж⁵⁵, хариуцуулах,
- Үлийн цагаан оготно ихэссэн нутагт хор цацах бус харин шон босгож түүгээр хооллогч шувуудыг нутагшуулах⁵⁶,
- Чоно болон зэрлэг ан амьтад мал сүрэгт орох болсон хийгээд ан үргээлэг хийх,
- Багийн нутаг дэвсгэр, ялангуяа бэлчээр нутагт ИНХ, ИТХ-ын санал, шийдвэргүйгээр хууль бус аргаар их хэмжээний газар олгосон зэрэг амьдрал ахуйдаа тулгарсан, байгаль орчинд сөрөг нөлөөтэй, газрын маргаан зөрчил үүсгэсэн асуудлыг хэлэлцэж, саналаа ИТХ-д уламжлах хууль эрх зүй зохицуулалт нээлттэй байна.

Гавьяат хуульч Б.Чимид багш “Багийн хурлаараа малаа ган, зудны үед яаж оторлох, онд мэнд оруулах вэ, өрх айлуудаа нутаг хэрхэн сэлгэх, ядарсан зүдэрсэндээ юугаар яаж туслах вэ, түлшээ хэзээ бэлтгэх, хүүхдүүдээ ямар унаагаар хэзээ сургуульд аваачих болон авчрах вэ, ноос, ноолуур, мах, сүүгээ зах зээлд хамтран борлуулах гээд арав, хорин өрхөөрөө хүч хамтрах, хөрөнгө хэмнэх тухай ярилцаж болно шүү дээ” гэж Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй номондоо сургасан билээ (Чимид.Б 2002, 149).

Сумын ИТХ-аар:

- Багийн ИНХ-аар хэлэлцсэн асуудлыг дэмжсэн тогтоол, захирамж гаргах, хөрөнгийг төсөвт тусгах,
- Ой, тал хээрийн түүмрээс сэргийлэх урьдчилсан арга, хяналт, зохион байгуулалтыг бэлтгэх,
- Багийн ИНХ-аар хэлэлцээд шийдэл хүрээгүй асуудлыг хэлэлцэх, энэ төвшиндээ шийдэх эрх зүйн зохицуулалт үгүй бол түүнийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллагад уламжлуулан шийдвэрлүүлэх⁵⁷,

⁵¹ Ашиглахгүй, эзэнгүй болсон өвөлжөөг сэргээж ашиглах тухай журам, зохицуулалт үгүйлэгдэж байна.

⁵² Төслийн хүрээнд ойжуулж байна гээд өндөр уулын царманд тал, хээрийн ургамал тариалж хөрөнгө үрж байгааг нутгийнхан “шоолж” байна. Тухайн нутагт ургах чадвартай ургамлыг нутгийн иргэдтэй зөвлөлдөж, хамтарч хийхийг санал болгох.

⁵³ Металл хайгчтай хэрмэл хүмүүс ирж, том майхан барьж ухаад явсныг сумын удирдлагад хэлэхэд арга хэмжээ аваагүй тохиолдол гарчээ.

⁵⁴ Отрын нутгийн “эзэн” бусад малчдаас малын тооноос хамаарч бод авч байгаа албан бус тохироо үүсчээ.

⁵⁵ Хөрс сайн, ургац арвинтай талбайг их хэмжээгээр аваад тариаланч, ногоочдод түрээслэдэг, өөрсдөө хот болон гадаадад суудаг давхраа бий болжээ.

⁵⁶ Завхан аймгийн Их-уул сумын Хужиртын хөндийд хэрэглэсэн нь үр дүнтэй болжээ.

⁵⁷ Багийн ИНХ-аар ганга ихтэй замыг засах тухай хэлэлцээд ИТХ-д асуудлыг дэвшүүлснээр УИХ-ын гишүүний дэмжлэгтэйгээр сайжруулсан шороон зам, гүүр хийжээ.

- Улс, аймаг, сумын “сайн малчин”, “аварга малчин” шалгаруулахдаа малын тоог баримталж, тооны хойноос хөөцөлдөж буйг өөрчилж, мал сүргээ тарга тэвээрэгтэй онд оруулсан, үүлдэр угсаа, малын чанарыг дээшлүүлсэн, ган, зуд зэрэг байгалийн эрсдэлийн үед өөрөө болоод хот айлаараа даван туулсан, шинэ залуу малчдад нөмөр нөөлөгтэй, туршлагаа эзэмшүүлсэн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ боловсруулсан зэрэг ажлын чанар, малч ухааны үзүүлэлтээр дүгнэх санаачилга өрнүүлэх,
- Орон нутгийн тусгай хэрэгцээ болон хамгаалалтад авах асуудлыг хуулийн дагуу хэлэлцэж, шийдвэрлэх зэрэг бодит ажлуудыг хийж болно. Хийж, хэрэгжүүлж байгаа сум, баг олон байна.

3.4. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ: ТӨР, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Газар нутгийг тусгай хамгаалалтад авах, хамгаалах нь төр, нутгийн удирдлага, иргэний хамтын ажиллагааны чухал талбар юм. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх бодлого боловсруулах үйл ажиллагаанд анхлан санаачлагч нь иргэн, тухайн нутгийн биологийн төрөл зүйл, түүх ёс зан заншилыг судалсан эрдэмтэд байх нь элбэг байна. Харин тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого хэрэгжүүлэгч нь төрийн төв байгууллага, нутгийн удирдлага болон иргэн байна.

3.4.1. ГАЗАР НУТГИЙГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТАНД АВАХ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын нэгэн чухал хэрэгсэл нь хойч үедээ байгалийн нөөцийг үлдээх зорилгоор төрийн хамгаалалтанд авч нөөцийн хэрэглээг бүрмөсөн эсвэл хэсэгчлэн хязгаарлах бодлого юм. Улс орон бүр өөрийн орны байгаль цаг уурын онцлог байдлаас хамааран тодорхой бүс нутгийг хамгаалалтанд авч хүний нөлөөллийн үйл ажиллагааг хязгаарлах бодлого хэрэгжүүлж байдаг.

Байгалийн нөөцийг тусгай хамгаалалтанд авах эдийн засгийн үндэслэл нь:

- тухайн нөөц дахин давтагдашгүй нөхөн сэргээх боломжгүй тул хойч үедээ үлдээх шаардлагатай;
- тухайн нөөцийг ашиглах нь эдийн засгийн хувьд одоо ач холбогдолтой ч нийтэд учрах хор хохирол үлэмж их байх;
- тухайн нөөцийг хор хохирол багатай ашиглах техник технологийн боломж нээгдээгүй;
- тухайн нөөц өмнө ашиглагдаж байсан ч хэт ачаалал үүссэний улмаас өгөөж нь буурсан байх зэрэг байна.

Байгалийн нөөцийг тусгай хамгаалалтанд нийгмийн үндэслэл нь:

- тухайн нөөцийг иргэдийн олонхи нь одоо ашиглахыг зөвшөөрөхгүй,
- тухайн нөөц даян дэлхийн эко системд давтагдашгүй хэв шинжийг агуулсан,
- тухайн нөөц улс орны түүхийн чухал олдвор, иргэдийн дурсамжийг агуулдаг.

Манай улс тусгай хамгаалалттай газар нутгийн дархан цаазат газар, байгалийн цогцолбор газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газар гэсэн ангиллаар тусгай хамгаалалтанд авч байна (Мягмарсүрэн Д., Намхай А., 2012).

3.4.2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Газар нутгийг тусгай хамгаалалтад авах нь байгаль орчны доройтлыг зогсоож, байгалийн жам ёсны шүтэлцээг хадгалах боломж нөхцөлийг хангах гол арга зам юм. Энэ нь байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй их өвийг хойч үедээ үлдээх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангаж, улмаар улс орны тогтвортой хөгжлийг баталгаажуулах үндсэн аргын нэг билээ.

Манай улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, БНМАУ-ын СнЗ-ын 146 тоот тогтоолоор батлагдсан “БНМАУ-ын дархан газрын дүрэм”⁵⁸-ийг өөрчлөн, зохицуулалтыг шинэчлэн 1994 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль батлагдаж, түүнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын төр тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 1997 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль батлан тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн гадуур болон давхацсан байдлаар орчны бүсийг тогтоож болохоор зааж өгсөн.

2012 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай 99 газар нутаг байгаа бөгөөд тэдгээрийн хэмжээ 27.2 сая га талбайд хүрч, нийт нутаг дэвсгэрийн 17.4 хувийг эзэлж байна. Мөн орон нутгийн тусгай хамгаалалтанд 1200 гаруй газар буюу 52.7 сая га газрыг эзэлж энэ нь нийт нутаг дэвсгэрийн 33.7 хувьд хүрчээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах бодлогын хэрэгжилтэнд нутгийн удирдлагын оролцоог хангах боломж эрх олгосон байгалийн нөөц болон дурсгалт газрын эргэн тойронд шаардлагатай газарт орчны бүсийг байгуулах заалтыг хуульчилсан.

Орчны бүсийг “Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутаг⁵⁹” гэж тодорхойлсон байна. Мөн хуулинд орчны бүсийн хилийн цэсийг дархан цаазат газрын хилийн заагийн гадна байхаар байгалийн цогцолбор газрын хувьд түүний хилийн заагийн гадна буюу хязгаарлалтын бүстэй нь давхцсан байхаар тодорхойлж өгсөн. Энэ нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын бүсийг өргөтгөх, хүний сөрөг нөлөөллийг багасгах ач холбогдолтой юм. Түүнчлэн энэ хуулиар сум, дүүргийн ИТХ шаардлагатай гэж үзвэл байгалийн нөөц газар, дурсгалт газарт орчны бүс, түүний заагийг тогтоох эрх олгосон нь тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах бодлого боловсруулалтанд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага оролцох өргөн боломж нээж өгсөн.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль эрх зүйн хүрээг системчлэн үзвэл:

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
4. Байгалийн ургамлын тухай хууль;
5. Орчны бүсийн тухай хууль;
6. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр;
7. Газрын тухай хууль;

⁵⁸ Д.Мягмарсүрэн, А.Намхай, 2012, Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, Мөнхийн үсэг-ХХК, х-5

⁵⁹ УИХ, 1997, Тусгай хамгаалалттай газар нутаг орчны бүсийн тухай хууль, 3-р зүйлийн 1

8. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
9. Ойн тухай хууль;
10. Газрын төлбөрийн тухай хууль;
11. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль;
12. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
13. Соёлын өвийг хамгаалах тухай хууль. Эдгээр хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмаас бүрдэнэ.

Үүнээс гадна Засгийн газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоол, тушаал шийдвэрүүдтэй сайн танилцаж хэрэгжилтийг зохион байгуулах нь чухал.

Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-ийн 6 дугаар зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан бөгөөд хуулийг дээдлэн ёсчлон биелүүлэхийг **үндсэн үүрэг** болгон зааж өгсөн. Түүнчлэн байгаль орчноо хамгаалах ажлыг **журамт үүрэг** болгон зааж өгсөн нь тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах үйл ажиллагаанд иргэн бүр оролцохыг иргэний үүрэг болгон зарлан тунхагласан байна. Харин төрд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, нөхөн сэргээлтийн холбогдогч талаар хийлгүүлэх бүрэн эрхийг олгосон байна. Хэрэв иргэний газрын тусгай хамгаалалтанд авахаар болвол улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авч болохоор зохицуулалт хийгдсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) нь тусгай хамгаалалттай газар нутгийн системийг үндэсний болон орон нутгийн төвшинд байгуулах, үндэсний тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, зохион шийдвэрлэж өгсөн. Хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг тус хуулиар зааж өгсөн байна. Үүнд: (1) улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө; (2) аялал жуулчлал болон бусад ажил үйлчилгээний орлого; (3) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив тусламж; (4) тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухайн хууль 1994 батлагдсанаас хойш 9 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд тусгай хамгаалалтанд авах байгалийн дурсгалт газрын хүрээг “ ..., эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор, ...” (2014 оны 07 сард) гэж нэмэгдүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зорилгыг хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүй үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулна гэж тодорхойлсон. Уг хуулийн байгаль орчны хамгаалах төр, иргэний үүрэг, эрхийг тодорхой зааж өгсөн. Үүнд:

Иргэний эрх⁶⁰

1. Гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
3. Байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;
4. Холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;
5. Байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах;
6. Сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших.

Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;
2. Байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;
3. Байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх.
4. Байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх.

Төрийн үүргийг дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
2. Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь зарчим баримтална:
 - хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцөл бүрдүүлэх;
 - экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж байгаль орчны тэнцлийг хангах.
3. Байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохистой ашиглах нөхцөлийг хангах;
4. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх.
5. Байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуультай нэгдэж иж бүрдэл болно. Байгаль орчны хамгаалах тухай хуульд

⁶⁰ УИХ, 1995, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, <http://www.legalinfo.mn/law/details/8935?lawid=8935> 2014 оны 9 сар

нийт 14 удаагийн өөрчлөлт оруулаад байгаа бөгөөд 2012 оны өөрчлөлтөөр байгалийн аудитын талаар талаар харилцааг зохицуулсан шинэчлэл хийсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)

ийн зорилго нь тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хуулийн 3-р зүйлд заасны дагуу тусгай хамгаалалттай газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор орчны бүсийг байгуулна. Дархан цаазат газар болон Байгалийн цогцолбор газарт орчны бүс нь тусгай хамгаалалттай газрын гадна байх ба байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүстэй давхцаж болно.

Орчны бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлд орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийг оролцоог өргөжүүлэх зорилго бүхий сайн дурын орчны бүсийн зөвлөл ажиллана (6.1). Орчны бүсийн зөвлөл нь орчны бүсэд газар, байгалийн бусад баялгийг ашиглахтай холбогдсон асуудлаар санал, зөвлөмж, төсөл, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах эрхтэй байна.

7 дугаар зүйлд заасны дагуу орчны бүсийн зөвлөл нь байгаль орчны доройтсон газар нөхөн сэргээлт хийх, доройтлыг багасгах, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих, байгаль хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгааны ажлыг нутгийн иргэдийн дунд зохион байгуулах зэрэг зорилгоор орчны бүсийн санг байгуулж болно. Энэ сан нь хэд хэдэн орлогын эх үүсвэрээс бүрдэнэ. Энд: гадаадын болон дотоодын иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн хандив, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоож өгсөн орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл, ажил, үйлчилгээний орлогын тодорхой хэсэг, байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогын тодорхой хэсэг болно. Энэхүү хуулийн заалтын хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн дотор байгаа уул уурхайн олборлолт болон аялал жуулчлалаас олох орлого нь тус сангийн орлогын эх үүсвэр байж болох юм.

Тус хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу орчны бүсэд явуулж байгаа үйл ажиллагаа, орчны бүсийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд орон нутгийн өөрөө удирдах болон төрийн холбогдох байгууллага хяналт тавьж зөвлөл хяналт хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагад туслалцаа үзүүлэхээр зохицуулсан байна.

Байгаль орчны яамаас баримталж байгаа бодлогын хандлага тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон орчны бүсийн тухай хуулийг нэгтгэн тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулж байна.

Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийг нийт нутаг дэвсгэрийн 30% хүртэл нэмэгдүүлэх амлалтаа биелүүлэх зорилгоор 1998 онд Монгол улсын их хурал **“Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”**-ийг батлан гаргасан байна. Үндэсний хөтөлбөрийг гурван үе шаттай 20 жилийн хугацаанд хэрэгжихээр төлөвлөсөн. Үүнд: нэг дэх үе шат :1998- 2005 он хүртэл; хоёр дахь үе шат: 2005 - 2015 он; гурав дахь үе шат: 2015 оноос хойш буюу 2018 хүртэл байхаар байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрт “Монгол Улсын нийт газар нутгийн 30%-ийг эзэлсэн, цогц, үр ашигтай менежмент бүхий экологийн хувьд бүх бүс бүсчлэлийг төлөөлсөн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бий болгох, сайжруулна” гэж үндсэн зорилгыг тодорхойлсон болно. Хөтөлбөрийг

хэрэгжүүлэх 10 үндсэн ажил байна. Үүнд: үндэсний хөтөлбөрийн өий болгох, шаардлагатай хууль эрх зүйн хүрээг бий болгох, засаглал, хүний нөөц, менежмент, судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, боловсрол, олон нийтийн оролцоо, санхүүжилт, дэд бүтэц, олон улсын хамтын ажиллагааг сайжруулахтай холбоотой хэрэгцээ шаардлагууд тусгагдсан байна. Түүнчлэн 1999 онд Монгол улсын Засгийн газар Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гаргасан байна.

Газрын тухай хуулийг өөрчилж 2002 онд шинэчлэн баталсан. Энэ хуулийн зорилт нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах, түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулах бөгөөд тус хуулийн 3-р зүйлд тодорхойлсноор газар гэдэг нь газрын гадаргуу, түүний хөрс, ой ус, ургамал бүхий орон зайн давхаргыг хэлнэ. Энэ хуулинд “Тусгай хэрэгцээний газар” хэмээн ангилал оруулж ирж, энэ нь төрийн өмч байна” гэж заасан. Тусгай хэрэгцээний газарт улсын болон орон нутгийн хамгаалалттай тусгай хамгаалалттай газар нутгууд багтана. Энэхүү хуулиар хувийн хэвшилд тусгай хэрэгцээний газрыг өмчлөхийг хориглосноор тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан тусгай хамгаалалттай газар нутаг дотор уул уурхайн олборлолт хийхийг хориглосон заалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж өгчээ. Түүнчлэн тус хуулийн 17.1.3 зүйлээр улсын тусгай хамгаалалтанд авах, хамгаалалтаас гаргах, хэмжээг тогтоох болон түүний газрын хилийн заагийг УИХ тогтоохоор зааж өгсөн. Мөн хуулийн 16.2 болон 20.1.3 аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, гаргах, түүний хэмжээ, хилийн заагийг тогтоох эрх олгосон.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2006)-ийн 5.4.2 зүйлд байгаль хамгаалах санг оруулсан бөгөөд сангийн хөрөнгийн эх үүсвэрийн зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлнэ гэж тодорхойлсон. Тус эх үүсвэрийг тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж; байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.2 (буюу Гамшгийн хор уршгийг арилгах тодорхой арга хэмжээнд зориулан гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс монгол улсад өгсөн буцалтгүй тусламж, хандив) дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө, ус бохирдуулсны төлбөрийн орлого зэргээс бүрдүүлэхээр заасан. Сангийн хөрөнгийг байгаль хамгаалах болон судалгаа шинжилгээний нэр бүхий 8 ажилд зарцуулахаар хязгаарлаж өгсөн нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтанд зарцуулагдах нэг эх үүсвэрийг баталгаажуулсан байна.

Ойн тухай хууль (2007) шинэчлэн баталсан. Тус хуулийн зорилго нь монгол улсын ойг хамгаалах, эзэмших, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тусгай хамгаалалттай газар нутгийн дотор байгаа ойн менежементийн асуудлыг тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна. Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвлийн өсөлт, нөхөн сэргээлийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Газрын төлбөрийн тухай хууль (1997)-ийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө төлбөр ноогдуулах, уг төлбөрийг улсын төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тус хуулийн 7.6-д “тусгай хамгаалалттай газар нутагт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг уг газар нь хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, хот тосгон, бусад суурины газрын үнэлгээний зэрэглэлийн алинд хамаарч байгааг харгалзан гурав дахин өсгөж тооцно” гэж заасан тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулахыг хориглохын зэрэгцээ орлого бүрдүүлэх ач холбогдолтой заалт болсон байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг 2012 онд шинэчлэн найруулж баталсан. Тус хуулийн зорилтыг “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах” хэмээн тодорхойлсон. Төлбөрийг тогтоохдоо:

- ургамлын төлбөрийг нэн ховор ургамал, ховор ургамал, элбэг ургамал гэсэн ангиллаар;
- ус, рашаан тэдгээрийн орчны төлбөрийг хүний унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус; уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус; эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан; эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин ангиллаар;
- ойгоос бэлтгэж ашигласан бүх төрлийн хэрэглээний мод, түлээ болон ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсний төлбөр гэсэн ангиллаар;
- ан амьтан ашигласны төлбөрийг ахуйн зориулалтаар агнасан, барьсан; үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан, барьсан; тусгай зориулалтаар агнасан, барьсан /соёл, шинжлэх ухаан, тусгай төлбөртэй/ гэж тус тус ангиллаар ногдуулахаар тусгасан байна.

Нөөц ашигласны төлбөрийг тооцох нэгжийг борлуулалтын орлого, нягт болон сийрэг шоо метр, шоо метр, экологи-эдийн засгийн үнэлгээ, тоо ширхэг болон килограмм зэрэг байхаар тодорхойлсон. Экологи-эдийн засгийн үнэлгээг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлан гаргаж байна.

Соёлын өвийг хамгаалах тухай 2014 онд батлагдсан хуулинд тусгай хамгаалалтын хуулийн хүрээнд зохицуулагдах дэлхий болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар гэсэн шинэ категорийг оруулж ирсэн. Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулах гэж тодорхойлжээ. Түүнчлэн соёлын өвийг хамгаалах нэг чухал зохицуулалтыг тусгай хамгаалалттай газар нутгийн зохицуулалт гэж үзсэн байна. Энэ хуулийн 42-45 зүйл нь тусгай хамгаалалттай дурсгалт газар нутгийн хамгаалалтын зохицуулалтыг нарийвчлан авч үзсэн байна.

3.4.3. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн зорилтыг байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах хэмээн тодорхойлсон. Хуулиар тусгай хамгаалалттай газар нутгийг 4 төрөлд ангилан тодорхойлдог.

1. Дархан цаазат газар 12 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 48.21%,
2. Байгалийн цогцолбор газар 22 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 42.16%,
3. Байгалийн нөөц газар 19 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 9.16%,
4. Дурсгалт газар 8 буюу нийт хамгаалалттай газар нутгийн 0.47%-г эзэлдэг.




Зураг 3.3. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний бүрэлдэхүүн

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг 24 хамгаалалтын захиргаа, зарим байгалийн дурсгалт болон нөөц газруудыг харьяа аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар хариуцаж үйл ажиллагаа явуулж байна.

Дархан цаазат газар

Дархан цаазат газар нь хамгаалалтын дэглэм хамгийн өндөртэй газар бөгөөд түүнийг байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг юм.

Дархан цаазат газрыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүсэд хуваана.



Зураг 3.4. Дархан цаазат газар нутаг

Онгон бүс нь хамгаалалтын хамгийн хатуу дэглэмтэй бүс бөгөөд энд зөвхөн байгалийн төлөв байдлыг өөрчлөхгүйгээр ажиглалт судалгааг хийж болох ба бусад үйл ажиллагааг бүрэн хориглоно.

Хамгаалалтын бүсэд ажиглалт судалгаа хийхээс гадна ургамал, амьтны аймгийн өсч үржих нөхцөлийг хангах, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хийхийг зөвшөөрдөг.

Хязгаарлалтын бүсэд судалгаа шинжилгээний ажил хийхийн зэрэгцээ байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараах үйл ажиллагаа явуулах боломж олгосон:

- 1) Ongon болон хамгаалалтын бүсэд зөвшөөрөгдсөн судалгаа, шинжилгээг хийх,
- 2) Хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх,
- 3) Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх,
- 4) Ан амьтны тооллого (тоо, нас, хүйс), сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах,
- 5) Рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах,
- 6) Байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах,
- 7) Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах,
- 8) Зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах,
- 9) Уул, овоо тахиx, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх,
- 10) Нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах.

Дархан цаазат газар нутагт тодорхой үйл ажиллагааг хуулийн хүрээнд хориглох нь хуулийн хийдлийг ашиглан байгаль орчинд хор хохиролтой үйлдэл хийхийг хязгаарладаг. Үүнд:


- 1) Газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;
- 2) Байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;
- 3) Ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулахаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх;

- 4) Хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх;
- 5) Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байранаас өөр барилга байгууламж барих;
- 6) Хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;
- 7) Тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах;
- 8) Аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;
- 9) Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;
- 10) Нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;
- 11) Хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах зэргийг шууд хориглосон.

Байгалийн цогцолборт газар

Байгалийн цогцолборт газар нь хамгаалалтын дэглэм дархан цаазат газраас харьцангуй хөнгөн боловч хүний үйл ажиллагааг нилээд хэмжээгээр хязгаарласан газар нутаг болно. Хуулинд байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газрыг байгалийн цогцолбор газар хэмээн тодорхойлжээ.

Байгалийн цогцолбор газрын хамгаалалтын дэглэмээр мөн онцгой, аялал жуулчлалын, хязгаарлалтын гэсэн гурван бүсэд хувааж байна.



Зураг 3.5. Байгалийн цогцолбор газар

Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авна.

Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно. Үүнд: Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс болон онцгой бүсэд хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа, явуулах түүнчлэн зөвшөөрөгдсөн газар загас барих зөвшөөрнө.

Хязгаарлалтын бүсэд аялал жуулчлалын бүсэд зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулж болох бөгөөд түүн дээр нэмж дараахь ажил үйл ажиллагааг энэ бүсэд эрхлэх боломжтой. Үүнд:

- Уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;
- Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг

батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих;

- Батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах;
- Биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засч тохижуулах;
- Тухайн нутаг дэвсгэр дэх сууринг экологийн магадлан шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх.

Түүнчлэн дархан цаазат газар нутагт хориглож байсан дараахь үйл ажиллагааг хязгаарлалтын бүсэд хийж болно. Харин онцгой бүсэд энэ хоёр үйл ажиллагааг явуулж болохгүй. Үүнд:

- 1) Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;
- 2) Нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах.

Байгалийн цогцолбор газар нутагт хориглох үйл ажиллагаа. Дээр дурьдсан хоёр үйл ажиллагаанаас бусад дархан цаазат газар нутаг хориглох бүх үйл ажиллагааг болон батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барихыг хориглоно.

Байгалийн нөөц газар

Улсын тусгай хамгаалалтад байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ. Түүнийг дараахь дөрвөн төрөлд хуваана. Үүнд:

- 1) Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий **байгалийн иж бүрдлийн нөөц газар**;
- 2) Ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий **биологийн нөөц газар**;
- 3) Эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий **байгалийн түүхэн олдворын нөөц газар**;
- 4) Газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий **геологийн нөөц газар**;
- 5) Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий **усны нөөц газар** юм.

Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэж болно.

Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Дурсгалт газар

Улсын тусгай хамгаалалтад байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ. Дурсгалт газрыг дараахь төрөлд хуваана:

- 1) Байгалийн дурсгалт газар;
- 2) Түүх, соёлын дурсгалт газар;

3) Дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар.

Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхарга зүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулдаг.

Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.

Дурсгал газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна.

Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0.1-3.0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Соёлын өвийн дурсгалт газар гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутаг гэж соёлын өвийн тухай хуулинд тодорхойлсон. Дэлхийн болон Үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын дэглэмийг хуулиар тогтооно.

1991 онд Засгийн газраас “Тусгай хамгаалалттай газрын дүрэм” батлан, тусгай хамгаалалттай горим, дэглэмийг тодорхойлж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 4 ангилалд оруулсан нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх эхлэл болсон юм. 1997 онд “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай” Монгол улсын хуулиуд шинээр гарч улмаар 1995 онд дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын нийтлэг болон тусгай горимыг Засгийн газар, 1998 онд “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийг УИХ батлан гаргаж мөрдүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи эрх зүйн үндэс үндсэндээ бүрдээд байна гэж үзэж болно. Өнөөдөр Төрийн бодлого, хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх хүрээнд 30 орчим дүрэм, журам, заавар эрх бүхий байгууллагуудаар батлагдан хэрэгжиж байна.

3.4.4. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ДАХЬ ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн хүрээг боловсонгүй болгох хэрэгцээ шаардлага хэд хэдэн үндэслэлтэй байна. Тусгай хамгаалалттай газар нутаг нь хүний үйлдлээс гадна байгалийн үйлчлэлээр өөрийн унаган төрхөө алдах байдал дэлхий дулаарал болон бусад хүчин зүйлээс хамааран эрчимтэй явагдаж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтанд иргэдийг оролцуулах зохицуулалт, арга ажиллагаа хэт ерөнхий, бүрхэг хэвээр байна. Иргэдийг оролцоог дэмжих зарчим, анхдагч шат нь мэдээлэл хүргэх чиглэл бөгөөд байгалийн нөөц газар болон дурсгалт газрын хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих, шийдвэр гаргалтанд оролцох эрх зүйн зохицуулалт үгүйлэгдсээр байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуйн нэгжийн оролцоог ч мөн адил нарийвчлан тодорхойлж өгөөгүй байгаа нь тэдэнд хамгаалалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг орхигдуулах боломж олгож байна.

Жишээ 5. Дархан цаазат Богдхан уулын тусгай хамгаалалттай газрын хил заагийн тухай

Богд хан уулаа бидний өвөг дээдэс эртнээс дархлан хамгаалж, XII-XIII үед Монголын Хэрэйд аймгийн Ван хаан тахиж Хан уул хэмээн нэрлэсэн бөгөөд 1778 онд дархалсан хэмээдэг. 1954 оны УИХ-ын Тэргүүлэгчдийн 31 дугаар тогтоолоор Чойбалсан уул нэрээр, 1974 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн 248 дугаар зарлигаар дархан цаазат газар болгожээ. УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулийн дагуу дархан цаазат газрын (ДЦГ) ангиллаар баталгаажуулсан байна.

Манай орны төдийгүй дэлхийн ууган дархан газар болохыг бататгаж, 1997 онд “Дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд хамрагдсан байна. Богд хан уул нь Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг.

Дархан цаазат уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс 2268.0 өндөрт өргөгдсөн Цэцээ гүн юм. Богдхан ууланд эмчилгээний ач холбогдолтой хэд хэдэн рашаан булгууд бий. Зарим газар хушин ой, хойд ба зүүн өмнөд хэсгээр нь шинэсэн ой зонхилон тархдаг нь тус уулын хэсэг бүрт экологийн нөхцөл өөр байдгийг гэрчилнэ. Богдхан уулан 70 овгийн 256 төрлийн 588 зүйл дээд ургамал ургадаг. Ургамлын аймаг нь экологийн 18 бүлэгт хамаарах бөгөөд эдгээрээс уулын тайгын экологийн бүлгүүд 80 хувийг, хээрийн ургамлууд 72 хувийг эзэлдэг. Хэнтийн тайгын голлох элемент болон олон зүйлийн хөхтөн амьтны тархалтын урд хил Богдхан уул болно. Богдхан ууланд монгол орны хөхтөн амьтны 35 хувь буюу 6 баг, 17 овог, 36 төрөл 54 зүйлд хамаарах хөхтөн амьтан нутагладаг. 174 овог, 270 гаруй төрөлд хамаарах 1660 зүйл шавж, 259 зүйлийн мезофаун, 93 микрофаун, 14 баг, 36 овогт багтах 194 зүйл шувуу бүртгэгдсэн.

Түүхийн сурвалжаас авч үзвэл 1809 онд Богдхан уулын 28 амыг цагдаатай болгож нутаг дэвсгэрт орох зөвшөөрлийг Богд хаан гардан олгодог журам тогтоож байсан байна.

Нэг. УИХ-ын гишүүн Ц.Оюунгэрэл, Л.Болд нарын санаачлан боловсруулсан “Зарим нутаг дэвсгэрийг тусгай хамгаалалттай газрын хилийн заагаас чөлөөлж, өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд заагдсан Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны Зайсан, Богины ам, мөн дүүргийн 4 дүгээр хорооны Арцат, Нүхтийн амны өгөгдсөн хэмжээсийг (координат) нарийвчлан зурагт буулгаж тулгахад дараах байдалтай байна. Үүнд:

- A. Дээрх нутаг дэвсгэрт баригдсан барилга байгууламжийг “цонх” үүсгэх байдлаар чөлөөлүүлэх;
- B. Дээрх нутаг дэвсгэрийг бүхэл “амаар” нь чөлөөлүүлэх 2 хувилбарыг ирүүлсэн байна.

Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх саналыг энэхүү аль ч хувилбараар шийдэхийн өмнө дараах асуудлуудыг цогцоор нь БХБЯ, БОНХЯ, ГХГЗЗГ, байгууллагууд хамтран шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ үүсч байна.

Хоёр. Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн ашиглалт, хилийн цэсийн асуудлын хүрээнд шийдвэрлэх тулгамдсан асуудлууд:

- 1. Хилийн цэсийг нэгдсэн аргачлалаар шинэчлэн тогтоох тухай.** УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан Богдхан уулын хилийн тэмдэглэгээг БОНХЯ, Нийслэлийн өмчийн харилцааны газар (НӨХГ) тус бүр зөрүүтэй хийсэн байна. Жишээлбэл:
 - a. Хан-Уул дүүрэг (ХУД)-ийн Шинэ яармаг хороолол, Буянт-Ухаа хорооллын төлөвлөлтийн бүсийг үзвэл БОНХЯ-ны тогтоосон хил заагт багтаж, харин НӨХГ-ын тогтоосон хилийн бүсэд ороогүй байна. Энэхүү зөрүүтэй байдлаас НБХБТГ-ын /хуучин нэрээр/ боловсруулсан төлөвлөгөөг Барилга хот байгуулалтын яам (БХБЯ)-ны батлах ажил хүлээгдэж байна. Гэтэл бодит байдалд тус бүсэд барилга байгууламж барьж эхэлсэн байна.
 - b. БОНХЯ-ны тогтоосон хилийн урт 88.2 км, талбай 42192.4 га, НӨХГ-аас тогтоосон хилийн урт 83.7 км, талбай 41122.3 га байгаа бөгөөд 4.2 км урт, 1070.1 га талбайгаар зөрүүтэй байна. Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны 41651 га талбайтай харьцуулбал БОНХЯ-наас 541.4 га-аар дутуу, НӨХГ-аас 528.7 га-аар илүү байна.
 - c. Сансрын зурагтай харьцуулахад ч хамгийн бага зөрүүтэй хэсэг буюу Яармагийн “Viva city” хорооллын урд талд 150 метр зурвас газарт туршилтын хэмжилт хийхэд 0.48 га (4866.464м²) талбайн зөрүүтэй байна.
- 2. Хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх тухай.** Тусгай хамгааллын нутаг дэвсгэрт хуулийн заалтын дагуу Зайсан, Богины ам, Арцат, Нүхт, Шинэ яармагийн хот төлөвлөлт БХБЯ, НӨХГ-ын аль ч төвшинд батлагдахгүй шийдэл хүлээгдэж байна. Гэтэл БОНХЯ-ны зөвшөөрлөөр эдгээр нутаг дэвсгэрт хэд хэдэн хороолол баригдсан нь “хуулийн гадуурхи хот” буюу “силос” үзэгдэл үүссэн байна. Эдгээр суурьшил, барилга байгууламжууд нь дархан цаазат газрын хязгаарлалтын бүсээс хэтэрч хамгаалалтын бүст зарим хэсэг газар нэвтэрсэн байна. Энэ нь Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 9.1, 9.2-ийг зөрчихөд хүрээд байна.
- 3. Газар ашиглалтыг хэрэгжүүлэх тухай.** Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу газар ашиглуулах зохицуулалттай бөгөөд дээрх нутаг дэвсгэрт дундажаар 50-75 жилийн насжилт бүхий барилга байгууламж бариулсан нь газар эзэмшлийн хэлбэр болж байна. Ийнхүү хууль зөрчсөн үйлдэлээс хариуцлага хэлэлцэх, эсвэл холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах асуудал хөндөгдөж байна.
- 4. Газрын ашиглалтын стандартыг хэрэгжүүлэх тухай.** Газрын ашиглалтын стандарт, нормитив, ялангуяа Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн ашиглалтын стандартыг нэн тэргүүн сайжруулан боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх шаардлага үүсч байна.
- 5. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг тодруулах тухай.** Богд хан уулын тусгай хамгаалалттай газрын хил дотор орших Манзушир хийд орчмын нутаг дэвсгэр Баянзүрх дүүрэг, Бөхөгийн ам, Ахмадын сувилалын орчмын нутаг дэвсгэр Хан уул дүүрэгт тус тус байгааг анхаарч Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт шилжүүлэх асуудал шийдэл хүлээж байна.
- 6. Байгаль орчны болон газрын суурь судалгаа мониторингийг хэрэгжүүлэх тухай.** Тус нутгийн “байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах”, хүний санаатай санамсаргүй үйлдэлээр эвдрэл өөрчлөлт орж, ан амьтан, хөрс, ургамлын тогтоц эрс өөрчлөгдсөнийг мэргэжлийн байгууллагууд 2005 он хүртэл судалсан дүнг сөрөг үзүүлэлт ихтэй байгааг дүгнэсэн байна. Иймд эдгээр судалгааны дүнг нэгтгэх, газрын мониторингийг ойрын жилд хийх хэрэгцээ үүсч байна.

7. Хил заагт өөрчлөх асуудлыг мэргэжлийн байгууллагын хамтран шийдвэрлэх тухай. УИХ-ын 2012 оны 38 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Туул зөрлөгт 33.5 га газрыг улсын тусгай хамгаалалтаас гаргасан байна. Энэ мэт хот төлөвлөлтөөр батлаагүй газар нутагт барилга байгууламж баригдсаны дараа нь хилийн цэсийг өөрчлөх аргыг хэрэгжүүлээд байх нь тусгай хамгаалалтанд авсан утга агуулга алдагдаж, хуулийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болно. Иймд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрийн хувилбар боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж байх саналыг дэвшүүлж байна.

Гурав. БХБЯ-ны сайдын өгөгдсөн үүргийн дагуу Баянзүрх дүүргийн гэр хороолол, V станц барихаар төлөвлөсөн газар, цанын бааз зэргийг судалж үзэхэд:

1. Тус дүүргийн 11 дүгээр хороо, Туул зөрлөгийн орчмын газрыг 2012 онд “улсын тусгай хамгаалалттай газраас чөлөөлж” суурин үүсгэжээ.
2. V станц барихаар төлөвлөсөн газар нь тусгай хамгаалалтын бүсэд хамрагдаагүй байна.
3. Цанын баазыг аялал жуулчлалын зориулалтаар олгосон байна.

Хэлэлцүүлэг (дүрд орж ажиллах)

1. Дүр буюу оролцогч талууд: Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яам, Тусгай хамгаалалтын газрын захиргаа, Нийслэлийн Газрын алба, Дүүргийн газрын алба, хувийн компани, иргэн, иргэдийн төлөөлөгч (УИХ-ийн гишүүн болон ИТХ-ын төлөөлөгч)
2. Оролцогч тус бүр өөр өөрсийн эрх ашигт нийцсэн хуулийг баримталж, хоорондоо мэтгэлцэнэ үү.
3. Манай улсын хуулиудыг хэрэглэх боломж юу байна вэ?
4. Энд хохирогч нь хэн бэ? Яагаад “хохирогч”-гүй байна вэ?
5. “Цонх” гаргах байдлаар шийдэх нь ямар үр дүн, үр дагавартай вэ?

3.4.5. НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТ

Нутгийн удирдлагын эрх хэмжээг ИТХ болон засаг даргын эрх хэмжээний хүрээнд авч үздэг. Учир нь байгаль орчны байцаагч болон тусгай хамгаалалттай газрын захиргаадын үйл ажиллагаа орон нутагт явагдаж байгаа боловч төвийн шууд удирдлагаар гол үйл ажиллагаа, эрх хэмжээ нь зохицуулагдаж байна.

1) Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын бүрэн эрх

Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалт хэрэгжүүлэлтэнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үүнд:

Өөрийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Засаг даргын илтгэлийг хэлэлцэж зохих шийдвэр гаргах, түүний биелэлтийг хангуулах; Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд ИТХ тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын бодлогын хэрхэн хэрэгжүүлсэн ямар хэмжээний төсөв зарцуулсан тухай тайланг жил бүр хэлэлцэж байх шаардлагатай болж байна. Мөн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах хэрэв тусгай хамгаалалттай газрын захиргаа байгаа бол түүнтэй хамтран ажиллах гэрээ байгуулах түүний хэрэгжилтийг дүгнэх зэрэг үйл ажиллагааг

хэрэгжүүлнэ.

Нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг дээд шатны ИТХ буюу Засгийн газарт уламжлах эрхийн хүрээнд иргэд, эрдэмтэн судлаачдын санал хүсэлтийг үндэслэн холбогдох баримт материалыг бүрдүүлэн уламжлах үйл ажиллагааг зохион байгуулна. Хэрэв улсын тусгай хамгаалалтанд авах үйл ажиллагааг удаашралтай байвал байгалийн зохистой байдлыг алдагдуулахгүйн тулд орон нутгийн тусгай хамгаалалтанд аваад дараа нь улсын тусгай хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулах боломжтой.

Нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоох. Энэ нь тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулиар олгогдсон байгаль орчноо хамгаалах бүрэн эрх нь бөгөөд үүнийг авч хэрэгжүүлснээр өнөөдөр 1200 гаруй газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд аваад байна. Түүнчлэн энэ нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бие даан шийдвэрлэж байгаа нэгэн чухал эрх болно.

2) Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; энэ эрхийн хүрээнд засаг даргын удирдлагад байгаа байгалт орчны байцаагчийг үл тооцвол маш бага нөөцтэйв Харин байгаль орчны хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах, хязгаарлалтын бүс болон ойр орчимд амьдарч байгаа иргэдийг оролцуулсан сүлжээ байгуулан ажиллуулах нь бодлого хэрэгжүүлэх нэг чухал гарц болно.

Өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтад авах талаар санал боловсруулж зохих байгууллагад уламжлах; засаг дарга иргэдтэй ойр байдгийн хувьд багийн засаг дарга болон бусад мэргэжилтэнүүдээрээ дамжуулан тусгай хамгаалалтанд оруулах талаар санал болосруулах өргөн боломж байна. Гэвч засаг дарга улсын тусгай хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулахын тулд судалгаа шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай байдаг. Тодорхой судалгаа нотолгоогүйгээр цөөн иргэдийн хүсэлтээр тусгай хамгаалалтанд авах гэсэн шийдвэр нь үр дүн бага бодлог.

3) Байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх

Энэ үүргийн биелүүлэх харилцаа хуулийн мэдлэг шаардсан чимхлүүр ажил бөгөөд үүнийг хэрэгжүүлэгч гол мэргэжилтэн нь байгаль орчны байцаагч болон сумын газрын даамал нар юм. Нөгөө талаас хамгаалалтыг хэрэгжүүлэх төсвийг сумын төсөвт зөв тооцоолон оруулах шаардлагатай. Нөгөө талаас байгалийн нөөц газраас түгээмэл тархац байгалийн баялаг ашиглуулан төлбөр авч сумын төсвийн тодорхой хувийг бүрдүүлэх нь элбэг байна. Гэвч энэ төлбөрийн тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах асуудал орхигдсон хэвээр байна.

4) Газар ашиглуулах тухай шийдвэр гаргах

Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг

хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана. Энэ нь Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах бодлого хэрэгжүүлэлтэнд оролцох боломжийг олгож байна. Гэвч энэ боломжоо ашиглах бодлого хэрэгжилтийг сайжруулах алхам хийхийн тулд байгалийн нөхцөл байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх зайлшгүй шаардлага үүсдэг.

Тухайн газрыг хоёр буюу түүнээс дээш этгээд ашиглах хүсэлт гаргавал газар ашиглалтын зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээний зардал зэргийг харгалзан сонголт хийнэ.

Аялал, жуулчлал эрхлэх зориулалтаар газар ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах материаллаг баазыг олон улсын стандарт, төвшинд хүргэсэн байдлыг нь харгалзан сонголт хийнэ.

Төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрт ашиглуулах газрын зориулалт, орших бүс, байршил, зааг, хэмжээ, дангаар буюу дундаа ашиглах талаар тодорхой заана. Газар ашиглуулахаас татгалзсан бол төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрт үүний шалтгаан, үндэслэлийг заана.

Сум, дүүргийн Засаг дарга Төрийн захиргааны төв байгууллага шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг өөрөө буюу хамгаалалтын захиргаатай хамтран байгуулна.

Газар ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

- тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө;
- газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;
- газрыг ашиглах, хамгаалах талаарх талуудын эрх, үүрэг, хариуцлага;
- гэрээ дуусгавар болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, уг газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх журам.
- тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналтын байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.
- байгаль орчны хяналтын улсын байцаагчид тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчигчдөд эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

Жишээ 6. Орон нутгийн тусгай хамгаалалтад авахад гарсан алдаа, сургамж

А аймгийн Б сумын I багийн иргэдийн саналыг тусгаж, сумын ИТХ, аймгийн ИТХ-аар 319158 га газрыг “Орон нутгийн тусгай хамгаалалтад авах” шийдвэр гаргасан нь 3 шатны шүүхэд хэлэлцээд хүчингүй болов.

Үйл явдлын дараалал, тодотгол

- 1) А аймгийн Б сумын I багийн иргэдийн саналыг тусгаж, сумын ИТХ-ын 2012 оны 25 тогтоолоор ... нутгийг “Орон нутгийн тусгай хамгаалалтад авах” тогтоол гаргаж, аймгийн ИТХ-д уламжлав.
- 2) А аймгийн ИТХ 2012.11.26-ны 1/5 дугаартай “Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах” тухай тогтоол гаргав.

- Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдэл нөөц газраар орон нутгийн тусгай хамгаалалтанд авахаар шийдвэрлэжээ.
 - Энэхүү нутгийн хил хязгаар дотор Х компанийн тогтоосон ашигт малтмалын талбай (Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг 2007 оноос эзэмшин, хайгуул хийж, 2011 онд тогтоосон нөөцийг бүртгүүлж, ашиглалтын өмнөх гэрээг 3 жилээр байгуулсан), Ү компанийн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн (тусгай зөвшөөрлийн хугацаа 2041 онд дуусах) зарим хэсэг орсон байна.
- 3) Захиргааны хэргийн шүүхэд Х компани “Аймгийн ИТХ-ын 2012.11.26-ны өдрийн А/5 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгож өгнө үү” гэсэн нэхэмжлэл гаргасан:
- А/5 дугаар тогтоолын үндэслэх хэсэгт Аймгийн ЗД-аас тогтоолд дурдагдсан 319158 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах санал гаргасан эсэхийг дурьдаагүй байгаа нь ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “к” заалтыг зөрчсөн байна.
 - Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг газар эзэмшигч болон тухайн шатны Засаг даргатай тохиролцсоны дагуу ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан байна. ИТХ тогтоол гаргахын өмнө тус компанитай уулзаж, тодорхой шийдэлд хүрсэн байх хуулийн заалтыг үл анхаарсан байна.
 - Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.23, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн гэж нэхэмжилжээ.
- 4) Захиргааны хэргийн шүүхэд Ү компани “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012.07.02-ны өдрийн хүчингүй болсон тогтоолыг 2012.11.26-ны тогтоол хуулбарлан давтсан” гэж нэхэмжлэл гаргасан:
- Байгалийн иж бүрдлийн нөөц газраар орон нутгийн тусгай хамгаалалтанд авах зайлшгүй шаардлагатай гэдгийг баталгаажуулсан судалгаа, шинжилгээ хийхгүйгээр зохих мэргэжлийн байгууллагын дүгнэлт байхгүйгээр шийдвэр гаргаж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хууль ёсны эрхийг хөндсөн.
 - Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-ийг тус тус зөрчсөн.
 - Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай саналыг тухайн шатны Засаг дарга боловсруулж, газар эзэмшигчтэй харилцан тохиролцоод саналаа ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, 20.2.5-г зөрчсөн гэж нэхэмжилжээ.
- 5) А аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2012.12.26-ны хуралдааны .. дугаар шийдвэрээр “Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.4, 20.2.5 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, А аймгийн ИТХ-ын 2012.11.26-ны өдрийн 1/5 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хууль бус” гэж тооцон хүчингүй болгожээ.
- 6) Хариуцагч буюу Аймгийн ИТХ-ын гомдол, тайлбартаа:
- Б сумын I багийн нутаг, Н сумын нутаг дэвсгэрийн 319158 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авахдаа ямар нэгэн хууль зөрчөөгүй бөгөөд Газрын тухай хуульд заасан үндэслэл журмыг баримталсан.
 - Тус газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсээс ИТХ-д 2012 онд хэлэлцүүлж, тогтоол гарсан. ЗЗНДНТУ-ын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Засаг даргын алба нь Тамгын газар байна... гэж заасан. Засаг даргын бодлого шийдвэрийг хэрэгжүүлдэг Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсээс уг асуудлыг хуралдаанд оруулж шийдвэрлүүлсэн нь Засаг дарга оруулаагүй гэх үндэслэл болохгүй”

- Энэхүү газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг 2013 оны Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан бөгөөд 4 дүгээр сарын 25-нд хуралдах аймгийн ИТХ-аар хэлэлцэнэ.
 - Орон нутгийн сонгууль оройтож болсонтой холбогдуулан аймгийн ИТХ-аар хэлэлцэн батлах асуудлууд тодорхой нөхцөл байдлын улмаас хойшлогдож, Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байгаа учраас хэрэгт нотлох баримтаар гаргаж өгөх боломжгүй байна.
- 7) Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн 2013.02.28-ны хуралдааны .. дугаар магадлалаар “ИТХ 2012.11.26-ны 1/5 дугаартай тогтоолын 1 дэх заалтын нэхэмжлэгч нарын эзэмшиж буй дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хамаарах хэсгийг хүчингүй болгон өөрчилж, шийдвэрийн тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээв.
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.“з”,
 - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2,
 - Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 25 дугаар зүйлийн 25.1.5,
 - Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 9, 11 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн
 - Нэр бүхий газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг тусгасан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь аймгийн ИТХ маргаан бүхий захиргааны актыг хэлэлцэж батлахаас өмнө батлагдаж хүчин төгөлдөр болоогүй байх тул уг актын хувьд эрх зүйн үндэслэл болж чадахгүй
 - Аймгийн Засаг дарга санал боловсруулж оруулаагүй, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс уг асуудлыг хуралдаанд оруулж шийдвэрлүүлсэн нь уг захиргааны актыг гаргах талаар тусгайлан заасан журам зөрчсөн байна гэдэг үндэслэлээр хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй байна гэж шийдвэрлэсэн байна.
 - Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах асуудал нь хуулиар хориглогдоогүй, цаашид энэ талаар шийдвэр гаргах А аймгийн ИТХ-ын эрх шүүхийн энэ шийдвэр болон бусад эрх зүйн актаар хязгаарлагдаагүй тул холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу асуудлаа шийдвэрлэх боломжтой болно.

Хэлэлцүүлэг:

- 1) Сумын ИТХ-ын шийдвэрийн ололт, алдаа юу байв?
- 2) Аймгийн ИТХ-ын шийдвэрийн ололт, алдаа юу байв?
- 3) Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын хэлтэст төлөөлүүлэн гүйцэтгүүлэх буюу эрх шилжүүлэх үү?
- 4) Х компани, Ү компанийн давуу тал юу байна вэ?
- 5) Танай суманд газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах асуудал үүсдэг үү? Хэрхэн шийдэж байна вэ?
- 6) Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахад үүсдэг бэрхшээлүүд юу байна вэ? Энэ талаархи хуулийн зохицуулалтыг тодорхой ярилцана уу?

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА ИРГЭДТЭЙ ХАРИЛЦАХ

4.1.ТӨЛӨӨЛЛИЙН БА ШУУД АРДЧИЛАЛ

Ардчилал нь хамтын шийдвэр гаргахад бүх нийтийн хяналтыг тогтоох, энэхүү хамтын хяналтад бүгд эрх тэгш байдалтай оролцох гэсэн хос хоёр зарчмыг агуулдаг. Ардчиллыг ийнхүү тодорхойлох нь хоёр зүйлийг анхнаас нь тодорхой болгож байна. Нэгдүгээрт, ардчилал бол бидний ихэвчлэн бодож төсөөлдөг шиг зөвхөн төр засгийн хүрээнд хамаатай зүйл биш. Ардчилсан зарчмууд бол хамтын шийдвэр гаргадаг бүх байгууллагад үйлчилдэг байх ёстой. Хоёрдугаарт, уламжлал ёсоор бол бид аливаа улс орныг төр засаг нь өрсөлдөөнт сонгуулиар дамжуулан ард түмнийхээ өмнө хариуцлага хүлээдэг, насанд хүрэгчид нь сонгох, сонгогдох тэгш эрх эдэлдэг иргэний ба улс төрийн эрхүүд нь хуулиар баталгаажсан бол “ардчилал” гэж нэрлэдэг. Гэхдээ амьдрал дээр бүх нийтийн хяналт улс төрийн эрх тэгш байдлын хоёр зарчмыг бүрэн төгс хэрэгжүүлсэн улс орон байдаггүй. Ийнхүү ардчилах үйл явц бол тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.⁶¹ Орчин үед ардчиллын хэлбэрийг төлөөллийн болон шууд, оролцоот ардчилал хэмээн ангилж байна.

Хүснэгт 4.1. Ардчиллын хэлбэрүүд, онцлог шинж

Ардчиллын хэлбэр	Онцлог шинж
Төлөөллийн ардчилал	<ul style="list-style-type: none"> Иргэдийн санаа бодол, ашиг сонирхлыг төлөөлөх цөөн тооны хүнийг Парламент, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагад төлөөлөгчөөр сонгодог. Төлөөлөгчдийг иргэдээс шууд сонгодог.
Шууд ардчилал	<ul style="list-style-type: none"> Бүх нийтийн санал асуулга (реферандум) явуулдаг. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх, батлахад иргэд өргөн оролцдог.
Оролцоот ардчилал	<ul style="list-style-type: none"> Иргэдэд ганцаарчилсан болон хамтдаа санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах ажиллагаанл оролцох боломж олгох (санал асуулга явуулах, нээлттэй хэлэлцүүлэг, телевизийн ярилцлага зохион байгуулах г.м)

Төлөөллийн ардчилал. Иргэд тодорхой төлөөллийн байгууллагаар дамжуулан төр засгийн болоод орон нутгийн засаглалын түвшинд бодлого тодорхойлж, шийдвэр гаргах үйл явцад оролцох хэлбэрийг шууд бус ардчилал буюу төлөөллийн ардчилал гэж тодорхойлдог. Төлөөллийн ардчиллын гол шинж нь төлөөллийн институци буюу нийт сонгуулиар сонгогдсон сонгуульт албан

⁶¹ Ардчиллыг танилцуулахуй:80 асуулт хариулт. Дэвид Бийтхам, Кевин Бойел ЮНЕСКО 1995

тушаалтан нар төр засгийн бүх шийдвэрийг гаргаж үйл ажиллагааныхаа төлөө сонгогчдын өмнө хариуцлага хүлээдэг.

Орчин үед үндэсний түвшинд улс төрийн үйл явцад иргэд оролцох зохион байгуулалт нь төлөөллийн ардчиллын хэлбэр болсон байна. Учир нь үндэсний түвшинд бодлого тодорхойлж шийдвэр гаргахад иргэд шууд оролцох цаг хугацаа, орон зай, зохион байгуулалтын боломж хязгаарлагдмал байдаг нь төлөөллийн ардчиллыг өргөжүүлсэн.

Нөгөө талаар улс төрийн бодлого, шийдвэрийг боловсруулж хэрэгжүүлэх мэргэшсэн улс төрийн институци бий болсон. Тухайлбал, Парламент, Засгийн газар, орон нутгийн захиргааны байгууллага нь бодлого тодорхойлж, шийдвэр гаргах улс төрийн мэргэшсэн тодорхой чиг үүрэг, эрх бүхий институци юм. Монгол Улсад үндэсний түвшинд төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий улс төрийн институт нь хууль тогтоох чиг үүрэг бүхий парламент (Улсын Их Хурал) юм. Улсын Их Хурал нь нийтийн чөлөөт ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагддаг төлөөллийн байгууллага болно. Орон нутагт иргэдийн төлөөллийн байгууллага (аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал) нь мөн адил төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэгч институци юм. Төлөөллийн ардчиллыг дэмжигчид иргэдийн хэрэгцээг мэддэг, нийгэм, улс төр, эдийн засгийн ээдрээтэй асуудлуудын шийдлийг олох чадвар бүхий өндөр боловсролтой сонгогдсон төлөөлөгчид нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн шийдвэр гаргана хэмээн үздэг. Гэтэл зарим нь үүнийг төлөөллийн ардчиллын сул тал гэж үздэг бөгөөд төлөөлөгчид нь нийтийн ашиг сонирхлоос илүү өөрсдийнхөө явцуу эрх ашигт үйлчилдэг гэж үздэг. Эрдэмтэн, улс төрийн онолч Ж.Ж.Руссо “Төлөөллийн тогтолцоонд сонгууль явагдах цөөн хэдэн жилийн дотор ард түмэн ганц л удаа чөлөөтэй байж, бусад үед эрх баригчдын гарт эргэн ордог нь боолчлолоос дээрдэх зүйлгүй” хэмээн маргаж байжээ.

Шууд ардчилал. Шууд ардчилал (оролцоот ардчилал)-ыг Афины ардчилал ч гэж нэрлэдэг. Афины иргэд улс төрийн шийдэл шаардлагатай тодорхой асуудлаар бүх нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал хураадаг байв. Афины ардчилал бол бидний өнөөгийн мэдэх ардчиллын хэлбэрүүдээс илүү их, бас арай бага ардчилсан байжээ гэж хэлж болно. Иргэд нийгмийнхээ гол гол шийдвэрт биечлэн оролцож шийдвэр гаргалтад оролцож, өөрсдийн хувь заяа, ашиг сонирхолд хамаарах тодорхой асуудалд шууд оролцож, санал өгөх боломжтой тул ардчиллын үнэт зүйл болох иргэний эрх, эрх чөлөөг бүхий л хүрээнд өргөжүүлдэг. Шууд ардчилалтай болохын тулд чуулган болох газар нэг дор байрлаж амьдрах бололцоотой харьцангуй цөөн тооны иргэдтэй байх шаардлагатай бөгөөд тэдгээр нь мэдлэг мэдээлэлтэйгээр улс төрийн шийдвэр гаргахад оролцохын тулд шаардагдах баримт нотолгоотой, бусад ажил үүргээс чөлөөлөгдсөн, харьцангуй зав чөлөөтэй хүмүүс байх хэрэгтэй.

Ийнхүү жинхэнэ шууд ардчиллын шаардлагыг өнөөгийн иргэд, төлөөлөгчид хангахгүй боловч үндэсний хэмжээний сонгууль, бүх нийтийн санал асуулга, зэрэг томоохон шийдвэр гаргахад шууд оролцох, түүнчлэн оршин суугаа газрынхаа орон нутгийн чанартай шийдвэр гаргахад байнга оролцох боломжтой юм.⁶² Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү

⁶² Ардчиллыг танилцуулахуй:80 асуулт хариулт. Дэвид Бийтхам, Кевин Бойел ЮНЕСКО 1995

эрхээ эдэлнэ” хэмээн шууд ардчиллын зарчмыг тунхагласан билээ.

Шууд ардчиллын давуу талууд:

1. Иргэдийн өөрсдийн хувь заяа, ашиг сонирхолд хамаарах тодорхой асуудалд шууд оролцож, санал өгөх боломжтой тул ардчиллын үнэт зүйл болох иргэний эрх, эрх чөлөөг бүхий л хүрээнд өргөжүүлдэг.
2. Улс төр, төр засгийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг дээшилнэ.
3. Хувийн ашиг сонирхлыг илүүд тавьсан улс төрчдийн оролцоог багасгаж, иргэд өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхлыг илэрхийлж хамгаалах боломжтой.
4. Төр засгийн шийдвэрийг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрөх байдал нэмэгдэнэ.

Шууд ардчиллын сөрөг тал:

1. Шийдвэр гаргах өртөг зардал нэмэгдэнэ.
2. Засгийн газар, хэвлэл мэдээлэл зэрэг сонирхлын бүлгүүд иргэдийн шийдвэрт нөлөөлөхийг оролдож болно.
3. Иргэдийн идэвх харилцан адилгүй байна.

Практикт “төлөөллийн ардчилал” буюу иргэдийн өмнөөс шийдвэр гаргахаар төр засаг сонгогддог ба “шууд ардчилал” буюу шийдвэр гаргахад иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх гэсэн ойлголтын хооронд зөрчил гардаг. Зарим нь тодорхой шийдвэр гаргахад иргэд шууд саналаа хэлж оролцох боломжтой болсноор сонгуульт төлөөлөгчдийн шийдвэр гаргах ажиллагаа хоцрогдсныг харуулж байна хэмээн үздэг. Иргэдийн оролцоо нь төрийн бодлогын үйл явц, сонгогдсон төлөөлөгчдийн шийдвэрийг бус, харин түүнд нэмэлт оруулах учиртай. Түүнчлэн иргэдийн оролцоо бий болсноор хууль тогтоох байгууллага, төрийн албан хаагчидтай тооцох хариуцлага сулрах учиргүй. Иргэдийн оролцооны хэлбэрүүд төлөөллийн ардчилалд хор хөнөөл учруулдаггүй, харин ч илүү үр өгөөжтэй ажиллах боломж бий болдог.

Оролцооны зорилгыг ардчиллын өнцгөөс харвал:

- Оролцоо нэмэгдэх нь илүү ардчилалтай байна гэсэн үг.
- Оролцоо нь хэв шинжээрээ эерэг хандлага учир оролцоог нэмэгдүүлэх нь өөрөө зорилт юм.
- Оролцоог нэмэгдүүлснээр эрх тэгш байдал бий болдог.
- Иргэний идэвхтэй нийгэм байгуулахад оролцоог өргөжүүлэх шаардлагатай.
- Нутгийн удирдлагын хууль ёсны хүлээн зөвшөөрөгдсөн байдал нэмэгдэнэ.
- Иргэдийн хариуцлага, идэвхийг дээшлүүлнэ.

Оролцооны зорилгыг бодлого хэрэгжүүлэх өнцгөөс харвал:

- Шинэ бодлого хэрэгжих, тогтвортой үр дүнг хадгалах нөхцөл бүрдэнэ.
- Оролцоог нэмэгдүүлснээр нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэж, хэрэгцээ ба бодлогын шийдлийн уялдаа сайжирч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.
- Тухайн бодлогод үзүүлэх дэмжлэг, хууль ёсоор хүлээн зөвшөөрөх байдал, ил тод байдал нэмэгдэж, хариуцлага дээшилнэ.
- Орон нутгийн үйлчилгээний чанар сайжирна.

4.2. ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

“Түлхүүрдэх боломж олгохгүй бол хаалгаа эвдүүлэх вий” энэхүү үгийн утга зүгээр нэг ёгт үг биш бөгөөд иргэдийн оролцооны хандлагыг өөрчлөхөд чухал ойлголт юм. Мэдээж иргэдийн оролцоо чухал уу? гэвэл хүн бүр л чухал гэж хэлнэ. Бид оролцоог зөвхөн нэг талын байр сууринаас буюу иргэд гэсэн талаас нь харж, ойлгож ирсэн бол оролцоо гэх үг нь өөрөө олон талыг хамарсан ойлголт байдаг.

Оролцоо бол хүн бүрийн өдөр тутмын амьдралын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ардчилсан улс орны иргэдийн хувьд энэ нь байнгын үйл ажиллагаа, үүрэг, хариуцлага нь болж байдаг.



Иргэдийн оролцоог нутгийн өөрөө удирдах ёсны үндэс суурь гэж үздэг. Нутаг орныхоо өмнө тулгамдсан аливаа асуудлыг шийдвэрлэхэд иргэд байх нь хүний эрх, эрх чөлөөний нэгэн адил жам ёсны шинж чанарыг агуулж байдаг. Учир нь хүний амьд байх, аюулгүй орчинд амьдрах, ажиллаж хөдөлмөрлөх, нийгэм соёлын унаган эрхүүд орон нутагт хэрэгжиж байдаг. Орон нутгийнхаа асуудалд иргэн бүр оролцож хамтын шийдвэр гаргах нь хүний жам ёсны эрхийг хангаж байгаа хэрэг юм. Үүнийг л бид нутгийн өөрөө удирдах ёс буюу иргэдийн оролцоотой шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх үйл явц гэсэн үг.

Иргэддээ оролцоо яагаад чухал болохыг тайлбарлан таниулах нь нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл болж ард иргэдээсээ сонгогдсон төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэгч ИТХ-ын төлөөлөгч таны болон төрийн байгууллага, албан тушаалтан бүрийн үүрэг, бас хариуцлага юм. Иргэддээ оролцох боломж нөхцөлийг нь нээж, энэ талаарх хууль эрх зүйн орчин нөхцөлийг нь хангаж өгөхгүй бол дээр хэлсэнчлэн **“хаалгаа эвдүүлэх”** болно.

Оролцооны гарц байхгүй нийгэмд нэг бол нам гүм, эсвэл дуулиан шуугиан л оршдог.



4.2.1. ИРГЭДИЙН ОРОЛЦОО ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Монгол Улсын иргэн бүр төрийн үйл хэрэгт оролцох эрхтэй бөгөөд чадавхитай. Иргэд өөрсөддөө тулгарч буй асуудал бэрхшээлийг бүрэн утгаар нь илэрхийлж, төлөөлж чадна. Тэгвэл иргэдийн оролцоог тоймлон авч үзвэл:

1. *Иргэдийн идэвх дээшилнэ.* Тухайн орон нутгийн, эсвэл цаашлаад улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд хамаатай аливаа асуудлуудыг хэлэлцэх, шийдвэр гаргахад иргэд идэвхтэй оролцсоноор өөрсдөө хэрэгцээгээ тодорхойлох боломжтой болдог. Сайн бодлого боловсруулах, зөв шийдвэр гаргахад иргэдийн өөрсдийн оролцоо хамгийн чухал бөгөөд, ингэж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, дэмжлэг илүү байж, иргэдтэй хамтран ажиллах боломжтой болдог.
2. *Иргэдээс төрд, орон нутгийн удирдлагад итгэх итгэл дээшилдэг.* Хэрвээ төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, бодлого, шийдвэрт иргэдийн оролцоо өндөр байвал үл итгэх хандлага нь буурдаг.
3. *Төр, орон нутаг, иргэний хооронд түншлэлийн харилцаа үүсдэг.* Төр засгийн болон аймаг орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, бодлого шийдвэр илүү ил тод, нээлттэй болж, иргэдийн хүлээх хариуцлага нэмэгддэг. Төр нь иргэнээ сонсдог, иргэн нь төрийн үйл хэрэгт оролцдог түншийн харилцаа тогтох ба түншийн хэн нэг нь давамгайлдаггүй, харилцан тэгш эрхтэй, бие биеэ сонсдог, хүндэлдэг, өөрөөр хэлбэл хамтрагчид байдаг.
4. *Гарч буй шийдвэр нь иргэдийн эрх ашигт нийцэх, амжилттай хэрэгжих үндэс болдог.* Төр иргэн хоорондын харилцаа хэр ойр байхаас хамаарч төрийн бодлого, шийдвэр хэр зэрэг оновчтой байх, цаашлаад хэр зэрэг амжилттай хэрэгжих нь шалтгаалдаг.
5. *Орон нутгийн бие даасан байдал дээшилдэг.* Орон нутгийн бие даасан байдал, түүнийг дээшлүүлэх асуудал нь ихээхэн чухлаар тавигдаад байгаа энэ үед иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар үүнийг шийдвэрлэхэд тодорхой дэмжлэг үзүүлж болно.

4.2.2. ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ДАВУУ БА СУЛ ТАЛ

Иргэдийн оролцоо нь ач холбогдолтой байж болохын зэрэгцээ сул тал бэрхшээл дагуулж болно. Учир нь орон нутгийн бодлого шийдвэрт иргэдийг татан оролцуулахад хүсэл сонирхол, цаг хугацаа зохион байгуулалт шаарддаг.

Хүснэгт 4.2. Иргэдийн оролцооны давуу болон сул талууд

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Иргэдийн саналыг шууд мэдэх боломжтой. • Бодлогын үндэслэл сайн. • Иргэдийн мэдээлэл сайжирна. • Иргэдийн идэвх нэмэгдэнэ. • Бодлого хэрэгжүүлэх арга зам хэрэгсэл тодорхой болно. • Гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд иргэдийн оролцоо сайжирна. • Ил тод байдал хангагдана. • Тулгамдаж буй асуудлыг оновчтой тодорхойлж шийдвэр гаргана. • Хардалт багасна. • Төр иргэний хамтын ажиллагаа сайжирч эргэх холбоо бэжжинэ. • Хяналт сайжирна. • Иргэний танхим ажиллаж орон нутгийн бодлого шийдвэр нээлттэй болсон. • ИНХ-ын үйл ажиллагаа тогтмолжих хандлага бий болно. • Нийгмийн бусад бүлгүүдийн сонирхлыг тодорхойлох боломжтой. • Орон нутгийн нөхцөл байдалд тулгуурласан бодлого шийдвэр гарна. • Иргэдийн хүсэл сонирхол шийдвэрт бодитой тусгалаа олно. 	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн ойлголт хангалтгүй байх, • Иргэд мэдээлэлгүй байх, • Хугацаа алдах, • Хэтийн бодлоготой уялдахгүй байх, • Өөр өөрийн үзэмжээр хандах, • Хэт лоббид автах, • Хуульд нийцээгүй шийдвэр гаргах, • Хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхолд автах, • Цөөнхийн эсэргүүцэлтэй тулгарах, • Иргэд хувийн эрх ашгийн үүднээс хандах хандлага-дан ганц өөрт тулгамдсан асуудал-аймаг орон нутгийн асуудал биш, • Хуучин үзэл бодолтой зууралдах хандлага, • Цөөн хүмүүсийн саналаар асуудал шийдэгдэж болзошгүй, • Урьдчилан тооцоолоогүй шийдвэр гарч болзошгүй, • Идэвхтэй хүмүүсийн санал давамгайлах гээд байдаг, • Зарим тохиолдолд санал бүрэн тусдаггүй, • Нэгдмэл бодлого шийдвэр гарахгүй байх, • Хэт жижиг асуудлаар шийдвэр гаргах, • Идэвхжүүлэх арга замыг тодорхойлох шаардлагатай, • Багийн түвшинд ах дүү, найз нөхдийн хүрээнд асуудалд хандах явцуу шийдвэр гарах нь бий, • Хэлэлцүүлэг нэр төдий болдог тал бий .

Иргэдийн оролцоогүйгээр төр засгийн үйл ажиллагаа буруу тийшээ хандана гэдгийг бүх төлөөлөгчид, төрийн албан хаагч ойлгох хэрэгтэй. Иргэдийн хандлагыг ч өөрчлөж, иргэддээ соён гэгээрүүлэх, мэдээ, мэдээллийг олгох нь чухал.

Хөвсгөл аймаг, Тариалан сумын ИТХ-ын дарга

4.2.3. ОРОН НУТАГТ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ БОЛОМЖТОЙ АРГА ХЭЛБЭРҮҮД

Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааны сайн туршлагыг нэгтгэн дүгнэж авч үзэхэд, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах дараах арга хэлбэрүүд байна. Үүнд:

- Хурал зохион байгуулах (тухайн бодлого шийдвэрт нөлөөлөх субъектийг тодорхойлж оролцуулах);
- Багийн Засаг даргаар дамжуулж санал авах (ийм тохиолдолд иргэд идэвхтэй оролцдог);
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж мэдээлэл түгээх санал авах;
- Санал асуулга (тухайлсан асуудлаарзорилтот бүлгүүдээс) явуулах;
- Иргэний танхимын үйл ажиллгааг идэвхжүүлэх;
- Хэрэгжүүлэх гэж байгаа асуудлаас хамаарч аргаа сонгох (бүгдийг хурал хэлэлцүүлгээр зохион байгуулах боломжгүй);
- Оролцох хүмүүсийг зөв тодорхойлох;
- Өдөрлөг, олон нийтийн арга хэмжээний явцад санал авах;
- Төлөөллийг харгалзалж оролцуулах (зорилтот бүлэг);
- Зар түгээх урилга хүргүүлэх (хэлэлцэх асуудлын мэдээлэл бүхий);
- Урамшуулал-дэмжлэг үзүүлэх асуудлыг тодорхой хүргэх;
- Мессеж илгээх (хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг гар утсаар мессеж хэлбэрээр хүргэх);
- Иргэний боловсрол олгох (оролцооны ач холбогдлыг ойлгуулах ухуулан таниулах);
- ИТХ-ын төлөөлөгчийн ажлыг дүгнэхдээ иргэдийн оролцоог шалгуур болгох;
- Багийн ИНХ-ын оролцоог нэмэгдүүлэх-хамаарал бүхий асуудлын тодорхойлж хэлэлцэх (иргэд өөрсдийн амьдрах орчинтой холбоотой асуудалд их идэвхтэй оролцдог);
- Мэдээлэл хүргэх-олон нийтийн үйл ажиллагаатай зэрэг зохион байгуулах-идэвхжүүлэх;
- Хурлын ач холбогдлыг тодорхой болгох- тодорхой бүлэг зохион байгуулж идэвхтэй иргэдээр дамжуулан идэвхжүүлэх-хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсийг сонгож тодорхойлон ухуулга хийлгэх;
- Цахим хэлбэрээр мэдээлэл түгээх авах (цахим орчинд залуучуудын саналыг авах боломжтой);
- Нээлттэй утас-саналын хайрцаг-фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах;
- Томоохон асуудлыг тодорхойлоход боломжит аргуудыг хэрэглэх - багийн ИНХ-аар дамжуулж гол саналаа авах;
- Иргэний нийгмийн байгууллагатай хамтран сонирхлын бүлгүүдэд зөвлөгөө өгүүлэх үйл ажиллгаага зохион байгуулах;
- Хуралдааныг телевизээр шууд дамжуулах-тухайн хуралдааны явцад утсаар хэлэлцэж буй асуудлаар санал авах;
- Форум зохион байгуулах;
- Багийн ИНХ-ыг оролцооны цөм болгох;
- Идэвхтэн ажиллуулах тодорхой бүлгийн ахлагчаар дамжуулан идэвхжүүлэх;
- Орон нутгийн радиог иргэдэд хэрэгцээт мэдээлэл дамжуулах суваг болгох.

ИТХ-ын төлөөлөгч иргэдтэйгээ ажиллаж буй хэлбэрүүд:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн зүгээс иргэдтэй ажиллаж буй дараах нийтлэг арга хэлбэрүүд байна.

- Төрийн бодлого, УИХ-аас батлан гаргасан хууль тогтоомж, ИТХ-ын тогтоолын шийдвэрийг иргэд олон нийтэд тайлбарлан таниулах ажлыг тогтмол хугацаанд ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албатай хамтран зохион байгуулах;
- Өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн болон аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч, мөн сум дүүргийнхээ ИТХ-ын төлөөлөгч нартай нэг баг болж хамтарсан уулзалт, ярилцлага, бусад арга хэмжээг зохион байгуулах, хамтран ажиллах;
- Сонгогдсон тойрогтоо тогтоосон хуваарийн дагуу уулзалт хийх нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай биечлэн явж танилцах;
- Нийгмийн эмзэг бүлэг, ядуу болон нэн ядуу иргэдийн амьдрал ахуйг анхаарч, тусламж дэмжлэг үзүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах;
- Иргэдийн тавьсан санал, хүсэлтэд анхааралтай хандаж, шуурхай шийдвэрлэх, тэдний эрх ашигтай холбоотой чухал асуудлыг дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- Сонгогдсон тойрог, сум, дүүрэг, баг хорооны ИНХ, Засаг дарга, ахмад, эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, цагдаа хууль хяналт, нам, олон нийт, төрийн бус байгууллагуудтай ажил хэргийн холбоо харилцааг үүсгэж хамтран ажиллах;
- ИТХ-ын төлөөлөгч та сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тухайн тойргийхоо иргэдэд мэдээлж ажлын тайлангаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, намын бүлэгтээ хүргүүлж байх;
- Тухайн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж иргэдээ хамруулах тал дээр санаачлага гаргаж ажиллах хэрэгтэй;
- Баг, хорооныхоо иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд анхаарч тусалж ажиллах, ИНХ-ын даргад хариуцуулан иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг, санал тэмдэглэх дэвтрээ төвлөрүүлэн байнгын холбоотой ажиллах;
- Иргэдээс санал асуулга авах. Өөрийн сонгогдсон тойрогтоо иргэдээс тусгайлан бэлтгэсэн асуудлаар тодорхой асуудлын хүрээнд саналыг авч болох юм. Энэ аргыг хуралдаанаар асуудал хэлэлцүүлэх санаачилж байгаа болон хуралдаанаар хэлэлцэхээр товлосон асуудлаар өөрийн саналаа бэлтгэхэд ашиглаж болно.

4.3. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Орон нутгийн түвшинд гарч буй бодлого, шийдвэрүүд нь үндэсний түвшинтэй харьцуулахад иргэдийн ашиг сонирхолд илүү ойр учраас энэ түвшинд иргэдийн оролцоог хангах нь ардчилсан засаглалыг төлөвшүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, хүний эрхийг хамгаалах, нийгмийн үйлчилгээг сайжруулахад гол хүчин зүйл гэдгийг олон нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо нь дараах байдлаар хэрэгжиж байна.


1) Улсын Их Хурлын түвшинд (Төлөөллийн байгууллага):

Иргэд Монгол Улсын Их Хурал, түүний Өргөдлийн байнгын хороонд хандаж гаргасан өргөдлын саналын хайрцгаар дамжуулан хүлээн авч байгаа. Энэхүү

саналын хайрцагаар Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах дараах асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авахаар заажээ. Үүнд:

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг боловсронгуй болгох, асуудалд санал өгөх;
2. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
3. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын шийдвэр, эрх зүйн актуудыг хянуулах.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д уг саналын хайрцгийг байрлуулж, хурлын дарга холбогдох нэг ажилтны ажил үүргийн хуваарьт тусган, саналын хайрцагт цугларсан иргэдээс ирсэн өргөдлийг 14 хоног тутам УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд шуудангаар хүргүүлж байхаар журам гарган ажиллаж байна.



2) Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын түвшинд (Төлөөллийн байгууллага):

Энэхүү түвшинд иргэдийн оролцоог хангаж ажиллаж буй дараах хэлбэрүүд байна. Үүнд:

- *ИТХ-ын Төлөөлөгч:* Иргэд өөрийн сонгосон ИТХ-ын төлөөлөгчөөрөө дамжуулан санал бодлоо илэрхийлж орон нутгийн шийдвэрт тусгуулж буй юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.14 дэх хэсэгт “Хуралдааныхаа дэгийг тухайн хурал өөрөө тогтоож, тогтоолоор батална” гэж заасан. Мөн хуулийн 24.1 дэх хэсэгт “Хурлын Тэргүүлэгчид, хороо, түүнчлэн төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй”, 24.2 дах хэсэгт “төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно” гэж заасан байдаг.

- *Хуралдааны дэг:* Бүх шатны ИТХ болон баг, хорооны иргэдийн нийтийн хурлын хуралдааны дэгдээ иргэдээ оролцуулах боломж нөхцлийг тусган хэрэгжүүлж байна. 2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний хөгжлийн хүрээлэн хамтран 14 аймаг, нийслэлийн 3 дүүрэг, нийт 17 ИТХ-уудын хуралдааны дэгд ИТХ-ын нээлттэй байдал, иргэдийн оролцоог хэрхэн хангаж ажиллаж буйг хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр үнэлжээ.

Хүснэгт 4.3. ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах шалгуур (ИТХ-уудын хуралдааны дэгд хийсэн судалгааны дүн)

№	Шалгуур үзүүлэлт	Судалгааны дүн
1	ИТХ-ын хуралдааны нээлттэй болон хаалттай байдал	Судалгаанд хамрагдсан ИТХ-ын дэгийн 40 хувь нь хуралдааныг нээлттэй болон хаалттай хийх талаар ямар ч зохицуулалт байхгүй, 60 хувь нь хуралдааныг “аль болох нээлттэй” хийнэ гэсэн зарчимтай байна. Мөн “шаардлагатай” гэж үзвэл хаалттай хийх, ингэхдээ хуралдааны даргалагч болон хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэхээр тусгасан байна. Эндээс үзвэл хуралдааныг хаалттай хийх ямар ч үндэслэлийг дэгээр тогтоогоогүй бөгөөд ганц үндэслэл нь “шаардлагатай бол” гэсэн үг л байна.
2	ИТХ-аар хэлэлцэх асуудалд олон нийтийн хэлэлцүүлэг явуулдаг эсэх	Нийт судалгаанд хамрагдсан дэгийн 90 орчим хувь нь хурлын хэлэлцэх асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах тухай заалт огт байхгүй. Гурван хурлын дэгд асуудлыг “шаардлагатай” гэж үзвэл олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж болно, “хэлэлцэх асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж болно”, “хэлэлцэх асуудлаар олон нийтийн саналыг авах эсэхийг хуралдаанд мэдээлж байж шийдвэрлэнэ” гэсэн зэргээс үзэхэд олон нийтийн хэлэлцүүлэг явуулдаггүй болохыг харуулж байна. Энэ нь ИТХ-ын үндсэн чиг үүрэг болох төлөөллийн чиг үүрэг алдагдсан, нөгөө талаас хурлын байгууллагын ажлын арга барил санаачлага байхгүйг харуулна.
3	ИТХ-д асуудал оруулах эрх олгодог эсэх	Судалгаанд хамрагдсан ИТХ-ын дэгд Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгч, Засаг дарга л асуудал оруулах эрхтэй болохоос биш тухайн нутаг дэвсгэрийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллага тулгамдсан, цаг үеийн зайлшгүй шийдвэрлэх асуудлаар Хуралд асуудал оруулах эрхгүй. Эдгээр иргэний нийгмийн байгууллагууд “асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно” гэсэн зохицуулалтаар хязгаарлаж байна. Энэ хязгаарлалтын дараа дэвшүүлсэн саналыг ИТХ-ын Тэргүүлэгчид хэлэлцээд Хуралд оруулахгүй гэж шийдэх юм бол уг асуудал хэлэлцэх боломжгүй гэсэн үг юм.
4	Иргэний нийгмийн бүлгүүдийг ИТХ-ын хуралдаанд оролцуулах, үг хэлэх эрх олгодог эсэх	Судалгаанд оролцсон ИТХ-ын дэгд иргэний нийгмийн бүлгүүдийг хуралдаанд оруулах талаар заалтууд байдаг ч энэ нь зөвхөн “урилгаар” болон “ажиглагч”-аар оролцох статусаар хязгаарлаж байна. Цөөн тохиолдолд 5 минут хүртэл хугацаагаар, хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр санал, шүүмжлэл хэлэх эрхтэй гэсэн байна. Гэхдээ урилгаар болон ажиглагчаар оролцох төлөөллүүд нь заавал ИТХ-ын Ажлын албатай урьдчилан тохиолцсон байх эсвэл зөвшөөрөл авсан байх шаардлагатай гэсэн байна.

5	ИТХ-ын талаарх мэдээллийг иргэдэд хүргэдэг байдал	Нийт судалгаанд хамрагдсан дэгийн 35 хувь нь ИТХ-ын талаар мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэдэг талаар ямар ч зохицуулалт байхгүй байна. 30 хувь нь зөвхөн хурлын товгыг л нийтэд мэдээлнэ гэснээс өөр зохицуулалтгүй байна. Үлдэх 35 хувь нь ИТХ-ын талаарх шийдвэрийг сурталчлах, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, мэдээлэх, мэдээллийн төвд байрлуулах зэрэг асуудлыг нэг, хоёр заалт төдийгөөр тусгажээ.
6	Хуралдааны тэмдэглэлийг олон нийт үзэх боломжтой эсэх	Нийт судалгаанд хамрагдсан дэгийн 90 гаруй хувь нь хуралдааны тэмдэглэлийг олон нийт үзэх боломжийн талаар огт тусгаагүй байна. Энэ нь ИТХ-ын үйл ажиллагаатай танилцах боломж иргэдэд огтхон ч байхгүйг харуулсан баримт юм. Хуралдааны тэмдэглэлийг олон нийт үзэх боломжтой нээлттэй байх нь иргэдийн оролцоог хангах хамгийн чухал наад захын хэрэгцээ шаардлага болох ёстой

ИТХ-ын хуралдааны дэгүүдээс үзэхэд зарим дэгд нь иргэдийн оролцоог хангахад хаалт болох “Хаалттай хуралдаж болно”, “Хуралдааны нууцыг хадгална”, “Хуралдааны үйл явцын тэмдэглэлийг нууцын дэвтэрт бичнэ” гэсэн заалтууд байгаа нь ИТХ-ын нээлттэй байдлыг хумих зохицуулалтууд болж байна.

- *Иргэний танхим:* Аймаг, Нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх (зарим дүүргийн хороо бүрт) иргэний танхимаараа дамжуулан иргэдийн санал бодлыг сонсон, нээлттэй хэлэлцүүлэг явуулах замаар иргэдийн оролцоог ханган ажиллаж байна.

- *Баг, хорооны ИНХ-ын түвшинд (Төлөөллийн байгууллага):* Иргэдийн оролцоог хамгийн их сонсож, шийдвэр гаргах дээд шатны удирдлагуудад уламжилдаг байгууллага нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, түүний хуралдаан юм. Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлд орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах тухай зохицуулалт орсон бөгөөд тус хуулийн 63.1 ээс 63.4 хүртэлх заалт нь иргэдийг шийдвэр гаргах үйл явцад оролцоулах, тэр дундаа орон нутгийн бодого, шийдвэрт иргэдийн санал санаачлагыг тусгуулах боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал:


63.1. Баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

63.2. Энэ хуулийн 63.1-т заасан санал болон баг, хорооны ИНХ дээр гарсан саналыг ИНХ хэлэлцэн, Тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

63.3. Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны ИНХ-аас ирүүлсэн саналыг сум, дүүргийн ЗДТГ ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум дүүргийн ИТХ-д өргөн мэдүүлнэ.

63.4. Сум дүүргийн ИТХ нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэн төсвийн төсөлд тусган батална.

Удирдлагын академийн доктор, профессор Ш.Батсүхээр ахлуулсан судалгааны баг “Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо” судалгааг 2014 он хийсэн бөгөөд тус судалгаанаас иргэд орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад ямар үүрэгтэйгээр оролцох хүсэлтэй байгааг харж болно.



Зураг 4.1. Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо

Нийт судалгаанд оролцогчдын 8.4 хувь нь өөрийн саналыг боловсруулж өгөхийг, 27.0 хувь нь гаргасан саналуудад санал өгөхийг, 40.5 хувь нь гарсан саналуудыг үнэлж дүгнэхийг, 12.9 хувь нь идэвхгүйгээр ажиллахыг хүсэж байгаагаар илэрхийлсэн бол 11.3 хувь нь оролцохыг хүсэхгүй байна гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, иргэдийн 75.9 хувь нь буюу 4 хүн тутамын 3 нь орон нутгийнхаа удирдлагын шийдвэрт ямар нэгэн байдлаар оролцох хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 45.0 нь гарсан саналуудыг үнэлж, дүгнэхийг хүсэж байна гэсэн бол 27 хувь нь гарсан саналуудад санал өгөхийг хүсэж байгаагаас харахад иргэд өөрсдөө санал оруулах бус бэлэн гаргасан саналуудад саналаа өгөх, тэдгээр саналуудыг үнэлж дүгнэхийг илүүд үзсэн байна. Дээрх асуудлыг насны бүлгээр авч үзвэл тодорхой үүрэгтэйгээр удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүсэхгүй байна гэж 18-25 насны залуучууд илүү хариулжээ. Харин иргэдийн 40-60 хувь нь гаргасан саналд санал өгөх, үнэлж дүгнэх үүрэгтэйгээр орон нутгийнхаа удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохыг хүссэн байна.⁶³

4.4. ИТХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАНДАЖ БҮЙ ИРГЭДИЙН ХАНДЛАГА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Иргэд өөрт нь хамааралтай асуудлаар оролцох хүсэлтэй байдаг тул хэлэлцэх асуудалдаа хамааралтай хүмүүсийг урих хэрэгтэй. Тэд оролцохдоо өөрсдийгөө нийгмийн нэг хэсэг гэдгээ мэдэрдэг. Иргэдийн оролцоог сайн зохион байгуулж чадвал хүмүүс шийдэл ярьж эхэлнэ. Тэдэнд мэдлэг чадвар бий.

Ядуу эмзэг бүлгийнхний дуу хоолойг бодлого, шийдвэртээ тусгаж эхэлснээр ядуурлыг бууруулж байгаа олон жишээ байна. Өөрөөр хэлбэл төрийн бодлого, аливаа үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэлгүй иргэд л идэвхигүй байдаг. Иргэдийг мэдээлэл авах боломжоор хангаад эхэлбэл тэд чадваржиж эхэлнэ. Иргэд зохион байгуулалтад орж сайн дурын холбоод эсвэл ИНБ-аар дамжуулан бодитоор оролцож чаддаг.


⁶³ Ш.Батсүх "Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо" 2015 он

Иргэд аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох тусам, тэднийг ийм үйл ажиллагаанд оролцуулах тусам нэгнээ сонсох, харилцан суралцах, хамтран шийдвэр гаргах соёлд суралцдаг.

Иргэдийн оролцоог *нэгдүгээрт*, зарчим болох талаас нь тодорхойлж, оролцох бололцоог төр бий болгох ёстой гэдэг хандлага, *хоёрдугаарт*, иргэдийн оролцоог тэдний үүрэг биш, эрх талаас нь тодорхойлох хандлага, *гуравдугаарт*, оролцоог арга хэрэгсэл болох талаас нь авч үзэж иргэдээс өөрсдөөс нь хамаарах зүйл гэж үзэн иргэний боловсрол, соёл, чадамжийн талаар авч үздэг хандлагууд байна.⁶⁴ Тэгвэл бодит байдал дээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын талаар иргэдийн хандлага ойлголт хэрхэн байгаа талаар нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшинг тогтоох судалгааг 2015 онд 5 аймгийн 15 сум, нийслэл Улаанбаатар хотын 7 дүүргийн 20 хорооны нийт 1200 өрхийг хамарсан судалгаанд оролцогчдын 55% нь ИТХ-ын талаар “Огт мэдэхгүй” гэсэн хариулт өгсөн байна.

Харин Улаанбаатар хотын иргэдийн 32% нь, орон нутгийн иргэдийн 71% нь ИТХ гэдэг байгууллагын талаар ямар ч ойлголт байхгүй, зарим иргэд бүр ийм байгууллага байдгийг ч мэдэхгүй гэж хариулсан байна.⁶⁵

ИТХ-ын талаар та мэдэх үү?



Зураг 4.2. ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт

Хүснэгт 4.4. ИТХ-ын талаарх Нийслэлийн иргэдийн ойлголт (Судалгааны дүн)

№	ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт хандлага
1	Ард иргэдийн дундаас сонгогдон ажиллаж байгаа иргэдийн төлөөллийн байгууллага
2	Ард иргэдийн санал хүсэлтийг авч, холбогдох газарт уламжлан, шийдвэрлэж өгдөг үйлчилгээний байгууллага
3	Ард иргэдийн дуу хоолойг төрд хүргэх, төр иргэдийн хооронд гүүр болох байгууллага
4	Иргэдийн амьжиргаа, нутаг орны хөгжлийг сайжруулах байгууллага
5	Өрх бүр, иргэн бүртэй хамгийн ойр тулж ажиллах байгууллага

⁶⁴ Steven J. Rosenstone and John Mark Hansen, *Mobilization, Participation, and Democracy in America* (New York: Macmillan Publishing Company, 1993), p.34.

⁶⁵ УИХ-ын Тамгын газар, ШХА, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшинг тогтоох судалгааны тайлан” 2015 он

6	Хороотой хамтран ажилладаг байгууллага
7	Орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлэгч хамгийн дээд байгууллага
8	Иргэдийг мэдээллээр хангадаг, иргэдийг зохион байгуулдаг байгууллага
9	Ард түмний эрх ашгийг хамгаалдаг байгууллага
10	Орон нутагт хуваарилсан төсөв санхүүг хуваарилж, зарцуулалтыг батлах эрх бүхий байгууллага
11	Хууль баталдаг байгууллага
12	Мөнгө л иддэг байгууллага
13	Засаг дарга болон сум, дүүргийн албан хаагчдыг хянадаг байгууллага
14	Цалин авдаггүй сайн дурын хүмүүсийн нэгдсэн байгууллага

Хүснэгт 4.5. ИТХ-ын талаарх хөдөө орон нутгийн иргэдийн ойлголт (Судалгааны дүн)

№	ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт хандлага
1	Засаг даргатай хамтарч ажиллах, ажлыг нь хянаж, чиглүүлдэг байгууллага
2	Орон нутагт хийгдэж байгаа ажилд хяналт тавьдаг байгууллага
3	Ард иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах эрх бүхий байгууллага
4	Ажил хийдэггүй байгууллага
5	Ард түмний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх ёстой байгууллага

ИТХ-ын талаарх иргэдийн дээрх ойлголтуудаас бид аль ойлголт, хандлагыг нь цааш улам бэхжүүлж, ямар ойлголт, хандлагыг нь зөв болгож, аль ойлголтыг нь засаж залруулах нь бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тэр дундаа төлөөлөгч бүрийн санал санаачлага, идэвх чармайлтын үр дүнгээс ихээхэн шалтгаалах нь ойлгомжтой. Ингэж байж ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт хандлагад тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарна.

Тэгвэл ямар учраас нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх тэдний мэдлэг, мэдээлэл муу байгааг иргэд өөрсдөө тайлбарлахдаа:

Нэгдүгээрт, улс төрд итгэх итгэл муудсан буюу төрийн ажил хийхээр хэн ч сонгогдсон бай иргэдийн амьдралд сайн нөлөө гарахгүй гэх бодол зонхилох болсон.

Хоёрдугаарт, хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, зав чөлөөгүй болсноор нутгийн удирдлагын байгууллагуудын талаарх мэдлэг бага болсон.

Гуравдугаарт, оновчтой сувгаар мэдээлэл авч чадахгүй байгаа, өөрөөр хэлбэл мэдээллийн хэрэгсэл олширсноор иргэд маш олон төрлийн мэдээллийг нэгэн зэрэг авах болсон нь тэдэнд хүссэн мэдээллээ л шүүж авахаас аргагүйд хүргэж байгаа гэсэн 3 үндсэн шалтгааныг нэрлэжээ. НӨУБ-ын талаар иргэдийн ойлголт ийнхүү дутуу дулимаг байгаа нь тулгамдсан асуудал гарсан үед хаана хандахаа мэдэхгүй байх, төрийн үйлчилгээ иргэдээсээ холдох, иргэдийн сонгуулийн болон бусад идэвх буурах, улмаар энэхүү Үндсэн хуулийн институцийн нэр хүнд унах сөрөг үр дагавартай юм.⁶⁶

Тэгвэл энэхүү сөрөг бөгөөд буруу хандлагыг хэрхэн засаж залруулах боломж

⁶⁶ УИХ-ын Тамгын газар, ШХА, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. "Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшинг тогтоох судалгааны тайлан" 2015 он

бидэнд байна вэ?

Иргэдийн оролцооны дараах хэлбэр одоогийн байдлаар түгээмэл байна. Үүнд:

- Төрийн дээд болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлж шууд оролцдог.
- Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр шууд оролцдог.
- Санал гомдлоо илэрхийлж оролцдог.
- Өөрийн харъяалах байгууллагаар дамжуулж санал бодлоо илэрхийлж оролцдог.
- Хуулиар олгосон оролцооны боломжуудыг ашигладаг.
- Нээлттэй хэлэлцүүлэг, ярилцлагад оролцдог.
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх замаар оролцдог.
- Цахим хэлбэрээр бодол санаагаа илэрхийлж оролцдог (facebook, Twitter цахим санал асуулга г.м).
- Жагсаалт цуглаанд нэгдэх замаар оролцдог.
- Гарын үсэг цуглуулах замаар оролцдог.

Ийнхүү оролцооны маш олон арга байдаг бөгөөд гагцхүү эдгээр аргуудаас аль аргыг хэрэглэж тухайн орон нутгийнхаа иргэдийн идэвх оролцоог дээшүүлэх нь ИТХ-ын Төлөөлөгч таны иргэдтэйгээ харилцах ур чадвар шаардах асуудал болоод байна.

ИТХ-ын хөгжлийн чиг хандлага, чадавх чадамжийн асуудал нь түүнийг бүрдүүлэгч ИТХ-ын төлөөлөгч бүр өөрсдийн хууль ёсны эрх ашгаа хэрхэн хангаж хуулийн хүрээнд хэрхэн иргэдтэйгээ харилцаж, иргэдийг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллаж, тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн ахуй амьдрал өсөн дэвшиж буйн үзүүлэлтүүд нь ИТХ-ын төлөөлөгч таны болон танай баг хамт олны иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг билээ.

Нөгөө талаар нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийг төлөөлж ажиллаж буй ИТХ-ын төлөөлөгч танд хандаж буй хандлагыг өөрчлөх цаг нэгэнт болсон. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд хүчтэй бөгөөд сонор соргог ажиллаж, Үндсэн хуулийн үүргээ “нэр төртэй” биелүүлж чадаж байгаа бол иргэдээ бухимдахаас өмнө асуудлыг таньж мэдээд шийдвэрээ гаргаж төр засагт асуудлыг тавьж шийдвэрлүүлж хэрэгжүүлэх учиртай. Тааруухан хэрэгжүүлж байгаагийн илрэл нь орон нутгийн шинжтэй элдэв зовлон бэрхшээл, төрийн төв бодлогын гажуудлаас үүдэн иргэд, тэдний олон нийтийн байгууллагуудын эсэргүүцлийн жагсаал цуглаан, ажил хаялт, өлсгөлөн зарлалт буурахгүй байгаа юм. Иргэд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын харьяаны хүмүүс яагаад ИТХ-даа хандаж асуудлаа тавихын оронд ТББ, эсвэл тэмцлийн элдэв хэлбэр сонгов гэдэг бол асуудал болж байна.

ИТХ-ууд хүчирхэг байж, тэр эрх хүч нь хуулиар хамгаалагдсан байж, төр, засгаас орон нутгийн эрх ашгийг хохироох шийдвэрийг сөрж болиулдаг чадамж Хуралд байх шаардлагатай. Ийм л ИТХ-ыг бий болгоход ИТХ-ын төлөөлөгчид чадавхжих, мэргэших шаардлагатай байгаа юм.

ИТХ хүчтэй байхын нэг шинж нь ИТХ-ын төлөөлөгчид өөрсдөө мэдлэгтэй, мэдээлэлтэй, асуудал шийдвэрлэх чадвартай байх явдал мөн.

ИТХ-ын төлөөлөгч хүн бол тухайн сонгогдсон нутаг дэвсгэрийнхээ нийт иргэд болон аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага, албан тушаалтан бүртэй нягт уялдаатай ажиллах нь чухал байдаг.

Нутгийн өөрөө удирдах байгууллага иргэдийн хоорондын харилцаа нь шийдвэрийг боловсруулах, үе шатнаас, хэрэгжилт, үнэлгээ хүртэлх өргөн хүрээнд байдаг. Иргэдийн оролцоог Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

1. *Мэдээллээр хангах:* Энэ нь нутгийн өөрөө удирдах байгууллага төрөл бүрийн мэдээллийг хэвлэн нийтэлж иргэдэд түгээх буюу нэг талын харилцаа.
2. *Зөвлөлдөх:* Нутгийн өөрөө удирдах байгууллагаас тодорхой асуудлаар иргэдийн санаа бодлыг сонсох буюу хоёр талын харилцаа.
3. *Идэвхтэй оролцоо:* Иргэд шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцох хэлбэр буюу ИТХ иргэдийн идэвхтэй хамтын ажиллагаа.

Энэ нь иргэд аливаа бодлогын хувилбарыг санаачлах, боловсруулах үйл явцыг хэлнэ.

Иргэний оролцооны талаарх судалгаа, ИТХ-уудын сайн туршлагууд

Манай орны тухайд 2000 оноос эхлэн Шууд ардчилал-иргэдийн оролцоог хөгжүүлэхэд нилээд анхаарал хандуулсан бөгөөд энэ хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагууд, гадны байгууллагуудын тусламжтайгаар төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал:

1. 2005 онд “Глоб Интернэшнл” ТББ-аас “Мэдэх эрх” иргэдэд зорилсан гарын авлага боловсруулж иргэдийн оролцооны хэлбэрүүд, иргэд бодлого боловсруулах үйл явцад хэрхэн оролцох зэрэг асуудлуудыг авч үзсэн байна.
2. Нээлттэй нийгэм хүрээлэн 2005 оноос хойш иргэдийн оролцооны 20 гаруй дагнасан судалгааны бүтээлүүдийг гаргасан.
3. МУИС-ийн багш Д.Бямбажав “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоо: эрх зүйн орчинг институцлалыг сайжруулах нь” бодлогын судалгааг хийсэн байна. Судалгаагаар Монгол Улсад төрийн бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоог хангах эрх зүйн орчинг тодорхойлох, давуу болон сул талуудыг илэрүүлэх, дэлхийн бусад оронд төр-иргэний нийгмийн хамтын ажиллагаа, ТББ-ын оролцоог хангасан сайн туршлагыг өөрийн орны нөхцөл шаардлагад тулгуурлан хэрэгжүүлэх, боломж арга замуудыг тогтоох, төрийн бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоог дэмжих бодлогын сонголтыг тодорхойлох зэрэг асуудлыг авч үзсэн байна.
4. “Мерси Кор Монгол” Олон улсын байгууллагын санхүүжилтээр 2007 онд судлаач Д.Бямбажав, С.Түмэндэлгэр нар “Орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо”-г Архангай, Хэнтий, Булган аймгуудын жишээн дээр судалж судалгааны тайлан гаргасан.
5. Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэнгээс 2013 онд багийн иргэдийн Нийтийн хуралд зориулсан “Багийн түвшинд иргэдийн оролцоо, эргэх холбоог сайжруулах нь” гарын авлагыг боловсруулан хэвлүүлжээ.
6. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Конрад-Аденауэр сангийн санхүүжилтээр 2013 онд “Шууд ардчилал-иргэдийн оролцоо” үндэсний сургалтын гарын авлагыг хэвлүүлж гаргасан.
7. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс 2014 онд төсвийн ил тод байдал хангалтгүй, иргэдийн оролцоо бага, үр дүн муутай байгаа байдалд судалгаа хийж, түүний шалтгаан нөхцөлийг тодорлуулах, асуудлыг

- шийдвэрлэх арга замыг тодорхойлсон “төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоог дээшлүүлэх хөшүүрэг, арга зам” гэсэн судалгааны тайланг хэвлүүлж олон нийтэд хүргэсэн.
8. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих нь” төслийг 2012 оноос хойш хэрэгжүүлж энэ хүрээнд нилээд олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлээд байна.
 9. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Азийн сан, Үндэсний хөгжлийн хүрээлэн Удирдлагын академи зэрэг олон байгууллагууд энэ салбарт анхаарал хандуулж олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн судалгаа шинжилгээний олон бүтээлүүд гарч байна.
 10. Удирдлагын Академийн доктор Ш.Батсүх, Я.Долгоржав, Ганцоож нар Конрад-Аденауэр сангийн санхүүжилтээр “Шууд ардчилал ба орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт”-ийн үйл явцад судалгаа хийсэн байна.
 11. УИХ-ын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлсэн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг-сайн туршлагыг эмхэтгэлийг 2016 оны 7 дугаар сард гаргасан бөгөөд уг бүтээлд ИТХ-аас төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавьж буй байдал, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ИТХ-ын хяналтын чиг үүргийг сайжруулах, нийгмийн эмзэг бүлгийг дэмжих, Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд ИТХ-аас хяналт тавих нь гэсэн чиглэлээр 8 аймгийн ИТХ, 21 сум, 2 дүүргийн ИТХ хурал дээрх тэтгэлэгт төсөл хамрагдаж нийт 200 орчин сая төгрөгний санхүүжилт авсан байна. Энэхүү сайн ИТХ-уудыг дэмжих тэтгэлэгт төслийн хүрээнд 9500 гаруй иргэн санал асуулга, судалгаанд хамрагдан нутгийн удирдлагын бодлого шийдвэрт саналаа хүргэж 10.0 мянга орчим иргэн сургалт, хэлэлцүүлэгт оролцох замаар ИТХ, орон нутгийн асуудлын талаар мэдээлтэй болсон байна.
 12. Орон нутгийн хөгжлийн хүрээлэн ТББ “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран ИТХ-уудын сайн туршлагын эмхэтгэлийг гаргасан байна. Тус сайн туршлагын эмхэтгэл нь нэгдүгээрт: ИТХ-ын хороод, Тэргүүлэгчид, Ажлын албаны үйл ажиллагаа, хоёрдугаарт: иргэний танхимын үйл ажиллагаа гуравдугаарт: орон нутагтаа мөрдүүлэх дүрэм, журам дөрөвдүгээрт: иргэдийн оролцоонд тулгуурлан асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж иргэдтэйгээ хамтран ажилладаг байдал, тавдугаарт: ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа зургаадугаарт: баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаа зэрэг 6 бүлгээр 15 аймгийн 30 сумын ИТХ-уудын сайн туршлагыг нэгтгэн эмхэтгэл болгон хэвлүүлж олон нийтэд хүргээд байна.



2000 оноос хойш иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сайн туршлага болохуйц олон арван эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд гарч байгаа нь ИТХ-ууд өмнө нь сайн туршлага судлах гээд цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй асуудалтай тулгардаг байсан бол эдгээр судалгааны бүтээлүүд нь эмхэтгэл болж хэвлэгдсэнээр ИТХ-уудад цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх давуу талыг олгож байна.

Гагцүү эдгээр нэр дурдсан болон дурдаж амжаагүй судалгааны дүн, сайн туршлагуудаас суралцаж, өөрийн орон нутгийн түвшинд хэрэгдэж, хэрэгжүүлэх нь тухайн ИТХ-ын болон Тэргүүлэгч, Төлөөлөгч, Ажлын албаны санаачлагаас бүрэн хамаарах учиртай.

4.5. ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХОЛБОГДОЛТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ

4.5.1. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

ИТХ-ууд энэ хуулиар ямар үүрэг хүлээсэн бэ? Төсвийн тухай хуулийн есдүгээр бүлэг 59-64 дүгээр заалт хүртэл үндсэндээ иргэдийн оролцоог хангасан орон нутгийн төсвийн үйл явцад олон нийтийн оролцоог хангахад энэхүү хууль голлох чиг үүрэгтэйгээр хэрэгжиж байгаа билээ. Тухайлбал, тус хуулийн 63.1 дэх заалтад "...Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх, дараалал арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.... гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно хэмээн иргэдийн оролцоог хуульчилсан.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх арга аргачиллыг Сангийн сайдын 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын дагуу зохион байгуулж байгаа бөгөөд иргэдийн Нийтийн Хурал 5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 30-ны хооронд хуралдаж, гаргасан шийдвэрээ 2 дугаар улиралд багтаан сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр заасан. ОНХС-гийн эх үүсвэр нь: Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын

5 хувь, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон доодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж хандив, доод шатны төсвийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь зориулж улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг зэргээс бүрдэж байна.

ОНХС гэх ойлголттой иргэд танилцаад багагүй хугацаа өнгөрсөн ч одоог хүртэл энэхүү ойлголт нэг мөр болоогүй байна. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь тухайн орон нутгийн хөгжилд тодорхой үр дүнгээ өгч байгаа хэдий ч дараах хүндрэл бэрхшээлүүд байсаар байна.

Үүнийг хэрхэн шийдвэрлэх тал дээр нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл болсон ИТХ-ын төлөөлөгч та бүхний идэвх санаачлага чухал юм.

ОНХС-тай холбоотой хүндрэл бэрхшээл

1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн саналын тухай тухайн орон нутгийн иргэдээс санал авч ИНХ-аар эрэмбэлэн тухайн сум, дүүргийнхээ ЗДТГ-т хүргүүлдэг ч батлагдах болохоор санал өгсөн төсөл хөтөлбөр нь өөрчлөгддөг.

Жишээ. “А сумын Б багийн иргэд Иргэдийн Нийтийн Хурлаараа багийн нутаг дэвсгэрт орших “Оргил” хэмээх булгийн эхийг хамгаалах, хашаажуулах саналыг олонхоороо дэмжиж, “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр энэ ажлыг хийхээр саналаа өгснийг сумын ИТХ-аар хэлэлцэж дээрх санал дэмжигдээгүй байна” багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан иргэдийн дээрх саналыг сумын ИТХ дэмжихгүй байх нь үндэслэлтэй юу.

2. ОНХС-гаар хэрэгжих төсөл хөтөлбөрийг тухайн шатны ИТХ нь хэлэлцэн баталдаг ч иргэдэд батлагдсан тухай мэдээлэл болон таны санал ингэж батлагддаг гэсэн мэдээллийг иргэдэд хүргэдэггүй.
3. Иргэд баг, хорооныхоо ИНХ-д оролцох идэвх сул байдгаас 900 гаруй өрхийг төлөөлж 39 хүн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж санал эрэмбэлэх хурлыг хийж байх жишээтэй. Энэ нь шууд ардчилал гэж үзэхэд хүндрэлтэй.
4. Иргэдэд ОНХС-гийн талаар мэдээлэл сайн хүрээгүйгээс нөгөө талаас ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээ нь хууль, журманд заасны дагуу Техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөл батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх, орон нутгийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдсан байх, бий болсон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал зардлын тооцоо, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ гээд шаардлагад нийцсэн эсэх нь тодорхойгүй байдаг зэрэг юм.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар 2014 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академийн доктор, профессор Ш.Батсүх, Я.Долгоржав, Б.Ганцоож нар “Шууд ардчилал иргэдийн оролцоо” (Иргэний танхим, Орон нутгийн хөгжлийн сан) нэртэй судалгааг хийж⁶⁷, Уг судалгаагаар ОНХС-ийн хэрэгжилтийн талаар иргэд хангалтгүй мэдээ, мэдээлэлтэй байгааг судалгаагаар гаргаж тавьсан байна. Тухайлбал:

⁶⁷ Ш.Батсүх Ш.Долгоржав, Я.Ганцоож “Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо” судалгааны тайлан 2014 он 13 дахь тал

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах хуулийн заалт, заавартай ч иргэдийн маань идэвх сул, саналаа тэр бүр илэрхийлж сураагүй, илэрхийлж байгаа нэг нь ямар ч тооцоо баримжаагүй, хэрэгжих үндэслэлгүй зүйл ярьдаг. Бидний зүгээс ч хот суурин газрынхантай ажил иргэдийн саналыг цахим хэлбэрээр авах зэрэг бололцоо муутай байлдаг. Иргэд, малчид ч санал асуулгын хуудсанд олигтай юм бичиж өгөхгүй юм даа ...

*Сүхбаатар аймгийн Түмэнцогт
сумын төрийн албан хаагчийн ярианаас*

Суманд хуваарилагдан ирж буй ОНХС-гийн мөнгөөр уг нь нийт сумынхаа эрх ашигт нийцсэн хүн бүр үр ашгийг нь хүртэж болохоор цөөн тооны чанартай, үлдэцтэй зүйлд зармаар байдаг, гэтэл иргэдийн саналыг аль болох харгалзах нэрээр олон зүйлд төсвөө тарамдуулж, эцэст нь цөөн хэдэн хүнтэй бүлэг хадландаа хашаа барих, ганц хоёр эрх малаа услах худаг гаргах мэт рүү орчих гээд байна...

*Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын
Засаг даргын ярианаас*

Бид өнгөрсөн жил сумандаа Иргэний танхим байгуулах байр засах, тоног төхөөрөмжид хэдэн сая төгрөг зарцуулсан. Гэтэл аудитын байгууллага болохоор болохгүй гээд акт тавьчихсан. Ер нь иргэний танхим гээчийн эрх зүйн үндсийг л тодорхой болгомоор байгаа юм

*Баянхонгор аймгийн Бууцагаан сумын
Засаг даргын ярианаас*

Бидэнд энэ мэтчилэн ОНХС-тай холбоотой хүндрэл бэрхшээл гарсаар байгаа бөгөөд энэ хүндрэл бэрхшээлээс хэрхэн гаргах, хууль эрх зүйн орчинг хэрхэн хэрэглэх талаар ИТХ-ын Тэргүүлэгч, Төлөөлөгч, хурлын хороод, Ажлын алба идэвх санаачлагатай ажиллаж иргэдэд мэдээлэл сурталчилгааг сайн өгөх хэрэгтэй.

4.5.2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД

ИТХ-ууд энэ хуулиар ямар үүрэг хүлээсэн бэ? УИХ-аас 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн 7.1.4-д **“Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”**-ыг нэмж оруулсан.

Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тоот тушаалаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам” батлагдаж энэ хүрээнд олон нийтийн худалдан авах ажиллагаа хэрэгжиж байна.

Тус журмын 2.2-д “Иргэдийн бүлгээр хийж гүйцэтгүүлэх төсөл, арга хэмжээ нь техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон Төсвийн тухай хуулийн 58.3.3-58.3.7, 58.4.3-58.4.8-д заасан төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулж болно.” гэж заасан бөгөөд 2.1-д “Сум дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулахдаа захиалагч нь хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу Үнэлгээний хороо байгуулна гэж заасан.

Тэгвэл худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн эсвэл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.⁶⁸ хэмээн хуульчилсан нь иргэдийн ороцоог худалдан авах ажиллагаанд заавал оролцуулахаар заажээ. Харин энэхүү хуулийн 47.6-д “Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна ” гэж хуульчилсан.

Жишээ. Б сумын ИТХ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу Үнэлгээний хороонд орж ажиллах иргэдийг сургах зорилгоор АЗ гэрчилгээ олгох сертификатын сургалтыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргуулж, иргэдийн оролцоог хангаж ажиллахыг үүрэг болгосон тогтоол гаргажээ. Уг тогтоолд Засаг дарга хориг тавьжээ. Энэ хориг нь хууль эрх зүйн үндэслэлтэй юу?

Хуулийн энэхүү заалтыг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн худалдан авах ажиллагааны газар болон албадууд иргэдийн оролцоог хангах чиглэлээр худалдан авах ажиллагаанд мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификатын сургалтыг зохион байгуулж ажиллаж байна. Харин нэг хүндрэл нь энэхүү сургалтын зардлыг орон нутгийн төсөвт суулгаагүй байдаг. ИТХ-ууд 2017 оны төсвийн төслийг хэлэлцэж

⁶⁸ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.4 дэх заалт

батлахдаа иргэдийн оролцоог хангах, оролцох боломжийг нээж дээрх сургалтын зардлыг тусгаж батлах нь зүйтэй. Эсвэл сургалтад тэнцсэн иргэдийн зардлыг хариуцаж тэнцээнгүй иргэд өөрсдөө сургалтын зардлаа хариуцахаар зохицуулалт хийж болох юм.

Нөгөө талаар энэ хуулийн талаар иргэд буруу ойлголттой байдгаас төрийн худалдан авах ажиллагаа нууц байлаг, тендэр гэхээр л хээл хахуультай холбон ойлгох хандлага давамгайл байдаг нь Нээлттэй нийгэм форумын хийсэн судалгаанаас харагдаж байна. Энэхүү хуулийн ач холбогдол, иргэд худалдан авах ажиллагаанд оролцсноор ямар ач холбогдолтой болохыг ойлгуулж, тайлбарлан таниулах нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуулиар хүлээсэн үүрэг юм.

Тус хуулийн хүрээнд шинээр бий болж буй нэг ойлгол нь “Иргэдийн бүлэг” юм. Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тоот тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-д заасны дагуу тендерт оролцогч нь Иргэний хуулийн шаардлага хангасан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр байгуулагдсан иргэдийн бүлэг байна хэмээн заасан байна. Иргэдийн бүлэг байгуулагдсанаар:

- орон нутгийн эдийн засгийг дэмжих, хөрөнгө оруулах;
- тухайн орон нутгийн иргэд өөрсдийн хүрээлэн буй орчин сум, дүүргийн тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт гэх мэт өөрсдийн амьдрахад тав тухтай орчин бүрдүүлэх ажилд өөрийн биеэр оролцож хяналт тавих;
- орон нутгийн иргэд тодорхой хугацаанд тодорхой орлоготой байж орон нутагт түр ажлын байр бий болох гэх мэт давуу талууд бий болно.

4.5.3. МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХУУЛИЙН ХҮРЭЭНД

ИТХ-ууд энэ хуулиар ямар үүрэг хүлээсэн бэ? Мэдээлэлтэй иргэд хүчирхэг байдаг. Мэдээллийн эрх чөлөөнд хүн мэдээлэл хүртэх, мэдээлэл олж авах, мэдээлэл түгээх эрхүүд тус тус багтдаг. Яагаад мэдээлэл хэрэгтэй вэ? Яагаал гэвэл бид төр нь иргэндээ үйлчилдэг ардчилсан нийгэмд амьдарч байна.

Улсын Их Хурлаас 2011 онд батлагдаж гарсан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” нь иргэн мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхээ эдлэхэд томоохон алхам болсон.

Тус хуулиар иргэдийг мэдээллээр хангах субъектыг өргөн хүрээтэй томъёолж өгсөн ба хуулийн 3.1.8-д нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь тус хуулиар тодорхой үүргийг хүлээсэн байгаа.

Энэхүү хуулийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллагуудын нь иргэдэд үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүүгийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэсэн 4 чиглэлээр мэдээллийг хүргэхээр хуульчилсан.

Хуулийн 7.1.4-т заасны дагуу үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулж мэдээлэлд нэмэлт өөрчлөлт орсон, эсвэл мэдээлэл бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд уг мэдээллийг 3 хоногийн дотор шинэчлэх үүргийг хүлээсэн.

Тэгвэл мэдээлэл хүсэж буй иргэн ямар эрхтэй вэ? Хуулийн 12.1-р зүйлд төрийн байгууллагаас мэдээлэл авахыг хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь дараах **эрхтэй**.

Үүнд:

1. Эрх тэгш байх,
2. Мэдээлэл авах хэлбэрээ сонгох,
3. Мэдээлэл авах шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх,
4. Нэмэлт лавлагаа авах,
5. Агуулгын талаар амаар тайлбарлуулах,
6. Албан ёсны эх сурвалжийг мэдэх,
7. Мэдээлэл авах эрх зөрчигдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах,
8. Хуульд заасан бусад эрх.

Харин дараах **үүргийг** иргэн хүлээсэн байдаг. Үүнд:

1. Хуульд заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх,
2. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчилгүй байх,
3. Авах мэдээллээ бодитой тодорхойлсон байх (хуулийн 12.2 дахь заалт).

Мэдээлэл авахыг хүссэн иргэний **хүсэлтийг** ямар үед буцааж болох вэ?

Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан дараах 2 тохиолдолд буцааж болно.

1. Хуульд заасан шаардлага буюу эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адитгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсэг зурсан байх шаардлагыг хангаагүй бол
2. Хүссэн мэдээлэл нь тухайн байгууллагын эзэмшилд байхгүй, хүсэлтийг өөр байгууллагад шилжүүлэх боломжгүй бол хүсэлтийг буцаана.

Төрийн байгууллагуудад ямар мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байлгахыг хориглодог вэ?

Хуулийн 4 дүгээр бүлэгт зарим төрлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөхийг **хориглосон**. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодит үндэслэл байгаа бол;
2. Монгол банк, санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шалгагдаж буй асуудалтай холбоотой бол;
3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол;
4. Олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах явцтай холбоотой бол;
5. Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр задлахаар бол
6. Хувь хүний зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд түүний нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулахаар бол;
7. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж, хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг эрх бүхий этгээдийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр тараахыг хориглоно.

УИХ-аас 2014 оны 7 дугаар сард батлагдаж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний

өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн **“Шилэн дансны тухай хууль** юм. Тус хуулиар улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо буюу шилэн дансныг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Тус хуулиар мэдээлэл нь үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зэрэг **зарчмыг** баримтлахаар заасан. Хугацааны хувьд:

1. Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн **төлөвлөлтийг** жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;
2. Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн **гүйцэтгэлийг** жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 8-ны өдрийн дотор
3. Дараа жилийн **төсвийн төслийг** жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;
4. Жилийн эцсийн **санхүүгийн тайланг** дараа жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн **аудитын дүгнэлтийг** бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч **хэрэгжүүлсэн арга хэмжээг** тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор
6. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний **шалтгааны тайлбарыг** улирал бүр байхаар хуульчилсан.

4.5.4. НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД

ИТХ-ууд энэ хуулиар ямар үүрэг хүлээсэн бэ? Нийтийн сонсголын тухай хуулиар төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасан асуудлаар нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангах чиг үүргийг хүлээсэн.

“Нийтийн сонсгол” гэдгийг хуулийн 5.1.1-д заасанчлан хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагааг хэлнэ.

Хуулийн 11.1-д заасанчлан **нэгдүгээрт**: тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүсэлт гаргасан **хоёрдугаарт**: тухайн асуудал эрхэлсэн хурлын байнгын хороо шийдвэр гаргасан бол нийтийн сонсголын зохион байгуулахаар хуульчилсан.

Дээрх хуулиар сонсголд оролцогч этгээдийн эдлэх эрх, хүлээх үүрэг, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагыг хэрхэн оролцуулах, сонсголд оролцогчдын эрх үүрэг, сонсгол зохион байгуулагч, түүний эрх, хүлээх үүрэг, сонсгол даргалагч, түүний эрх, хүлээх үүрэг, сонсгол зохион байгуулах нийтлэг журам, сонсголын

тэмдэглэл, сонсголын тов, сонсголыг нийтэд зарлах, сонсголд оролцох хүсэл гаргах, оролцогчийг бүртгэх, сонсголд шинжээч, орчуулагч, хэлмэрчийг оролцуулах, сонсгол хойшуулах, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага гэсэн агуулыг энэхүү хуулиар тусгайлан зааж оруулсан байна.

Нийтийн сонсголын тухай хууль нь төрийн байгууллага, албан тушаалтан нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад чиглэж байна. Нийтийн сонсголын тухай хуулиар сонсголын төрөл, хэлбэрийг 1) хууль тогтоомжийн төсөл, 2) ерөнхий хяналтын, 3) төсвийн хяналтын, 4) томилгооны, 5) захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн, 6) орон нутгийн гэж ангилсан.

Хүснэгт 4.6. Нийтийн сонсголын төрөл, зохион байгуулах үндэслэл

№	Сонсголын хэлбэр	Сонсгол явуулах чиглэл, нөхцөл
1	Хууль тогтоомжийн төслийн сонсгол:	Хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх, нийтийн ашиг сонирхолтой шууд хамааралтай нийгэм, эдийн засаг болон байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд хууль тогтоомжийн төслийн сонсголыг явуулна. Хууль тогтоомжийн төслийн сонсгол явуулах асуудлыг тухайн байнгын хорооны нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар шийдвэрлэх бөгөөд иргэн хуулийн этгээд уг сонсголыг явуулах хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн байнгын болон дэд хороонд хандан гаргана.
2	Ерөнхий хяналтын сонсгол:	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мониторинг хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор УИХ, нутгийн өөрөө удирдах байгууллага ерөнхий хяналтын сонсголыг явуулахаар тусгасан байна. Ингэхдээ хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг тогтмол явуулах бөгөөд тухайн хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болсноос хойш 24-30 сарын дотор эхний хяналтын сонсголыг, дараагийн сонсголыг таван жил тутамд нэгээс доошгүй удаа заавар зохион байгуулна.
3	Төсвийн хяналтын сонсгол:	УИХ нь төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төсвийн сахилга батыг дээшлүүлэх, төсвийн орлого, зарлага, төсвөөс санхүүжүүлсэн болон хөрөнгө оруулсан үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хянах зорилгоор улсын нэгдсэн төсвийн биелэлт, зарцуулалттай холбоотой асуудлаар төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулна.
4	Томилгооны сонсгол:	Улсын их хурал өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар албан тушаалтныг томилохдоо нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй гишүүдийн хүсэлтийг үндэслэн томилгооны сонсголыг явуулна.

5	Захиргааны хэм хэмжээ, төлөвлөлтийн сонсгол:	Захиргааны хэм хэмжээний актыг батлах, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргахын өмнө зохион байгуулна.
6	Орон нутгийн сонсгол:	УИХ, засгийн газар нь тухайн орон нутгийн ИТХ-ын хүсэлт, тухайн асуудал хариуцсан байнгын хорооны шийдвэрийг үндэслэн тодорхой асуудлаар тухайн газарт очиж сонсгол явуулна.

Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголыг тухайн асуудал эрхэлсэн байнгын, дэд, түр хороо, нутгийн өөрөө удирдах байгууллагаас зохион байгуулах сонсголыг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн ажлын алба, Засгийн газраас зохион байгуулах сонсголыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар хариуцан явуулах бөгөөд бусад байгууллагаас зохион байгуулах сонсголыг Тамгын газар, түүнтэй адилтгах нэгж зохион байгуулна.

Нийтийн сонсголын тухай хуулийг мөрдөж эхэлснээр хууль тогтоох болон төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэд төрөөс гарах шийдвэрийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлэх, шийдвэрт нөлөөлөх эрх зүйн үндэс бүрэлдэж, төр иргэдийн хооронд мэдээллийн эргэх холбоо үүсч, иргэдээс төрд итгэх итгэл нэмэгдэх бөгөөд үүний үр дүнд хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актын чанар сайжирч, нийтээр хүлээн зөвшөөрөх хандлагад эерэг нөлөө үзүүлнэ.

Орон нутгийн удирдлага Нийтийн сонсголын тухай хуулийг хэрэгжүүлэх журмаа УИХ-ын тогтоолоор батлагдсан "Нийтийн сонсголыг зохион байгуулах журам"-ыг үндэслэн боловсруулж мөрдөх юм.

4.5.5. ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД

ИТХ-ууд энэ хуулиар ямар үүрэг хүлээсэн бэ? Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн Ажлын алба нь Захиргааны ерөнхий хуулийн 5.1.5-д зааснаар нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага байна гэж заажээ. Захиргааны ерөнхий хуулиар захиргааны актын төрөлд нутгийн өөрөө удирдах байгууллагаас гарч буй тогтоол шийдвэрийг хамааруулж ойлгохоор болсон.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь захиргааны байгууллага болохын хувьд захиргааны шийдвэрийг гаргахдаа тухайн асуудалд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтоох, түүний ач холбогдол бүхий шаардлагатай үйл ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг хүлээсэн.

Шийдвэр гаргах үйл ажиллагаа явагдах хэлбэр болон хамрах хүрээг захиргааны байгууллага тогтоох ба оролцогчийн гаргасан нотлох баримт өргөдөл хүсэлтийг харгалзан өөрөө бие даан шийдвэрлэнэ.

Тухайн шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай тохиолдол бүрийн үндэслэлийг нутгийн өөрөө удирдах байгууллага нарийвчлан шинжлэн судлах үүрэгтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно.

Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар гаргасан тайлбар болон өргөдөл гомдлыг хүлээн авахаас захиргааны

байгууллага татгалзаж болохгүй.

Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна.Үүнд:

1. ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;
2. оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;
3. шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;
4. гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;
5. баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;
6. шаардлагатай бол туршилт хийх;
7. оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах гэсэн нотлох баримтыг цуглуулна.

Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтооход оролцогч энэ хуульд заасан хүрээнд оролцож, захиргааны байгууллага өөрт байгаа болон байх ёстой мэдээлэл, нотлох баримтыг оролцогчоос шаардахгүй. Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгохоор хуульчилсан.

Тус хуулийн 26.1-д оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэж үзээд захиргааны шийдвэр гаргах захиргааны байгууллага эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлохоор заасан



Сонсох ажиллагааны талаарх **мэдэгдлийг** эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд дараах байдлаар хүргүүлнэ. Үүнд:

1. хорь буюу түүнээс доош тооны этгээдийг сонсохоор бол мэдэгдлийг этгээд тус бүрт шууд хүргүүлэх;
2. хорин нэг буюу түүнээс дээш тооны этгээдийг сонсохоор бол /ижил утгатай өргөдөл гомдол гаргасан 20 ба түүнээс дээш этгээд дундаасаа төлөөлөгч томилж захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох бөгөөд/ төлөөлөгчид шууд хүргүүлэх эсвэл тухайн орон нутагт хүргэх боломжтой хэвлэл мэдээллийн хэрэгсэл шуудан болон тэдгээрт урьдчилан мэдэгдэх бусад арга хэрэгслийг ашиглаж хүргүүлнэ.
3. Сонсох ажиллагааны талаарх мэдэгдэлд дараах **мэдээллийг** тусгана:
 - сонсох ажиллагааг явуулах журам ажиллагаа явуулах он сар өдөр цаг байрлал дарааллын талаарх мэдээлэл;
 - захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль захиргааны хэм хэмжээний актын зүйл заалт;
 - захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх мэдээлэл үндэслэл
4. Сонсох ажиллагааг дараах **арга хэлбэрээр** явуулна. Үүнд:
 1. сонсгол зохион байгуулах;
 2. саналыг бичгээр авах;
 3. биечлэн уулзах;
 4. утсаар санал авах;
 5. цахим хэлбэрээр санал авах;
 6. төлөөлөгчөөр дамжуулж санал авах;
 7. бусад гэсэн хэлбэртэй байна.

Сонсох ажиллагаа явуулах хугацаа оролцогчийн тайлбар санал гаргах боломжийг хангасан байна. Мөн сонсох ажиллагааны явц үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулна. Сонсох ажиллагааны үед гарсан саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.

Дараах **тохиолдолд** сонсох ажиллагааг хийхгүй байж болно.

- нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол;
- гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол;
- иргэн хуулийн этгээдийн өргөдөл гомдлыг ханган шийдвэрлэж байгаа тохиолдолд;
- захиргааны шийдвэрийг техник хэрэгслийн тусламжтайгаар гаргаж байгаа бол;
- захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа бол;
- төр байгууллага хувь хүний нууцын тухай хуулиар хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдад дамжуулах боломжгүй мэдээлэлд хамаарах бол.

Сонсох ажиллагааг хийгээгүй шалтгаанаа захиргааны байгууллага нотлох үүрэгтэй. Оролцогч төр байгууллага болон хувь хүний нууцыг задруулахгүй байхыг захиргааны байгууллагаас шаардах эрхтэй. Захиргааны байгууллага нууцыг задруулахгүй байх **үүрэгтэй** бөгөөд задруулсан тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ. Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргахтай холбоотой мэдээлэл өгөх үүрэгтэй. Оролцогчоос гаргасан хүсэлт, тайлбар, мэдээлэл зэрэг нь захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад бүрэн бус, эсхүл буруу бичигдсэн байвал захиргааны байгууллага оролцогчид холбогдох зөвлөгөө өгөх **үүрэгтэй**.

4.5.6. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙН ХУУЛИЙН ХҮРЭЭНД

Энэхүү хуулиар ИТХ-ууд ямар эрх үүрэг хүлээсэн бэ? Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх хэтийн зорилт болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрхэн батлах болон хэрэгжилтийг нь хангаж ажиллах талаар эрх үүргийг хуульчилж өгсөн.

Тухайн шатны ИТХ нь Засаг даргад чиглэл өгч, өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх, хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж боловсруулан ИТХ батална. Ингэхдээ эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан хөгжлийн хэтийн төлөвлөлтийг зохион байгуулахаар хуульчилсан. Нутгийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцыг хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж тайланг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)-т хүргүүлэхээр заасан.

Мөн хуулийн 15.4-т тухайн шатны ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэхээр заасан. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг ИТХ зохион байгуулахаар хуульчилж өгсөн. Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны ИТХ батална.

Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг ИТХ-д танилцуулж 02 дугаар сарын 20-ны дотор ЗГХЭГ-т хүргүүлэхээр хуульчилсан.

Тэгвэл хөгжлийн төлөвлөлтийг хийхэд иргэд, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг тус хуулийн 19-р зүйлд зааж өгсөн бөгөөд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг хэвлэн нийтлэх, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна.

Дээрх хөгжлийн баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр **хэлэлцүүлэг** зохион байгуулна. Үүнд:

- хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;
- эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;
- тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;
- төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд

хэлэлцүүлгийг зохион байгуулах бөгөөд хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, төслийг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэхээр энэхүү хуулийн 19 дүгээр зүйлд хуульчилж өгсөн.

Хүснэгт 4.7. Иргэдийн оролцоог хангахтай холбоотой зарим хууль тогтоомжийн заалтууд

№	Холбогдох хууль	Холбогдох заалтын дугаар
1	Монгол улсын үндсэн хууль, 1992	3.1; 16.9; 16.17; 25.16; 26.2; 57.3; 62.2
2	Монгол улсын их хурлын тухай хууль, 2006	7.1.14; 7.1.15; 19.4.2; 19.2.9; 19.2.10; 20.4.1; 29.12; 39.1.10; 39.1.11; 43.5
3	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006	12.1.6; 12.1.7; 12.1.9; 17.1.2; 17.1.3; 17.1.4; 20.1.9; 20.1.10; 22.1.4; 22.1.13; 22.1.16
4	Төрийн албаны тухай хууль, 2002	3.2; 4.2.2; 4.2.3
5	Нийтийн сонголын тухай хууль, 2015	1.1; 4.1.3; 4.2; 8.3; 11.2.1; 13.1; 16.1; 17.1; 21.1
6	Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, 2004	4.2; 22.6; 22.7; 23.1
7	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, 2004	4.1; 14.1;
8	Статисткийн тухай хууль, 1997	4.5; 11.1; 18.3; 22.7
9	Төсвийн тухай хууль, 2011	5.1.4; 6.5.2; 67.3
10	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, 1995	7.3; 7.9; 9.1; 16.1; 16.2; 18.1; 18.2; 20
11	Өмч хувьчлах тухай хууль, 1991	2
12	Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003	4.1.2; 5.5
13	Төрийн аудитын тухай хууль, 2003	3.1; 23.1; 24.1; 25.1
14	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль, 2005	21.1; 21.2; 21.3; 21.4; 22.3; 22.4
15	Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, 1998	1
16	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2003	5.5; 5.6
17	Эрүүл мэндийн тухай хууль, 2011	8.1.7; 47.1; 47.1.1; 47.1.2; 47.1.3; 47.1.4; 47.1.5; 50.1; 50.1.1; 50.1.2; 28.1; 28.1.1; 28.1.2; 28.1.3; 28.1.4; 28.1.5
18	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008	32; 32.1.6; 34; 34.1.1; 34.1.2; 34.1.3; 34.1.4; 34.1.5; 34.1.6; 34.1.7
19	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012	18; 18.1; 18.2; 18.3; 18.4; 18.5
20	"Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай" УИХ-ын 48 дугаар тогтоол, 2010	1.2.2; 3.3.4.2; 3.3.4.3; 4.2.3; 5.3.2; 5.5.2; 5.5.3

ХАВСРАЛТ.

МАЛЧИД, ТАРИАЛАНЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

*Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны
10 дугаар сарын 18-ны өдрийн 25 дугаар хурлын тогтоолын
хавсралт*

Нэг. Журмын зорилго

Энэхүү журам нь таримал ургамал, тариалангийн талбайг мал, тэжээвэр амьтдаас хамгаалахын тулд малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг ханган, тэдгээрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож таримал ургамал тариалагч, малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1. Таримал ургамлыг мал, амьтдаас хамгаалах журмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын холбогдох хуулийн заалтыг баримтлан гүйцэтгэнэ.
- 2.2. Үр тариа, тэжээлийн ургамал, таримал хадлан, жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, олон наст ургамал болон ойг нөхөн сэргээх зориулалтаар тарьсан ба хашиж хамгаалсан мод, бут, сөөг, хот тосгоны ногоон байгууламжийн ургамлуудыг таримал ургамалд хамааруулна.
- 2.3. Энэ журамд Газрын тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын тухай хууль, Таримал ургамлын үр сортын тухай хуулинд заасны дагуу тарьж эхэлснээс ургац хураан авч дуусах хүртэл хугацаа хамаарна.
- 2.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн таримал ургамал тариалсан талбайгаа хашаажуулах, тэмдэг-жүүлэх, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээнэ.
- 2.5. Малчин, мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгж нь өөрсдийн мал, тэжээвэр амьтдыг байнгын хариулга, маллагаатай, хараа хяналттай байлгах үүрэг хүлээнэ.
- 2.6. Зөрчил гаргасан тохиолдолд Иргэний хууль, Газрын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон энэ журамд заасны дагуу хохирлыг төлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон сум, багийн Засаг даргын үүрэг

3.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үүрэг

- 3.1.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын малд төлбөр, хураамж ногдуулах хэмжээг тогтоох.
- 3.1.2. Малчид, тариаланчдын үйл ажиллагааг зохицуулсан журам батлах, өөрчлөх.
- 3.1.3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сумын Засаг даргын дэргэдэх үнэ тогтоох комиссын санал, тухайн зах зээлийн үнэ ханшийг үндэслэн малын жишиг үнэлгээг тогтоох.
- 3.1.4. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тариаланчид, ногоочид, малчдын саналыг өргөн тусгаж өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газрыг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.2. Сумын Засаг даргын үүрэг

- 3.2.1. Таримал ургамал тариалсан газрын нэр, байршил, тариалалт эхлэх, ургац хурааж дуусах хугацааны талаар шийдвэр гаргаж нийтэд зарлан мэдээлнэ.
- 3.2.2. Малчид, мал бүхий иргэдийн хаваржих, зусах, намаржих газар болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бус нутгийн газрыг малын тоо, газар тариалангийн талбайн байршлыг харгалзан тогтоож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.2.3. Холбогдох мэргэжилтнүүд, малчид, тариаланчдын төлөөлөл оролцсон хохирол тогтоох сумын комисс байгуулна. Сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга, Байгаль орчны байцаагч, Газрын даамал, Хөдөө аж ахуйн тасгийн дарга болон Газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, иргэний төлөөлөл гэх мэт
- 3.2.4. Таримал ургамлын талбайд мал тэжээвэр амьтад орж хохирол учирсан тохиолдолд хохирлыг сумын комисс тухайн таримал тариалсан эзэн, тарианд орсон мал, тэжээвэр амьтны эздийг байлцуулан тогтоож баталгаажуулна.
- 3.2.5. Тариалангийн талбайд мал орж хохирол учруулсан мэдээлэл ирсэн тохиолдолд сумын комисс 2 хоногт багтаан газар дээр нь очиж, хоёр талын төлөөлөгч, хөндлөнгийн гэрчийг байлцуулан хохирлын акт тогтооно. Сумын комиссын зардлыг таримал ургамал тариалагч хариуцна.
- 3.2.6. Хохирол учруулсан нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий улсын байцаагч захиргааны хариуцлага тооцно.
- 3.2.7. Сумын комиссын тогтоосон хохирлын актыг талууд эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.
- 3.2.8. Малын өвөлжөө, хаваржаа, намаржааны болон сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан талбайг хашаажуулах арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сан, төсөл, хөтөлбөр аж ахуйн нэгж, малчид байгууллагын хөрөнгөөр хамтран шийдвэрлэнэ.
- 3.2.9. Малчид, тариаланчдын зөвлөлгөөн, уулзалтыг жил бүр зохион байгуулж малчид, тариаланчдыг мэдээ, мэдээллээр ханган ажиллана.
- 3.2.10. Таримал ургамлын талбайгаас 500 метрийн дотор өвөлжөө, хаваржааны газар шинээр олгохгүй байна.
- 3.2.11. Хамтын хөдөлмөрөөрөө хоршин, бүлэг хоршооны зохион байгуулалтанд орж, мал аж ахуйгаа эрчимжүүлсэн малчдад нутаг бэлчээрээ зүй зохистой ашиглахад дэмжлэг үзүүлж тэжээлийн ургамал тариалах талбай олгож болно.

3.3. Багийн Засаг даргын үүрэг

- 3.3.1. Энэхүү журмыг нийт тариаланч малчин, мал бүхий иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудад таниулах сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 3.3.2. Сумын төв, суурин газрын малыг тариалалт эхлэхээс дуусах хүртээх хугацаанд байнгын хариулга, маллагаатай байлгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авна.
- 3.3.3. Багийн Засаг дарга хаваржаа, намаржаа, өвөлжөө, зуслан болон сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан иргэн, аж ахуйн нэгж, тэнд нутаглаж буй малчид, мал бүхий иргэдтэй гурвалсан гэрээ байгуулж харилцан үүрэг хүлээж, журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Таримал ургамал тариалагчийн үүрэг

- 4.1. Тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өмчөө хамгаалах зорилгоор тариалсан талбайнхаа ойролцоо нутагладаг мал бүхий иргэн, айл өрх, аж ахуйн нэгжтэй тарианд мал оруулахгүй байх, оруулсан нөхцөлд хохирлыг хэрхэн тооцох талаар тохиролцон гэрээ байгуулна.
- 4.2. Таримал ургамал бүхий талбайд орж хохирол учруулсан мал, тэжээвэр амьтны эзэн нь тогтоогдоогүй нөхцөлд мал амьтныг зориулалтын хашаанд хашиж энэ тухай сумын комисст мэдэгдэн эзэн нь тогтоогдсон үед хашиж малласан хугацаанд гарсан зардал учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 4.3. Таримал ургамал бүхий талбайд мал орж хохирол учруулсан бол орсон малын тоо, зүс, ээмэг, тамга, малын мөр, таримал ургамлыг сүйтгэсэн байдлыг фото зураг, видео камераар баталгаажуулан баримтжуулна.
- 4.4. Тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага таримал ургамлаа мал, тэжээвэр амьтдаас хамгаалж хашаа барих, харуул сахиул гаргах замаар байнгын хамгаалалтанд байлгана,
- 4.5. Тариалсан талбайг тэмдэгжүүлж 500 хүртэл га тутамд нэг манаач, сахиул байхаар тооцон унаа, холбооны хэрэгслээр хангаж ажиллана.
- 4.6. Сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь талбайгаа оөрийн хүч хөрөнгөөр хашаажуулна.
- 4.7. Таримал ургамал тариалагч, иргэн аж ахуйн нэгж, байгууллага тариалсан талбайд орсон мал, тэжээвэр амьтдыг тусгайлан хашиж, сумын комисс болон эзэнд нь мэдэгдэж тоо толгой, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 4.8. Сумын комиссыг өөрсдийн унаа, зардлаар авч хохирлоо тогтоолгоно.
- 4.9. Таримал ургамалд мал, тэжээвэр амьтад хохирол учруулсан нөхцөлд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоосон жишиг үнэлгээнд үндэслэн учирсан хохиролд дүйцэхүйц мал, тэжээвэр амьтдыг барьцаалан авч төлбөрөө барагдуулсан нөхцөлд буцаан олгоно.
- 4.10. Малчдын өвөлжөө, намаржааны ойролцоо байрлах үр тарианы бригад болон төмс хүнсний ногоо тариалж буй аж ахуйн нэгж, иргэд малчдын өвөлжөөг харж хамгаалах талаар гурвалсан гэрээнд тусган хэрэгжүүлж болно.
- 4.11. Таримал ургамлаа эрсдлийн даатгалд хамруулна.
- 4.12. Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу буюу зайлшгүй тохиолдолд харилцан тохиролцсоны дагуу зарим талбайгаас сүрэл, технологийн хаягдлаа талбайн захад гаргаж өгч болно.
- 4.13. Сумын төвийн ойролцоо таримал ургамал тариалсан иргэд, аж ахуйн нэгж нь ургац хураалтын үед мал бүхий иргэдийн малыг нэгдсэн хариулгатай болгох ажилд тусалж малчны цалин урамшуулалд дэмжлэг үзүүлж болно.
- 4.1.14. Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих зорилгоор тариалангийн талбайн орчмын малчдын хүсэлт захиалгаар тариалангийн сэлгээндээ тэжээлийн ургамал тариална.

Тав. Малчин мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

- 5.1. Малчин, мал бүхий иргэд сум багаас гаргасан хуваарьт газартхаваржиж, зусаж, намаржина.
- 5.2. Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь таримал ургамал тариалсан, уриншилсан талбайд мал бэлчээхгүй, оруулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 5.3. Тариалангийн талбайн ойролцоо нутаглаж буй малчин, мал бүхий иргэд

- малаа ургац хураалт дуустал байнгын хариулгатай байлгах буюу алсын, ойрын бэлчээрт гаргах арга хэмжээ авна.
- 5.4. Сум орон нутгаас зааж өгсөн бэлчээрт гараагүйгээр таримал ургамалд хохирол учруулсан нөхцөлд хохирлыг тухайн малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 100 хувь хариуцна.
 - 5.5. Таримал ургамал бүхий талбайн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бод малаа хаших хашаатай байж, шөнийн цагаар малаа хашиж байна.
 - 5.6. Таримал ургамал хамгаалах журам зөрчигдөж байгааг мэдсэн иргэн сумын комисст нэн даруй мэдэгдэнэ.
 - 5.7. Таримал ургамал тариалсан талбайд мал, тэжээвэр амьтан орсноос учирсан бодит хохирлыг сумын комиссын тогтоосон актыг үндэслэн энэ журамд заасны дагуу нөхөн төлнө.
 - 5.8. Таримал ургамалд учруулсан хохирлоо 5 хоногийн дотор ямар нэгэн хэлбэрээр барагдуулна.
 - 5.9. Хохирлын хэмжээ, хохирол төлөхтэй холбогдсон гомдлоо шүүхэд гаргаж болно.
 - 5.10. Сумын заасан нутагт хаваржиж, зусаж, намаржиж байгаа малчин, мал бүхий иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн мал нь таримал ургамал тариалсан талбайд өдрийн цагаар орвол хохирлыг малын эзэн, тариан талбайн эзэн 50/50 хувь, шөнийн цагаар орвол малын эзэн хохирлыг бүрэн хариуцна. Шөнийн цаг гэдгийг оройи 22.00 цагаас өглөөний 06.00 цаг гэж ойлгоно.
 - 5.11. Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрчимжсэн хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бодлого чиглэлийг түлхүү барьж өндөр ашиг шимтэй цөөн тооны малаар сүргийн бүтцээ бүрдүүлэхийг эрхэмлэнэ.
 - 5.12. Сумын төвийн болон суурин газрын мал бүхий иргэд хамтран багийн Засаг даргын зохион байгуулснаар малаа байнгын хариулгатай болгож шөнийн цагаар хашиж байна.

Зургаа. Журам зөрчигчид хулээлгэх хариуцлага

- 6.1. Газрын тухай хуулийн 52.2, 53.3, 54.3-т заасан заалтыг зөрчсөн бол энэ хуулийн 63.1.8-д заасны дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь учруулсан хохирлыг үндэслэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 6.2. Таримал ургамал тариалсан талбайд мал амьтан оруулж устгаж гэмтээсэн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан бол сум, багийн Засаг дарга энэ хуулийн 10.2, 12.5-ыг үндэслэн арга хэмжээ авна.
- 6.3. Өдрийн цагаар таримал ургамлын талбайд орсон малын учруулсан хохирлын 50 хувийг мал, тэжээвэр амьтны эзэн, 50 хувийг таримал ургамал эрхлэгч хариуцах ба шөнийн цагаар учруулсан хохирлыг 100 хувь малчин, мал бүхий иргэд, байгууллагаар төлүүлнэ.
- 6.4. Таримал ургамлын хөгжлийн үе шат /соёололт, бутлалт, гол хатгалт, түрүүлэлт, цэцэглэлт, үрийн бүрдэлт, цутгалт, сүүн болц, аарцан болц/ бүрийн хохирлыг үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө буюу технологийн картанд тусгагдсан ургацаар тооцно.
- 6.5. Таримал ургамал бүрэн боловсорч хураалтын үе явагдаж байгаа үед учруулсан

хохирлыг биологийн ургацаар /ургац тогтоолтоор нэг га-гаас авахаар тогтоосон ургацаар/ тооцож барагдуулна.

- 6.6. Төв суурин газрын иргэн, аж ахуйн чэгж, байгууллага мал тэжээвэр амьтдаа нэгдсэн хариулгад хамруулаагүйгээс таримал ургамалд хохирол учруулсан бол хохирлыг тухайн мал, амьтны эзэн бүрэн хариуцаж төлнө.
- 6.7. Таримал ургамлыг хашиж хамгаалсан талбайн хашаа, байгууламжийн эвдэж устгасан этгээдээр түүнийг сэргээн босгоход гарах зардлыг 2 дахин нугалж төлүүлнэ.
- 6.8. Хохирол учруулсан этгээд хохирлыг санаатайгаар барагдуулаагүй бол хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг сум, багийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, хохирогч нар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

оОо

 pdfelement

БАГИЙН ЗАСАГ ДАРГА, МАЛЧИД, ТАРИАЛАНЧДЫН ГУРВАЛСАН ГЭРЭЭ

... оны ... сарын ... өдөр

№ ...

Нэг дэх талаас: Таримал ургамал тариалагч иргэн /аж ахуйн нэгж/ ...
... –ийг төлөөлөн ... овогтой ... эцгийн нэр ...
... нэр РД: ...

Хоёрдагч талаас: Малчин /мал бүхий иргэн/ ... –ийг төлөөлөн
... овогтой ... эцгийн нэр ... нэр РД: ...

Гуравдагч талаас: ... аймгийн ... сумын ... багийн Засаг дарга ...
... –ийг төлөөлөн ... овогтой ... эцгийн нэр ...
... нэр РД: ... нар харилцан тохиролцож энэхүү гэрээг
байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

Таримал ургамал тариалагч иргэн, аж ахуйн нэгж, малчин, мал бүхий иргэдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, малчид, тариаланчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгоход оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 Энэхүү гэрээг боловсруулахдаа Монгол Улсын холбогдох хуулийн заалтууд, аймгийн ИТХ-ын 2013 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Малчид тармаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ыг баримтлан гүйцэтгэнэ.
- 2.2. Газрын тухай хуулийн 54.3.1 заасны дагуу Тариалангийн талбайд өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр мал амьтан оруулах, бэлчээхийг хориглоно” гэсэн заалтыг биелүүлэхэд гурван талт гэрээний үйл ажиллагааг чиглүүлнэ
- 2.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн таримал ургамал тариалсан тапбайгаа хашаажуулах, тэмдэгжүүлэх, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээнэ.
- 2.4. Малчин, мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгж нь өөрсдийн мал тэжээвэр амьтдыг байнгын хариулга, маллагаатай, хараа хяналттай байлгах үүрэг хүлээнэ.

Гурав. Багийн Засаг даргын эрх үүрэг

- 1.1. “Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ыг нийт тариаланч, малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, Байгууллагуудад таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 1.2. Сумын төв, суурин газрын малыг тариалалт эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд байнгын хариулага, маллагаатай байлгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авна
- 1.3. Хаваржаа, намаржаа, өвөпжөө, зуспан болон сумын төв суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан иргэн, аж ахуйн нэгж, тэнд нутаглаж буй малчид, мал бүхий иргэдтэй гурвалсан гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.

- 1.4. Таримал ургамал тариалсан талбайд мал, тэжээвэр амьтан орсон тохиолдолд багийнхаа малчин, мал бүхий иргэдэд хурдан шуурхай мэдээллэнэ.
- Дөрөв. Таримал ургамал тариалагчийн үүрэг
- 4.1. Тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өмчөө хамгаалах зорилгоор тариалсан талбайнхаа ойролцоо нутагладаг малчин, мал бүхий иргэд, айл өрх, аж ахуйн нэгжтэй тарианд мал оруулахгүй байх, оруулсан нөхцөлд хохирлыг хэрхэн тооцох талаар тохиролцон гэрээ байгуулна
- 4.2. Таримал ургамал бүхий талбайд орж хохирол учруулсан мал тэжээвэр амьтны эзэн нь тогтоогдоогүй нөхцөлд мал амьтныг зориулалтын хашаанд хашиж энэ тухай сумын комисст мэдэгдэн эзэн нь тогтоогдсон үед хашиж малласан хугацаанд гарсан зардал учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 4.3. Таримал ургамал бүхий талбайд мал орж хохирол учруулсан бол малын тоо, зүс, ээмэг, тамга, малын мөр, ургамлыг сүйтгэсэн байдлыг фото зураг, видео камераар баталгаажуулан баримтжуулна
- 4.4. Тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага таримал ургамлаа мал, тэжээвэр амьтдаас хамгаалж хашаа барих, сахиул томилж өглөөний 05 цагаас оройн 22 хүртэл ажиглуулна.
- 4.5. Тариалсан талбайг тэмдэгжүүлж, 500 хүртэл га тутамд нэг манаач, сахиул байхаар тооцон унаа, холбооны хэрэгслээр хангаж ажиллана
- 4.6. Сумын төв, суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь талбайгаа өөрийн хүч хөрөнгөөр хашаажуулна.
- 4.7. Таримал ургамал тариаланч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тариалсан талбайд орсон мал, тэжээвэр амьтдыг тусгайлан хашиж, ажлын хэсэг, багийн Засаг дарга нар болон эзэнд нь мэдэгдэж тоо толгой, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- 4.8. Таримал ургамалд мал, тэжээвэр амьтад хохирол учруулсан нөхцөлд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоосон жишиг үнэлгээнд үндэслэн учирсан хохиролд дүйцэхүйц мал, тэжээвэр амьтдыг барьцаалан авч төлбөрөө барагдуулсан нөхцөлд буцаан олгоно.
- 4.9. Хаваржаа, намаржаа, өвөлжөө, зуслан болон сумын төв суурин газрын ойролцоо таримал ургамал тариалсан иргэн, аж ахуйн нэгж, тэнд нутаглаж буй малчид, мал бүхий иргэдтэй гурвалсан гэрээ байгуулах ажилд оролцон харилцан үүрэг хүлээж, журмын хэрэгжилтийг ханган гэрээг байгуулан ажиллана.
- 4.10. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан журмыг хэрэгжүүлэн, гурвалсан гэрээгээ сайн биелүүлсэн мал, тэжээвэр амьтдаа таримал ургамал тариалсан талбайд оруулаагүй малчин, мал бүхий иргэнийг тодорхой нөхцөлөөр урамшуулна.

Тав. Малчин, мал бүхий иргэний хүлээх үүрэг

- 5.1. Малчин, мал бүхий иргэд нь сум, багаас заасан хуваарьт газар хаваржиж, зусаж, намаржина.
- 5.2. Малчин, мал бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь таримал ургамал тариалсан, уриншилсан талбайд мал бэлчээхгүй, оруулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 5.3. Тариалангийн талбайн ойролцоо нутаглаж буй малчин, мал бүхий иргэд

малаа тариалалтын үед болон 08 дугаар сарын 25-наас 10 дугаар сарын 15 хүртэл өдрийн цагаар байнгын хариулага, маллагаатай байлгаж шөнийн цагаар хашина.

- 5.4. Сум орон нутгаас зааж өгсөн бэлчээрт гараагүйгээр таримал ургамалд хохирол учруулсан нөхцөлд хохирлыг тухайн малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 100 хувь хариуцна.
- 5.5. Таримал ургамал бүхий талбайн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бод малаа хаших хашаатай байж. шөнийн цагаар малаа хашиж байна.
- 5.6. Таримал ургамал тариалсан талбайд мал, тэжээвэр амьтан орсноос учирсан бодит хохирлыг сумын комиссын тогтоосон актыг үндэслэн журамд заасны дагуу нөхөн төлнө.
- 5.7. Таримал ургамалд учруулсан хохирлоо 5 хоногийн дотор ямар нэгэн хэлбэрээр барагдуулна.
- 5.8. Хохирлын хэмжээ, хохирол төлөхтэй холбогдсон гомдлоо шүүхэд гаргаж болно.
- 5.9. Сумын заасан нутагт хаваржиж, зусаж, намаржиж байгаа малчин, мал бүхий иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн мал нь таримал ургамал тариалсан талбайд өдрийн цагаар орвол хохирлыг малын эзэн, тариан талбайн эзэн 50/50 хувь, шөнийн цагаар орвол малын эзэн хохирлыг бүрэн хариуцна.
- 5.10. Сумын төвийн болон суурин газрын мал бүхий иргэд хамтран багийн Засаг даргын зохион байгуулснаар малаа байнгын хариулгатай болгож шөнийн цагаар хашиж байна.

Зургаа. Гэрээг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 6.1. Газрын тухай хуулийн 52.2, 53.3. 54 3-т заасан заалтыг зөрчсөн бол энэ хуулийн 63.1.8-д заасны дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь учруулсан хохирлыг үндэслэн иргэнийг хөдөлмөрын хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 6.2. Таримал ургамал тариалсан талбайд мал амьтан оруулж устгаж гэмтээсэн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан зөрчил / Бэлтгэсэн хадлан тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан оруулан гишгүүлэх, идүүлэх зэргээр таримал ургамал, жимс жимсгэний болон бусад суулгац, тарьц устгасан гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг шүүхийн журмаар нөхөн төлүүлж 500-25000 төгрөгөөр торгох/ гаргасан бол сум, багийн Засаг дарга энэ хуулийн 10.2.12.5-ыг үндэслэн арга хэмжээ авна.
- 6.3. Өдрийн цагаар таримал ургамлын талбайд орсон малын учруулсан хохирлын 50 хувийг мал, тэжээвэр амьтны эзэн, 50 хувийг таримал ургамал эрхлэгч хариуцах ба шөнийн цагаар учруулсан хохирлыг 100 хувь малчин, мал бүхий иргэд байгууллагаар төлүүлнэ.
- 1.4 Таримап ургамлын хөгжлийн үе шат / соёололт, бутлалт, гол хатгалт, түрүүлэлт, цэцэглэлт, үрийн бүрдэлт, цутгалт, сүүн болц, аарцан болц / бүрийн хохирлыг үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө буюу технологийн картанд тусгагдсан ургацаар

тооцно.

- 1.5 Таримал ургамал бүрэн боловсорч хураалтын үе явагдаж байгаа үед учруулсан хохирлыг биологийн ургацаар /ургац тогтоолтоор нэг га-гаас авахаар тогтоосон ургацаар/ тооцож барагдуулна.
- 1.6 Төв суурин газрын иргэн. аж ахуйн нэгж. байгууллага мал тэжээвэр амьтдаа нэгдсэн хариулгад хамруулаагүйгээс таримал ургамалд хохирол учруулсан бол хохирлыг тухайн мал, амьтны эзэн бүрэн хариуцаж төлнө.
- 1.7 Таримал ургамлыг хашиж хамгаалсан талбайн хашаа, байгууламжийн эвдэж устгасан этгээдээр түүнийг сэргээн босгоход гарах зардлыг 2 дахин нугалж төлүүлнэ
- 1.8 Сумын ажлын хэсгийн тогтоосон хохирлын актыг талууд эс зөөшөөрвөл гомдолоо шүүхэд гаргана.
- 1.9 Хохирол учруулсан этгээд хохирлыг санаатайгаар барагдуулаагүй бол хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг сум, багийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, хохирогч нар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан

Ургамал тариалагчийг
төлөөлж:

Багийн Засаг дарга:

Малчиныг төлөөлж:

Хаяг:

Утас:

Гарын
үсэг:



pdfelement

ЭХ СУРВАЛЖ, УНШИХ МАТЕРИАЛ

- Peter F. Dale, John D. (1999). McLaughlin. *Land Administration*. New York: Oxford University Press.
- Raleigh, Barlawe. (1978). *Land Resource Economics*. New Jersey: Michigan State University.
- UNECE. (2005). *land administration principles*.
www.shuukh.mn сайт. УБ, 2016.
- Амарсанаа, Ж., Баянбилэг, Д. (2013). *Захиргааны хэрэг*. УБ, Захиргааны хэрэг.
- Батсүх, Ш., Долгоржав, Я., Ганцоож, Б. (2014). *Шууд ардчилал - Иргэдийн оролцоо*. УБ: Конрад-Аденауэр сан, Удирдлагын Академи.
- Долгоржав, А., Гуннар Андерссон, Золзаяа, Л., Лувсанжамц, Л. (2003). *Монгол Улсад Нутгийн өөрийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх нь*. УБ: МНУХ, ШТЗИ-SIPU, SALA IDA.
- Жаргал, Г. (2016). *Манлайлалд алхам алхмаар суралцах нь*. УБ: Арилдал.
- Монгол Улсын Газрын бодлого, удирдлага*. (2013). Улаанбаатар.
- Жаргал, Г., Солонго, Д., Уянга, М. (2014). *Газар баялгаас өмч үүсгэх арга: Газрын эрх зүй*. Улаанбаатар.
- Лхагва,Т. (2009). *Экологи*. Улаанбаатар.
- Мягмарсүрэн, Д., Намхай, А. (2012). *Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд*. УБ: Мөнхийн үсэг.
- Сэлэнгэ аймгийн ИТХ-ын малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам*. (2013). Сүхбаатар.
- Хамтын Идэрпүрэв, А. болон. (2016). *Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын сайн туршлагын эмхтгэл*. УБ: МОН 13/101 төсөл, ОНХХ.
- Хамтын Тунгалаг, О. болон. (2016). *Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлах зарим журам, дүрмийн төслүүд*. УБ: МОН-13/101 төсөл, Тунгаамал төв.
- Хамтын Цэгмэд, С. болон. (2016). *Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дэмжих тэтгэлэг*. УБ: МОН-13/101 төсөл.
- Ханс-Георг Петерсен. орч Намсрай, Б., Энхбаяр, Г., Амартүвшин, М., Ариунаа, Л. ред Энхтайван, Л. (2008). *Төрийн эдийн засаг*. Улаанбаатар.
- Хулдорж, Б., Бум-аюуш, М., Дагва, Ш., Мягмар, Д., Шомбодоон, Д. (2012). *Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилт*. УБ: ЗГ, НҮБ.
- Чимид, Б. (2002). *Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй*. УБ : Удирдлагын Академи.
- Чимид, Б., Жаргал, Г., Отгончимэг, Х. (2005). *Сум, дүүргийн эрх зүйн байдалд холбогдсон хуулийн системчилсэн эмхтгэл*. УБ: ХЗҮТ, УА.
- Ыханбай, Х. (2010). *Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежмент*. УБ: БОАЖЯ, ОУХСТ төсөл.

Бусад гарын авлага

1. Австралийн Засгийн газар. (2006). *Уурхайг хаах, үйл ажиллагааг дуусгавар болгох*. Австралийн хамтын нөхөрлөл, Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр,
2. Австралийн Засгийн газар. (2006). *Орон нутгийн иргэдийн оролцоо ба хөгжил гарын авлага*. Австралийн хамтын нөхөрлөл, Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр,
3. Австралийн Засгийн газар. (2007). *Биологийн олон янз байдлын менежмент*. Австралийн хамтын нөхөрлөл, Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр,
4. Австралийн Засгийн газар. (2008). *Эрсдэлийн үнэлгээ ба менежмент*. Австралийн хамтын нөхөрлөл, Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр,
5. Австралийн Засгийн газар. (2008). *Усны менежмент*. Австралийн хамтын нөхөрлөл, Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр,
6. Австралийн Засгийн газар. (2009). *Агаарын бохирдол, дуу чимээ, чичиргээ*. Австралийн хамтын нөхөрлөл, Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр,
7. Австралийн Засгийн газар. (2009). *Цианид менежмент*. Австралийн хамтын нөхөрлөл, Уул уурхайн салбарт зориулсан тэргүүлэх туршлага, тогтвортой хөгжлийн хөтөлбөр.



pdfelement